

МОНГОЛ УЛСЫН
ХӨГЖЛИЙН БОДЛОГО ТӨЛӨВЛӨЛТ,
УЛСЫН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН САЛБАРЫН
СУУРЬ СУДАЛГАА

ЭЦСИЙН ТАЙЛАН

2017 он 2 сар

ЯПОНЫ ОЛОН УЛСЫН ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ БАЙГУУЛЛАГА
(ЖАЙКА)

АЛМЕК Ви Пи Ай ХК
Ай Си Нэт ХК
ЭКСИ ИДЕА ХХК

3R
JR
17-010

МОНГОЛ УЛСЫН
ХӨГЖЛИЙН БОДЛОГО ТӨЛӨВЛӨЛТ,
УЛСЫН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН САЛБАРЫН
СУУРЬ СУДАЛГАА

ЭЦСИЙН ТАЙЛАН

2017 он 2 сар

ЯПОНЫ ОЛОН УЛСЫН ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ БАЙГУУЛЛАГА
(ЖАЙКА)

АЛМЕК Ви Пи Ай ХК

Ай Си Нэт ХК

ЭКСИ ИДЕА ХХК

EXCHANGE RATE USED IN THE REPORT

USD 1 = MNT 2,484

USD 1 = JPY 113.50

(RATE IN JANUARY 2017)

ГАРЧИГ

1	Судалгааны агуулга	1-1
1.1	Судалгааны үндэслэл	1-1
1.2	Судалгааны зорилго, үр дүн	1-3
1.3	Судалгааны хэрэгжүүлэх тогтолцоо, холбогдох байгууллага	1-4
2	Монгол улсын хөгжлийн бодлого төлөвлөлтийн тогтолцоо	2-1
2.1	Шинэ Засгийн газрын бүтэц	2-1
2.2	Хөгжлийн бодлого төлөвлөлтийн хуульд тулгуурласан хөгжлийн бодлого тогтолцоо	2-3
2.3	Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал 2030	2-6
2.4	Улсын хөрөнгө оруулалтын бодлогын үндсэн суурь	2-10
2.5	Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр	2-11
2.6	Эдийн засгийг сэргээх хөтөлбөр (ERP).....	2-20
3	Улсын хөрөнгө оруулалтын өнөөгийн байдал, тулгамдаж буй асуудал	3-1
3.1	Улсын хөрөнгө оруулалтын хөрөнгийн эх үүсвэр болон өнөөгийн байдал, тулгарч буй асуудал	3-1
3.2	Мега төслийн хэрэгжилт ба явцын тухай	3-26
3.3	Хөгжлийн бодлого, улсын хөрөнгө оруулалтын салбарт хэрэгжүүлж буй хандивлагч байгууллагын хамтын ажиллагааны төсөл хөтөлбөрийн тухай.....	3-28
3.4	Улсын хөрөнгө оруулалтын хэрэгжилттэй холбогдох асуудал	3-32
3.5	Сургалт, сургалтын хөтөлбөр, хэрэгжүүлэх бүтэц.....	3-40
4	Үндэсний хөгжлийн газрын бодлого зохицуулалт, үйл ажиллагааны чиг үүргийн ерөнхий агуулга.....	4-1
4.1	Монгол улсын хөгжлийн бодлого төлөвлөлтийн бүтэц, төсөв санхүүгийн тогтолцоо, сургамж	4-1
4.2	Бүтэц зохион байгуулалт, үйл ажиллагааны чиг үүрэг	4-4
4.3	Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөр (PIP : Public Investment Program)-ийг боловсруулах хууль эрх зүйн орчин	4-7
4.4	Үндэсний хөгжлийн газарт тулгарч буй өнөөгийн асуудал	4-9
5	Улсын хөрөнгө оруулалтын мөчлөг дэхь асуудал, шийдвэрлэх арга хэмжээний чиглэл 5-1	
5.1	Улсын хөрөнгө оруулалтын мөчлөгийг цэгцлэх.....	5-1
5.2	Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөр боловсруулах үе шат бүрт тулгарах асуудал, шийдвэрлэх арга хэмжээ.....	5-9
5.3	Үндэсний Хөгжлийн Газар, Сангийн яамны хамтын ажиллагаа, зохицуулалтын тогтолцоог боловсронгуй болгох.....	5-30

5.4	Төсвийн менежмент дахь улсын хөрөнгө оруулалтын эх үүсвэрийн хамрах хүрээ	5-34
6	Хөгжлийн бодлого төлөвлөлт, улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөр боловсруулах чадавхийг бэхжүүлэх хамтын ажиллагааны чиг хандлага (туслалцааны хувилбар). 6-1	
6.1	Хамтын ажиллагааны төслийн зорилго, хүлээгдэж буй үр дүн.....	6-1
6.2	Хамтран ажиллагч байгууллага сонгох тухай	6-3
6.3	Хэрэгжүүлэх бүтэц, тогтолцооны хэм хэмжээ	6-5
6.4	Хамтын ажиллагааны бүтэц бүрдүүлэхэд чиглэсэн хамтын ажиллагааны салбар (хамтын ажиллагааны бүрэлдэхүүн хэсэг)	6-7
6.5	Хандивлагчдын хамтын ажиллагааны тойм	6-12
6.6	Хэрэгжүүлэхэд анхаарах асуудал	6-15
7	Дүгнэлт.....	7-1
7.1	Монгол улсын шинэ хөгжлийн бодлогын тогтолцоо бүрдүүлэхэд дэмжлэг үзүүлэх ач холбогдол	7-1
7.2	Техникийн хамтын ажиллагааны төсөл хэрэгжүүлэхэд анхаарах асуудал	7-4

Хавсралт материал

Хавсралт.....	Сангийн Яамны Бүтэц зохион байгуулалт
Хавсралт.....	Төсвийн тухай хууль
2 бүлгийн хавсралт-1	Эдийн засгийг сэргээх хөтөлбөр, хэрэгжүүлэх төлөвлөгөө
2 бүлгийн хавсралт-2	2016 оны УИХ-ын 71-р тогтоол хавсралт 1
3 бүлгийн хавсралт.....	Хандивлагч байгууллагуудын төслүүдийн агуулга
7 бүлгийн хавсралт.....	RESOLUTION OF THE GOVERNMENT OF MONGOLIA

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 2.1.1	Монгол улсын Засгийн газрын бүтэц	2-1
Хүснэгт 2.2.1	Хөгжлийн бодлого төлөвлөлтийн хуульд тусгагдсан бодлогын бичиг баримт	2-4
Хүснэгт 2.3.1	2030 оны зорилтууд.....	2-7
Хүснэгт 2.5.1	Монгол улсын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрөөс (2016-2020)	2-11
Хүснэгт 3.1.1	MTFF2017-2019-д тусгагдсан эдийн засгийн гол үзүүлэлтүүд	3-2
Хүснэгт 3.1.2	MTFF 2017-2019 дэхь төсвийн гол тоон үзүүлэлт.....	3-2
Хүснэгт 3.1.3	MTFF 2017-2019 дэхь урсгал болон хөрөнгийн зардлын хуваарилалт	3-3
Хүснэгт 3.1.4	2017 оны төсөвт тусгагдсан хөрөнгийн зардлын санхүүжилтийн задаргаа	3-6
Хүснэгт 3.1.5	Засгийн газрын өрийн задаргаа (2016 оны 9 сарын сүүлийн байдлаар)	3-9
Хүснэгт 3.1.6	Сингапурын бирж дэх арилжсан бондын задаргаа	3-10
Хүснэгт 3.1.7	2017 оны төсөв дэхь гадаадын зээл тусламж.....	3-11
Хүснэгт 3.1.8	Хөгжлийн банкнаас хийсэн хөрөнгө оруулалт	3-13
Хүснэгт 3.1.9	2015 оны Хөгжлийн банкны санхүүгийн байдлын тайлан.....	3-14
Хүснэгт 3.1.10	2015 оны Хөгжлийн банкны санхүүгийн байдлын тайлан	3-15
Хүснэгт 3.1.11	2015 оны Хөгжлийн банкны бонд болон зээлдэж авсан мөнгөний задаргаа	3-16
Хүснэгт 3.1.12	2016 оны Засгийн газрын 37-р тогтоолын агуулга	3-18
Хүснэгт 3.1.13	Төсвийн хөрөнгө оруулалттай концесын төслүүд	3-19
Хүснэгт 3.1.14	2017 оны аймаг тус бүрийн төсвийн төсөл	3-20
Хүснэгт 3.1.15	Төсвийн тухай хуулинд заагдсан орон нутгийн төсвөөр хэрэгжүүлэх үйл ажиллагааны жагсаалт	3-21
Хүснэгт 3.1.16	2017 оны төсөв дэхь ОНХС-ийн төсвийн дүн.....	3-25
Хүснэгт 3.2.1	Үндэсний хөгжлийн газрын төслүүд (2016 оны 10 сарын байдлаар).....	3-27
Хүснэгт 3.4.1	Үндэсний Хөгжлийн газар болон Сангийн яамны Хөгжлийн бодлого, улсын хөрөнгө оруулалттай холбогдох хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хууль, төсвийг тухай хууль, төсвийн удирдлагын тухай хуульд заасан эрх үүрэг	3-34
Хүснэгт 4.2.1	Үндэсний хөгжлийн газрын үйл ажиллагаа	4-6
Хүснэгт 5.1.1	Хэрэгжилт, хяналт-шинжилгээ, үнэлгээний үе шатанд хамаарах хууль журам	5-4
Хүснэгт 5.1.2	Дэлхийн банкны “Улсын хөрөнгө оруулалтын менежментийн 8 үзүүлэлтийг Монголын тогтолцоонд нийцүүлэх”	5-7
Хүснэгт 5.2.1	Хөрөнгө оруулалтын арга хэрэгслийг судлах үндсэн үзүүлэлтийн жишээ.....	5-22
Хүснэгт 5.3.1	PIF-н мөчлөг дэх ҮХГ, СЯ-ны уялдаа хамтран ажиллах санал.....	5-30
Хүснэгт 5.4.1	Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн дагуу боловсруулсан.....	5-38

Зургийн жагсаалт

Зураг 2.2.1	Хөгжлийн бодлого төлөвлөлтийн уялдаа.....	2-5
Зураг 2.3.1	Тогтвортой хөгжлийн үзэл баримтлалын 4 үндсэн бодлого.....	2-8
Зураг 2.3.2	Бодлого 1. “Эдийн засгийн тогтвортой хөгжил”	2-8
Зураг 3.1.1	MTFF 2017-2019 Орлого зарлагын харьцуулалт	3-3
Зураг 3.1.2	Зарлага болон хөгжлийн төсвийн төлөв байдал, хувь	3-4
Зураг 3.1.3	Орлогын төлөв байдал.....	3-4
Зураг 3.1.4	Зарлагын төлөв байдал	3-5
Зураг 3.1.5	Урсгал болон Төсвийн тэнцлийн төлөв байдал.....	3-7
Зураг 3.1.6	Төсвийн тухай хуулиар заагдсан ОНХС-гийн төсвийн хуваарилалтын тухай.....	3-23
Зураг 3.1.7	Төсвийн тухай хуулиар заагдсан ОНХС-гийн зарцуулалтыг шийдэх процедур.....	3-24
Зураг 4.2.1	Үндэсний хөгжлийн газрын бүтэц зохион байгуулалт	4-4
Зураг 4.3.1	2017 оны улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөр боловсруулах төлөвлөгөө	4-8
Зураг 5.1.1	Дэлхийн банкны “Улсын хөрөнгө оруулалтын менежментийн 8 үзүүлэлт”	5-6
Зураг 5.2.1	Улсын хөрөнгө оруулалтын менежментийн тогтолцоог бүрдүүлэхэд тулгарах асуудал, арга хэмжээ	5-9
Зураг 5.2.2	Guidance and Screening шатны асуудал, арга хэмжээний хувилбар	5-10
Зураг 5.2.3	Formal Project Appraisal шатны асуудал,	5-15
Зураг 5.2.4	Independent Review of Appraisal шатны асуудал,	5-17
Зураг 5.2.5	Project Selection and Budgeting шатны асуудал,	5-19
Зураг 5.2.6	Хөрөнгө оруулалтын ерөнхий зураглалын ач холбогдол	5-20
Зураг 5.2.7	Implementation шатны асуудал, шийдвэрлэх арга хэмжээний хувилбар	5-23
Зураг 5.2.8	Project Adjustment шатны асуудал, шийдвэрлэх арга хэмжээний хувилбар	5-25
Зураг 5.2.9	Facility Operation шатны асуудал, шийдвэрлэх арга хэмжээний хувилбар.....	5-27
Зураг 5.2.10	Completion Review and Evaluation шатны асуудал,	5-28
Зураг 5.4.1	Хөрөнгийн орлого, зарлагын эзлэх хувь	5-34

ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР

ADB	Азийн хөгжлийн банк (Asian Development Bank)
BOT	Барьж-ашиглах-шилжүүлэх (Build-Operate-Transfer)
BT	Барьж-шилжүүлэх (Build-Transfer)
CD	Чадавхийг бэхжүүлэх (Capacity Development)
CBM	Нүүрсний давхаргын метан (Coalbed Methane)
CNY	БНХАУ-ын Юань (Chinese Yuan)
CS	Төвийн систем (Central System)
DBM	Монгол улсын Хөгжлийн Банк (Development Bank of Mongolia)
EBRD	Европын Сэргээн Босголт Хөгжлийн Банк (European Bank for Reconstruction and Development)
EFF	Өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөр (Extended Fund Facility)
ERP	Эдийн засгийг сэргээх хөтөлбөр (Economic Recovery Program)
EU	Европын холбоо (European Union)
FDI	Гадаадын шууд хөрөнгө оруулалт (Foreign Direct Investment)
FHF	Ирээдүйн өв сан (Future Heritage Fund)
FIFTA	Гадаадын хөрөнгө оруулалт, гадаад худалдааны агентлаг (Foreign Investment and Foreign Trade Agency)
FRC	Санхүүгийн Зохицуулах Хороо (Financial Regulatory Commission)
FS	Техник, эдийн засгийн үндэслэл (Feasibility Study)
GDP	Дотоодын нийт бүтээгдэхүүн (Gross Domestic Products)
GIZ	Германы олон улсын хамтын ажиллагааны нийгэмлэг (Deutsche Gesellschaft für Internationale Zusammenarbeit)
GGGI	Даян дэлхийн ногоон өсөлтийн хүрээлэн (Global Green Growth Institute)
GNI	Үндэсний нийт орлого (Gross National Income)
HDF	Хүний хөгжлийн сан (Human Development Fund)
IAAC	Авлигатай тэмцэх газар (Independent Authority Against Corruption)
ICT	Мэдээлэл, харилцаа холбооны технологийн газар (Information and Communication Technology)

IFC	Олон улсын санхүүгийн байгууллага (International Finance Corporation)
IMA	Хөрөнгө оруулалтын газар (Invest Mongolia Agency)
IMF	Олон улсын валютын сан (International Monetary Fund)
JCC	Хамтарсан зохицуулах хороо (Joint Coordinating Committee)
JICA	Японы олон улсын хамтын ажиллагааны байгууллага (Japan International Cooperation Agency)
JPY	Японы иен (Japanese Yen)
JST	ЖАЙКА-ийн судалгааны баг (JICA Study Team)
KOICA	БНСУ-ын “КОЙКА” Олон улсын хамтын ажиллагааны байгууллага (Korea International Cooperation Agency)
LDF	Орон нутгийн хөгжлийн сан (Local Development Fund)
LDPP	Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хууль (Law on Development Policy Planning)
MCUD	Барилга, хот байгуулалтын яам (Ministry of Construction and Urban Development)
MDPI	Монгол улсын хөгжлийн бодлого төлөвлөлт, улсын хөрнгө оруулалтын суурь судалгаа (Data Collection Survey on the Development Policy and Public Investment in Mongolia)
MED	Эдийн засаг хөгжлийн яам (Ministry for Economic Development)
MNT	Монголын Төгрөг (Mongol Tugrik)
MOF	Сангийн яам (Ministry of Finance)
MONDEP	Монгол улсын бүсчилсэн хөгжлийн нэгдсэн судалгаа (Data Collection Survey on the Regional Comprehensive Development in Mongolia)
MOU	Харилцан ойлголцлын санамж бичиг (Memorandum of Understanding)
MP	Ерөнхий төлөвлөгөө (Master Plan)
MTFF	Дунд хугацааны төсвийн хүрээ (Medium-term Financial Framework)
NDA	Үндэсний Хөгжлийн Газар (National Development Agency)
NDIC	Үндэсний Хөгжил Шинэтгэлийн Хороо (National Development and Innovation Committee)
NGO	Төрийн бус байгууллага (Non-Governmental Organization)
ODA	Албан ёсны хөгжлийн тусламж (Official Development Assistance)

OIE	Дэлхийн мал амьтны эрүүл мэндийн байгууллага (Office International des Epizooties, World Organization for Animal Health)
OT	Оюу-толгой (Oyu Tolgoi)
PFM	Төсвийн санхүүгийн удирдлага (Public Financial Management)
PIP	Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөр (Public Investment Program)
PPP	Төр-хувийн хэвшлийн түншлэл (Public-Private Partnership)
SDC	Швейцарийн хөгжлийн агентлаг (Swiss Agency for Development and Cooperation)
SDGs	Тогтвортой хөгжлийн зорилтууд (Sustainable Development Goals)
SDV	Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал 2030 (Sustainable Development Vision 2030)
SGX	Сингапурын Хөрөнгийн бирж (Singapore Exchange)
SME	Жижиг дунд үйлдвэрлэл (Small Medium-size Enterprise)
TA	Техникийн хамтын ажиллагаа (Technical Assistance)
TDB	Худалдаа хөгжлийн банк (Trade and Development Bank of Mongolia)
TT	Таван толгой (Tavan Tolgoi)
UB	Улаанбаатар (Ulaanbaatar)
UNDP	НҮБ-ын Хөгжлийн Хөтөлбөр (United Nations Development Programme)
USAID	АНУ-ын Олон Улсын Хөгжлийн Агентлаг (United States Agency for International Development)
USD	Америк доллар (United State Dollar)
WB	Дэлхийн банк (World Bank)
WS	Ворк шоп (Workshop)

1 Судалгааны агуулга

1.1 Судалгааны үндэслэл

Уул уурхайн хөгжилд чиглэгдсэн гадаадын шууд хөрөнгө оруулалтын өсөлтийн нөлөөгөөр Монгол улсын эдийн засгийн бодит дотоодын нийт бүтээгдэхүүний өсөлт 17.3% хүрч эдийн засаг огцом өссөн хэдий ч 2013 оноос хойших зэс, нүүрс зэрэг ашигт малтмалын ханшийн уналт болон баялгийн үндсэрхэг үзлийн нөлөөгөөр гадаадын шууд хөрөнгө оруулалт огцом буурчээ. Экспортын хамгийн том харилцагч болох БНХАУ-ын эдийн засгийн зогсонги байдлын улмаас бодит ДНБ-ийн өсөлтийн хэмжээ тасралтгүй буурсаар 2015 онд 2.3% болов. 2011 онд ДНБ-ийн 4.0% байсан төсвийн алдагдал 2015 онд 8.3% болж түүнчлэн 2011 онд ДНБ-ийн 32.7% байсан гадаад өр 2015 онд 90.7 % хүртэл өсөв.

2012 онд гадаадын шууд хөрөнгө оруулалт болон гадаад худалдаа, хөрөнгө оруулалтыг дэмжих зорилгоор Эдийн Засгийн Хөгжлийн Яам байгуулагдсан хэдий ч улсын хөгжлийн нэгдсэн бодлого байхгүй, өргөжүүлэх зарчмыг нь эргэн харсны дүнд 2014 оны 11 сард татан буулгаж, үйл ажиллагааг Сангийн яаманд шилжүүлсэн. 2015 оны 11 сард Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хууль батлагдаж, түүнд хөгжлийн бодлого боловсруулахад шаардлагатай аргачлал, хэрэгжилтийн хяналт, мониторингийн талаарх үндсэн зарчмууд тусгагдсан. Түүнчлэн, улс төрийн намуудын хамтын оролцоотой ажлын хэсэг байгуулагдан, 2030 он хүртэлх урт хугацааны “Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал 2030”-төслийг боловсруулсан нь 2016 оны 2 сард УИХ-аар батлагдсан.

Энэхүү үзэл баримтлалд тулгуурлан 2016 оны 6 сард болсон УИХ-ын сонгуулийн үр дүнд байгуулагдсан Засгийн газар нь 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр болон дунд хугацааны хөгжлийн бодлого боловсруулах төлөвлөгөөтэй. Мөн улсын төсвөөр хэрэгжүүлэх төслүүдийг стратеги төлөвлөгөөтэй хэрэгжүүлэх улсын төсвийн хөрөнгө оруулалтын хөтөлбөр (PIP) боловсруулан, улсын төсвөөр хэрэгжүүлэх төсөл, төр хувийн хэвшлийн хамтын ажиллагаагаар (PPP) хэрэгжүүлэх төсөл, Хөгжлийн банк (DBM) зэрэг Засгийн газрын холбогдох санхүүгийн байгууллагын шугамаар хэрэгжих төслүүд хэмээн төрөлжүүлж байна. Нөгөөтэйгүүр өсөн нэмэгдэх хөгжлийн төслийн хэрэгцээ шаардлагыг хэрхэн дунд хугацааны хөгжлийн бодлого, улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрт (PIP) тусгах, төслийн боловсруулалтаас хэрэгжүүлэлт хүртэл хэрхэн хяналт, үнэлгээ хийж явах зэрэг тодорхой бус зүйлүүд олон, тодорхой тогтолцоо бий болгох зэрэг шийдэх ёстой асуудал олон байна.

Монгол улсын Засгийн Газар 1) одоо байгаа 200 гаруй салбар тус бүрийн хөгжлийн бодлогыг цэгцлэх, 2) НҮБХХ-ийн тусламжтайгаар хэрэгжиж буй зарим аймаг дахь орон нутгийн хөгжлийн хөтөлбөрийг эргэн харах сайжруулах ажлыг хийж байгаа боловч, урт хугацааны хөгжлийн хөтөлбөр, хөрөнгө оруулалтын хөтөлбөртэй уялдаа

холбоо болон тодорхой бодлогын хүрээнд нийцсэн аргачлал гаргах зэрэг ажлууд нь цаашид чухал ач холбогдолтой. Гэвч Засгийн Газар, орон нутгийн засаг захиргааны хүний нөөцийн чадавхи хангалтгүй байгаа тодорхой харагдаж байгаа ба хуучин Эдийн Засгийн Хөгжлийн Яаманд асуудал болж байсан зүйлсийг сургах чадваржуулах зэрэг арга хэмжээг авах шаардлагатай.

Дээр дурдсан хөгжлийн бодлого, улсын төсвийн хөрөнгө оруулалтын хөтөлбөртэй холбогдох Монгол улсын Засгийн Газрын чиг хандлага, тулгарч буй асуудлын талаар Монгол улсын Засгийн газар болон Японы олон улсын хамтын ажиллагааны байгууллага (ЖАЙКА) нь тус салбарт техникийн хамтын ажиллагааны төсөл хэрэгжүүлэх хэрэгцээний талаар хэлэлцсэн. ЖАЙКА-д Монгол улсын Засгийн Газрын хөгжлийн бодлого, улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөр, холбогдох салбарын мэдээлэл, хууль эрх зүйн орчин, тогтолцоо, бүтэц тус бүрийг ажил үүргийн хуваарилалт, хүний нөөцийн чадавхийг сайжруулах дэмжлэгийн хэрэгцээ болон бусад хандивлагч байгууллагуудын дэмжлэг зэрэг холбогдох мэдээллийг цуглуулан, дүн шинжилгээ хийн цаашдын Япон улсын хамтын ажиллагааны чиглэл, шинэ төслүүдийг шийдвэрлэх зорилгоор энэхүү судалгааг хэрэгжүүлж байна.

1.2 Судалгааны зорилго, үр дүн

(1) Судалгааны зорилго

Энэхүү судалгаагаар Монгол улсын хөгжлийн бодлого, улсын болон төсвийн хөрөнгө оруулалтын хөтөлбөрийн өнөөгийн байдлын талаар холбогдох газруудтай уулзалт ярилцлага хийх замаар мэдээлэл цуглуулж, дүн шинжилгээ хийнэ. Улмаар ЖАЙКА-ийн зүгээс Монгол улсад үзүүлэх хамтын ажиллагааны нэг болох “Засаглалыг бэхжүүлэх хөтөлбөр” дэхь улсын төсвийн менежментийн салбарын хөгжлийн бодлого, улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөр зэрэг хамтын ажиллагааны чиг хандлагын талаар, илүү системтэйгээр стратегийн дэмжлэг үзүүлэхэд хэрэгцээтэй санал дэвшүүлэх зорилготой суурь судалгаа юм.

(2) Судалгааны хамрах хүрээ

Монгол улсын нийт нутаг дэвсгэр (Судалгааны төв Улаанбаатар хот)

(3) Хүлээгдэж буй үр дүн

Тус судалгаанаас доорх 4 үр дүн хүлээгдэж байна.

- (i) “Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал 2030”-д үндэслэсэн дунд хугацааны хөгжлийн бодлого төлөвлөлт, улсын төсвийн хөрөнгө оруулалтын хөтөлбөр, бүсийн хөгжлийн бодлого, салбарын хөгжлийн бодлого, аймгийн хөгжлийн хөтөлбөр болон холбогдох хууль эрх зүй, дүрэм журам, бүтэц, зохион байгуулалт, төсөв, Засгийн Газрын чиг хандлага, арга хэмжээ, тэдгээртэй уялдах дунд хугацааны төсвийн хүрээ (Medium Term Fiscal Framework: MTFF), түүнчлэн хөгжлийн бодлого болон улсын төсөвтэй холбогдох бусад хандивлагчдын тусламж дэмжлэгийн чиг баримжаа болон өнөөгийн асуудлуудыг тодорхойлох.
- (ii) Улсын хөрөнгө оруулалтын төсөл, төр хувийн хэвшлийн түншлэлийн төсөл, хөгжлийн төсөл хэрэгжүүлэх мөчлөгийн бүхий л үе шатны (боловсруулах, батлах, төсөв хуваарилах, төслийн мониторинг, худалдан авалт, менежмент зэрэг) УИХ, Засгийн Газрын холбогдох байгууллагуудын үүрэг, хариуцлага, чадавхид анализ дүгнэлт хийж, үр дүнтэй хөгжлийн төслийн менежмент, хяналтын тогтолцоог бий болгоход тулгарч буй асуудлыг тодорхойлох.
- (iii) Сангийн Яам, Үндэсний Хөгжлийн Газар¹ болон холбогдох яам агентлаг, орон нутгийн захиргааны байгууллага түүнчлэн “Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал 2030” боловсруулах оролцсон УИХ-ын тамгын газрын холбогдох хүмүүстэй хамтран сургалт, семинар зохион байгуулж, цаашид шийдвэрлэх асуудлын талаар нэгдсэн ойлголттой болох юм.
- (iv) Хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хөтөлбөрийн чадавхийг бэхжүүлэх, ЖАЙКА-ийн хамтын ажиллагааны үндсэн чиглэлд тавигдах шаардлагын талаар санал дэвшүүлэх.

¹ Монгол улсын зүгээс хүсэлт тавьсан үед улсын хэмжээний төсөл, арга хэмжээний хөрөнгө оруулалтын хөтөлбөр боловсруулах ажлыг Сангийн яам хариуцаж байсан хэдий ч, Шинэ Засгийн Газар бүтцээр Үндэсний хөгжлийн газар байгуулагдсан. Үүнтэй зэрэгцэн “Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хууль”-д нэмэлт өөрчлөлт хийгдэж Улсын хэмжээний хөгжлийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний үйл ажиллагаа, түүнчлэн Төсвийн тухай хуульд 30 тэрбум төгрөгөөс (ойролцоогоор 1,37 тэрбум) дээш төсөл, арга хэмжээний хөрөнгө оруулалтын хөтөлбөрийг тус газарт хариуцан хэрэгжүүлчээр заасан.

1.3 Судалгааны хэрэгжүүлэх тогтолцоо, холбогдох байгууллага

(1) Судалгааны явц, шат дараалал

Судалгааны төлөвлөгөөнд тусгагдсан агуулгын дагуу дараах үйл ажиллагааг хэрэгжүүлсэн.

Япон дахь судалгаа 1 (2016 оны 10 сар): Холбогдох баримт мэдээллийг цэгцлэх, энэхүү судалгааны асуудалтай холбогдох үндсэн ойлголтыг нягтлах (Монголын Засгийн газрын холбогдох байгууллагаас цуглуулсан мэдээлэл хамрагдана) ажлыг хийж эхлэлийн тайлан боловсруулсан.

Монгол дахь судалгаа 1 (2016 оны 11сарын эхэн - 12 сарын эхэн): Монгол улсын Засгийн Газар болон холбогдох байгууллагуудад эхлэлийн тайлан танилцуулж, санал солилцох эхний семинарыг судалгааны багаас зохион байгуулсан. Энэхүү семинараар судалгааны зорилго, техникийн туслалцааны талаар тайлбар хийж, ирээдүйд тулгарч болох асуудлыг талаар нэгдсэн ойлголттой болсон. Мөн хөгжлийн бодлого зохицуулалт, хөрөнгө оруулалтын хөтөлбөр боловсруулах үүрэг бүхий байгууллага болох Үндэсний хөгжлийн газрын дарга, ажилтнуудтай зөвлөлдөж Үндэсний хөгжлийн газрын үйл ажиллагаа, хууль эрх зүйн орчин, хүний нөөцийн чадавхын талаар авч хэлэлцсэн.

Түүнчлэн хөрөнгө оруулалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэх хэрэгжилтийн үеийн тогтолцоо, асуудлын талаар Сангийн яам, Үндэсний хөгжлийн газар болон бусад холбогдох байгууллагын үйл ажиллагаа, ажил үүргийн хуваарилалт, зохицуулалт зэрэг асуудлын талаар Төрийн байгуулалтын байнгын хорооны даргатай санал солилцож Монгол улсад нэн тохиромжтой хөрөнгө оруулалтын хөтөлбөрийг нэвтрүүлэх боломж бүтэц зохион байгуулалт, хүний нөөцийн тал дээр учир дутагдалтай байгааг тодорхойлсон.

“Тогтвортой хөгжлийн зорилт”-д тусгагдсан хөгжлийн бодлогын хэрэгжилт, төсвийн бодлого төлөвлөлтийн чадавхийг бэхжүүлэх чиглэлээр илүү анхаарал хандуулан дэмжлэг үзүүлж буй хандивлагч байгууллагуудаас холбогдох мэдээллийг асууж тодруулан цаашид үзүүлэх дэмжлэгийн чиглэл болон асуудлын талаар мэдээлэл цуглуулан судалгааг хэрэгжүүлсэн.

Япон дахь судалгаа-2 (2016 оны 12 сар): Монгол дахь судалгааны явцад цуглуулсан мэдээллийг цэгцлэн Монгол улсын Засгийн газар, холбогдох байгууллагуудын хүсэлтийг голчилж, Япон улсаас ямар хамтын ажиллагаа хэрэгцээтэй байгаа болон тэрхүү аргачлалтай холбогдох “Таамаглал дэвшүүлж” хэлэлцсэн.

Монгол дахь судалгаа 2 (2017 оны 1 сарын дундаас 2 сарын эхэн): Энэхүү судалгаа нь өмнөх судалгаанаас гарсан таамаглалын саналыг ахин тодруулах зорилготой судалгаа байсан ба 3 чиглэлд хэрэгжүүлсэн.

Нэгдүгээрт, Үндэсний хөгжлийн газар нь 2017 оны 5 сарын 15-ны өдөр хуульд заасан үүргийн дагуу Засгийн газарт улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрийг боловсруулан өргөн барих ажилтай холбогдуулан бүх салбарын яам, агентлагаас тэргүүлэх ач холбогдолтой 10 төсөл арга хэмжээний саналыг авч тэдгээрийг үнэлэн хэлэлцэх зөвлөлдөх уулзалтыг 2017 оны 1 сарын 27, 28-ны өдрүүдэд зохион байгуулсан. Тус уулзалт нь Үндэсний хөгжлийн газрын үйл ажиллагааны нэг хэсэг болох “Салбар хоорондын уялдааг хангах” нэн чухал ажлыг гүйцэтгэсэн гэж үзэж байгаа бөгөөд ЖАЙКА-ийн судалгааны баг нь энэхүү бодит үйл ажиллагааны үйл явцыг ажиглахын зэрэгцээ шаардлагатай зөвлөгөөг өгөх хэрэгтэй гэж үзэн 2 өдөр зохион байгуулагдсан зөвлөгөөнийг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлсэн.

Хоёрдугаарт, хуульд тусгагдсаны дагуу улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрийг боловсруулах ажлын хэрэгжилтийн бүх үе шатанд өнөөгийн Монгол улсын нөхцөл байдалд тулгарч буй асуудал, тэдгээрийг шийдвэрлэхэд чиглэсэн шаардлагатай бодлогын талаар ЖАЙКА-ийн судалгааны баг судалгааны явцад олж авсан мэдээлэл асуудлын талаар Үндэсний хөгжлийн газар болон Сангийн яамны холбогдох хүмүүст зориулсан сургалт, семинарыг зохион байгуулсан. Энэхүү сургалтаар тэр дундаа Үндэсний хөгжлийн газар, Сангийн яам хоорондын бодит үйл ажиллагаан дээр зохицуулалт хийх асуудлын талаар илүү нухацтай авч үзсэн. Сургалтын төгсгөлд дээр дурдагдсан асуудалд суурилан ЖАЙКА-аас үзүүлэх дэмжлэгийн голлох агуулгын саналыг тавьж оролцогчдын саналыг авсан.

Гуравдугаарт, голлох хандивлагч байгууллагуудад хоёрдахь удаагийн мэдээлэл цуглуулах судалгааг явуулсан. Энэхүү судалгаа нь хандивлагч байгууллагуудын хэрэгжүүлж буй төсөл хөтөлбөрүүдийн нарийвчилсан мэдээллийг авахын зэрэгцээ ЖАЙКА-ийн төлөвлөж буй хамтын ажиллагааны төсөлтэй уялдуулан зохицуулах шаардлагыг тодорхойлох зорилготой юм. Монгол улсад хийсэн судалгааны үеэр ЖАЙКА-ийн Монгол дахь төлөөлөгчийн газраас судалгааны бүхий л үйл ажиллагаанд идэвхитэй оролцож тухай бүрд нь маш чухал зөвлөмжийг өгч дэмжлэг үзүүлсэн.

(2) Судалгаанд санал солилцсон холбогдох байгууллагууд

Монгол дахь судалгааны явцад доорх Засгийн Газрын холбогдох байгууллагуудтай уулзаж зөвлөлдөх ,сонсгол хийх зэргээр санал солилцсон болно.

Монгол улсын Засгийн газрын холбогдох байгууллагууд :

- УИХ-ын Төрийн байгуулалтын байнгын хорооны дарга
- Ерөнхий сайдын ажлын алба, Ерөнхий сайдын ахлах зөвлөх, хөгжлийн бодлого хариуцсан зөвлөх
- Сангийн яам (Эдийн засгийн бодлогын газар, Төсвийн бодлого, төлөвлөлтийн газар, Төсвийн хөрөнгө оруулалтын газар, Хөгжлийн санхүүжилтийн газар)
- Үндэсний хөгжлийн газар (ҮХГ-ын дарга, дэд дарга, Хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтэс, Салбарын хөгжлийн бодлого зохицуулалтын хэлтэс,

Хөрөнгө оруулалтын нэгдсэн бодлогын хэлтэс)

Барилга, хот байгуулалтын яам, Зам тээврийн хөгжлийн яам, Эрчим хүчний яам, Уул уурхай хүнд үйлдвэрийн яам, Хүнс хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэрийн яам, Байгаль орчин, аялал жуулчлалын яам, Хууль зүй дотоод хэргийн яам, Гадаад хэргийн яам, Боловсрол соёл шинжлэх ухаан спортын яам, Батлан хамгаалах яам, Харилцаа холбоо мэдээллийн технологийн газар зэрэг холбогдох байгууллагын бодлого төлөвлөлтийн газрын ажилтнууд.

Сангийн Яаманд дэмжлэг үзүүлж буй хандивлагч байгууллага :

- Азийн хөгжлийн банк (АХБ), Европын холбоо (ЕХ), ХБНГУ-ын олон улсын хамтын ажиллагааны нийгэмлэг (GIZ), Дэлхийн банк (ДБ), БНСУ-ын Олон улсын хамтын ажиллагааны байгууллага (КОЙКА)

Үндэсний хөгжлийн газартай цаашид хамтрах ажиллахаар төлөвлөж буй хандивлагч байгууллага :

- Нэгдсэн үндэсний байгууллагын Хөгжлийн Хөтөлбөр (НҮБХХ), ХБНГУ-ын олон улсын хамтын ажиллагааны нийгэмлэг (GIZ), Олон улсын санхүүгийн корпораци (IFC)

Эрдэмтэн судлаач :

- “ Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал 2030”- боловсруулсан ажлын хэсгийн голлох гишүүд

2 Монгол улсын хөгжлийн бодлого төлөвлөлтийн тогтолцоо

2.1 Шинэ Засгийн газрын бүтэц

2016 оны 6 сард болсон УИХ-ын сонгуулийн дүнд байгуулагдсан шинэ Засгийн газрын бүтэц, бүрэлдэхүүн шинэчлэгдэн зохион байгуулагдсан. Шинээр байгуулагдсан Засгийн газрын бүтцийг хүснэгт 2.1.1-т харууллаа. Шинэ засгийн газрын томоохон өөрчлөлтийн хувьд, хуучин Аж үйлдвэрийн яамыг татан буулгаж, хуучин Аж үйлдвэрийн яамны Стратеги төлөвлөлтийн газар нь шинээр байгуулагдсан Үндэсний хөгжлийн газар, Хөнгөн аж үйлдвэрийн бодлого зохицуулалтын газар нь Хүнс, Хөдөө аж ахуй, Хөнгөн үйлдвэрийн яаманд, түүнчлэн Хүнд аж үйлдвэрийн бодлого, зохицуулалтын газар нь Уул уурхай, Хүнд үйлдвэрийн яаманд тус тус нэгдсэн байна. Засгийн газрын бүтцийн шинэчлэлээр улсын хөгжлийн бодлого төлөвлөлтийн тогтолцоонд томоохон өөрчлөлт гарч эхэлж байна. Бүтцийн шинэчлэлээр ерөнхий сайдын эрхлэх асуудлын хүрээнд улсын хөгжлийн бодлого төлөвлөлтийн тохируулагч агентлаг болох “Үндэсний хөгжлийн газар”-ыг шинээр байгуулан, урт хугацааны тогтвортой хөгжлийн үзэл баримтлалыг хэрэгжүүлэхэд чиглэсэн төрийн захиргааны тогтолцоо бүрэлдэж байна.

Хүснэгт 2.1.1 Монгол улсын Засгийн газрын бүтэц

Яам	Засгийн газрын тохируулагч агентлаг	Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг	
	Ерөнхий сайд	Тагнуулын ерөнхий газар Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газар Үндэсний хөгжлийн газар	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
	Шадар сайд	Мэргэжлийн хяналтын ерөнхий газар Онцгой байдлын газар Шударга өрсөлдөөн хэрэглэгчийн төлөө газар Стандарчлал хэмжилзүйн газар	
Засгийн газрын хэрэг эрхлэх газар	Засгийн газрын хэрэг эрхлэх газрын дарга		
Байгаль орчин, аялал жуулчлалын яам	Байгаль орчин, аялал жуулчлалын сайд		Цаг уур орчны шинжилгээний газар
Гадаад харилцааны яам	Гадаад харилцааны сайд		
Сангийн яам	Сангийн сайд		Гаалийн ерөнхий газар

			Татварын ерөнхий газар
Хууль зүй, дотоод хэргийн яам	Хууль зүй, дотоод хэргийн сайд	Цагдаагийн ерөнхий газар Хил хамгаалах ерөнхий газар	Улсын бүртгэл, оюуны өмчийн ерөнхий газар Архивын ерөнхий газар Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар Гадаадын иргэн харьяатын газар
Барилга, хот байгуулалтын яам	Барилга, хот байгуулалтын сайд		Газар зохион байгуулалт, геодези зураг зүйн газар
Батлан хамгаалах яам	Батлан хамгаалах сайд	Зэвсэгт хүчний жанжин штаб	
Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яам	Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайд		Биеийн тамир, спортын газар Соёл, урлагийн газар
Зам тээврийн хөгжлийн яам	Зам тээврийн хөгжлийн сайд		Иргэний нисэхийн ерөнхий газар
Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам	Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд		Ашигт малтмал газрын тосны газар
Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд		Мал эмнэлэг үржлийн газар
Хөдөлмөр нийгмийн хамгааллын яам	Хөдөлмөр нийгмийн хамгааллын		Эрүүл мэнд, нийгмийн даатгалын ерөнхий газар Хөдөлмөр, халамж үйлчилгээний ерөнхий газар Хүүхэд залуучуудын хөгжлийн газар
Эрчим хүчний яам	Эрчим хүчний сайд		
Эрүүл мэндийн яам	Эрүүл мэндийн сайд		
Засгийн газрын хэрэг эрхлэх газар +13 яам	16 сайд	29 агентлаг	

Эх сурвалж : ЖАЙКА-ийн судалгааны баг

2.2 Хөгжлийн бодлого төлөвлөлтийн хуульд тулгуурласан хөгжлийн бодлого тогтолцоо

Хөгжлийн бодлого тогтолцооны хувьд “Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хууль” 2015 оны 11 сарын 26-нд батлагдсан. Өнөөг хүртэл улсын хөгжлийн бодлого төлөвлөлт нь бүх хэмжээнд (үндэсний, орон нутаг, салбарын хэмжээний) хэрэгжилтийн хугацаа нь харилцан адилгүй олон тооны бодлого, стратеги, хөтөлбөр, төлөвлөгөө байдаг ч хэрэгжилтийн хууль эрх зүйн орчин бүрдээгүй, бодлого хоорондын зохицуулалт болон төлөвлөлт боловсруулах нэгдсэн тогтолцоо, арга зүй дутмаг, түүнчлэн хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэрэгжүүлэх хөрөнгийн эх үүсвэр тодорхой тусгагдаагүй байсан. Дээрх хүчин зүйлүүдээс үндэслэн хөгжлийн бодлого төлөвлөлт, хэрэгжилт, хяналт-шинжилгээ, үнэлгээний талаарх ерөнхий зарчим, журмыг томъёолон, хөгжлийн бодлого төлөвлөлт хариуцсан төрийн захиргааны байгууллагын эрх үүрэг, хариуцлагыг тодорхойлон, хөгжлийн бодлого төлөвлөлтийн нэгдсэн тогтолцоог бүрдүүлэх зорилт бүхий хуулийг боловсруулан баталсан.

Энэхүү хуулинд хөгжлийн бодлого төлөвлөлтийн бичиг баримтыг хэрэгжүүлэх хугацаа, үйлчлэх хүрээгээр (үндэсний, орон нутгийн, салбарын зэрэг) төрөлжүүлэн, хэрэгжүүлэх байгууллага, хяналт-шинжилгээний тогтолцоо, баталгаажуулах байгууллагыг тодорхой тусгасан байна (Хүснэгт 2.2.1).

Хүснэгт 2.2.1 Хөгжлийн бодлого төлөвлөлтийн хуульд тусгагдсан бодлогын бичиг баримт

	Бодлогын бичиг баримт	Хугацаа (жил)	Хэрэгжүүлэгч байгууллага	Батлах	Хяналт, үнэлгээ
Урт	Улсын хөгжлийн үзэл баримтлал	15-20	Засгийн газар	УИХ	Сангийн яам 4 жил тутамд
	Төрөөс баримтлах бодлого	8-10	Сангийн яам Төрийн захиргааны төв байгууллага	ЗГ	Сангийн яам 2 жил тутамд Засгийн газар 4 жил тутамд
	Бүсчилсэн хөгжлийн бодлого		Үндэсний Хөгжлийн Газар	ЗГ	ҮХГ, НЗБ 2 жил тутамд Засгийн газар 4 жил тутамд
	Аймаг, нийслэлийг хөгжүүлэх хэтийн зорилт		Засаг дарга	ИТХ	НЗБ 2 жил тутамд ИТХ, ЗГХЭГ 4 жил тутамд
Дунд	Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр	3-5	Засгийн газрын хэрэг эрхлэх газар	УИХ	ЗГХ 2 жил тутамд
	Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр		Засаг дарга	ИТХ	ИТХ 2 жил тутамд
	Үндэсний хөтөлбөр болон дэд хөтөлбөр		Төрийн захиргааны төв байгууллага	ЗГ	жил бүр Засгийн газар
	Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөр		Үндэсний хөгжлийн газар	ЗГ	2 жил тутамд ҮХГ
Богино	Улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл	1	Сангийн яам	УИХ	жил бүр УИХ
	Аймаг, нийслэл, сум, дүүргийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл		Нутгийн захиргааны байгууллага	ИТХ	жил бүр ЗГХ
	Улсын болон орон нутгийн төсөв		Сангийн яам	УИХ	жил бүр

Эх сурвалж : Монгол Улсын хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хууль



Эх сурвалж: Үндэсний Хөгжлийн Газар

Зураг 2.2.1 Хөгжлийн бодлого төлөвлөлтийн уялдаа

2.3 Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал 2030

2016 оны 2 сард УИХ-аар батлагдсан “Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал 2030” нь шинэ Засгийн газрын хүрээнд ч хөгжлийн үндсэн шалгуур болох улсын хөгжлийн гол чиг хандлага юм. Үүнд 2030 он хүртэл зорилтуудыг тодорхойлон, хэрэгжүүлэх тодорхой 20 үндсэн үзүүлэлтийг тусгасан байна.

2030 оны зорилтууд

1. Дунд орлоготой орнуудыг тэргүүлэгч улс орнуудын эгнээнд орно. 2016-2030 оны ДНБ-ий жилийн дундаж өсөлт 6.6%, нэг хүнд ногдох үндэсний нийт орлого 17,500 ам.долларт хүрнэ.
2. Орлогын тэгш бус байдлыг багасгаж, орлогын тэгш бус байдлын үзүүлэлтийг 30 хүргэн бууруулж, нийт хүн амын 80% нь чинээлэг дундаж давхаргын ангилалд багтсан байна.
3. Ядуурлын бүх төрлийг эцэс болгоно.
4. Эрүүл, урт удаан амьдрах нөхцөлийг хангаж, дундаж наслалтыг 78 хүргэнэ.
5. Хүний хөгжлийн өндөр үзүүлэлт бүхий улс орнуудын эгнээнд багтаж, эхний 70 орны нэг болно.
6. 2017-2024 онуудад төсвийг алдагдалгүй болгож, хуримтлал үүсгэх замаар Засгийн газрын өрийг барагдуулж, эдийн засгийн тогтвортой өсөлтийн нөхцөлийг хангана.
7. Ногоон хөгжлийн зорилтыг хэрэгжүүлж, ногоон эдийн засгийн үзүүлэлтээр дэлхийн эхний 30 орны нэг болно.
8. Ойжуулалтыг нэмэгдүүлж, цөлжилтийг бууруулж, усны нөөцийг үр ашигтай ашиглах зорилтыг хэрэгжүүлж, байгаль орчны багц үзүүлэлтээр дэлхийн эхний 90 орны нэг болно.
9. Төрийн алба нь цэвэр тунгалаг, хариуцлагатай, ардчилсан иргэний нийгмийн засаглалыг төлөвшүүлж, засаглалын хүрээнд хөгжлийн бодлогоо хэрэгжүүлэх чадварыг дээшлүүлж, авлигыг устгана.
10. Бизнесийн орчинг сайжруулж, бизнес эрхлэлтийн үзүүлэлтээр дэлхийд эхний 40 орны нэг болно.

Хүснэгт 2.3.1 2030 оны зорилтууд

	Үзүүлэлт	Суурь түвшин (2014)	Зорилтот түвшин (2030)
1	Жилийн дундаж өсөлт	7.8%	6.6% (2016-2030 дундаж)
2	Нэг хүнд ногдох үндэсний нийт орлого	4,166 ам.доллар	17,500 ам.доллар
3	Хүний хөгжлийн үзүүлэлт	103-р байр	70-р байр
4	Дундаж наслалт	69.8	78
5	Ядуурлын түвшин	21.6%	0%
6	Өрсөлдөх чадварын үзүүлэлт	104-р байр	70-р байр
7	Бизнес эрхлэлтийн үзүүлэлт	56-р байр	40-р байр
8	Байгаль орчны багц үзүүлэлт	111-р байр	90-р байр
9	Нийгмийн даатгалд хамрагдсан хүн амын эзлэх хувь	84.4%	99%
10	Жини коэффициент	36.5	30
11	1000 амьд төрөлт дэх нялхсын эндэгдлийн түвшин	15.1	8
12	100,000 амьд төрөлт дэх эхийн эндэгдлийн түвшин	30.6	20
13	ЕБС-ийн анги дүүргэлт, улсын дундаж	27.3 хүүхэд	20 хүүхэд
14	Олон улсын худалдааны хорио цээрт нээлттэй болсон газар нутгийн эзлэх хувь	0%	60%
15	Цөлжилтөд өртсөн газар нутгийн эзлэх хувь	78.2%	60%
16	Экспортод боловсруулах үйлдвэрлэлийн эзлэх хувь	17%	30%
17	МУ-д аялах гадаадын жуулчдын тоо	39.2 сая хүн	200 сая хүн
18	Цахилгаан эрчим хүчээр хангагдсан хүн ам	84%	100%
19	Экспортод боловсруулах үйлдвэрлэлийн эзлэх хувь	17%	50%
20	Гол нэр төрлийн шатахууны хэрэгцээг дотоодын эх үүсвэрээс хангах хувь	0%	100%

Эх сурвалж : Монгол улсын урт хугацааны тогтвортой хөгжлийн үзэл баримтлал 2016-2030

Мөн дараах зурагт харуулсанчлан 4 үндсэн бодлогын хүрээнд бодит зорилтуудыг дэвшүүлж, 5, 5 жилээр 3 үе шатад хуваан жишгийг тогтоосон байна. Эдгээр зорилтуудыг дунд урт хугацааны хөгжлийн бодлого, Засгийн газрын үйл ажиллагааны төлөвлөгөө, улсын эдийн засаг, нийгмийн хөгжлийн жилийн төлөвлөгөө болон улсын төсөвтэй уялдуулан хэрэгжүүлнэ.

1. Эдийн засгийн тогтвортой хөгжил	2. Нийгмийн тогтвортой хөгжил	3. Байгаль орчны тогтвортой байдал	4. Засаглал
<ul style="list-style-type: none"> ХАА Аялал жуулчлал Аж үйлдвэр Уул уурхай Эрчим хүч, дэд бүтэц Макро ЭЗ-ийн бодлого Бизнесийн орчинг сайжруулах 	<ul style="list-style-type: none"> Хүртээмжтэй өсөлтийн үндсэн дээр нийгмийн тэгш байдлыг хангах Эрүүл мэндийн чанартай, хүртээмжтэй шуурхай тогтолцоо Мэдлэгт суурилсан нийгмийг хөгжүүлэх, ур чадвар бүхий иргэдийг хөгжүүлэх 	<ul style="list-style-type: none"> Усны нөөцийн нэгдсэн менежмент Уур амьсгалын өөрчлөлтөнд дасан зохицох Экосистемийн тэнцвэртэй байдал 	<ul style="list-style-type: none"> Засгийн газрын бодлого боловсруулах, хэрэгжилт, хяналтыг сайжруулах Төрийн байгууллын удирдлагыг сайжруулан, засаглалын ил тод шударга, хариуцлагатай ажиллагааг хангах Улс төрчид болон төрийн албан хаагчидын ёс суртахууныг сайжруулж, авилгалыг арилгах

Эх сурвалж: “Монгол улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал”-аас ЖАЙКА-ийн судалгааны баг боловсруулав.

Зураг 2.3.1 Тогтвортой хөгжлийн үзэл баримтлалын 4 үндсэн бодлого

Дээр дурдсан Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тухай хуулинд урт хугацааны хөгжлийн бодлого болох “Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал- 2030” болон богино дунд хугацааны бодлого төлөвлөлт боловсруулах тухай тусгагдсан. Тус хуульд урт хугацааны тогтвортой хөгжлийн үзэл баримтлал нь Монгол улсын хөгжлийн үндэс болоод зогсохгүй УИХ, орон нутгийн сонгуульд нэр дэвшиж буй нэр улс төрийн нам болон дэвшигч нь сонгуулийн мөрийн хөтөлбөртөө хөгжлийн үзэл баримтлалд нийцүүлэн боловсруулах үүрэгтэй хэмээн тусгаж өгсөн.



Эх сурвалж : Монгол улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал 2030-г үндэслэн ЖАЙКА-ийн судалгааны баг боловсруулав.

Зураг 2.3.2 Бодлого 1. “Эдийн засгийн тогтвортой хөгжил”

Ялангуяа 1-р бодлого болох “Эдийн засгийн тогтвортой хөгжил”-ийн хүрээнд ХАА, аялал жуулчлал, аж үйлдвэр, уул уурхай, эрчим хүч, дэд бүтцийн голлох салбаруудаас гадна макро эдийн засгийн бодлого, стратегийг авч үзсэн ба эдгээрийг Зураг 2.3.3 үзүүлэв. Энэхүү стратеги нь ХАА-н салбарын чадавхийг бэхжүүлэх, боловсруулах үйлдвэрлэлд шилжих, уул уурхайн экспортыг дэмжих зэрэг аж үйлдвэрийг төрөлжүүлэх, экспортын олон улс дахь өрсөлдөх чадварыг дээшлүүлэх, хөрөнгө оруулалтыг дэмжих замаар эдийн засгийн өсөлтийг хангаж, олон улсад өрсөлдөх чадварыг сайжруулах үүднээс цахилгаан эрчим хүчний хэрэгцээгээ дотоодын эх үүсвэрээр хангадаг болох, зам тээврийн сүлжээг өргөжүүлэх, аялал жуулчлалын хөгжлийг дэмжихүйц дэд бүтцийг бүрдүүлж, олон улсын тавцанд Монголын аялал жуулчлалын имижийг бүрдүүлэх зэрэг зорилтыг дэвшүүлсэн байна.

Мөн макро эдийн засгийн бодлогын хүрээнд дунд хугацааны өрийн стратегийг хэрэгжүүлж, үйлчилгээний зардлыг бууруулж, өрийн дээд хязгаарыг хатуу мөрдөх зэрэг өрийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэхийн зэрэгцээ улсын төсвийн хяналтыг (орлого зарлагын төлөвлөгөө, зарцуулалт) оновчтой хэрэгжүүлнэ гэжээ.

Макро эдийн засгийн үндсэн зарчмууд

- Тогтвортой эдийн засгийн дундаж өсөлт 6.6% -с дээш
- Төсвийн алдагдлыг бууруулах
- Төсвийн тэнцвэртэй байдлыг хангах
- Өрийн хязгаарыг тогтоох
- Олон улсын зах зээл, үнийн хэлбэлзлийн эрсдлээс сэргийлэх
- Гадаад валютын нөөцийг хадгалах
- Гадаад худалдааны тэнцлийг ашигтай болгон, гадаад валютын тогтвортой байдал
- Банк санхүүгийн салбарын тогтвортой байдал, найдвартай, хариуцлагатай байдлыг хангах, зээлийн хүүгийн бодлого
- Олон улсын эдийн засгийн хамтын ажиллагааны байгууллагуудтай хамтран ажиллах
- Төр, хувийн хэвшлийн уялдаа хобоог сайруулах, олон улсын хамтын ажиллагааны сан болон урт хугацааны хөнгөлөлттэй санхүүжилтыг авах, олон улсын санхүүгийн байгууллагатай хамтран ажиллах

Салбарын хөгжлийн үндсэн зарчмууд

- Бүтээмж өндөртэй үйлдвэрлэлийг бий болгох шинэ технологийг нэвтрүүлэх, инновацийг ашиглан шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээ үйлдвэрлэлийг дэмжих
- Нөөцийн үр ашигтай үйлдвэрлэлийг дэмжих
- Эдийн засаг, нийгмийн бүх салбарт үр ашигтай, үр дүнтэй аргыг дагаж мөрдөх

Эх сурвалж: “Монгол улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал”-аас ЖАЙКА-ийн судалгааны баг боловсруулав.

Зураг 2.3.3 Макро эдийн засгийн салбарын хөгжлийн үндсэн зарчим

2.4 Улсын хөрөнгө оруулалтын бодлогын үндсэн суурь

Макро эдийн засгийн таамаглалыг дэвшүүлэх ажилтай уялдуулан, Монгол улсын засаглалын салбар дахь төсвийн алдагдлыг бууруулах ажил шинэ Засгийн газрын шийдвэрлэх ёстой гол асуудал болоод байна. Засгийн газраас “Эдийн засгийг сэргээх хөтөлбөр” (ERP) боловсруулсан бөгөөд 2017 онд эргэн төлөгдөх өрийн санхүүгийн эх үүсвэрийг хэрхэн шийдвэрлэх асуудал чухал асуудал хэдий ч энэхүү хөтөлбөр нь улсын хөрөнгө оруулалтын төсвийн боломжийг тусгасан байна.

Үүнтэй уялдуулан ОУВС болон бусад олон улсын байгууллагуудын дэмжлэгийг хэрхэн хүлээн авах, түүний дараагийн төсвийн бодлогод томоохон нөлөө үзүүлэх чухал шийдвэр хүлээгдэж байгаа бөгөөд эдгээрийг харгалзсан дунд хугацааны улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөр (PIP) боловсруулах шаардлагатай. Шинэ Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр нь бодит хэрэгжилтийн төсөв, санхүүгийн асуудлыг шийдвэрлэхгүй бол улс төрийн чиг хандлагатай “хүслийн жагсаалт (Wish-List)” төдий болох тул, үйл ажиллагааны хөтөлбөртэй уялдсан улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрийг хэлэлцэж шийдвэрлэх хэрэгтэй. Түүний тулд үйл ажиллагааны хөтөлбөрийн нарийн агуулга, тэргүүлэх дарааллыг тойрсон улс төрийн болон салбар хоорондын зохицуулалт шаардлагатай.

Хууль эрх зүйн заалтын дагуу “Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөр” (PIP) боловсруулах ажил Сангийн яамнаас Үндэсний хөгжлийн газар луу шилжсэн. Хуулийн нэмэлт өөрчлөлтөөр Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөр (PIP) тусгагдах хөгжлийн төслийн үр ашиг, өгөөжийн үнэлгээг Үндэсний хөгжлийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн буюу Үндэсний хөгжлийн газар хийнэ (Төсвийн тухай хууль 28.6), төслийн үр дүнг тооцох аргачлалыг санхүү төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн буюу Сангийн яам батална (Төсвийн тухай хууль 28.11) хэмээн тус тус заагдсан байна. Нөгөө талаас, хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулинд улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрийн хяналт шинжилгээ, үнэлгээг 2 жил тутамд хийхээр заагдсан байна. Иймэрхүү байдлаар улсын хөрөнгө оруулалтын бодлогын суурь орчин бүрэлдэж ирж буй хэдий ч улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөр (PIP) боловсруулах шатны төслийн тэргүүлэх ач холбогдол, эрэмбэ дарааллыг тогтоох ерөнхий стандарт, санхүүгийн эх үүсвэр, процедур, төслийн үнэлгээний шалгуур зэрэг асуудлууд тодорхой бус тусгагдаагүй.

Хөгжлийн төлөвлөгөө болон санхүүгийн тэнцвэр чухал асуудал бөгөөд Үндэсний хөгжлийн газрын салбар хоорондын зохицуулалт, Сангийн яам хоорондын ажил үүргийн хуваарилалт, зөвшилцөл, хамтын ажиллагаа чухал ач холбогдолтой.

2.5 Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр

2016 оны 10-р сард шинэ Засгийн газар энэхүү тогтвортой хөгжлийн үзэл баримтгал болон мөрийн хөтөлбөрт тулгуурлан бүхий л яам тамгын газар (Улаанбаатар хотын захиргааг хамруулна) нь одоогийн Засгийн газрын томилогдох хугацаанд хэрэгжүүлэх голлох бодлого, төслийг сонгон шалгаруулан тэдгээрийг “Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр”- т эмхэтгэн оруулсан байна. Монгол улсын Засгийн газрын үндсэн бодлого чиглэл болгон дараах 5 чиглэлийг дэвшүүлж тус бүр нэн тэргүүнд хийх шаардлагатай бодлогын чиг хандлагыг тусгаж өгсөн.

1. Эдийн засгийн хүндрэлийг даван туулах онцгой бодлого
2. Эдийн засгийн тогтвортой өсөлтийг хангах бодлого
3. Нийгмийн бодлого
4. Байгаль орчин, ногоон хөгжлийн бодлого
5. Засаглалын бодлого

Эдгээрээс “1) Эдийн засгийн хүндрэлийг даван туулах онцгой бодлого” болон “2) Эдийн засгийн тогтвортой өсөлтийг хангах бодлого”-той холбогдох үйл ажиллагааны хөтөлбөрийг хүснэгт 2.5.1-т нэгтгэн харуулав. Энэхүү хүснэгтээс харахад голлох зорилтот бодлогын дагуу авах арга хэмжээ нь олон талт бодлогын чиглэл, үйл ажиллагааны хөтөлбөрийг гарган тус тусын зорилгод тогтвортой хөгжлийн үзэл баримтлалыг тусган, үндсэн үзэл баримтлал болгосон байгаа нь харагдаж байна. Гэсэн хэдий ч үйл ажиллагааны чиглэл болон бодлогыг хэрэгжүүлэх уялдаа холбоо болон төсвийн хэрэгцээг харгалзан үзэх, тэргүүлэх дараалал зэргийг нарийвчлан бодолцох хэрэгтэй бөгөөд, эдгээрийг цаашид шинэ Засгийн газрын шийдвэрлэх чухал асуудал гэж үзэж байна.

Хүснэгт 2.5.1 Монгол улсын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрөөс (2016-2020)

Бодлогын тулгуур	Үйл ажиллагааны хөтөлбөр
<p>1. Эдийн засгийн хүндрэлийг даван туулах онцгой бодлого</p> <p>Эдийн засагт үүссэн хүндрэлийг богино хугацаанд даван туулж, макро эдийн засгийн тэнцвэрийг хангах, эдийн засгийн бүтцийг төрөлжүүлж, түүхий эдийн үнээс хэт хамааралтай байдлыг бууруулж,</p>	<ol style="list-style-type: none"> 1. Эдийн засгийн хүндрэлийг богино хугацаанд даван туулах, тогтворжуулах хөтөлбөр боловсруулна. 2. Макро эдийн засгийн тогтвортой байдлыг хангаж, гадаад, дотоодын хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлнэ. 3. Төсвийн нэгдмэл байдлыг ханган, төсвөөс гадуурх санхүүжилтийг зогсоож, хөрөнгө оруулалтын бодлого, төлөвлөлтийг боловсронгуй болгох замаар үр ашгийг нэмэгдүүлнэ. 4. Төсвийн сахилга батыг сайжруулж, үр ашиггүй зардлыг танах, хэмнэлтийн горимд шилжүүлэх замаар төсвийн алдагдлыг бууруулна. 5. Орон нутгийн хөгжлийн сангийн зарцуулалтыг үр дүнтэй, ард иргэдэд нээлтэй, ил тод болгоно. 6. Ард иргэд, аж ахуйн нэгж, улс орноо өрийн дарамтаас гаргаж, иргэдийн тогтвортой амьжиргааг дэмжин орлогыг нэмэгдүүлнэ. 7. Төрөөс захиалгаар гүйцэтгэсэн ажил үйлчилгээний хөлсөө авч чадахгүй байгаа

<p>төлбөрийн тэнцлийн эрсдэлийг багасгах, дунд хугацаанд учирч буй өрийн дарамтыг бууруулах, эдийн засгийг дархлаатай болгох, улмаар эдийн засаг дунд хугацаанд тогтвортой тэлэх бодлогыг баримтална.</p>	<p>иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын төлбөрийг барагдуулна.</p> <ol style="list-style-type: none"> 8. Өр зээлийн нөхцөлийг хөнгөвчилж, үндсэн төлбөрийн хугацааг хойшлуулах чиглэлээр яриа хэлэлцээ хийж, улсын төсөвт тулгарч буй өрийн дарамтыг үе шаттайгаар бууруулна. 9. “Үнэ тогтворжуулах” хөтөлбөрийн хүрээнд олгосон зээлийн ашиглалтад үнэлэлт, дүгнэлт өгч, үр ашгийг дээшлүүлэх бодлого хэрэгжүүлнэ. 10. Хөгжлийн банкны бонд, зээлийн зарцуулалтыг дүгнэж, төсөл, хөтөлбөрт үнэлгээ хийж, зориулалтын бусаар ашигласан, хугацаа хэтэрсэн зээлийг буцаан төлүүлнэ. 11. Шинэ төрлийн татвар бий болгохгүй ба үндэсний үйлдвэрлэлийг дэмжих бодлогын хүрээнд тодорхой салбарт үйл ажиллагаа явуулж байгаа 1.5 тэрбум төгрөгөөс бага жилийн орлоготой аж ахуйн нэгжийн орлогын албан татварыг 1 хувь болгон бууруулна. 12. Аж ахуйн нэгжийн болон хувь хүний орлогын албан татварыг орлогын түвшингээс хамаарсан шатлалтай болгоно. 13. Хувь хүний орлогын албан татварын хөнгөлөлтийг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээтэй уялдуулах эрх зүйн орчинг бүрдүүлнэ. 14. Үндэсний хөрөнгө оруулагчдыг бүхий л талаар дэмжиж, эхний хөрөнгө оруулалтаа нөхөх хүртэл орлогын албан татвараас хөнгөлөх, чөлөөлөх эрх зүйн орчинг бүрдүүлнэ. 15. Эрх бүхий байгууллагуудаас үндэсний аж ахуйн нэгжүүдэд тавигдсан татварын актын хүү, торгууль, алданги, үндсэн татварын нөхөн төлбөр төлөх хугацааг сунгах, хаалгасан дансыг нь нээх зэргээр бизнес эрхлэгчдээ дэмжинэ. 16. Эдийн засгийн хүндрэлээс улбаалан ажил, орлого нь хумигдан, зээлээ төлж чадахгүйд хүрч, “Найдваргүй зээлдэгчдийн жагсаалт”-д бүртгэгдсэн аж ахуй нэгж, иргэдэд зээлээ эргэн төлж, зээлийн түүхээ сайжруулах боломж олгоно. 17. 5-аас доошгүй жил тасралтгүй үйл ажиллагаа эрхэлж, байнгын ажлын байр шинээр бий болгосон хөнгөн, жижиг, дунд бизнес эрхлэгчдийг урт хугацаатай, хөнгөлөлттэй зээлээр дэмжинэ. 18. Төрийн үйлчилгээний шимтгэл, төлбөрийн хэмжээг бууруулна. 19. Төрөөс бизнес эрхлэгчдэд олгож байгаа тусгай зөвшөөрлийн тоог гурав дахин цөөрүүлж, хүчинтэй байх хугацааг уртасган, давхардсан хяналт шалгалт, хүнд суртлыг арилгана. 20. Эдийн засгийн хүндрэлийг даван туулах, эмзэг байдлыг бууруулах, эрсдэлийг багасгах чиглэлээр олон улсын болон бүс нутгийн банк, санхүүгийн байгууллагуудтай нягт хамтран ажиллана. 21. Түншлэгч улс орон, олон улсын банк, санхүүгийн байгууллагуудтай зөвшилцөх уулзалтуудыг сэргээн зохион байгуулна. 22. Эдийн засгийн суурь үзүүлэлтүүд болон Монгол Улсын зээлжих зэрэглэлийг сайжруулж, гадаадын хөрөнгө оруулагчдын итгэлийг сэргээнэ. 23. “Монголд үйлдвэрлэв” хөтөлбөрийг хэрэгжүүлж, үйлдвэрлэл, худалдаа, үйлчилгээний өрсөлдөх чадварыг дээшлүүлнэ. 24. “Эрдэнэс Монгол” компани болон Оюутолгой төслийн үйл ажиллагааг эрчимжүүлж, Тавантолгой, стратегийн ач холбогдол бүхий бусад ордуудыг эдийн засгийн эргэлтэд оруулна.
<p>2. Эдийн засгийн тогтворой өсөлтийг хангах бодлого</p>	<ol style="list-style-type: none"> 1. Монгол Улсын үндэсний нийт орлогыг нэмэгдүүлж, дундаж-дээгүүр орлоготой орнуудын эгнээнд буцаан оруулна. 2. Монгол Улсын Үйлдвэржилтийн газрын зургийг гаргаж, хүнд аж үйлдвэрийн хөгжлийн хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлнэ. 3. Монгол Улсад үйлдвэрлэсэн уул уурхайгаас бусад салбарын бүтээгдэхүүний

	<p>50-аас дээш хувийг экспортод гаргаж буй аж ахуйн нэгжийг татварын бодлогоор дэмжинэ.</p> <ol style="list-style-type: none"> 4. Иргэн бүрийн эзэмшиж буй 1072 хувьцааг амь оруулж, үнэ цэнэтэй болгоно. 5. Оюутолгой, Тавантолгой, Эрдэнэт зэрэг томоохон компаниудын үр ашгийг иргэн бүрд хүртээмжтэй байлгах бололцоог бүрдүүлнэ. 6. Томоохон төслийг хэрэгжүүлж буй аж ахуйн нэгжүүдэд олгох зээлийн хугацааг уртасгаж, хүүг бууруулах нөхцөлийг бүрдүүлнэ. 7. Иргэндээ ээлтэй, эдийн засагтаа үр өгөөжтэй банк санхүү, хөрөнгийн зах зээлийг хөгжүүлнэ. 8. Стандартчилал, хэмжил зүйн талаарх хууль тогтоомжийг олон улсын нийтлэг зарчимд нийцүүлэн шинэчилж, “Үндэсний чанарын хөтөлбөр”-ийг хэрэгжүүлнэ. 9. Бараа бүтээгдэхүүний зах зээлд өрсөлдөх чадварыг дээшлүүлэх, худалдаан дахь техникийн саад тотгорыг багасгахад Стандартчилал, тохирлын үнэлгээний үр дүнг хүлээн зөвшөөрөх, хэрэглэх, ашиглах механизмыг оновчтой болгоно. 10. Үйлдвэрлэлд ашиглагддаг уур, ус, дулаан, цахилгааны тарифыг тогтвортой байлгаж, аажмаар бууруулах бодлого баримтална. 11. Малын гаралтай түүхий эдийг бэлтгэх, тээвэрлэх, боловсруулах нийлүүлэлтийн нэгдсэн тогтолцоог бүрдүүлнэ. 12. Чөлөөт бүсүүдийн үйл ажиллагааг эрчимжүүлж, гадаад, дотоодын хөрөнгө оруулалтыг дэмжиж ажиллана. 13. Зах зээл дэх шударга өрсөлдөөнийг дэмжиж, хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах хууль, эрх зүйн орчинг сайжруулна. 14. Дотоодын үйлдвэрлэлийг гааль, татварын бодлогоор дэмжинэ. 15. Экспортын нэг цонхны бодлого хэрэгжүүлж, гааль, татвар, мэргэжлийн хяналт зэрэг төрийн үйлчилгээг цахим хэлбэрээр, эсхүл нэг цэгт үзүүлж, чирэгдлийг багасгана. 16. “Итгэлийн зээл”-ийг олгож, жижиг, дунд үйлдвэрлэл, өрхийн аж ахуй, бичил бизнес эрхлэгчдэд дэмжлэг үзүүлнэ. 17. Хөдөө орон нутаг, алслагдсан бүс нутагт бизнес эрхлэлтийг дэмжих “Бүсийн хөнгөлөлт”-ийн бодлого хэрэгжүүлнэ. 18. Шатахууны үнийг дэлхийн зах зээлийн үнэтэй уялдуулан үнийн дарамтыг бууруулна.
<p>3. Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарын хүрээнд авч хэрэгжүүлэх арга хэмжээ</p>	<ol style="list-style-type: none"> 1. Хүн амын хүнсний хангамжийг тогтворжуулах, стратегийн хүнсний нийлүүлэлтийн улирлын хамаарлыг бууруулах зорилгоор “Мах, сүүний анхдугаар аян”-ыг зохион байгуулж, хүн амыг эрүүл, аюулгүй бүтээгдэхүүнээр хангана. 2. Хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн өрсөлдөх чадварыг дээшлүүлж, нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн экспортлох боломжийг бүрдүүлнэ. 3. Органик болон зохицуулах үйлчилгээтэй хүнсний эрх зүйн орчинг бүрдүүлж, энэ чиглэлийн үйлдвэрлэлийг хөгжүүлэх санхүү, хөрөнгө оруулалт, татварын бодлогыг хэрэгжүүлнэ. 4. Аймаг, нийслэл, сум, суурин газруудын хэрэгцээнд тохирсон орчин үеийн дэвшилтэт технологи бүхий бага, дунд оврын хүнсний боловсруулах жишиг загвар үйлдвэрийг байгуулахыг дэмжинэ. 5. Хүнсний аюулгүй байдлын бүртгэл, мэдээллийн нэгдсэн цахим санг бий болгоно. 6. Иргэдийн эрүүл, баталгаат хүнс хэрэглэх нөхцөлийг бүрдүүлж, хүнсний бүтээгдэхүүний бэлтгэл, боловсруулалт, хадгалалт, тээвэрлэлт, борлуулалтын тогтолцоог бий болгож, хүнсний аюулгүй байдлыг сайжруулна. 7. Дотоодын хүнсний бүтээгдэхүүний нэр төрлийг олшруулж, тахиа, гахай, зөгий,

	загасны аж ахуй зэрэг дэд хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэн, бүтээгдэхүүний нийлүүлэлт, хүртээмжийг нэмэгдүүл
<p>4. Мал аж ахуйн чиглэлээр;</p>	<ol style="list-style-type: none"> 1. Мал аж ахуйн үйлдвэрлэлийн үр ашгийг нэмэгдүүлэх, эдийн засгийн эргэлтийг сайжруулах, дэвшилтэт техник, технологийн шинэчлэлийг хийх, инновацийг нэвтрүүлэх зорилгоор “Монгол мал” үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг эрчимжүүлнэ. 2. “Төрөөс малчдын талаар баримтлах бодлого”, “Монгол малчин”, “Малжуулах” хөтөлбөрийг хэрэгжүүлнэ. 3. Бэлчээрийн болон эрчимжсэн мал аж ахуй, фермерийн аж ахуйг зохистой хослуулснаар мах, махан бүтээгдэхүүний экспортыг дэмжиж, жилд экспортлох хэмжээг 50 мянган тоннд хүргэж, малчин өрхийн орлогыг нэмэгдүүлнэ. 4. Мал аж ахуйн мэргэжилтнийг бэлтгэх, давтан сургах, мал аж ахуйн хөгжлийн талаарх олон улсын туршлагыг судлах, нэвтрүүлэх, “Малчдыг мэдлэгжүүлэх, мэдээллээр хангах” хөтөлбөр хэрэгжүүлнэ. 5. Мал аж ахуйн үйлдвэрлэл эрхлэгчдийг хөнгөлөлттэй зээл, хөрөнгө оруулалт, даатгал, татварын уян хатан бодлогоор дэмжих, малын гаралтай түүхий эдийн үнэ ханшийн уналтаас хамгаалах, малчдад ирж буй хүндрэлийг багасгахад чиглэгдсэн мал аж ахуйн хөгжлийг дэмжих тусгай санг өргөжүүлж, малчин өрхийн орлого, амьжиргааны баталгааг хангана. 6. Малыг бүртгэлжүүлж, малын гаралтай түүхий эд бэлтгэлийн чанар стандартыг дээшлүүлж, гарал үүслийг тодорхой болгох системийг бүрдүүлнэ. 7. Малчдыг орон сууцны хөтөлбөрт хамруулах, нийгмийн асуудлыг шийдэх арга хэмжээ авна. 8. Мал эмнэлгийн албаны тогтолцоог олон улсын жишигт нийцүүлж, үйл ажиллагааны шуурхай, нэгдмэл байдлыг ханган, мал, амьтны гоц халдварт, халдварт, зооноз өвчнөөс урьдчилан сэргийлэх, өвчнийг хяналтад авах, тэмцэх стратегийг хилийн боомтуудыг түшиглэн бүсчлэн хэрэгжүүлж, мал аж ахуйн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг экспортлох боломжийг нэмэгдүүлнэ. 9. Малын тоог чанарт шилжүүлж ашиг шим, хүртээмжийг сайжруулах, генетикийн нөөцийг хамгаалах, үржил селекцийн ажлыг шинжлэх ухааны үндэслэлтэй явуулах, биотехнологийн ололтыг нэвтрүүлэх, шинэ үүлдэр, омгийг бий болгох, орон нутгийн мал үржлийн нэгжүүдийг чадавхжуулна. 10. Малын тэжээлийн үйлдвэрийг бүсчлэн байгуулах үйл ажиллагаанд зээлийн дэмжлэг үзүүлж, өвс тэжээлийн аюулгүй нөөцийг нэмэгдүүлнэ. 11. Хөдөөгийн хүн ам болон мал аж ахуйн усан хангамжийг нэмэгдүүлэх зорилгоор бэлчээрт худаг, хөв цөөрөм барьж байгуулан ашиглалт, хяналтыг сайжруулна. 12. Бэлчээрийн ашиглалтыг сайжруулах, нөхөн сэргээх, талхагдал, цөлжилтийг бууруулах, бэлчээрт хөнөөл учруулж буй мэрэгч амьтан, шавжтай байгаль орчинд халгүй, дэвшилтэт аргаар тэмцэнэ. 13. Мал аж ахуйн салбарын тогтвортой хөгжлийг хангахад чиглэгдсэн Малын генетик нөөцийн тухай, Мал, амьтны эрүүл мэндийн тухай, Мал аж ахуйн хөгжлийг дэмжих тухай хуулийг тус тус боловсруулж, эрх зүйн таатай орчинг бүрдүүлнэ. 14. Мал аж ахуй эрхлэх уламжлалт хэв маяг, мэдлэгийг хадгалах, баяжуулах, малын тоо, төрөл, сүргийн бүтцийн зохист харьцааг баримтлах, эрчимжсэн аж ахуйг төрөлжүүлэн хөгжүүлэх хөтөлбөр хэрэгжүүлнэ.
<p>5. “АТРЫН-III аян”-ыг үргэлжлүүлэх</p>	<ol style="list-style-type: none"> 1. Эргэлтийн талбайн ашиглалтыг сайжруулж, газар тариалан, эрчимжсэн мал аж ахуй эрхлэх бүс нутгийг тогтоон үр тариа, төмс, гол нэрийн хүнсний ногоог 100 хувь, таримал тэжээлийн 50 хувийг дотоодын үйлдвэрлэлээр хангана.

<p>хүрээнд</p>	<ol style="list-style-type: none"> 2. Жимс жимсгэний нэр төрөл, үйлдвэрлэлийг нэмэгдүүлж, чацарганы үйлдвэрлэлийн нэгдсэн сүлжээ байгуулан, хүн амыг амин дэм бүхий жимс жимсгэнээр ханган, экспортын орлогыг нэмэгдүүлнэ. 3. Газрын үржил шим, үр өгөөж, таримал ургамлын үр үржүүлгийн аж ахуйг цогцолбор байдлаар хөгжүүлж, үрийн сорт чанарыг сайжруулах замаар га-аас авах ургацын хэмжээг нэмэгдүүлнэ. 4. Ургамал хамгааллын цогц арга хэмжээг төлөвшүүлж, тариалангийн талбайн хөрсийг элэгдэл, эвдрэлээс хамгаалж, үржил шимийг сайжруулах, таримлын зохистой сэлгээ, тэг элдэншүүлгийн технологийг үе шаттайгаар нэвтрүүлнэ. 5. Усны хайгуул, судалгаанд үндэслэн услалтын систем шинээр барьж, сэргээн засварлах, усалгааны дэвшилтэт техник, технологи нэвтрүүлэхийг дэмжиж, усалгаатай талбайн хэмжээг жил бүр нэмэгдүүлнэ. 6. Өвөл, зуны хүлэмжийн загвар, цогцолбор аж ахуйг хөгжүүлж, хот суурингийн хүн амыг шинэ ургацын ногоогоор тогтвортой хангана. 7. Газар тариалангийн зориулалттай дэвшилтэт техник, тоног төхөөрөмж, бордоо, ургамал хамгааллын бодисыг татварын бодлого, санхүүгийн лизингийн арга хэрэгслээр дэмжинэ. 8. Зоорь, агуулах, элеватор, үтрэмийн техник, тоног төхөөрөмжийн хүчин чадлыг нэмэгдүүлэх, хадгалалт борлуулалтын нэгдсэн тогтолцоог бүрдүүлэхэд дэмжлэг үзүүлнэ. 9. Тариалангийн даатгалын эрх зүйн орчинг бүрдүүлнэ
<p>6. “ҮНДЭСНИЙ ҮЙЛДВЭРЛЭЛ” хөтөлбөрийн хүрээнд</p>	<ol style="list-style-type: none"> 1. Үйлдвэржилтийн 21:100 хөтөлбөрийг хэрэгжүүлж, импортыг орлох экспортын чиглэлийн тэргүүлэх болон жижиг, дунд үйлдвэрлэл, хоршоо, худалдаа, үйлчилгээний салбарын татвар, эрх зүй, бизнесийн таатай орчинг бүрдүүлж, нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хэмжээг нэмэгдүүлнэ. 2. Хөдөө аж ахуйн бараа, бүтээгдэхүүний үнийн зохицуулалтын эрх зүйн орчинг бүрдүүлнэ. 3. Хөнгөн, жижиг дунд үйлдвэр, хоршооны салбарт урт хугацаат хөрөнгө оруулалтын болон санхүү, зээлийн уян хатан бодлого хэрэгжүүлнэ. 4. Ноос, ноолуур, арьс ширэн түүхий эдийн бэлтгэл тээвэрлэлт, үндэсний үйлдвэрт тогтвортой нийлүүлэх тогтолцоог бүрдүүлж, түүхий эдийн санг бий болгоно. 5. Олон улсын худалдааны болон хөрш орнуудын боомтын бүсэд үйлдвэрлэл, худалдаа хөгжүүлэхийг дэмжинэ. 6. Хөнгөн, жижиг, дунд үйлдвэрийн салбарын боловсон хүчнийг бэлтгэх, сургах, давтан сургах тогтолцоог хөгжүүлж “Мэргэжилтэй ажилтан” хөтөлбөр хэрэгжүүлнэ. 7. Хөнгөн үйлдвэрийн салбаруудыг хөгжүүлэх зорилгоор зөвлөгөө, мэдээлэл, сургалт явуулах мэдээллийн болон инкубатор төвийг тухайн салбарын мэргэжлийн холбоодыг түшиглэн байгуулахыг дэмжинэ. 8. Гадаад орны өндөр болон дэвшилтэт технологи бүхий үйлдвэрийг франчайзаар оруулж нутагшуулан, хөнгөн, жижиг дунд үйлдвэрийн салбарт “Хөгжлийн загвар” үйлдвэр байгуулахыг дэмжинэ. 9. Хөнгөн үйлдвэрийн чиглэлээр дэлхийн тэргүүлэх, дэвшилтэт техник технологийн үзэсгэлэнг Монгол Улсад тогтмол зохион байгуулж, гадаад оронд зохион байгуулагдаж буй үйлдвэрийн тоног төхөөрөмж, бараа, бүтээгдэхүүний үзэсгэлэнд үйлдвэрлэгчдийг дэмжиж хамруулна. 10. Хөнгөн үйлдвэрийн парк байгуулж, салбарын үйлдвэрүүдийн хамтын ажиллагааг дэмжин, кластерыг бүртгэлжүүлэн бодлогоор дэмжинэ.

	<p>11. Хөдөө аж ахуйн биржээр арилжаалах бараа, түүхий эдийн нэр төрөл, тоо хэмжээг нэмэгдүүлж, үйл ажиллагааг боловсронгуй болгоно.</p>
<p>7. Геологи, уул уурхай, хүнд үйлдвэрийн салбарын хүрээнд авч хэрэгжүүлэх арга хэмжээ</p>	<ol style="list-style-type: none"> 1. Монгол орны геологийн зураглал, ерөнхий эрэл, агаарын геофизик, геохимн, гидрогеологи, геоэкологийн судалгааны ажлын хэмжээг нэмэгдүүлэх замаар уул уурхайн салбарын тогтвортой хөгжлийг дэмжинэ. 2. Олон улсын жишгийн дагуу Үндэсний геологийн алба, Үндэсний геомэдээллийн санг байгуулан, мэдээлэл түгээх үйлчилгээг хялбаршуулна. 3. Геологи, уул уурхайн салбарт хөрөнгө оруулалтыг татах эрх зүйн таатай орчинг бүрдүүлж, харилцан үр ашигтай төсөл, хөтөлбөрийг хамтран хэрэгжүүлнэ. 4. Уул уурхайн үйлдвэрлэл дэх төрийн оролцоог зохистой хэмжээнд байлгаж, Кадастрын бүртгэлийн системийг боловсронгуй болгож, тусгай зөвшөөрөл олгох үйлчилгээг хөнгөн шуурхай болгоно. 5. Газрын тосны эрэл, хайгуул, ашиглалтын ажлыг эрчимжүүлж, нөөцийг өсгөнө. 6. “Төрөөс эрдэс баялгийн салбарт баримтлах бодлого”-ын 3.1.2-т заасан иргэд бичил уурхайн салбарт хууль ёсны бүтцээр хоршиж ажиллах чиглэлийг хэрэгжүүлэн холбогдох эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгоно. 7. Уул уурхайн дэд бүтцийн хөгжлийн урт хугацааны төлөвлөлт боловсруулж, салбар хоорондын уялдааг сайжруулна. 8. Уул уурхайн судалгааны нэгж байгуулж, эрдэс баялгийн салбарт хөрөнгө оруулалтын таатай орчинг бий болгоно. 9. Хоёрдогч ашигт малтмал ашиглах эрх зүйн орчинг бий болгож, уурхайн нөхөн сэргээлт, хаалтыг олон улсын жишигт хүргэнэ. 10. “Алт-2” хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардагдах санхүүжилтийг Монголбанктай хамтран шийдвэрлэнэ. 11. Алтны олборлолтыг нэмэгдүүлж, бичил уурхай эрхлэгчдийн олборлосон алтыг худалдан авах эрх зүйн орчинг бүрдүүлнэ. 12. Газрын тосны олборлолтыг тогтвортой нэмэгдүүлэн, газрын тос боловсруулах үйлдвэр байгуулна. 13. Зэсийн баяжмал хайлуулах, цэвэршүүлэх үйлдвэр байгуулах ажлыг дэмжиж ажиллана. 14. Дархан, Сэлэнгийн бүсэд хар төмөрлөгийн цогцолбор байгуулах нөхцөлийг бүрдүүлнэ. 15. Нүүрс угаах, гүн боловсруулах үйлдвэр болон нүүрсний нийлэг хийн үйлдвэр байгуулахыг бодлогоор дэмжинэ. 16. Шингэрүүлсэн түлш, шатах тослох материалын үйлдвэр байгуулах ажлыг бодлогоор дэмжинэ. 17. Метал хийц, угсралтын үйлдвэрийг хөгжүүлнэ
<p>8. Дэд бүтцийн салбарын хүрээнд авч хэрэгжүүлэх арга хэмжээ</p> <p>Барилга, хот байгуулалтын чиглэлээр:</p> <p>Иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах нөхцөлийг хангасан хот, суурин газрыг төлөвлөж, байгаль орчин, хүний эрүүл</p>	<ol style="list-style-type: none"> 1. Ипотекийн зээлийн нөхцөлийг хөнгөвчилж, зээлийн хөтөлбөрийг олон хувилбарт хэлбэрээр хэрэгжүүлэх бодлого баримталж, зээлийн цар хүрээ, хүртээмжийг нэмэгдүүлнэ. 2. Хүн амын орон сууцны хэрэгцээг хангах зорилгоор нэгдсэн бодлого боловсруулж, “Хямд өртөгтэй орон сууц” үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлнэ. 3. Норм, нормативын баримт бичгийн тогтолцоог олон улсын жишигт нийцүүлэн шинэчилж, олон улсын норм, нормативын баримт бичгийг хэрэглэх орчинг бүрдүүлнэ. 4. Монгол Улсын хүн амын нутагшилт, суурьшлын хөгжлийн ерөнхий төслийг бүс нутаг, бүлэг суурингийн тогтолцоог оновчтой тогтоох чиглэлээр үе шаттайгаар боловсруулна. 5. Газрын нэгдсэн бодлого, тогтолцоог бүрдүүлж, газар ашиглах, эзэмших, өмчлөх

<p>мэндийн шаардлагад нийцсэн барилгын үйлдвэрлэлийг дэмжиж, аюулгүй, хүртээмжтэй орон сууцаар хангах төрийн бодлогыг боловсруулан хэрэгжүүлнэ.</p>	<p>эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгоно.</p> <ol style="list-style-type: none"> 6. Монгол Улсын нутаг дэвсгэрийг бүрэн зурагжуулах, шинэчлэх, геодезийн нэгдсэн сүлжээг бий болгох замаар орон зайн өгөгдөл, мэдээллийг нийтийн хэрэглээнд нэвтрүүлнэ. 7. Улаанбаатар хотыг хөгжүүлэх эрх зүйн орчинг бүрдүүлнэ. 8. Улаанбаатар хотыг хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөөтэй уялдуулан “Гудамж”, “Дугуйн зам” дэд хөтөлбөрүүдийг хэрэгжүүлнэ. 9. Улаанбаатар хот, аймгийн төвүүдийн ногоон байгууламжийг 3 дахин нэмэгдүүлэх бодлого баримтална. 10. Улаанбаатар хот болон томоохон хотуудыг дахин төлөвлөж, хөгжүүлэх бодлогын хүрээнд барилга байгууламжийг шинэчлэх, гэр хорооллын дахин төлөвлөлтийн төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлж, агаарын бохирдлыг бууруулах нөхцөлийг бүрдүүлнэ. 11. Хот, суурин газруудад шинээр баригдах орон сууцны хорооллын инженерийн хангамжийн шугам сүлжээний техникийн шийдлийг хонгилын системээр төлөвлөн, үе шаттай хэрэгжүүлнэ. 12. Барилга байгууламжийн өөрийн өртгийг бууруулах, барилгын үйлдвэрлэлийн хугацааг уртасгах, барилгын жинг хөнгөрүүлэх, дулаан алдагдлыг бууруулах, галд тэсвэрлэлтийг сайжруулахад чиглэсэн барилгын материалын үйлдвэрлэлийг хөгжүүлэх бодлого боловсруулж хэрэгжүүлнэ. 13. Хот, суурин газруудын газар хөдлөлтийн үйлчлэлийн давтамж, эрчмийг шинэчлэн тогтоож, барилга байгууламжийн төлөвлөлтөд тусгах, ашиглагдаж буй барилга байгууламжуудын бат бэх, найдвартай байдлыг сайжруулах арга хэмжээг төлөвлөж, үе шаттай хэрэгжүүлнэ. 14. Нийтийн аж ахуйн талаар төрөөс баримтлах нэгдсэн бодлогыг хот, суурин газрын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөтэй уялдуулан боловсруулж хэрэгжүүлнэ. 15. Улаанбаатар хотод шинээр төлөвлөж байгаа орон сууцны хорооллын унд-ахуйн хэрэглээний цэвэр усыг тусад нь төлөвлөх, гарсан бохир усыг саарал усны стандартын шаардлагад нийцүүлэн дахин боловсруулж, ариутгах татуургын системд технологийн зориулалтаар болон ногоон байгууламжийн усалгаанд ашиглах зэрэг техникийн шийдлийг зураг төсөлд тусгаж, хэрэгжүүлэх ажлыг эхлүүлнэ. 16. Хот, суурин газрын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөтэй уялдуулан гадаад, дотоодын хөрөнгө оруулалтаар Улаанбаатар хот болон бусад томоохон хот, суурин газрын цэвэрлэх байгууламжийг үе шаттай шинэчлэх ажлыг эрчимжүүлнэ. 17. Цэвэрлэх байгууламжаар цэвэрлэсэн ус болон хөрсний усыг үйлдвэрийн технологийн хэрэгцээнд ашиглах боломжийг бүрдүүлнэ. 18. Утасгүй интернетийн хүртээмжийг нэмэгдүүлж, амралт, зугаалгын бүс, номын санд ашиглах боломжийг бүрдүүлнэ. 19. Улаанбаатар хотын цэвэр усны хангамжийг сайжруулах ажлын хүрээнд Туул, Сэлбэ, Дунд голын урсацыг нэмэгдүүлж, эргийн дагуу олон нийтийн соёл, амралтад зориулсан тохилог орчныг бүрдүүлнэ. 20. Улаанбаатар хотын орон сууцны хороолол, нийтийн үйлчилгээний төвүүдийн дэргэд газар доорх болон давхар зогсоол барьж, авто зогсоолыг хоёр дахин нэмэгдүүлнэ. 21. Улаанбаатар хотын Сэлбэ, Баянхошуу дэд төвүүдийн инженерийн шугам сүлжээг барьж байгуулах ажлыг дуусгана.
<p>9. Эрчим хүчний</p>	<ol style="list-style-type: none"> 1. Улс орны эдийн засгийн аюулгүй байдал, тогтвортой хөгжлийн үндэс болсон

<p>салбарын чиглэлээр</p> <p>Улс орны эдийн засгийн аюулгүй байдлын үндэс болсон эрчим хүчний тогтвортой, найдвартай ажиллагааг бүрэн хангаж, экспортын чадамжтай болох нөхцөлийг бүрдүүлнэ</p>	<p>суурь салбарын тасралтгүй, найдвартай ажиллагааг хангах зорилгоор ашиглалтад байгаа цахилгаан станцуудын хүчин чадлыг өргөтгөх, шинэчлэх ажлыг хэрэгжүүлнэ. /Чойбалсангийн ДЦС, Улаанбаатарын Гуравдугаар ДЦС/</p> <ol style="list-style-type: none"> 2. Монгол Улсын эрчим хүчний хангамжийн найдвартай байдал, өсөн нэмэгдэж байгаа хэрэглээг бүрэн хангах шинэ эх үүсвэрийг барих, Өмнөд говийн уул уурхайн цахилгааны хэрэглээг хангах Тавантолгойн уурхайн нүүрсээр ажиллах цахилгаан станцыг барих асуудлуудыг шийдвэрлэнэ. 3. Шивээ-Овоо, Тэвшийн говь болон бусад нүүрсний ордыг түшиглэн экспортын зориулалттай том чадлын цахилгаан станц, тогтмол гүйдлийн цахилгаан дамжуулах шугам барих төслийг эхлүүлнэ. 4. Сэргээгдэх эрчим хүчний үйлдвэрлэлийг зохистой харьцаагаар хөгжүүлнэ. 5. Бүс нутгийн эрчим хүчний систем, хүнд үйлдвэрүүд, том хэрэглэгчид, эрчим хүчний эх үүсвэрүүдийг холбосон цахилгаан дамжуулах агаарын шугам, дэд станцыг барьж, эрчим хүчний нэгдсэн систем байгуулах ажлыг үргэлжлүүлнэ. 6. Аймгийн төвүүд болон томоохон хот, суурин газарт дулааны станц, шугам сүлжээг шинээр барих, өргөтгөх, эрчим хүчээр бүрэн хангах ажлыг үе шаттай хэрэгжүүлнэ. 7. Сумын төвүүдийг төвлөрсөн цахилгаан системд бүрэн холбож дуусган сэргээгдэх эрчим хүч болон цэвэр технологид суурилсан төвлөрсөн инженерийн байгууламж буюу дулаан хангамж, цэвэр бохир усны сүлжээтэй болгох ажлыг үе шаттай хэрэгжүүлнэ. 8. Эрчим хүчний хэмнэлт, үр ашгийг дээшлүүлэх, алдагдлыг бууруулах, инновацын түвшний шинэ техник технологи нэвтрүүлэх чиглэлээр тодорхой арга хэмжээ, төсөл хөтөлбөрийг хэрэгжүүлнэ. 9. Дулаан, цахилгааны үнийг тогтвортой байлгаж, цаашид үе шаттайгаар бууруулах бодлого баримтална. 10. Тавантолгой болон төвийн бүсийн нүүрсний ордуудад давхаргын хийн нарийвчилсан судалгааг хийж, ашиглах боломжтой нөөцийг тогтоох, орон нутгийн хийн хангамжид ашиглах загвар төсөл хэрэгжүүлэх, шинэ техник технологид үндэслэсэн нүүрсийг хийжүүлэх, утаагүй түлш үйлдвэрлэх дунд чадлын үйлдвэр барьж, хэрэглэгчдийг утаагүй түлшээр хангах төслийг эхлүүлж, агаарын бохирдлыг бууруулна.
<p>10. Зам тээврийн салбарын чиглэлээр:</p> <p>Эдийн засгийн өсөлтийг дэмжсэн, нийгмийн хэрэгцээ шаардлагад нийцсэн, аюулгүй, ая тухтай үйлчилгээ үзүүлэх зам, тээвэр, ложистикийн сүлжээг өргөжүүлэн хөгжүүлнэ.</p>	<ol style="list-style-type: none"> 1. Олон улс, хот хоорондын болон орон нутгийн чанартай авто замын сүлжээн дэх хатуу хучилттай авто замын сүлжээг өргөтгөж, бүх аймгийн төвийг нийслэл хоттой хатуу хучилттай авто замаар холбож дуусгах, Мянганы замын хэвтээ тэнхлэгийн хэсгийг үргэлжлүүлнэ. 2. “Тавантолгой-Гашуун сухайт”, “Хөөт-Бичигт” чиглэлийн төмөр замыг барьж ашиглалтад оруулна. 3. “Тавантолгой-Гашуун сухайт” чиглэлийн төмөр замаас Оюутолгойн салбар төмөр зам, “Шивээ хүрэн-Сэхэ” чиглэлийн боомтын төмөр замыг барьж дуусгана. 4. “Зүүнбаян-Ханги” чиглэлийн төмөр замын барилгын ажлыг эхлүүлнэ. 5. Улаанбаатар төмөр замын техникийн шинэчлэлт хийж нэвтрүүлэх чадварыг нэмэгдүүлж, “Богд Хан” төмөр замыг барьж байгуулах ажлыг эхлүүлнэ. 6. “Эрдэнэт-Овоот” чиглэлийн төмөр замыг барьж байгуулах ажлыг эхлүүлнэ. 7. Үндэсний болон олон улсын тээвэр, ложистикийн сүлжээг хөгжүүлж, “Хөшиг”-ийн хөндийд холимог тээвэр ложистикийн төв байгуулна. 8. Төрөөс агаарын тээврийн салбарт баримтлах бодлогод тулгуурлан орон нутгийн болон олон улсын нислэгийн тоог нэмэгдүүлэх, өрсөлдөөнийг дэмжих замаар тус салбарт үнэ тарифыг бууруулна.

	<ol style="list-style-type: none">9. Жижиг нисэх онгоц, нисдэг тэрэгний зах зээлийг хөгжүүлж, гамшгаас хамгаалах, хүнс, хөдөө аж ахуй, эрүүл мэндийн түргэн тусламжийн үйлчилгээ, иргэний агаарын тээвэр, аялал жуулчлалын чиглэлээр ашиглана.10. Тээврийн салбарын олон улсын хамтын ажиллагааг хөгжүүлж, бүс нутгийн дэд бүтэц, тээврийн интеграцид нэгдэн орох замаар дамжин өнгөрөх тээврийг хөгжүүлнэ.11. Монгол Улс, ОХУ, БНХАУ-ын гурван талт хамтын ажиллагааны механизмын хүрээнд Бүс нутгийн хамтын ажиллагааны төлөвлөлтийн төв байгуулж, дэд бүтцийн чиглэлээр урьдчилан тохиролцсон төслүүдийн ТЭЗҮ-ийг боловсруулж, зарим ажлыг эхлүүлнэ.12. Далайн тээвэр, хөлөг онгоцны бүртгэлийн үйл ажиллагааг өргөжүүлж, дотоодын гол, мөрөн нууруудад байгаль орчинд ээлтэй аялал жуулчлалын аюулгүй усан замын тээврийг хөгжүүлнэ.13. БНХАУ-ын Тяньжин хотын Дунзяны чөлөөт боомт бүсэд тээвэр ложистикийн төвийг байгуулна.14. Эрэлтэд нийцсэн, хүрээлэн орчинд нээлтэй тээврийн ухаалаг систем нэвтрүүлнэ.15. Улаанбаатар хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөтэй уялдуулан автозамын сүлжээг сайжруулах зорилгоор Баянзүрх, Яармаг, Сонсголонгийн гүүр болон Улаанбаатар-Налайх чиглэлийн автозамыг шинээр барина.16. Улаанбаатар хотын автозамын ачааллыг бууруулах, түгжрэлийг багасгах зорилгоор гүүрэн гарцуудыг шинээр байгуулан, тусгай замын автобус /BRT/-ыг нийтийн тээврийн үйлчилгээнд шинээр нэвтрүүлнэ.
--	---

Эх сурвалж : Монгол улсын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрөөс

2.6 Эдийн засгийг сэргээх хөтөлбөр (ERP)

Монгол улсын Засгийн газар 4 жилийн үйл ажиллагааны хөтөлбөр боловсруулсны дараа, хөтөлбөрт тусгагдсан эдийн засгийн хямралыг даван туулах зорилго бүхий “Эдийн засгийг сэргээх хөтөлбөр” (ERP)-ийг боловсруулж, 2016 оны 11 сарын 16-нд УИХ-аар батлуулсан. Эдийн засгийн тогтворжуулах, төсвийн хүндрэлийг даван туулах зорилгоор дараах 2 стратеги зорилт тавин, хэрэгжүүлэх нарийвчилсан төлөвлөгөөг боловсруулсан.

Стратеги 1. Макро эдийн засгийн тэнцвэрт байдлыг богино хугацаанд сайжруулах

- 1.1. Улсын төсвийн алдагдлыг бууруулж, санхүүжилтийн тогтвортой байдлыг хангахад чиглэсэн төсвийн бодлого хэрэгжүүлнэ.
- 1.2. Төлбөрийн тэнцлийн дарамтыг бууруулж, инфляцийн тогтвортой байдлыг хангахад чиглэсэн мөнгөний бодлого хэрэгжүүлнэ.
- 1.3. Гадаад валютын орох урсгалыг нэмэгдүүлж, ойрын хугацаанд төлөх гадаад өр төлбөрийг санхүүжүүлэх эх үүсвэрийг шийдвэрлэнэ.

Стратеги 2. Дунд хугацааны эдийн засагт бүтцийн өөрчлөлт хийж, өрийн дарамтыг багасгах

- 2.1 Уул уурхайн бус салбарын экспортын орлогыг нэмэгдүүлж, эдийн засгийг төрөлжүүлэх үндэс суурийг тавих
- 2.2 Бодит салбарын өсөлтийг дэмжих томоохон төслүүдийг эхлүүлж, дэд бүтцийн бүтээн байгуулалтын ажлыг эрчимжүүлэх
- 2.3 Эдийн засгийн өсөлтийг дэмжих хариуцлагатай засаглалыг бэхжүүлж, хууль эрх зүйн тогтвортой орчныг бүрдүүлэх

Энэхүү хөтөлбөрийг хэрэгжүүлэх нарийвчилсан төлөвлөгөөнд хөтөлбөрийг хэрэгжүүлэх сайжруулах, бааз суурийг өргөжүүлэх, орон нутгийн хөгжлийн сангийн зарцуулалтад үр ашгийн шинжилгээ хийж, 2017 оны төсвийн алдагдлыг ДНБ-ний 9.9% дээшгүй байлгах зэрэг тодорхой арга хэмжээнүүдийг тусгасан. Түүнчлэн концессоор хэрэгжсэн, одоо хэрэгжиж байгаа төсөл хөтөлбөрүүдэд шалгалт хийж, дүгнэлт гаргахын зэрэгцээ цаашид хэрэгжүүлэх концессын зүйлийн жагсаалтыг шинэчлэн баталж, хэрэгжүүлэх механизмыг тодорхой болгох, “Төр-хувийн хэвшлийн түншлэлийн тухай хууль”-ийг батлуулж хэрэгжүүлэх асуудал тусгагдсан байна.

Мөн Засгийн газар, Хөгжлийн банкны гадаад бондын эргэн төлөлт буюу дахин санхүүжүүлэх төлөвлөгөө боловсруулж, хэрэгжүүлэхийн зэрэгцээ Засгийн газрын болон Хөгжлийн банк, Монгол банкны болзошгүй өр төлбөрийн судалгааг хийх, эрдлээс сэргийлэх арга хэмжээ авах асуудал хөндөгдсөн байна. Түншлэгч улс орон, олон улсын банк, санхүүгийн байгууллагуудтай зөвшилцөх уулзалтуудыг зохион байгуулж, урт хугацаатай, бага хүүтэй санхүүгийн эх үүсвэр татах, гадаадын шууд

хөрөнгө оруулалтыг татах хууль, эрх зүйн орчныг сайжруулна. Засаглалыг бэхжүүлэх тал дээр Хөгжлийн банк болон улсын төсвийн уялдааг хангах, Хөгжлийн банкны засаглалын тэнцвэрт байдал, ил тод байдал, тайлагнах үйл ажиллагааг боловсронгуй болгох, үйл ажиллагааны хүрээг тэлэх, бие даасан байдлыг бэхжүүлэх, Хөгжлийн банкны тухай хуулийн тодотголыг боловсруулан батлуулж, байгууллагын бүтцийг шинэчлэн зохион байгуулах ажил хөтөлбөрт тусгагдсан байна.

Нөгөөтэйгүүр эдийн засгийн өсөлтийг дэмжих томоохон төслүүдийн хэрэгжилтийг эрчимжүүлэх, дэд бүтцийн тодорхой төслүүдийг дэмжих талаар дурдсан байгаа хэдий ч улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөртэй хэрхэн уялдах талаар тодорхой дурдагдаагүй байна.

Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр болон Эдийн засгийг сэргээх хөтөлбөрт тусгагдсан төслийн жагсаалтын тухайд салбарын яам, тамгын газраас санал авсны үндсэн дээр Засгийн газрын хуралдаанаар эцэслэж шийддэг. Гэхдээ олон жилийн өмнөөс яригдаж ирсэн томоохон төслүүд орсон байгаагаас гадна, салбарын яам, тамгын газраас ирсэн саналыг Засгийн газар, УИХ-аар хэлэлцэх үед төслийн тоо болон төсвийн хэмжээ нэмэгдэж батлагдах нь олонтаа тохиолддог. Үүний гол шалтгаан нь сонгуулийн өмнөх амлалт, улс төрийн ашиг сонирхол байдаг нь ойлгомжтой. Улсын хөрөнгө оруулалтын төсөл болон хувийн хэвшлийн бүтээн байгуулалтын төслийн хэрэгжилтэд улс төрийн оролцоо, дарамт шахалтыг багасгахгүй бол энэхүү асуудал шийдэгдэхгүй. Цаашид шийдвэр гаргах тогтолцооны ил тод байдлыг хангах асуудал зайлшгүй шаардлагатай бөгөөд үүний тулд мэдээллийг олон нийтэд ил тод болгох, олон талын оролцоог хангах, санал бодлыг тусгах зэргээр төрийн засаглалын хариуцлагыг дээшлүүлэх механизм бүрдүүлэх нь зүйтэй.

3 Улсын хөрөнгө оруулалтын өнөөгийн байдал, тулгамдаж буй асуудал

Энэхүү бүлэгт улсын хөрөнгө оруулалтын өнөөгийн байдал болон асуудлын тухай улсын хөрөнгө оруулалтын хөрөнгийн эх үүсвэрт тулгарч буй асуудлыг онцлон (3.1 бүлэг) мега төслүүдийн бодлогын үйл явц болон тэдгээрийн асуудалтай талуудыг авч үзнэ (3.2 бүлэг). Мөн хөгжлийн бодлого, төсвийн салбар дахь гол хандивлагчдын хамтын ажиллагааны төслүүдийн талаар болон үзүүлэх дэмжлэгийн хэм хэмжээний талаар дурдав (3.3 бүлэг). Цаашилбал улсын хөрөнгө оруулалтын хэрэгжилттэй холбогдох асуудлуудын талаар авч хэлэлцэнэ (3.4 бүлэг). Цаашилбал сургалт, сургалтын хөтөлбөр, хэрэгжүүлэх бүтэц зохион байгуулалтын талаар дурдсан (3.5 бүлэг).

3.1 Улсын хөрөнгө оруулалтын хөрөнгийн эх үүсвэр болон өнөөгийн байдал, тулгарч буй асуудал

Монгол улсын хөрөнгө оруулалт түүний хөрөнгийн эх үүсвэр болон тулгарч буй асуудлыг тодорхойлж, улсын төсвийн өнөөгийн байдлыг хураангуйлан, түүнчлэн гадаад өрийн нөхцөл байдал, Хөгжлийн албан ёсны тусламж (ХАЁТ)-аар үзүүлэх эдийн засгийн дэмжлэг болон зээл, Хөгжлийн банкны (DBM) төсвийн хянан зарцуулалт, концессын барих-шилжүүлэх (BT) нөхцөлтэй хөрөнгө оруулалт болон улсын төсвөөс төлөх төлбөр, аймаг зэрэг хөдөө орон нутаг дахь төсвийн хөрөнгө оруулалтын талаар дурьдана.

(1) Нэгдсэн төсвийн өнөөгийн байдал

Энэхүү дэд бүлэгт УИХ-аар батлагдсан 2017-2019 оны дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэл болон 2016 оны төсвийн тухай (төсвийн тодогтолыг багтаасан болно) мөн 2017 оны төсвийн тухай хуулинд үндэслэн Монгол улсын төсвийн өнөөгийн байдлын тухай авч хэлэлцэнэ.

1) Дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэл (MTFF)

MTFF 2017-2019 нь өмнөх үеийнхээс 6-н сараар хоцорч 11 дүгээр сарын 15-ны өдөр 2017 оны төсвийн хамтаар УИХ-аар батлагдсан. MTFF2017-2019-д тусгагдсан гол тоон үзүүлэлтүүдийг дараах хүснэгтэд нэгтгэв.

Хүснэгт 3.1.1 МТФФ2017-2019-д тутгагдсан эдийн засгийн гол үзүүлэлтүүд

Эдийн засгийн гол үзүүлэлтүүд	МТФФ	Төсөөлөл	
	2017	2018	2019
Дотоодын нийт бүтээгдэхүүний өсөлтийн хувь	3.0%	5.1%	7.1%
Хэрэглээний үнийн индекс	6.5%	7.6%	8.0%

Эх сурвалж : Монгол улсын засгийн газар материалд тулгуурлан ЖАЙКА-ийн судалгааны баг боловсруулав

ДНБ-ий өсөлтийн хувийг 2017 онд 3.0% хэмээн тогтоож түүнээс хойш 2018 онд 5.3%, 2019 онд 7.1% болж шат дараалан өснө гэж үзсэн. Хэрэглээний үнийн индекс нь мөн шат дараалсан өсөлтийг төсөөлж байгаа хэдий ч бага зэрэг дарсан байдалтай байна. Эдийн засгийн өсөлтийн үндэслэлийг энэхүү баримт бичигт тодорхой дурдаагүй бөгөөд Сангийн яам болон УИХ-ын байнгын хорооны гишүүдтэй уулзаж ярилцсан боловч тодорхой үндэслэлийг тогтоож чадаагүй болно

Төсвийн зарцуулалттай холбогдох тоон үзүүлэлтийг дараах хүснэгтэд харуулав.


Хүснэгт 3.1.2 МТФФ 2017-2019 дэхь төсвийн гол тоон үзүүлэлт

Төсвийн гол үзүүлэлт	МТФФ	төсөөлөл	
	2017	2018	2019
Орлого (тэр бум төг)	6,160.2	6,822.6	Орлого (тэр бум төг)
ДНБ-д эзлэх хувь	23.3%		ДНБ-д эзлэх хувь
Зарлага (тэр бум төг)	8,568.9	8,971.2	Зарлага (тэр бум төг)
ДНБ-д эзлэх хувь	32.3%		ДНБ-д эзлэх хувь
Төсвийн тэнцэл (тэр бум төг)	▲2,408.7	▲2,148.6	Төсвийн тэнцэл (тэр бум төг)
ДНБ-д эзлэх хувь	▲9.1%		ДНБ-д эзлэх хувь

Эх сурвалж : Монгол улсын Засгийн газар МТФФ2017-2019-д тулгуурлан ЖАЙКА-ийн судалгааны баг боловсруулав.

Сангийн яамны төсвийн бодлогын газрын мэргэжилтэн тайлбарлахдаа энэ удаагийн МТФФ-ын гол зарчим нь үе шаттайгаар төсвийг алдагдлыг бууруулах бөгөөд тухайлбал төсвийн тэнцлийн ДНБ-д эзлэх хувийг 2017 онд 9.1%, 2018 онд 7.5%, 2019 онд 5.5% болгон бууруулахаар зорьж байна. Хэдий тийм боловч зарлага, орлогын аль аль нь төсвийн тэнцлийн нийт дүнгээс хамааралтайгаар тогтоогдсон тул 2018 он болон 2019 оны төсөөллийг гаргасан тодорхой үндэслэл нь байхгүй. Төсвийн орлогын ДНБ-д эзлэх хувь нь бүгд 23%-тай байхаар зориж байгаа тул ДНБ-ий өсөлттэй дүйцэх эсвэл түүнээс илүү өсөлттэй байна хэмээн найдаж байна. Харин зарлагын хувьд ДНБ-д эзлэх хувь нь бага хувиар 32.3%, 31.3%, 29.2% болон жил бүр бууруулж байгаа хэдий ч зорилго болгож буй ДНБ-ий өсөлтийн хувь нь өндөр байгаа тул бодит дүнгээр нь авч үзвэл 2017 онд 87.7 их наяд төгрөг, 2018 онд 89.7 их наяд төгрөг, 2019 онд 93.2 их наяд төгрөг болгон өсгөсөн байна.

2012 оноос хойших улсын төсөв болон төсвийн алдагдлын шилжилтийг харвал (зураг 3.1.1) 2016 оны төсөвт засвар оруулсан үед тэлсэн төсвийн алдагдлыг энэ 3 жилд шат дараалалтайгаар бууруулах чиглэлтэй байгаа нь харагдаж байна.



Эх сурвалж: МТФФ 2016-2018, 2016 оны төсөвт өөрчлөлт оруулсан бичиг баримт, МТФФ2017-2019-д тулгуурлан судалгааны баг боловсруулав.

Зураг 3.1.1 МТФФ 2017-2019 Орлого зарлагын харьцуулалт

Урсгал зардал болон хөрөнгийн зардлын хуваарилалтыг доорх хүснэгтээр харуулав.


Хүснэгт 3.1.3 МТФФ 2017-2019 дэхь урсгал болон хөрөнгийн зардлын хуваарилалт

Нэгж : Тэрбум төг

Зардалын агуулга	2017 оны төсөв		2018 оны төсөөлөл		2019 оны төсөөлөл	
	Дүн	хувь	Дүн	Хувь	Дүн	Хувь
Урсгал зардал	7,085.0	82.7%	7,453.6	83.1%	7,775.9	83.5%
Хөрөнгийн зардал	1,483.9	17.3%	1,517.6	16.9%	1,540.6	16.5%

Эх сурвалж : МУ Засгийн газар МТФФ 2017-2019-д тулгуурлан ЖАЙКА-ийн судалгааны баг боловсруулав

Зардал түүний дотроос улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдэх дотоодын төслүүдийн хөрөнгийн эх үүсвэр болох төсвийн зардлын ДНБ-тэй харьцах харьцаа нь 2017 онд 17.3%, 2018 оны төсөөлөл нь 16.9 %, 2019 оных 16.5% байхаар тус тус тусгагдсан байна. Энэ нь мөн адил 2012 оноос хойших ДНБ-нд эзлэх хувийг 20%-д бариулж төсвийн тогтвортой байдлыг хангах чиглэлтэй байгаа нь харагдаж байна.




Эх сурвалж: МУ-ын Засгийн газрын МТФФ2017-2019-д тулгуурлан ЖАЙКА-ийн судалгааны баг боловсруулав

Зураг 3.1.2 Зарлага болон хөгжлийн төсвийн төлөв байдал, хувь

2) Орлого болон зарлагын төлөв байдал


2010 оноос хойших орлогын өөрчлөлтийг харахад татварын орлого нь 2010 оны жилийн эцсийн тайланд 2.7 их наяд байснаас 2017 онд төсөвт 5 их наяд төгрөг болж 185%-ын өсөлттэйгээр нэмэгдсэн байна. Ялангуяа нэмүү өртгийн албан татварын орлого нь 2010 онд 0.6 их наяд төгрөг байснаас 1.3 их наяд буюу 200%-р огцом өссөн. Мөн нийгмийн даатгалын орлогын хувьд ч 2010 онд 0.3 их наяд байсан бол 2017 оны төсөвт 1.1 их наяд буюу 340%-р өссөн байна.



Эх сурвалж: Сангийн яамны мэдээлэлд тулгуурлан ЖАЙКА-ийн судалгааны баг боловсруулав

Зураг 3.1.3 Орлогын төлөв байдал

2010 оноос хойших зарлагын өөрчлөлтийг авч үзэхэд урсгал зардал нь 2010 оны эцсээр 1.2 их наяд төгрөг байсан бол 2017 онд 3.0 их наяд буюу 250%-р өсч татварын орлогын өсөлтийг давсан байна. Улсаас олгох татаас болон даатгалын зардалын хувьд ч 2010 оны эцсээр 1.0 их наяд байсан бол 2017 онд 2.6 их наяд төгрөг, хөрөнгийн зардал нь 2010 оны эцсээр 0.6 их наяд төгрөгөөс 2017 оны эцсээр 1.5 их наяд буюу 251% -аар өсч аль аль нь урсгал зардалтай бараг адил хувиар өссөн байна. Инфляци болон валютын ханшийн нөлөө байгаа хэдий ч жил бүрийн зарлагын өсөлтийн хувь нь орлогоосоо өндөр байна. 2010 оны гүйцэтгэлээр 4230 тэрбум байсан хэдий ч 2017 оны төсвөөр 1 их наяд 34,57 тэрбум төгрөг буюу 3,181% аар нэмэгдсэн байгаа бөгөөд төсвийн зарлагатай ижил дүнтэй байна. Үүний шалтгаан нь 2012 оноос хойш хэвлэсэн бондын хүү нь сүүлийн үед хэвлэсэн бондоос 10% аар өндөр хүүтэй болж төсвийн дарамт болоод байгаа нь тодорхой харагдаж байна.



Эх сурвалж: Сангийн яамны мэдээлэлд тулгуурлан ЖАЙКА-ийн судалгааны баг боловсруулав

Зураг 3.1.4 Зарлагын төлөв байдал

3) Хөрөнгө оруулалтийн зардал

2017 оны төсөвт тусгагдсан хөрөнгө оруулалтын зардлыг дараах хүснэгтэд харуулав. 2016 оны төсвийн тодотголоор 2.4 их наяд төгрөг байсан хөрөнгийн зардал нь төсвийг хумих бодлогын хүрээнд 2017 оны төсвийн тухай хуулиар 1.5 их наяд төгрөг болон их хэмжээгээр буурсан ба үүнд 2016 онд болсон Улсын их хурлын сонгуулийн нөлөө бас байж болох юм. Түүнчлэн жил бүрийн төсөв түүн дотор улсын нэгдсэн төсвийн зарим хэсгийг төсөл тус бүрээр задлан олон нийтэд ил болгодог хэдий ч орон нутгийн төсвийн хувьд төсөл тус бүрээр гаргасан задаргааг нийтэд ил болгодоггүй. Мөн түүнчлэн улсын төсвөөс санхүүжих төслүүдийн жагсаалтанд 30 тэрбум төгрөгөөс давсан төр хувийн хэвшлийн хамтын ажиллагаагаар (PPP) хийгдэхээр төсөл ч орсон байсан

Хүснэгт 3.1.4 2017 оны төсөвт тусгагдсан хөрөнгийн зардлын санхүүжилтийн задаргаа

Нэгж: тэрбум төгрөг

Үзүүлэлт	Улсын төсөв	Хөгжлийн банк	Гадаадын зээл тусламж	Нийт
(1) Нэгдсэн төсөв				
(1.1) Дотоодын хөрөнгө оруулалт	*196	-	332	528
(1.2) Томоохон хэмжээний засварын ажил	*31	-	26	57
(1.3) Бусад	*23	-	65	88
(1.3) Бусад	**93	-	38	131
(1.4) Төслийн санхүүжилттай Авто замын сан	30	-	1	32
(1.4) Төслийн санхүүжилттай Авто замын сан	-	*173	-	173
(1.5) Стратегийн нөөц хөрөнгө				
(1.6) Төсвийн хөрөнгө оруулалт				
Улсын нэгдсэн төсвийн нийлбэр	375	173	462	1,009
(2) Орон нутгийн төсөв				
(2.1) Дотоодын хөрөнгө оруулалт	35	-	72	107
(2.2) Их засвар	1	-	-	1
(2.3) Бусад	-	-	2	2
(2.4) Төслийн санхүүжилттай Авто замын сан				
(2.4) Төслийн санхүүжилттай Авто замын сан	***263	-	-	-
(2.4.1) УБ хотын төсвийн хөрөнгө оруулалт	12	-	-	-
(2.4.1) УБ хот ОНХС татаас	62	-	-	-
(2.4.2) УБ хот ОНХС татаас	28	-	-	-
(2.4.3) Аймгуудын хөрөнгө оруулалт				
(2.4.4) Аймаг, ОНХС татаас				
(2) Орон нутгийн нэгдсэн төсвийн нийлбэр	401	-	73	475
Нийт (1) + (2)	776	173	535	1,484

Эх сурвалж: Сангийн яамны мэдээлэлд тулгуурлан ЖАЙКА-ийн судалгааны баг боловсруулав.

*2017 оны төсвийн тухай хуулинд төсөл тус бүрээр харуулсан байгаа үзүүлэлт


** 2017 оны төсвийн тухай хуулинд төсөл тус бүрээр дүнг харуулсан концессын хэсэг төслийг оруулсан

***Нийслэлийн иргэдийн төлөөлөгчдийн хурлийн шийдвэрт үндэслэн 2017 оны Улаанбаатар хотын төсвийн санхүүжилтээр санхүүжүүлэх төслийн жагдлаалтаас хамрагдсан болно.

4) Төсвийн тэнцлийн төлөв байдал

Зарлагын өсөлт нь орлогын өсөлтийг давж байгаа тухай 2)-т дурдсан ба орлого зарлагыг тэнцлийн төлөв байдал жилээс жилд муудаж байна.

Урсгал зарлага нь 2010 оны тэнцлээр 0.8 их наяд төгрөгийн ашигтай байсан бол 2016 оны төсвийн тодотголоор эсрэгээрээ 1.5 их наяд төгрөгийн алдагдалтай болж, 2017 оны төсөвт 1.1 их наяд төгрөгийн алдагдалтай байна. Мөн төсвийн тэнцлийн хувьд хөрөнгийн зарлагын өсөлт нөлөөлөн 2010 оны жилийн эцсийн тэнцлээр 0.04 их наяд төгрөгийн ашигтай байсан боловч 2011 оны жилийн эцсээр алдагдалтай гарч буурсан. 2016 оны төсвийн тодотголоор их хэмжээний алдагдалтай буюу 4.3 их наяд төгрөг, 2017 онд төсвийг хумих бодлого барьсан хэдий ч 2.4 их наяд төгрөгийн алдагдалтай гарч энэ нь урсгал орлогын 39%-тай дүйцэхүйц мөнгөн дүнгээр алдагдлыг бий болгож төсвийн хямрал хурц болж байна.



Эх сурвалж: Сангийн яамны мэдээлэл дээр тулгуурлан ЖАЙКА-ийн судалгааны баг боловсруулав.

Зураг 3.1.5 Урсгал болон Төсвийн тэнцлийн төлөв байдал

(2) Гадаад өрийн өнөөгийн байдал (Чингис бонд зэрэг төсвийн эх үүсвэрийн хэрэгжилт ба эргэн төлөлт)

1) Гадаад өрийн тухай

Засгийн газрын гадаад өр нь 1. Хандивлагч байгууллага болон гадаадын банкнаас авсан зээл 2. Гадаадын хөрөнгө оруулагч нарт хандан гаргасан өрийн бичиг 3. Төрийн өмчит аж ахуйн нэгж болон бусад аж ахуйн нэгжид гаргасан өрийн баталгаа гэж хуваагдана.

Судалгааны багийн олж авсан хэд хэдэн мэдээллийн эх сурвалжаас 2016 оны 12 сарын сүүлийг байдлаар засгийн газрын өрийн задаргааг нэгтгэн харахад засгийн газраас баталгаа гаргасан зээлийг оролцуулаад нийт өрийн үлдэгдэл нь 17.865 их наяд (6 тэр бум 878сая 200 мянган Ам Доллар) төгрөг байна. Энэ нь 2017 оны төсөв дэх ДНБ-ий

26.5 их наяд төгрөг (10.67 тэрбум ам.доллар)-ийн 64.5%, төсвийн нийт орлогыг 2.8-аар үржүүлсэнтэй тэнцэнэ.

Мөн, ойрын 5 жилийн дотор буюу 2021 оны сүүл хүртэл эргэн төлөлтийн хугацаа нь дуусах өндөр дүнтэй өрүүдийг доор дурьдав.

- (i) 2017оны 3 сард эргэн төлөх засгийн газрын баталгаатай Хөгжлийн банкны бонд 580 сая ам.доллар.
- (ii) 2018оны 1 сард эргэн төлөх Засгийн газраас гаргасан бонд 500 сая ам.доллар
- (iii) 2018 оны 6 сард эргэн төлөх Засгийн газрын бонд 1 тэр бум юан
- (iv) 2019 оны 9 сард эргэн төлөх Засгийн газрын баталгаатай Хөгжлийн банкны Кредит Свис банкнаас зээлсэн 300 сая ам.доллар.
- (v) 2020оны 5 сард эргэн төлөх Засгийн газрын баталгаатай Худалдаа хөгжлийн банкнаас гаргасан бонд 500 сая ам.доллар¹
- (vi) 2021 оны 4 сард эргэн төлөх Засгийн газраас гаргасан бонд 500 сая ам.доллар
- (vii) 2021 оны 3 сард эргэн төлөх Кредит Свис банкнаас зээлсэн 240 сая ам.доллар

¹ Монгол Улсын Засгийн газар бондын барьцаа байхгүй

Хүснэгт 3.1.5 Засгийн газрын өрийн задаргаа (2016 оны 9 сарын сүүлийн байдлаар)

Нэгж: тэр бум төг

Үзүүлэлт	USD (сая)	CNY (сая)	JPY (сая)	MNT-рүү шилжүүлсэн дун
(1) Хандивлагч болон гадны санхүүгийн байгууллагаас авсан зээл	725			1,800
(1.1) ADB	630			1,565
(1.2) JICA	438			1,089
(1.3) БНХАУ-ын экспорт импортын банк	422			1,048
(1.4) Дэлхийн банк	240			596
(1.5) Кредит свис банк	350			870
(1.6) бусад				
Нийт	2,805	-	-	6,968
(2) Гадаадын хөрөнгө оруулагчдад гаргасан Бонд				
(2.1) 2012 оны 12 сард гаргасан бонд (эргэн төлөлтийн хугацаа 2018 оны 1 сар)	500	-		1,242
	1,000	-		2,484
(2.2) 2012 оны 12 сард гаргасан бонд (эргэн төлөлтийн хугацаа 2022 оны 12 сар)	-	1,000		358
	500	-		1,242
(2.3) 2015 оны 6 сард гаргасан бонд (эргэн төлөлтийн хугацаа 2018 оны 6 сараар төлөвлөж байна)				
(2.4) 2016 оны 04 сард гаргасан бонд (эргэн төлөлтийн хугацаа 2021 оны 4 сар)				
Нийт	2,000	1,000	-	5,326
(3) Засгийн газраас аж ахуйн нэгжид гаргасан өрийн баталгаа	1,042		30	3,322
(3.1) Хөгжлийн банк	87			215
(3.2) МИАТ компани	5			13
(3.3) Эрдэнэс Монгол компани	500			1,242
(3.4) Худалдаа хөгжлийн банк (TDB)				
Нийт	1,634	-	30	4,793
Нийт (1) + (2) + (3)	6,439	1,000	30	17,087

Эх сурвалж: Сангийн яам болон SGX-ын мэдээлэлд тулгуурлан ЖАЙКА-ийн судалгааны баг боловсруулав

*2017 оны 3 сард эргэн төлөх 580 сая ам.доллар болон самурай бондын 30 тэр бум иэнийг багтаасан.

2) Бондын арилжаа

Монгол Улсын Засгийн газар нь Сингапурын хөрөнгийн биржид бонд арилжих бүртгэлтэй. 2012 оны 11 GLOBAL MEDIUM TERM NOTE PROGRAM –аар 5 тэрбум ам.долларын 2015 оны 6 сард мөн адил GLOBAL MEDIUM TERM NOTE PROGRAM-ын хүрээнд 5 тэрбум ам.доллар арилжих эрхийг авсан. Эхний бондын эрхээр 2012 оны 12 сард 5 жилийн эргэн төлөлтийн хугацаатай 5 тэрбум ам.долларын бонд, 10 жилийн эргэн төлөлтийн хугацаатай 1 тэрбум ам.долларын бондыг тус тус гаргасан бол дараагийн эрхийн хүрээнд 2015 оны 6 сард гурван

жилийн эргэн төлөлтийн хугацаатай 1 тэрбум юаны бонд, 2016 оны 4 сард таван жилийн эргэн төлөлттэй 500 сая ам.долларын бондыг гаргасан. Эдгээр бонд нь өндөр хүүтэй бөгөөд 4.125%-10.875% тул улсын төсөвт хүндээр тусах шалтгаан болж байна.

Улмаар Худалдаа хөгжлийн банк болон Хөгжлийн банк нь Засгийн газрын баталгаатайгаар тус бүр 500 сая ам.доллар болон 580 сая ам.долларыг гаргасан байна. Хөгжлийн банкны эргэн төлөлтийн хугацаа нь 2017 оны 3 сар болно. Түүнчлэн Ж.Эрдэнэбат ерөнхий сайд 2017 оны 1 сард ард түмэндээ хандан хэлэхдээ энэхүү бондыг эргэн төлөлтийг хийхэд шаардлагатай санхүүгийн эх үүсвэр бий гэсэн бол энэ удаагийн тайланг нэгтгэж буй энэ цаг мөчийг хүртэл ямар нэгэн санхүүгийн эх үүсвэр тодорхой болоогүй байна.

Хүснэгт 3.1.6 Сигапурын бирж дэх арилжсан бондын задаргаа

Ангилал	Арилжсан он сар	Эргэн төлөлт	Хүү	валют	Дүн
Засгийн газраас гаргасан бонд	2012.12	2018.1	4.125%	USD	500,000,000
	2012.12	2022.12	5.125%	USD	1,000,000,000
	2015.6	2018.6 төлөвлөгөө	7.50%	CNY	1,000,000,000
	2016.4	2021.4	10.875%	USD	500,000,000
Засгийн газрын баталгаатай Хөгжлийн банкны бонд	2012.3	2017.3	5.75%	USD	580,000,000
Засгийн газрын баталгаатай ХХБанкны бонд	2015.5	2020.5	9.375%	USD	500,000,000

Эх сурвалж: Сингапурын хөрөнгийн биржийн мэдээлэлээр ЖАЙКА-ийн судалгааны баг боловсруулав.

(3) ХАЁТ-аар үзүүлэх эдийн засгийн дэмжлэг болон зээлийн тухай

Сангийн яамнаас авсан материалд 2017 оны төсөв дэх ХАЁТ-ын зээл болон буцалтгүй тусламжийн дэмжлэгийн тухай доорх байдлаар туссан байна. Хятад улсын хөнгөлөлттэй зээл болон буцалтгүй тусламжийн аль аль нь эхний байранд байгаа бөгөөд мөнгөн дүн нь зээл 265 тэрбум төгрөг (107 сая ам.дол), буцалтгүй тусламж 42 тэрбум төгрөг (17сая ам.дол) байна. Хөнгөлөлттэй зээлийг салбараар нь 1) Зам тээвэр 2) Эрчим хүч, уул уурхай 3) Боловсрол хэмээн эрэмбэлсэн бол буцалтгүй тусламжийн хувьд 1) Боловсрол 2) Нийгмийн халамж 3) Байгаль орчин хэмээн эрэмбэлсэн.

Нөгөөтэйгүүр Япон улсын хөнгөлөлттэй зээлийн төсөл болох Улаанбаатар хотын шинэ олон улсын онгоцны буудал барих төсөл нь хамгийн том хэмжээний тусламж байсан бөгөөд 2017 оны төсөвт 160 тэрбум төгрөг (64 сая ам.дол) тусгасан байна. Түүний дараа БНХАУ-ын хөнгөлөлттэй зээлийн “Аймгуудын газар тариалангийн бүтээгдэхүүний нийлүүлэлт болон ядуурлыг үгүй болгох төсөл” нь орсон бөгөөд 2017 оны төсөвт 40 тэрбум төгрөг (16 сая ам.дол) суусан байна.

Хүснэгт 3.1.7 2017 оны төсөв дэхь гадаадын зээл тусламж

нэгж : тэрбум төгрөг

Үзүүлэлт	Төг	Ам.дол (сая)
(1) Зээлдэгч орон		
(1.1) БНХАУ	265	107
(1.2) ЖАЙКА	194	78
(1.3) АХБ	143	58
(1.4) Дэлхийн банк	69	28
(1.5) Бусад	99	40
Нийт	770	310
(2) Буцалтгүй тусламж		
(2.1) БНХАУ	42	17
(2.2) АХБ	22	9
(2.3) Өмнөд Солонгос	16	7
(2.4) Кувейт	16	6
(2.5) Дэлхийн банк	15	6
(2.6) НҮБХХ	10	4
(2.7) Бусад	24	10
Нийт	145	59
Нийлбэр (1) + (2)	916	369

Эх сурвалж: Сангийн яамны мэдээлэлд тулгуурлан ЖАЙКА-ийн судалгааны баг боловсруулав.

Тайлбар: тооцоололд, зарлагын суурь хэмжээг харуулсан болно.

(4) Хөгжлийн банкны төслийн төлөвлөлт, хэрэгжилтийн явц болон удирдлага хяналтын өнөөгийн байдал ба тулгарч буй асуудлууд

Хөгжлийн банк нь Хөгжлийн банкны тухай хуулийн дагуу байгуулагдсан улсын банк болно. Хөгжлийн банкны тухай хуулийн 21.1 дүгээр зүйлд УИХ нь Хөгжлийн банкны өөрийн хөрөнгөд оруулах Засгийн газрын хувь болон хэмжээг батлаж, мөн Засгийн

газраас гаргах зээлийн баталгааны дээд хэмжээг тогтоох эрхтэй. Засгийн газар нь УИХ-ын тогтоолын дагуу зээлийн баталгааг Хөгжлийн банкинд гаргана. Гэвч Хөгжлийн банк нь Монгол банк болон Санхүүгийн зохицуулах хороо (FRC)-ны хяналтанд байдаггүй².

Мөн дээрх хуулийн 8-р зүйлийн дагуу томоохон хэмжээний төсөл хөтөлбөрүүдийн санхүүжилтийг УИХ-аар баталсан төсөл хөтөлбөрүүдийн жагсаалтын дагуу зээлийн хороо шийдвэрийг гаргах ба хөрөнгө оруулалтыг хийх төсөл хөтөлбөр бүрт Засгийн газраас баталгааг гаргасны үндсэн дээр санхүүжүүлнэ (мөн хуулийн 9.1). Мөн Улсын төсвөөс санхүүгийн дэмжлэг авах боломжтойгоос (9.2-р зүйл) гадна Хөгжлийн банкны татан төвлөрүүлсэн болон Засгийн газрын баталгаа гаргаснаас бусад хөрөнгийн эх үүсвэрээр санхүүжүүлэх төсөл, хөтөлбөрийн санхүүжилтыг Хөгжлийн банкны Төлөөлөн удирдах зөвлөл шийдэх боломжтой (9.3-р зүйл).

Гэвч Засгийн газрын ажлын хэсгийн судалгаагаар УИХ-аар батлуулалгүйгээр олгосон Монголын хөрөнгийн бирж болон орон сууцны барилгын санхүүжилт зэрэг зарим нэг төслийн санхүүжил, мөн гадаад валютын өрийн ханшийн эрсдлийн хяналтын хангалтгүй байдал зэрэг үйл ажиллагааны доголдол нь томоохон асуудал болж өмнөх тэргүүн нь баривчлагдсан.

Хөгжлийн банкны бас нэгэн асуудал бол Засгийн газраас баталгааг гаргасан бондыг УИХ-ын тогтоол гараагүй байхад төсвөөс гадуур зарлагдах явдал юм. Тиймд ERP-д цаашид “Хөгжлийн банк болон улсын төсвийн холбоо хамааралыг нэмэгдүүлж, эрсдлийг бууруулах, хөгжлийн банкны засаглал ба түүний ил тод байдал, мэдээлэх тайлагнах явцыг сайжруулах, үйл ажиллааны хүрээг өргөжүүлэх, бие даасан байдлыг хангах, Хөгжлийн банкны тухай хуулийг шинэчлэх, байгууллагын бүтцийг дахин шинэчлэх ” зэрэг нь заагдсан байна. Хөгжлийн банкны хуулийг 2017 оны 2 дугаар сарын 10-ны өдрийн УИХ-ын шийдвэрээр шинэчилсэн бөгөөд шинэчлэгдсэн хуулийн агуулгыг эцсийн байдлаар хараахан танилцаагүй байна. Хуулийн төсөлд Засгийн газрын тогтоосон аргачлалын дагуу Монгол банкнаас хяналт тавина гэсэн өөрчлөлтийг оруулсан байна.

Түүнчлэн УИХ-аас баталсан Хөгжлийн банкны эх үүсвэртэй төсвийн хөрөнгө оруулалтын төслөл хөтөлбөрүүдийг доорх хүснэгтээр харуулав. Эдгээр төсөл нь улсын төсвөөс Хөгжлийн банкаар дамжин санхүүжих ба 2017 оны төсөвт 119 төсөл тусгагдсан. 119 төслийн дотроос шинэ олон улсын нисэх онгоцны буудлыг холбосон авто замын төслийг оруулаад нийт 6 төслийн хөрөнгө оруулалтын мөнгөн дүн нь 30 тэр бум төгрөгийг давсан байгаа тул улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөр т тусгагдах (PIP) төсөл хэмээн үзэж байна. Гэтэл Хөгжлийн банктай уулзаж ярилцахад 2017 оны төсөвт суусан төсөл хөтөлбөрүүдийг улсын төсвөөс эх үүсвэртэй төсвийн хөрөнгө

² Daiwa Institute of Research Inc. 2014 “ 2013 оны Financial Services Agency: Монгол улсын санхүүгийн салбарын дэд бүтцийн суурь судалгаа ” эцсийн тайлан.

оруулалтын төсөл рүү шилжүүлэх төлөвлөгөөтэй болохыг мэдсэн. Энэ тухай Сангийн яамнаас мөн баталгаажуулсан ба эцсийн дүндээ Хөгжлийн банкаар дамжуулалгүй улсын төсвөөс шууд санхүүжүүлэх байх магадлалтай байна.

Хүснэгт 3.1.8 Хөгжлийн банкнаас хийнсэн хөрөнгө оруулалт

Нэгж: тэрбум төгрөг

Үзүүлэлт	Төслийн тоо	Жилийн нийт дүн	Төслийн нийт дүн
2015 оны хоёр дахь төсвийн тодотголын	214	452,351.0	2,112,885.9
2016 оны төсвийн тодотголын	167	367,059.1	1,593,149.0
2017 төсөв	119	172,794.9	1,012,951.7

Эх сурвалж: Сангийн яамны мэдээлэлд тулгуурлан ЖАЙКА-ийн судалгааны баг боловсруулав.

(5) Хөгжлийн банкны санхүүгийн байдал

Хүснэгт 3.1.9- нь 2015 оны 12 сарын 1-өдрийн байдлаар гаргасан санхүүгийн байдлыг үзүүлсэн болно. Хөгжлийн банкны энэхүү хүснэгт нь Pricewaterhouse Cooper Audit ХХК-гийн зүгээс бүх үзүүлэлтийн хувьд зөв бодитой гэсэн аудитын дүгнэлтийг авсан. Тэрхүү санхүүгийн байдлын тайлангаас харахад банкны нийт хөрөнгийн хэмжээ нь 6.1 их наяд төгрөг (2.4 тэр бум ам.дол) ба түүний 80%-аас дээш буюу 4.5 их наяд төгрөг (2 тэрбум ам.дол) –ийг зээлд зарцуулсан³. Нийт дүрмийн сангийн 2.874 тэрбум төгрөг буюу (116 сая ам.доллар) нь нийт хөрөнгийн 4.7% эзэлж байгаа нь Худалдаа хөгжлийн банк, Хаан банк, Голомт банк, зэрэг арилжааны банкнуудын цэвэр хөрөнгийн хэмжээ харилцуулхад дундаас доогуур байгаа

³ Хөгжлийн банкны тухай хуулийн 24-т өөрийн хөрөнгийг 50 дахин нэмэгдүүлснээс хэтрэхгүй хөрөнгө оруулалт зээлийн баталгааг гаргах боломжтой

Хүснэгт 3.1.9 2015 оны Хөгжлийн банкны санхүүгийн байдлын тайлан
(авсан болон олгосон зээлийн харьцуулсан хүснэгт)

нэгж : тэрбум төг

Үзүүлэлт	MNT(төг)	USD(сая)
Хөрөнгө		
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	700	281
Банкны хадгаламж	154	62
Богино хугацааны хөрөнгө оруулалт	131	53
Зээл	4,909	1,976
Бусад	176	71
Нийт хөрөнгө	6,070	2,444
Өр төлбөр		
Бусад банкнаас авсан зээл	436	175
Өрийн бичиг	1,727	695
Бусдаас авсан зээл	3,567	1,436
Бусад	54	22
Нийт өр төлбөр	5,783	2,328
Хөрөнгө		
Үндсэн хөрөнгө	245	99
Бусад	42	17
Нийт хөрөнгө	287	116
Өр төлбөр ба хөрөнгийн нийлбэр	6,070	2,444

Эх сурвалж: PwC аудитын санхүүгийн тайлангийн хүснэгтээс ЖАЙКА судалгааны баг боловсруулав.

Дараагийн хүснэгтээс гаргасан зээлийг салбар тус бүрээр нь харвал Авто залын салбар нь 1.4 их наяд төгрөг (550 сая ам.дол) буюу нийт зээлийн 27%-ийг эзэлж байна. Авто замаас гадна улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих төсөл хөтөлбөрийн ихэнх нь төмөр зам, цахилгаан станц зэрэг дэд бүтэцтэй холбоотой төсөл хөтөлбөрүүд бөгөөд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих төсөлд зориулсан зээлийн 94%-ыг, бусад зээлийг оролцуулсан нийт зээлийн талаас илүү хувийг эзэлж байна. Нөгөөтэйгүүр хувийн аж ахуйн нэгжид олгосон зээлийн ихэнх нь үйлдвэрлэл, уул уурхайн салбарт бөгөөд хувид олгох зээлийн 80%-ыг эзэлж байна.

Мөн зээлийн 56% нь 2018 оныг хүртэл Засгийн газраас төлөгдөх төсвийг хөрөнгө оруулалттай төсөл хөтөлбөрийн санхүүжилт ба үлдсэн нь хувийн аж ахуйн нэгжид олгосон зээл юм. Нийт гаргасан зээлийн мөнгөн дүнгийн 12% буюу 586 тэр бум төгрөгийн эргэн төлөлт дээр асуудалтай байгаа бөгөөд чанаргүй зээлийн ангилалд ороод байна. Төсвийн хөрөнгө оруулалттай төсөл рүү шилжүүлсэн санхүүжилтын хувьд зарчмын хувьд Засгийн газраас эргүүлэн төлүүлэх боломжтой тул зөвхөн 7% нь чанаргүй зээлд ангилагдаж байна. Нөгөөтэйгүүр хувийн аж ахуйн нэгжид олгосон зээлийн 18% нь чанаргүй зээлд орсон. Мөн түүнчлэн энэхүү зээлийн дотроос 18% нь зээлийн үнэ цэнэ бууралтын зардлыг суулгасан байна. Монголын хувийн арилжааны банкыг тэргүүлэгч Худалдаа хөгжлийн банк болон Хаан банкны чанаргүй зээл нь

тухайн банкны гаргасан нийт зээлийн дүнгийн 10%-аас доогуур байгаа тул тухайн үеийн Хөгжлийн банкны менежментэд асуудал талууд харагдана.

Улмаар эргэн төлөгдөх боломжгүй зээлийн чанар бууралтын нөөц хөрөнгөд 77.3тэр бум төгрөг төсөвлөгдсөн боловч үүнд засгийн газраас эргэн төлөгдөх хэсгийн нөөц хөрөнгө нь бараг суугаагүй бөгөөд ихэнх нь буюу 75.6 тэр бум төгрөгийг хувийн аж ахуйн нэгжид гаргасан зээлийн чанар бууралтын нөөц хөрөнгөөр төсөвлөсөн байна.

Хүснэгт 3.1.10 2015 оны Хөгжлийн банкны санхүүгийн байдлын тайлан

нэгж : тэр бум төг

Үзүүлэлт	Улсын төсвөөс эргэн төлөлт хийгдэх зээл	Хувийн аж ахуйн нэгжийн эргэн төлөх зээл	Нийт	Хувь
(1) Эргэн төлөлтийн хугацаан дотроо байгаа				
(1.1) Авто зам	1,186	-	1,186	
(1.2) Төмөр зам	443	-	443	
(1.3) Улсаас хэрэгжүүлж буй төсөл	406	-	406	
(1.4) Цахилгаан станц	365	23	388	
(1.5) Үйлдвэрлэл	9	815	823	
(1.6) Уул уурхай	6	601	607	
(1.7) Бусад	149	96	246	
Нийт	2,564	1,535	4,099	82%
(2) Эргэн төлөлтийн хугацаа дууссан ч элэгдэлгүй	-	302	302	
(2.1) Барилгын салбар				
Нийт	-	302	302	6%
(3) чанаргүй зээл				
(3.1) авто зам	180	-	180	
(3.2) үйлдвэрлэл	-	370	370	
(3.3) бусад	-	36	36	
Нийт	180	406	586	12%
Зээлийн чанар бууралтын нөөц	2,744	2,243	4,987	100%
Нийт	-2	-76	-77	-2%
Нийт	2,742	2,167	4,909	98%

Эх сурвалж: PwC аудитын санхүүгийн тайлангаас ЖАЙКА-ийн судалгааны баг боловсруулав

Мөн Хөгжлийн банкны хөрөнгийн эх үүсвэр нь хүснэгт 3.1.11-ын дагуу Өрийн бичиг (бонд), Засгийн газар болон гадаадын санхүүгийн байгууллагаас авсан зээлээс бүрдэнэ. Өнөөг хүртэл гаргасан бонд нь SGX дээр гаргасан 2017оны 3 сард эргэн төлөх 580 сая ам.долларын Засгийн газрын баталгаатай бонд болон Японд гаргасан 30 тэрбум иений самүрай бонд болно. Засгийн газраас 2.5 их наяд төгрөлийг зээлсэн ба дээрх хүснэгтийн улсын төсвөөс эргэн төлөгдөх 2.7 их наяд төгрөгт хараахан хүрээгүй. Бонд болон авсан зээлийн аль алиных нь талаас илүү хэсгийн эргэн төлөлтийн хугацаа нь 5 жил дотор байгаа төдийгүй хүү нь харьцангуй өндөр буюу 5%-аас дээш тул цаашид

урт хугацааны бага хүүтэй хөрөнгийг татах нь тогтвортой үйл үйл ажиллагааг үргэлжлүүлэхэд хэрэгтэй юм.

Хүснэгт 3.1.11 2015 оны Хөгжлийн банкны бонд болон зээлдэж авсан мөнгөний задаргаа

單位：十億 MNT

Ангилал	Үзүүлэлт	Эргэн төлөх хугацаа	Хүү(%)	Валютын үндсэн зээл	Нийт	Бусад болзол нөлөө гэх мэт
(1) Бонд	(1.1) SGX-д гаргасан бонд	2017он	5.75	580 сая ам.доллар	1,175	Үндсэн зээлийн хүү нь засгийн газрын баталгаатай
	(1.2) Самүрай бонд	2024 он	1.52	30 тэр бум иен	404	Үндсэн зээлийн хүү нь засгийн газрын баталгаатай, Үндсэн зээл болон 5 жил хагасын хүү нь JVIC-ийн баталгаатай
	(1.3)					
	Нийт бондын дүн					1,727
(2) Буцаан авсан зээл	(2.1) Засгийн газраас авсан зээл	1/3:2018 он 2/3:2022 он	4.7917	(Төгрөг)	2,564	Чигис бондноос хэрэглэсэн
	(2.2) Синдикаци зээл	2017 он болон 2019 он	LIBOR +4.250 ~4.375	300 сая ам.доллар	598	Кредит свис , Мицүбиши сүмитомо, Хятад, Тайваны 4 банкнаас бүрдсэн Синдикаци зээл. Монголын засгийн газрын баталгаатай.
	(2.3) Улсын хөгжлийн банк(CDB)	2022 он	6.0	149.5сая ам.доллар	302	Хятдын төрийн банк. Монголын засгийн газрын баталгаатай
	(2.4) Олон улсын хөрөнгө оруулалтын банк (ИВ)	2022 он	EURIBOR +6.0	20 сая евро	43	ИВ нь хуучнаар ЗХУын зүүн талын орнуудын бий болгосон банк. Монголын засгийн газрын баталгаатай
	(2.5) ОХУ хөгжлийн банк (VEB)	2023 он	3.2	20сая ам.доллар	35	VEB нь ОХУ төрийн банк
	(2.6)Комерц банк		1.9-2.3	11 сая евро	24	
Бусдаас зээлсэн нийт дүн					3,567	
Нийт					5,294	

Эх сурвалж: PwC-ийн тайлангаас ЖАЙКА-ийн судалгааны баг боловсруулав

(6) Төр, хувийн хэвшлийн түншлэлийн төсөл хөтөлбөрийн төлөвлөгөө, хэрэгжилтийн явц болон хэрэгжүүлэлтийн бүтэц, тулгарч буй асуудлууд

2010 оноос хэрэгжсэн Концессын тухай хуулинд төрийн өмчийн болон орон нутгийн өмч хөрөнгийн эрх ашгийг хөрөнгө оруулагчид олгох үеийн харилцааг тогтоосон. Тус хуулийн 4.1-т Барих-Ашиглах-шилжүүлэх (BOT) төрөл болон Барих-шилжүүлэх (BT)

төрөл зэрэг нийт 7 концессын төрлийг тодорхойлсон ба 2013 онд шинэчлэгдсэн хамгийн сүүлийн концессын жагсаалд орсон 125 төсөл нь хэд хэдэн төрлөөр хэрэгжихээр бичигдсэн байдаг.

Мөн дээрх хуулиар тухайн төслийн гүйцэтгэх хувийн аж ахуйн нэгжийг шийдэхдээ уралдаант шалгаруулалтын аргаар (11-р зүйл) болон шууд гэрээний аргаар (17-р зүйл) шийднэ хэмээн заасан. Дээр дурьдсан жагсаалтад орсон төсөл хөтөлбөрүүдийн 6 нь шууд гэрээгээр үлдсэн нь сонгон шалгаруулалтын аргаар шийдвэрлэгдсэн.

2015 оны 2 сард шинэчлэгдсэн төсвийн тухай хуулийн 28.10-т төсвийн хөрөнгө оруулалт (PIF)-нд концессын гэрээг багтаахаар болсон.

Нөгөөтэйгүүр Барих-шилжүүлэх (BT) концессын төрлөөр хийгдэх гэрээ нь “Тайлан тэнцлээс гадуурх хүлээсэн үүрэг (өрийн баталгаа)” – үүсэхэд ихээхэн нөлөө үзүүлдэг тухай БНХАУ-ын орон нутгийн захиргааны жишээ дээр ч анхааруулж байна⁴. Монгол улсад ч төсвийн сахилга батын талаас өрийн эрсдэл байгаа тул өрийн удирдлагын тухай хууль болон Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн дагуу 2016 оны 8 сарын 17-ны өдрийн Засгийн газрын 37-р тогтоол “Концессын төслүүдийн талаар авах арга хэмжээ”-нд Барих-шилжүүлэх (BT) концессын төрлөөр хийгдэх төсөл хөтөлбөрүүдийг үндэсэндээ царцааж, дахин 2016 оны 9 сарын 9-ны өдрийн УИХ-ын 47-р тогтоолоор “Улсын төсөв болон Хөгжлийн банкнаас эргэн төлөгдөх нөхцөлтэй хөрөнгө оруулалтын төслийн санхүүжигдээгүй үлдэгдэл, Барих-шилжүүлэх концессын гэрээний эргэн төлөлт, шүүхийн шийдвэрээр олгох санхүүжилтыг 2017 оноос векселиэр баталгаажуулахгүй байх” хэмээн шийдсэн. Энэхүү тогтоолоор концессын гэрээнээс үүдэлтэй өрийн нэмэгдэлтийг зогсоож чадсан.

⁴ Gomi Youko (2014 он) “Дараагийн онцлох БНХАУ-ын орон нутгийн захиргааны өр BT” Олон улсын валютын судалгааны хүрээлэн олон улсын санхүүгийн сэдвүүд No.250 2014 он 2 сар 19 өдөр https://www.iima.or.jp/Docs/topics/2014/250_j.pdf (2017он 2 сар16)

Хүснэгт 3.1.12 2016 оны Засгийн газрын 37-р тогтоолын агуулга

Агуулга	
1	<p>Дараах арга хэмжээ авахыг Үндэсний хөгжлийн газар, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт үүрэг болгосугай</p> <p>1) концессын зүйлийн жагсаалтад “барих-шилжүүлэх” төрлөөр хэрэгжүүлэхээр тусгасан улсын болон орон нутгийн төсвөөс эргэн төлөх нөхцөлтэй концессын гэрээг 2018 оны төсвийн жил хүртэл аливаа этгээдтэй байгуулахгүй байх;</p> <p>2) улсын болон орон нутгийн төсвөөс эргэн төлөх нөхцөлтэй, концессын гэрээ нь хүчин төгөлдөр болоогүй төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхгүй байх;</p> <p>3) концессын гэрээ байгуулах замаар улсын болон орон нутгийн төсвөөс эргэн төлөх үүрэг шинээр үүсгэхгүй байх;</p> <p>4) концессын гэрээ байгуулсан боловч ажил нь эхлээгүй гэрээний үйлчлэлийг зохих журмын дагуу зогсоох;</p> <p>5) шинээр концессын гэрээний дагуу хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг улсын болон орон нутгийн төсвөөс эргэн төлөх үүрэг хүлээхгүйгээр, улсын болон орон нутгийн төсөвт төлбөрийн ачаалал үүсгэхгүйгээр концессын бусад төрлөөр хэрэгжүүлж ажиллах.</p>
2	<p>Орон нутгийн төсвөөс эргэн төлөх нөхцөлтэйгээр аливаа төсөл, арга хэмжээг концессын зүйлийн жагсаалтад нэмж тусгахгүй байхыг аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд зөвлөсүгэй.</p>
3	<p>Засгийн газраас улсын эдийн засаг, нийгмийн хөгжилд чухал гэж үзэн тэргүүлэх ач холбогдол өгч байгаа 2020 он хүртэл төсөвт хүндрэл учруулахгүй концессын зарим төслийг “барих-шилжүүлэх” төрлөөр хэрэгжүүлэхэд энэ тогтоолын 1 дүгээр зүйл хамаарахгүй.</p>
4	<p>Энэ тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Сангийн сайд Б.Чойжилсүрэн, Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Ж.Мөнхбат нарт үүрэг болгосугай.</p>

Эх сурвалж: Засгийн газрын 37-р тогтоол

(7) “Барих шилжүүлэх” концессын төрлөөр хийгдэх хөрөнгө оруулалт

Тиймд 2016 оны төсвийн тодотголоор Концессын гэрээгээр хийгдэх улсын төсвийн хөрөнгө оруулалттай төслийн жагсаалтыг оруулдаг болсон. Доорх 3.1.12 хүснэгтэнд тэдгээр төслүүдийг нэгтгэсэн ба төсвийн хөрөнгө оруулалтаар гүйцэтгэх нь зүйтэй төслүүд ч орсон байна. Мөн түүнчлэн 2016 оны төсвийн тодотголд суусан (1.1)-ийн Олон улсын авто замын төсөл нь 2017 оны төсөвт Улсын төсвөөс болон Хөгжлийн банкнаас эх үүсвэртэй улсын хөрөнгө оруулалттай төсвийн жагсаалтад тусгагдаагүй байна. Сангийн яам нь хувийн аж ахуйн нэгжүүд нь барилгын ажлыг үргэлжлүүлж байгаа ба 2017 оны төсвийн төлөвлөлтийн үед хасагдсан тул улсын төсвөөс санхүүжилт хийхгүй хэмээн тайлбарласан.

Хүснэгт 3.1.13 Төсвийн хөрөнгө оруулалттай концесын төслүүд

Нэгж: тэрбум төгрөг

Үзүүлэлт	Дуусах он	Тухайн жилийн нийт дүн	Төслийн нийт дүн
(1) 2016 оны төсвийн тодотгол			
(1.1) Сэлэнгэ аймгийн хүдэр-Сүхбаатар чиглэлийн олон улсын хатуу хучилттай зам	2019 он	57,163.3	95,272.2
(1.2) Мандал сум 15.8 км хатуу хучилттай зам	2016 он	13,141.7	13,141.7
(1.3) Алтанбулаг сумын цэвэр усны байгууламжийн их засвар	2016 он	400.0	400.0
2016 оны төсвийн тодотголын нийлбэр		70,705.0	108,813.9
(2) 2017 оны төсөв			
(2.1) Алтай- Дарви чиглэлийн хатуу хучилттай 165 км авто зам	2019 он	16,118.0	176,405.4
(2.2) Алтай- Дарви чиглэлийн хатуу хучилттай 98 км авто зам	2019 он	10,517.1	117,042.0
(2.3) УБ Баянзүрх дүүргийн сургуулийн барилгын өргөтгөл	2017 он	10,787.0	10,787.0
(2.4) Бусад 9 төсөл	-	34,096.5	47,879.5
2017 оны төсвийн нийт дүн		71,518.6	352,113.9

Эх сурвалж: Сангийн яамны мэдээллээр ЖАЙКА судалгааны баг боловсруулав

(8) Орон нутаг (аймаг гэх мэт) дахь төсвийн хөрөнгө оруулалт

1) 2017оны төсвийн төсөл дэх орон нутгийн төсвийн тухай.

2017 оны төсвийн төсөлд тусгагдсан орон нутгийн төсвийг доорх хүснэгтээр харуулав.

Хүснэгт 3.1.14 2017 оны аймаг тус бүрийн төсвийн төсөл

(Нэгж : сая төг)

Аймаг	Орлого	Зарлага	Зарлага>Орлого үеийн улсын төсвөөс гаргах нөхөн олговор	ОНХС-аас санхүүжих
Архангай	6,027.8	18,038.1	12,010.3	634.1
Баян Өлгий	6,658.0	17,037.3	10,379.3	447.5
Баянхонгор	5,612.2	16,842.3	11,230.1	742.3
Булган	17,969.0	16,408.6	0.0	609.6
Говь-Алтай	5,426.8	13,731.6	8,304.8	609.2
Дорноговь	16,049.3	11,872.1	0.0	345.4
Дорнод	13,415.3	16,079.0	2,663.7	290.0
Дундговь	4,620.4	10,441.8	5,821.5	357.1
Завхан	6,613.1	16,119.4	9,506.3	436.9
Өвөрхангай	8,507.4	18,162.7	9,655.3	678.9
Өмнө-Говь	58,373.5	17,943.9	0.0	448.0
Сүхбаатар	7,054.4	12,259.2	5,204.8	541.4
Сэлэнгэ	14,316.6	17,566.4	3,249.8	732.5
Төв	11,576.4	19,344.6	7,768.2	637.7
Увс	6,148.2	17,365.4	11,217.2	548.2
Ховд	7,945.9	15,825.1	7,879.2	697.3
Хөвсгөл	8,378.2	25,150.9	16,772.7	1,159.4
Хэнтий	7,218.6	15,797.7	8,579.1	607.1
Дархан-Уул	15,053.6	14,228.7	0.0	1,285.9
Улаанбаатар	549,151.3	273,676.7	0.0	322.2
Орхон	37,661.0	15,054.8	0.0	1,016.3
Говь Сүмбэр	4,287.4	3,786.9	0.0	171.6
Нийт	818,064.4	602,733.2	130,242.3	13,318.6

Эх сурвалж : Сангийн яам 2017 оны төсвийн төсөлд тулгуурлан ЖАЙКА-ийн судалгааны баг боловсруулав

Төсвийн тухай хуулиар нийслэл, дүүрэг, аймаг, сумд нь доорх санхүүгийн эх үүсвэрээс үйл ажиллагаагаа явуулна.

- Нийслэл, дүүрэг, аймаг, сумдын татвар болон татварын бус орлого
- Улсын төсвөөс хуваарилагдах орлого
- Улсын төсвөөс өгөх төсвийн дэмжлэг

Мөн төсвийн тухай хуулинд орон нутгийн төсөв нь түүнийг давсан зарлага гаргахгүйн тулд төлөвлөлт, зөвшөөрөл, хэрэгжүүлэлтийг баримтлана хэмээн заасан байдаг. Нөгөөтэйгүүр орон нутгийн төсөв нь өр үүсгэх мөн аливаа баталгааг гаргах нь хориотой хэдий ч өрийн удирдлагын тухай хууль болон төсвийн тухайн хуулиар тухайн төсвийн жил дотроо өөрийн дээд байгууллагаасаа богино хугацааны зээл авах нь зөвшөөрөгдсөн байдаг.

Орлого нь илүү гарсан аймгийн хувьд төсвийн тухай хуулийн дагуу илүү гарсан орлогын 30%-ыг нэгдсэн төсөвт нийлүүлж, үлдсэн 70 %-ийг тухайн аймагт үлдээдэг.

2) нутгийн төсвийн зарцуулалт ба санхүүгийн эх үүсвэр

Төсвийн тухай хуулиар орон нутгийн төсвөөр доорх үйл ажиллагааг явуулна.

Хүснэгт 3.1.15 Төсвийн тухай хуулинд заагдсан орон нутгийн төсвөөр хэрэгжүүлэх үйл ажиллагааны жагсаалт

Үйл ажиллагааны төрөл	Нийслэл	Дүүрэг	Аймаг	Сум
Тухайн орон нутгийн удирдлага хэрэгжүүлэх	○	○	○	○
хот төлөвлөлт, барилгажуулалт, шинээр дэд бүтэц бий болгох	○	—	○	◎
Тухайн орон нутгийн өмчийн барилга байгууламжийн засвар үйлчилгээ шинээр өмч бий болгох, хөрөнгө оруулалт хийх	○	—	○	-
Нийгмийн халамжийн үйлчилгээ	○	○ Захирагчийн шийдвэрийг дагана	○	○ Захирагчийн шийдвэрийг дагана
хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ядуурлыг бууруулах хөтөлбөр, арга хэмжээг хэрэгжүүлэх	○	—	○	—
Жижиг дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх	○	—	○	—
Бэлчээрийн менежмент хийх	○	—	—	—
малын тэжээлийн нөөц бүрдүүлэх	—	—	○	—
усан хангамж, бохир ус цэвэрлэх байгууламж бий болгох, (2017оноос)	○	—	○	◎
орон сууц, нийтийн аж ахуйн үйлчилгээ	○	—	○	—
үерийн хамгаалалтыг зохион байгуулах	○	—	○	—

нийтийн тээврийн үйлчилгээ	○	—	○	—
мал амьтны халдварт өвчинтэй тэмцэх, хортон шавжийн устгал, хяналтыг хэрэгжүүлэх, мал эмнэлгийн үйлчилгээ (2017 оноос)	○	◎	○	◎
Эрчимжсэн мал аж ахуйг (2017 оноос)	—	◎	—	—
Байгалийн гамшгаас урьдчилан сэргийлэх (нийслэлээс бусад нь 2017 оноос)	○	○	○	○
байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх	○	—	○	—
авто зам, гүүр, тэдгээрийн гэрэлтүүлэг, гэрлэн дохио болон бусад холбогдох байгууламжийг бий болгох	○ Зам нь томоохон хэмжээний зам	—	○ Зам нь аймаг-сумыг холбосон зам	—
нийтийн эзэмшлийн газар, хот тохижилт, нийтийн ариун цэвэр, гудамж талбайн гэрэлтүүлэг, цэвэрлэгээ, хог зайлуулалтыг зохион байгуулах	○	○	○	◎
цэцэрлэгжүүлэлт, явган зам, амралт болон хүүхдийн тоглоомын талбайг тохижуулах, арчлах	—	○	—	○
Тухайн орон нутгийнхаа хэвийн үйл ажиллагааг хангахын тулд өндөр хүчдэлийн болон цахилгааны шугам, дэд өртөөний ашиглалт, засвар үйлчилгээ	○	—	○	—
хуульд заасан бусад чиг үүргийг хэрэгжүүлэх	○	○	○	○ 2017

Эх сурвалж : Төсвийн тухай хуульнаас ЖАЙКА-ийн судалгааны баг боловсруулав

жич : ◎ –ОНХС-аас шаргах үзүүлэлт

Мөн төсвийн тухай хуулийн 61 дүгээр зүйлээр аймаг болон нийслэл нь дараах үйл ажиллагааг төлөөлөн гүйцэтгэнэ.

- сургуулийн өмнөх боловсрол;
- ерөнхий боловсрол;
- соёлын үйлчилгээ;
- эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээ;
- газрын харилцаа, кадастр;
- хүүхдийн хөгжил, хамгааллын үйлчилгээ;
- нийтийн биеийн тамир.

3) Орон нутаг дахь төсвийн хөрөнгө оруулалт, орон нутгийн хөгжлийн сан

(i) Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт

Орон нутаг дахь төсвийн хөрөнгө оруулалт нь 1. Орон нутгийн төсвөөр хэрэгжүүлэх төсөл хөтөлбөр болон 2. Орон нутгийн хөгжлийн сан (LDF)-аар хэрэгжих төсөл хөтөлбөрт хуваагддаг. Төсвийн ангилалын хувьд эхнийх буюу 1. нь хөрөнгийн зарлагад багтаж дараагийн 2. нь урсгал зардал доторх нөхөн олговрын мөнгөн дүнд орсон байдаг.


(ii) LDF Орон нутгийн хөгжлийн сангийн өнөөгийн байдал

ОНХС-г Засгийн газрын тусгай сангийн тухай хуулинд бус төсвийн тухай хуулинд тогтоосон сан юм. Тухайн шатны төсвийн захирагч нь орон нутгийн хөгжлийг дэмжих зриого бүхий орон нутгийг хөгжүүлэх сантай байна.

Орон нутгийг хөгжүүлэх сан нь Орон нутгийг хөгжүүлэх нэгдсэн сан болон тухайн засаг захиргааны нэгж болгонд байгуулсан Орон нутгийн сантай. Орон нутгийг хөгжүүлэх нэгдсэн сан гэж төсвийн хухай хуулийн 4.1.28-д орон нутгийг хөгжил болон тэнцвэртэй байдлыг хангах зориулагдсан орон нутгийн хөгжлийг дэмжих сан хэмээн тодорхойлсон байдаг. ОНХС нь доорх эх үүсвэрүүдтэй байна. Орон нутгийн хөгжлийн сангийн тухай доор дурдав. (Тус хуулийн 59.1)

- Импортын бараа болон үйлчилгээнээс гаднах НӨАТ-ын 5% (2016 он хүртэл 10%)
- Ашигт малтмалын нөөц ашиглалтын төлбөр 5%
- Дотоодын төрийн бус байгууллагын хандив болон ХАЁТ-ын Орон нутгийн хөгжлийн санд үзүүлэх тусламж дэмжлэг
- Нефтийн тусгай зөвшөөрлийн ашиглалтын төлбөрийн 30 %

Улсын төсвөөс эхлээд орон нутгийг хөгжүүлэх нэгдсэн сан руу шилжиж, тэндээс дахин 1. Орон нутгийн удирдлагын хөгжлийн индекс 2. Хүн ам 3. Хүн амын нягтаршил, зай, нутаг дэвсгэрийн талбай 4. Орон нутгийн удирдлагын татвар хураан цуглуулах чадвар зэргийг харгалзан тухайн засаг захиргааны нэгжийн орон нутгийн хөгжлийн санруу хуваарилагддаг.




Эх сурвалж: Төсвийн тухай хуульнаас ЖАЙКА-ийн судалгааны баг боловсруулав.

Зураг 3.1.6 Төсвийн тухай хуулиар заагдсан ОНХС-гийн төсвийн хуваарилалтын тухай

Аймаг, нийслэл, сум, дүүргийн ОНХС-гийн эх үүсвэр нь ОНХНС-аас хуваарилагдах орлогоос гадна 1. Аймаг, нийслэлээс сум дүүргийн ОНХС-аас аймаг дүүргийн ОНХС руу олгох хуваарилалт дээр нэмээд 2. Татварын хувь хэмжээг нэмэгдүүлэх болон зарлагыг хэмнэх замаар бий болгосон нэмэгдэл эх үүсвэр 3. Орон нутгийн хөгжлийг дэмжих дотоод гадаадын тусламж дэмжлэг 4. Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн орлогоос улсыг чанартай томоохон төсөл арга хэмжээг хэрэгжүүлэгч хуулийн этгээдийн төлсөн ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн орлогыг хассан зөрүүний 10% (2016 оноос 30%-аас) 5. Ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрлийн төлбөрийн орлогын 50 % нь болно.

Нөгөөтэйгүүр ОНХС-гийн зарцуулалт нь төсвийн тухай хуулийн 63-р зүйлд заасны дагуу дараах шат дараалалтайгаар шийдвэрлэгдэнэ.



Эх сурвалж: Төсвийн тухай хуульнаас ЖАЙКА-ийн судалгааны баг боловсруулав.

Зураг 3.1.7 Төсвийн тухай хуулиар заагдсан ОНХС-гийн зарцуулалтыг шийдэх процедур

Мөн түүнчлэн төсвийн тухай хуулийн 60.3-т ОНХС-г дараах зорилгоор ашиглахыг хориглосон.

- орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр хуулиар тогтоосон чиг үүргээс бусад хөтөлбөр, арга хэмжээ
- улс төрийн нам, төрийн бус байгууллагын үйл ажиллагааны зардал
- үндэсний их баяр наадмаас бусад баяр, наадам, ойн арга хэмжээ, шашны зан үйлийн болон ёслолын зардал
- нийтийн эрх ашигт нийцээгүй үйл ажиллагаа
- зээл олгох, санхүүгийн үр дагавар бүхий баталгаа гаргах, хохирлыг нөхөн төлөх үүрэг авах
- орон нутгийн иргэдийн саналыг аваагүй, орон нутгийн төсвийн төлөвлөгөөнд тусг аж батлаагүй зардал, арга хэмжээ

(iii) 2017 оны төсөв дэх ОНХС болон ОНХС-ийн асуудалтай талууд

2017 оны төсөвт тусгагдсан ОНХС-руу хуваарилах төсвийн мөнгөн дүнг доорх хүснэгтэд нэгтгэв.

Хүснэгт 3.1.16 2017 оны төсөв дэхь ОНХС-ийн төсвийн дүн

Нэгж : тэрбум төг

Шилжүүлэг	Үзүүлэлт	Дүн
Улсын төсөв ↓	Импортын бараа үйлчилгээнээс бусад НӨАТ-ын орлогоос олгох 5%	20.6
Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан	Ашигт малтмалын тухай хуулийн 47-р зүйлд заасан ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн 5%	15.5
	Газрын тосны орлогын 30%	8.1
Улсын төсөв ↓	Мега төслийн ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр (10%)	9.5
Орон нутгийн хөгжлийн сан	Ашигт малтмалын тухай хуулийн 32-р зүйлд заасан ашигт малтмал хайгуул болон ашиглалтын тусгай зөвшөөрлийн төлбөрийн 50%	18.5
	ОНХС-руу хуваарилах нийт төсвийн дүн	72.1

Эх сурвалж : Сангийн яамны боловсруулсан 2017 оны төсвийн төсөлд тулгуурлан ЖАЙКА-ийн судалгааны баг боловсруулав

ОНХС нь иргэдийн оролцоон дээр үндэслэн доороосоо дээш чиглэсэн идэвхи санаачлагатайгаар төсвийн төвлөрлийг багасгах нэгэн арга зам болж байгаагаараа үр дүнтэй хэдий ч санхүүгийн аудитын газар болон хэвлэл мэдээлэлээс зарцуулалтын удирдлагын хувьд асуудалтай гэж үзэж байна. ОНХС-ийн асуудлын тухай 2017оны 7 сарын 19-ний өдрийн Олоо.mn сайтад “Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийг зориулалтаар нь ашиглаж байна уу” сэдвийн доор нийтлэгдсэн.Энэхүү нийтлэлд Авилгатай тэмцэх газраас баяр наадмын зардалд Засгийн газраас тогтоосон жишигээс хол давсан дүнгээр зарцуулсан тухай болон иргэдийн саналыг авалгүйгээр дотуур байрны барилгын ажилд 200 сая төгрөгийг зарцуулсан байсан тул Дорноговь аймгийн хариуцагчид анхаарулга өгсөн тухай бичсэн байсан.

Энэ байдлаас үүдэн Эдийн засгийг сэргээх хөтөлбөрт ОНХС-гийн ач холбогдлын дүгнэлт, сангийн ашиглалт (зарцуулалт)-ын нээлттэй болон ил тод байдлыг хангах гэсэн үзүүлэлтүүд багтсан.

3.2 Мега төслийн хэрэгжилт ба явцын тухай

Өмнөх бүлгүүдэд дурдсанчлан төсвийн тухай хуулийн дагуу 30 тэрбум төгрөгөөс дээш төсвийн хөрөнгө оруулалт нь Улсын төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд багтдаг. Нөгөөтэйгүүр Засгийн газар болон УИХ-ын баримт бичигт мега төсөл гэсэн нэршил нилээдгүй харагддаг хэдий ч мега төслийн тухай Засгийн газар дотроо нэгдсэн ойлголт ухагдахуун байхгүй.

Гэвч төсвийн тухай хуулийн 60.8-д улсын томоохон хэмжээний төсөл хөтөлбөрийн хувьд Засгийн газраас төслийн жагсаалт болон хэрэгжүүлэгчийг батлана хэмээн заасан. Үүний дагуу 2015 оны 8 сарын 31 өдрийн 347-л Засгийн газрын тогтоол (2016 оны 3 сарын 28-ны өдөр шинэчлэгдсэн)-д Таван толгой болон Оюу толгой, Эрдэнэтийн 3 компани гол хэрэгжүүлэгч нь болж буй 3 төсөлд жагсаалтад орно.

Түүнчлэн Үндэсний хөгжийн газар дотроо бол 50 тэрбум төгрөгөөс давсан төслийг мега төсөл хэмээн тодорхойлж байна. Мөн 30-50 тэрбум төгрөгийн төслийг том хэмжээний төсөл хэмээн мега төслөөс ялган дууддаг. 2015 оны 10 сарын байдлаар мега төсөлд тооцогдсон төслүүдэд Үндэсний хөгжлийн газар байгуулагдахаас өмнөх төслүүд нь голчилж байна. Үндэсний хөгжлийн газар нь байгуулагдснаас хойш мега төслүүдийн хөрөнгө оруулалтын асуудал болон яам хоорондын зохицуулалтыг харицаж байгаа бөгөөд хэрэгжилттэй холбоотой асуудлыг тухайн төслийг хариуцах яам агентлаг эсвэл холбогдох яам агентлагаас бүрдсэн төслийн нэгж нь хариуцна. Үндэсний хөгжлийн газар нь шинээр байгуулагдсан төрийн захиргааны байгууллага тул хуучнаар аж үйлдвэрийн яамны хариуцаж байсан ХАА-н үйлдвэрлэл, технологийн парк байгуулах төслийг хүлээн авч хариуцах болсон.

Түүнчлэн өнөөг хүртэл мега төсөл хэмээн нэрлэгдэж байсан төслийг төсвийн хөрөнгө оруулалтын хөтөлбөрийн /PIP/ боловсруулалт, хэрэгжилтийн хүрээнд нэгтгэж, төслийн хэрэгжилтийг хурдасгах төлөвтэй байна. Бүхэлд нь улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрт багтаах уу аль эсвэл урьдын адил мега төслийн хэлбэрээр тусад нь авч үзэх үү гэдэг нь одоогийн байдлаар чиглэл нь тодорхой бус байна.

Хүснэгт 3.2.1 Үндэсний хөгжлийн газрын төслүүд (2016 оны 10 сарын байдлаар)

Салбар	Төслийн нэр	Хөрөнгө оруулалтын дүн
Барилгын материал	“Эрдэст” шөрмөсөн чулууны үйлдвэр	180 тэрбум ам.дол
Төмөр замын барилга	Оорцог толгой шохойн чулууны боловсруулах үйлдвэр	6,30 сая ам.дол
	Таван толгой-Гашуун сухайт хоорондын төмөр зам	1.3 тэрбум ам.дол
	Оюутолгойн туслах зам	1 15.1 сая ам.дол
	Хөөт-Бичигт хоорондын төмөр зам	1,1 тэрбум ам.дол
	Эрдэнэт-Овоот хоорондын төмөр зам	1.3 тэрбум ам.дол
Газрын тосны боловсруулалт	Газрын тосны боловсруулах үйлдвэр	1 тэр бум ам.дол
Газрын тосны хими	Хийжүүлсэн нүүрс	2 тэрбум ам.дол
	Хийжүүлсэн нүүрс	88,9 сая ам.дол
Ган, Төмөр	Дархан Сэлэнгийн бүсийн ган болон төмөрлөгийн цогцолбор үйлдэр бүтээн байгуулалт болон дэд бүтцийн барилга	800 сая ам.дол
	Эрдэнэтийн төмөрлөгийн үйлдвэрийн үйлдвэр	15 сая ам.дол
	「Монгол ган」 төсөл	26,3 сая ам.дол
Аж үйлдвэрийн парк	Баян говийн аж үйлдвэрийн парк барих төсөл	1,55 тэрбум ам.дол
Зэсийн үйлдвэрлэл	Цагаан суврагын зэс молбедины ордын ашиглалт	700 сая ам.дол
	Зэсийн баяжмалын үйлдвэр	79.88 сая ам.дол
	Уулын баяжуулах Эрдэнэт үйлдвэр	35.8 сая ам.дол
Атны орд	Гацууртын алтны орд	228 сая ам.дол
Эрчим хүч	Металлургийн кокс болон ногоон эрчим хүчний хосолсон бүс	232 сая ам.дол
	Эгийн голын усан цахилгаан станц	825 сая ам.дол
	Улаанбаатарын 3-р дулааны цахилгаан станцын чадавхийн нэмэгдүүлэх төсөл (250MW)	350 сая ам.дол
	Таван толгой цахилгаан станц	1 тэрбум ам.дол
	Дорнод дулааны цахилгаан станц	90 сая ам.дол
	Аймгийн төвүүдийн дулааны цахилгаан станц болон цахилгаан түгээх сүлжээ	130 сая ам.дол
	Аманголын уурхайн цахилгаан станц (2,020MW экспортлох)	1.25 тэрбум ам.дол
	Эрдэнэцогтын уурхайн цахилгаан станц (2,640MW экспортлох), 500KV цахилгааны шугам	2 тэрбум 458 сая 800 мянган ам.дол
	Хушаат цавын уурхайн цахилгаан станц (3,000MW экспортлох)	2.575 тэрбум ам.дол
	Шивээ овоогийн уурхайн эрчим хүч үйлдвэрлэх цогц байгууламж	11 тэрбум ам.дол
Хөдөө аж ахуй	ХАА үйлдвэрлэл, технологийн парк	130 сая ам.дол

Эх сурвалж : Үндэсний хөгжлийн газрын материалаас ЖАЙКА-ийн судалгааны баг боловсруулав.

3.3 Хөгжлийн бодлого, улсын хөрөнгө оруулалтын салбарт хэрэгжүүлж буй хандивлагч байгууллагын хамтын ажиллагааны төсөл хөтөлбөрийн тухай

Голлох хандивлагчид хөгжлийн бодлого, улсын хөрөнгө оруулалтын салбарт хамтын ажиллагааны төсөл хөтөлбөрийг хэрэгжүүлж бас төлөвлөж байна. Энэ бүлэгт тэдгээр байгууллагуудтай уулзаж мэдээлэл цуглуулах байдлаар судалсан үр дүнг нэгтгэн оруулав. Түүнчлэн хавсралт материалаар голлох хандивлагчдын Үндэсний хөгжлийн газар болон Сангийн яамтай хамтран хэрэгжүүлж буй төслийн ерөнхий агуулгыг танилцуулна.

(1) НҮБ-ийн хөгжлийн хөтөлбөр

Үндэсний хөгжлийн газартай хамтран Тогтвортой хөгжлийн зорилтуудын мониторинг үнэлгээ, мөн аймгийн түвшинд хөгжлийн бодлогыг боловсруулахад дэмжлэг үзүүлэх сонирхолтой байгаа. Тогтвортой хөгжлийн зорилтуудын мониторинг болон үнэлгээний хувьд Threshold21 (T21) моделин өргөжүүлсэн хувилбарыг нэвтрүүлэх туршилтыг өөр оронд хэрэгжүүлээд байгаа бөгөөд түүнийг Монголын байгаль орчны салбарт тохирох эсэхийг хэлэлцэж нэвтрүүлэх эсэхийг шийдвэрлэх төлөвлөгөөтэй. Харин бодлого боловсруулах дэмжлэгийн хувьд Тогтвортой хөгжлийн зорилтод хүрэхийн тулд бүх аймгийн түвшинд Хөгжлийн санхүүгийн үнэлгээ (Development Finance Assessment)-н дээр төвлөрсөн дэмжлэгийг үзүүлэх ба аймгийн хөгжлийн бодлогыг хэрэгжилт рүү шилжүүлэхэд шаардлагатай санхүүгийн үнэлгээг Архангай аймаг болон говь аймагт туршилтаар хэрэгжүүлэх гэж байна. Мөн улсаас хэрэгжүүлж буй төсөл хөтөлбөрийн удирдлага хяналтыг чадавхижуулах төлөвлөгөөгүй байна. Харин одоогийн хөрөнгө оруулалт хийгдэх төлөвлөгөөтэй байгаа төсөл хөтөлбөрийг санхүүжүүлэх хувилбарыг хэлэлцэж санхүүгийн эх үүсвэрийг хэрхэн бий болгох тухай судлана хэмээсэн. Түүнчлэн НҮБХХ нь тусламж дэмжлэгийнхээ гол төвийг аймгийн түвшинд барих ихэнх тохиолдолд засаг захиргааны төв хэсэг үү ханддаг ЖАЙКА-ийн хамтын ажиллагаатай хамтрах хүсэлтэй.

(2) Дэлхийн банк

Сангийн яамтай хамтран 2 төсөл хэрэгжүүлж байна. Эхнийх нь Олон салбарыг хамарсан техникийн хамтын ажиллагааны төсөл (Multi-Sectoral Technical Assistance Project (MSTAR I)) бөгөөд энэ оны 6 сард эхний шат дуусч 7 сараас дараагийн шат буюу MSTAR II эхлэх гэж байна. Уг төслийн хүрээнд 1. Хөрөнгийн зарлагын багцыг нэгтгэх 2. Хөрөнгө оруулалтын эрэмбэлэлтийг оновчтой болгох 3. Төр хувийн хэвшлийн түншлэл 4. Төр хувийн хэвшлийн түншлэл дэх Сангийн яамны оролцоон дээр хамтран ажиллаж байна. Мөн одоо дотоодын зөвлөх 20 хүн Сангийн яаманд томилогдон гол тоглогч нь болон Сангийн яамны өдөр тутмын ажил үүргийг гүйцэтгэж байна. Хэрэв төслийн дараагийн шат цуцлагдвал Сангийн яамны өдөр тутмын үйл ажиллагаа зогсонги болох тул анхаарах шаардлагатай.

Дараагийн төсөл нь Тогтвортой амьжиргаа-3 төсөл (Third Sustainable Livelihoods Project) юм.2001 оноос эхэлсэн Тогтвортой амьжиргаа төслийн 3-р шатны төсөл бөгөөд 2014 оноос 2018 он хүртэл хэрэгжинэ. Энэхүү төсөл нь 3 бүрэлдхүүн хэсэгтэй.

1. Орон нутгийг хөгжүүлэх төрийн бодлогын хүрээнд засаглал болон амьдарлын чадавхийг сайжруулах 2. Үр дүн сайтай идэвхи зүтгэлтэй суманд ОНХС-гаар дамжуулан урамшууллыг олгон иргэдийн оролцоог нэмэгдүүлэх үйл ажиллагаа 3. Төслийн менежмент мониторинг, үнэлгээг дэмжих үйл ажиллагаанаас бүрдэнэ.

(3) Олон улсын валютын сан

Үндэсний хөгжлийн газартай 2016 оны 11 сараас 2017 оны 7 сар хүртэл нийт 9 сарын санамж бичгийг байгуулсан. Санамж бичгийн гол агуулга нь улсын хөрөнгө оруулалтын төлөвлөгөөны сонгон шалгаруулалт, үнэлгээ болон төр хувийн хэвшлийн түншлэлд дэмжлэг үзүүлэх юм. 2016 оны 11 сарын яамдуудын зөвлөлдөх уулзалтыг хамтран зохион байгуулснаас гадна 2017 оны 1 сард Үндэсний хөгжлийн газрын ажилчидад 3 өдрийн сургалтыг зохион байгуулж төслийн үнэлгээний аргачлалын тухай жишээн дээр тулгуурлан заасан. Мөн ирэх 5 дугаар сард улсын хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг өргөн барихтай холбогдуулан Үндэсний хөгжлийн газарт томилогдон төслийн сонголт, үнэлгээн дээр дэмжлэг үзүүлэх зөвлөхийг одоо шалгаруулж байна хэмээсэн. Энэ мэтчилэн ОУВС нь төр засгийн дээд хэсэгт үзүүлэх хамтын ажиллагаанаас гадна санхүүгийн байгууллагынхаа хувьд бизнесийн зорилгоор хамтран ажиллах тодорхой PPP төслийг санаачлах зэрэг доод хэсэг рүү хандсан санхүүгийн тусламжийг үзүүлэх бодолтой байна. ОУВС-ийн хамтын ажиллагааны хугацаа болон салбарын давхцал бага тул ЖАЙКА-тай хамтран ажиллах хүсэлтэй.

(4) Азийн хөгжлийн банк

Судалгааны техникийн хамтын ажиллагааны төсөл болох Санхүүгийн менежментийн ил тод бөгөөд үр дүнтэй байдал (Transparency and Efficiency in Financial Management) төсөл нь 2016 оны 11 сард дууссан. Энэхүү төслийн хамтрагч тал нь Сангийн яамны төсвийн хөрөнгө оруулалтын газар бөгөөд төсвийн хөрөнгө оруулалтын удирдлага хяналтанд мэдээлэл харилцааны технологийг бий болгох бэлтгэл судалгааг хэрэгжүүлж байна. Судалгаагаар 1. Хөгжлийн төсвийн төлөвлөгөөг боловсруулах болон зарцуулах процес 2. Шилэн дансны хуулийн дагуу төсвийн хөрөнгө оруулалттай төслийн интернэтэд байршуулсан нээлттэй байдал болон түүний холбогдох дүрэм журам судлахын хамтаар сургалт семинарыг зохион байгуулах, төсвийн хөрөнгө оруулалтын зарлагын бодит үр дүнг тодорхойлох зэрэг үйл ажиллагааг хэрэгжүүлснээс гадна татварын системийн цахимжуулах өнөөгийн нөхцөл байдлын судалгааг явуулсан. Энэ жилийг дуустал төслийн үйл ажиллагаа үргэлжилэх ба ирэх жилд 15 сая ам.долларын зээлийн төслийг эхлүүлэх төлөвлөгөөтэй. Мөн бага орлоготой иргэдийн нийгмийн хамгааллыг гол зорилгоо болгосон 150 сая ам.долларын Policy-Based Loan, мөн Төв банк болон бусад банкнуудыг хамруулсан 150 сая ам.долларын банкны салбарыг чадавхижуулах төслийг төлөвлөж байна.

(5) Европын холбоо

Хэрэгжүүлэгч байгууллагаар GIZ оролцсон “Эдийн засгийн тэгш өсөлтийг хангах сайн засаглал”(Economic Governance for Equitable Growth (EG4EG)) төслийн хүрээнд 1) Уул уурхайн салбарын PFM-ыг сайжруулах (хяналт шалгалт, үнэлгээ) 2)Уул уурхайн салбарт ажиллах ажилчдын хамлаалалт, нийгмийн хамгаалал 3) Дээрх 1),2) -оос бусад орон нутгийн хөгжлийн төлөвлөгөөг боловсруулах дэмжлэг (бодлого) үзүүлэх 3-н үндсэн бүрэлдхүүн хэсэгтэйгээр хэрэгжүүлж байна. 2016 оны LDPP-г зарласны дараах хөгжлийн бодлогын баримт бичгийг төслийг боловсруулахаас эхлэн нийтэд танилцуулах хүртэл, мөн танилцуулсны дараах хяналт шалгалт болон үнэлгээг явуулах удирдамж буюу Сангийн яамны сайдын 249-р тушаалыг боловсруулахад хамтран ажилласан. Энэхүү төсөл нь 3 жилийн хугацаатай бөгөөд 2018 оны 1 сар хүртэл үргэлжилнэ. 2017 оны 2 сарын эхээр төслийн сүүлийн жилийн үйл ажиллагааны төлөвлөгөөг батлуулж хамтран ажиллах салбарыг тогтоох болно. Одоогийн байдлаар төсвийн дүрэм журам талаас улсын төсвийн хөрөнгө оруулалтыг сонирхож байна.

(6) ХБНГУ-ын Хөгжлийн хамтын ажиллагаа

2020 оныг хүртэл Үндэсний хөгжлийн газартай хамтран хэрэгжүүлж буй Эрдэс баялаг түүхий эдийн иж бүрэн санаачлага (Integrated Mineral Resource Initiative (IMRI)) төслийн хүрээнд баруун хойд 4 аймаг (Баянхонгор, Сэлэнгэ, Увс, Өвөрхөнгө)-т доороос дээш чиглэсэн арга замаар Уул уурхайн компани, орон нутгийн засаг захиргаа, иргэд ТББ, жижиг дунд үйлдвэрлэлийн 4 талын оролцоотой орон нутгийн цогц хөгжлийн хөтөлбөрийг дэмжин ажиллаж байна. 2016 оны 11 сард Тогтвортой хөгжлийн үндэсний 6 дахь форумыг Үндэсний хөгжлийн газартай хамтран зохион байгуулсан. Уул уурхайн салбарын эдийн засгийн бодлого болон орон нутгийн хөгжил нь гол сэдэв болсон ба эдийн засгийн бодлогод аялал жуулчлал, худалдаа, хөдөө аж ахуйн салбарыг ч хамруулах төлөвлөгөөтэй байна. Одоо Швейцарын хөгжлийн агентлагтай хамтарсан санхүүжилттэйгээр жижиг дунд үйлдвэрлэлийн салбарт хамтарсан төслийг хэрэгжүүлж байна. Мөн Канадын засгийн газартай хамтран дээрхтэй адил арга замаар өөр аймагт орон нутгийн хөгжлийг дэмжин ажиллах тал дээр хэлэлцэж байна. Орон нутгийн хөгжлийн салбарт аль аль талын сонирхол нэгдвэл ЖАЙКА-тай хамтран ажиллах боломжтой хэмээн санал болгосон.

(7) KOICA

Сангийн яамтай хамтран Дунд хугацааны төсвийн төлөвлөлтийн чадавхийг бэхжүүлэх, төсвийн удиртгалын тогтолцоог сайжруулах төсөл (The Project for the Medium Term Fiscal Planning Capacity Building and Improvement of Fiscal Management E-system in Mongolia) –ийг 2015 оноос 2018 он хүртэл хэрэгжүүлж байгаа бөгөөд төслийн хүрээнд компьютер, болон түүний техник хангамж зэрэг тоног төхөөрөмжийн нийлүүлэлт, зөвлөх үйлчилгээ, систем бий болгох, мөн чадавхижуулах гэсэн олон

төрлийн бүрэлдхүүн хэсгүүдээс бүтсэн төсөл юм. 1) МТЕФ-ын хууль зүйн тогтолцооны хүрээг бий болгох 2) МТЕФ-д шаадлагатай бүрдүүлэлтийг боловсронгуй болгох 3) макро төсөөлөл болон улсын нэгдсэн төсвийн хянах чадварыг сайжруулах 4) улсаас хэрэгжүүлэх төсөл хөтөлбөрийг эрэмбэлэх болон төсвийн төслийн хяналт 5) Улсын төсвийн удирдлага хяналтын байгууллагын бүтцийг шинэчлэх 6) МТЕФ-н итгэлтэй баталгаатай байдлыг хангах мэдээлэлийн системийг бий болгох гэсэн зургаан үндсэн чиглэлээр үйл ажиллагааг хэрэгжүүлж байна.

(8) Бусад

б)-д өгүүлсэн Швейцарын хөгжлийн агентлаг болон Канадын Засгийн газраас гадна 2016 оны 12 сард Үндэсний хөгжлийн газраас зохион байгуулсан хандивлагчдын хуралд ТИКА, НҮБ-ын REDD (ойн хомсдол, доройтлоос үүдэлтэй хүлэмжийн хийн ялгарлыг буруулах) хөтөлбөр, Австралийн Засгийн газар, Европын холбоо, АНУ-ын олон улсын хөгжлийн агентлаг (USAID), Европын сэргээн босголт хөгжлийн банк (EBRD, Даян дэлхийн ногоон өсөлтийн байгууллага (GGGI)-ын нэрс нь бичигдсэн байсан хэдий ч хэрэгжүүлж буй үйл ажиллагааны тухай тодорхой мэдээлэлгүй байна.

Хэдий тийм боловч ОУВС-ийн хамтын ажиллагаа шийдэгдвэл ОУВС-гаас гаргах чиглэлийн дагуу бусад хандивлагч байгууллагууд тус бүрдээ хэрэгжүүлж буй төсөл хөтөлбөрийнхөө агуулга болон хэрэгжүүлэх төлөвлөгөөгөө нэлээдгүй өөрчлөх шаардлагатай болох тул анхаарах хэрэгтэй.

3.4 Улсын хөрөнгө оруулалтын хэрэгжилттэй холбогдох асуудал

Энэхүү бүлэгт дурдсанчлан улсын хөрөнгө оруулалтын хувьд дараагийн сэдэвт улс төрийн нөлөөнөөс үүдсэн асуудал, хөрөнгийн эх үүсвэр зэрэг төлөвлөгөө боловсруулах үеийн бүтцийн асуудлын талаар нэгтгэв.

(1) Улс төрийн нөлөөнөөс үүдэлтэй асуудал

2016 оны 6 сарын УИХ-ын сонгуулиар үнэмлэхүйгээр ялсан Ардын нам нь 80 гаран хувийн суудлыг авсан бөгөөд Ардын намын засгийн эрхийн шийдвэр нь шууд бодлогод тусгагдах болсон. Одоогийн Ж.Эрдэнэбат ерөнхий сайдын засгийн газрын ихэнхи сайд нар нь Ардын намын дарга болон УИХ-ын дарга М.Энхболдын нөлөөнд автсан хэмээн яригдаж байна. Энэхүү байдал нь Ардын намын эрх ашигтай шууд хобогдох төсвийн хөрөнгө оруулалтыг нэн тэргүүнд хэрэгжүүлэх эрсдлийг дагуулна. Гэвч 2016 оны УИХ-ын 71-р тогтоолоор ERP-д үндсэнлэн макро эдийн засгийг тогтворжуулахын тулд Засгийн газраас хэмнэлтийн горимд орсон нь улсын төсвийн хувьд эдийн засгийн үр нөлөө багатай төсвийг хөрөнгө оруулалтыг зогсоох үр дүнтэй хэмээн үзэж байна.

Нөгөөтэйгүүр 2017 оны 3 сард Засгийн газрын баталгаатай Хөгжлийн банкны 580 сая ам.долларын эргэн төлөлтийн хугацаа нь болж байгаа бөгөөд ОУВС-гаас дэмжлэг авах хувилбараас гадна Хятад улсаас зээлэх талаар мөн хэлэлцэж байна. Хэрэв ОУВС-гаас авбал нилээд хатуу чанга төсвийн сахилгыг шаардах болно. Харин татварын тогтолцооны хувьд харьцангуй зөөлөн нөхцөлтэй Хятадын дэмжлэгийг сонгосон тохиолдолд эдийн засгийн хувьд Хятадаас хамааралтай байдал нь улам нэмэгдэж, хөрш орны нөлөөг багасгахын тулд гуравдагч оронтой дипломат хаилцааг түлхүү хэрэгжүүлж буй гадаа харилцааны бодлогод өөрчллөлт орох магадлалтай.

(2) Төсвийн эх үүсвэр түүнтэй холбогдох

(1) -д бичсэнчлэн эдийн засгийн үр ашиг багатай төсвийн хөрөнгө оруулалтыг хийх эрсдэл гарах хэдий ч нөгөөтэйгүүр 2016 оны 12 сарын хандивлагчдын хурал дээр зарласан олон улсын амлалт ч гэж хэлж болохуйц Эдийн засгийг сэргээх хөтөлбөрийн дүрэм журам болон өмнөх засгийн мөнгө тараах бодлогын дүнд үүсээд буй төсвийн хүнд байдлаас хөрөнгө оруулалтыг хийх боломжгүй байгаа нь эсрэгээрээ үр дүнгүй хөрөнгө оруулалтыг зогсоож байгаа хэрэг болно. Нөгөөтэйгүүр эрдэс баялагийн үнийн сэргэлт нь тулгуур болж Монголын эдийн засаг уналтын хамгийн доод түвшнээс дахин өсч эхлэхэд татварын орлого болон уул уурхай ашигт малтмалын ашиглалтын төлбөрөөс нэмэгдэх орлогыг зээлийн эргэн төлөлт рүү шилжүүлэлгүй эдийн засгийн үр дүн багатай төсвийн хөрөнгө оруулалтын зарлагад хэрэглэх эрсдэл үүснэ.

Мөн ОУВС-гийн дэмжлэг орсноор орлого болон зарлага аль алинд нь ОУВС-гийн хяналт тавигдаж эдийн засгийн үр нөлөөнөөс үл хамааран төсвийн хөрөнгө

оруулалтын зарлага нь зогсонги байдалд орсноор ирээдүйн эдийн засгийн өсөлтийн саад болох магадлал ч бий. Мөн улсын хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд гадаадын шууд хөрөнгө оруулалтыг санхүүгийн эх үүсвэрийн нэг болгох хэрэгтэй байгаа ч өнгөрсөн хугацаанд төрийн бодлогын огцом өөрчлөлт зэргээс алдагдсан гадаадын хөрөнгө оруулагчдын итгэлийг дахин сэргээх хэрэгтэй байна. Эдийн засгийг сэргээх хөтөлбөрт гадаадын шууд хөрөнгө оруулалтыг татахын тулд хууль эрх зүйн орчны сайжруулалт болон гадаадын хөрөнгө оруулагчдын эрх ашгийг хамгаалах зөвлөлийг бий болгохоос гадна хөрөнгө оруулагчдийн эрх ашгийг хамгаалах хууль эрх зүйн орчныг бий болгох тухай тусгагдсан ба Үндэсний хөгжлийн газар нь эдгээрийн гол хариуцагч байгууллага юм.

Мөн ОУВС-ийн дэмжлэг орсноор орлого болон зарлага аль алинд нь ОУВС-гийн хяналт тавигдаж эдийн засгийн үр нөлөөнөөс үл хамааран төсвийн хөрөнгө оруулалтын зарлага нь зогсонги байдалд орсноор ирээдүйн эдийн засгийн өсөлтийн саад болох магадлал ч бий. Мөн улсын хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд гадаадын шууд хөрөнгө оруулалтыг санхүүгийн эх үүсвэрийн нэг болгох хэрэгтэй байгаа ч өнгөрсөн хугацаанд төрийн бодлогын огцом өөрчлөлт зэргээс алдагдсан гадаадын хөрөнгө оруулагчдын итгэлийг дахин сэргээх хэрэгтэй байна. Эдийн засгийг сэргээх хөтөлбөрт гадаадын шууд хөрөнгө оруулалтыг татах тулд хууль эрх зүйн орчны сайжруулалт болон гадаадын хөрөнгө оруулагчдын эрх ашгийг хамгаалах зөвлөлийг бий болгохоос гадна хөрөнгө оруулагчийг хамгаалах хууль эрх зүйн орчныг бий болгох тухай бичээстэй байдаг ба Үндэсний хөгжлийн газар нь эдгээрийн гол хариуцагч байгууллага юм.

Улмаар Эдийн засгийг сэргээх хөтөлбөр нь өнгөрсөн хугацаанд концессоор хэрэгжсэн болон одоо хэрэгжиж буй төслийг дахин нягтлан шалгаж цаашид хэрэгжих төслийн батлах, хэрэгжүүлэх механизмыг тодорхой болгох, холбогдох хууль тогтоомжийг сайжруулахыг шаарддаг тул, зөвхөн төлбөрийг хойшлуулах үр дүнгээс хэтэрдэггүй “барих-шилжүүлэх” төрөл биш “барих-үйл ажиллагаа явуулах- шилжүүлэх ” төрлийг ашиглан төр хувийн хэвшлийн хамтын ажиллагааны төрлийг ашигтай байдлаар хэрэгжүүлэх эхлэл болж магадгүй юм.

Мөн одоо УИХ-р хэлэлцэж буй Хөгжлийн банкны бүтцийн өөрчлөлт нь улсын хөрөнгө оруулалтын эх үүсвэртэй холбогдоно. Хөгжлийн банкны бие даасан удирдлага нь бэхэжсэнээр эдийн засгийн үр дүн муутай төсвийн хөрөнгө оруулалтыг хийхгүй болох сайн талтай хэдий ч хөрөнгийн таталт нь муудвал санхүүгийн эх үүсвэрийн утгаа алдах тул цаашид Going Concern тогтвортой үйл ажиллагааг явуулахын тулд төсөв болон санхүүгийн техникийн тал дээрээ хандивлагч байгууллага, гадаадын санхүүгийн байгууллагаас хөрөнгийн бас техникийн туслалцаа ихээр хэрэгтэй болно.

(3) Төлөвлөгөө боловсруулах үеийн хүндрэл (тогтолцооны асуудалтай тал)

2-р бүлэгт дурдсанчлан Хөгжлийн бодлого төлөвлөлтийн хууль, Төсвийн тухай хуульд улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөр РИР болон хөгжлийн бодлого төлөвлөлт, хяналт-шинжилгээ, үнэлгээ зэрэг хөгжлийн бодлого, хөрөнгө оруулалтын үндсэн суурь хүрээ тодорхойлогдсон байгаа хэдий ч Үндэсний хөгжлийн газар байгуулагдсан тул Үндэсний хөгжлийн газар болон Сангийн яам хоорондын үүрэг хариуцлагыг хуулиар нарийн тогтоон, түүнчлэн төрийн захиргааны хэрэгжилтийн хүрээнд тодорхой бус асуудлууд олон байгаа нь харагдаж байна. Юуны түрүүнд цаашид авч хэлэлцэхийн тулд дараах хүснэгтэд Үндэсний хөгжлийн газар болон Сангийн яамны хөгжлийн бодлого төлөвлөлт болон улсын хөрөнгө оруулалтын асуудлын хууль эрх зүйн хүрээн дэхь эрх үүргийг цэгцлэн харуулав.

Хүснэгт 3.4.1 ҮХГ болон СЯ-ны хөгжлийн бодлого, улсын хөрөнгө оруулалттай холбогдох хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хууль, төсвийн тухай хууль, өрийн удирдлагын тухай хуульд заасан эрх үүрэг

Хуулийн нэр	Үндэсний Хөгжлийн Газар	Сангийн яам
Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хууль	<ul style="list-style-type: none"> Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрийг төлөвлөж, батлахад Төсвийн тухай хуулийн 28, 29 дүгээр зүйлийг баримтална. (11.3) Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрийн гүйцэтгэлд үндэсний хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага хоёр жил тутам хяналт-шинжилгээ, үнэлгээ хийнэ. (11.4) Үндэсний хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага бүсчилсэн хөгжлийн бодлогыг боловсруулах ажлыг холбогдох төрийн захиргааны төв байгууллагатай хамтран зохион байгуулна. (13.2) Үндэсний хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь төрийн захиргааны төв болон нутгийн захиргааны байгууллагаас ирүүлсэн саналд үндэслэн бүсчилсэн хөгжлийн бодлогын төслийг боловсруулж, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж, батлуулна. (13.5) Үндэсний хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь хөгжлийн бодлогыг уялдуулан зохицуулах хөгжлийн 	<ul style="list-style-type: none"> Төрийн захиргааны төв байгууллага өөрийн эрхлэх асуудлын хүрээнд Монгол Улсын хөгжлийн үзэл баримтлалын хэрэгжилтийн явцад хоёр жил тутам хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, тайланг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ. Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага энэ хуулийн 7.5-д заасан тайланг нэгтгэн боловсруулж, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлнэ. (7.5, 7.6) Монгол Улсын хөгжлийн үзэл баримтлалын хэрэгжилтэд дөрвөн жил тутам хөндлөнгийн үнэлгээ хийлгэх ажлыг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага зохион байгуулна. (7.7) Салбар хоорондын түвшинд хэрэгжүүлэх төрөөс баримтлах бодлогыг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага холбогдох төрийн захиргааны төв байгууллагатай хамтран боловсруулна. (8.2) Өмнө батлагдсан ижил төстэй үндэсний хөтөлбөрийн үндсэн зорилт, агуулгын хүрээнд шинээр боловсруулах, үргэлжлүүлэн хэрэгжүүлэх үндэсний

	<p>бодлого төлөвлөлтийн мэдээллийн нэгдсэн санг үүсгэж, эрхлэн хөтөлнө. (22.3, 22.4)</p> <ul style="list-style-type: none"> • Энэ хуулийн 22.2-т заасан эмхэтгэлийг боловсруулж, хэвлэн нийтлэх, 22.3-т заасан мэдээллийн нэгдсэн санг эрхлэн хөтлөх журмыг үндэсний хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага тус тус батална. (22.4) • Үндэсний хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага хөгжлийн бодлого төлөвлөлтийн талаар баримтлах чиглэлийг тодорхойлох, хөгжлийн бодлогын баримт бичиг боловсруулахад нэгдсэн удирдлагаар хангах, арга зүйн зөвлөгөө өгөх, чадавхыг бэхжүүлэхэд холбогдох байгууллагад дэмжлэг үзүүлнэ. (22.5) 	<p>хөтөлбөрийн жагсаалтыг энэ хуулийн 9.3-т заасан төлөвлөгөөний хамт Засгийн газар батална. (10.2)</p> <ul style="list-style-type: none"> • Салбар хоорондын түвшинд хэрэгжүүлэх үндэсний хөтөлбөрийн төслийг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага холбогдох төрийн захиргааны төв байгууллагатай хамтран боловсруулна. (10.4) • Нутгийн захиргааны байгууллага нь үндэсний хэмжээний бодлогын чанартай арга хэмжээ болон улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрийн хязгаарыг хангаж байгаа төсөл, арга хэмжээний саналыг улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлд тусгуулахаар жил бүрийн 02 дугаар сарын 15-ны дотор төрийн захиргааны төв байгууллага болон санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ. (12.3) • Төрийн захиргааны төв болон холбогдох төрийн захиргааны байгууллага улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийн төслийг өөрийн эрхлэх асуудлын хүрээнд нутгийн захиргааны байгууллагаас ирүүлсэн саналыг тусган, нэгтгэн боловсруулж, жил бүрийн 3 дугаар сарын 01-ний дотор санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад ирүүлнэ. (12.4) • Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь төрийн захиргааны төв болон нутгийн захиргааны байгууллагаас улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлд тусгах саналыг хүлээн авч нэгтгэн, улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөр, төсвийн хүрээний мэдэгдэлтэй уялдуулан боловсруулж, жил бүрийн 4 дүгээр сарын 01-ний дотор Засгийн газарт хүргүүлнэ. (12.6) • Улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлд үндэслэн санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага
--	--	--

		<p>тухайн жилийн төсвийн төслийг боловсруулна. (12.9)</p> <ul style="list-style-type: none"> Хөгжлийн бодлогын баримт бичгийг шийдвэрлэх арга замыг тодорхойлж, гарах үр дүн, үр нөлөөг эдийн засаг, нийгмийн хөгжлийн загвар, төсөөлөлд үндэслэн бодлогын хувилбарыг боловсруулах (17.1.2) Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь дэргэдээ Бодлогын судалгааны хүрээлэн ажиллуулж болно. (22.6)
<p>Төсвийн тухай хууль</p>	<ul style="list-style-type: none"> улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийн төслийн талаар санал, дүгнэлт боловсруулж, санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлэх (12¹.1.1) улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрийн төсөл боловсруулах. (12¹.1.2) Төсвийн ерөнхийлөн захирагч улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрт тусгуулах төсөл, арга хэмжээний саналаа үндэсний хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад хүргүүлнэ. (28.2) Үндэсний хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрт тусгах төсөл, арга хэмжээний тэргүүлэх ач холбогдол, хэрэгжүүлэх дарааллыг дараах зүйлийг харгалзан тогтооно (28.3) Үндэсний хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага энэ хуулийн 28.3.1-28.3.8-д заасныг харгалзан улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрт тусгагдах 30.0 тэрбум төгрөгөөс дээш хэмжээний төсөл, арга хэмжээнд техник, эдийн засгийн үндэслэлийн урьдчилсан судалгааг хийнэ. (28.4) Үндэсний хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны 	<ul style="list-style-type: none"> Санхүү төсвийн асуудал эрхэлсэн засгийн газрын гишүүний бүрэн эрх дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэл, төсвийн төсөл, төсвийн тодотголын төсөл болон жилийн төсвийн хязгаарыг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэх (11.1.1) Улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийн төсөл боловсруулж, Засгийн газарт хүргүүлэх (12.2.1) улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрийн төсөл боловсруулах (12.2.2) Улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл болон Засгийн газрын үйл ажиллагааны төлөвлөгөөний талаарх бодлогын удирдамж; (27.4.3) Хөрөнгө оруулалтын эдийн засгийн үр ашиг, нийгмийн ач холбогдлыг харгалзан үр дүнг тооцох аргачлалыг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална. (28.11) Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, тухайн шатны Засаг дарга хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний нийт саналыг дараах байдлаар жилийн төсвийн төсөлд тусгана (29.3) Нийт төсөвт өртөг нь 30.0 тэрбум төгрөгөөс бага өртөгтэй хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний техник, эдийн засгийн үндэслэлийн тооцоо судалгааг тухайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хариуцан хийх бөгөөд

	<p>байгууллага улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрт тусгагдах төслийг энэ хуулийн 28.3.9, 28.3.11-т заасан шаардлагыг хангаж байгаа эсэхийг хянан баталгаажуулна. (28.5)</p> <ul style="list-style-type: none"> • Үндэсний хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага энэ хуулийн 28.3.2, 28.3.3-т заасан эдийн засгийн үр ашиг, нийгмийн ач холбогдлыг харгалзан үзэхэд үр дүнтэй болох нь урьдчилсан судалгаагаар тогтоогдсон нөхцөлд зураг төсөв, техник, эдийн засгийн үндэслэлийн тооцоо хийнэ. (28.6) • Үндэсний хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага жил бүрийн 5 дугаар сарын 15-ны дотор тухайн жилд хийгдэх хөрөнгө оруулалтын хөтөлбөрийн тодотголын төслийг Засгийн газарт хүргүүлнэ. (28.9) • Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрийн хүрээнд шинээр болон үргэлжлэн хэрэгжих хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний саналыг үндэсний хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага бэлтгэнэ. Түүнчлэн энэ хуулийн 28.1-д зааснаас бусад, нийт төсөвт өртөг нь 30.0 тэрбум төгрөгөөс бага өртөгтэй хөрөнгө оруулалтын төслийн саналыг төсвийн ерөнхийлөн захирагч төсвийн удирдамжид заасны дагуу тус тус бэлтгэж үндэсний хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад энэ хуулийн 8.4.3-т заасан хугацаанд ирүүлнэ. (29.1) 	<p>санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага энэ хуулийн 28.6-д заасны дагуу тухайн хөрөнгө оруулалтын төслийн үр дүнтэй болохыг тогтоосон нөхцөлд төсөвт тусгана. (29.6)</p>
<p>Өрийн удирдлагын тухай хууль</p>		<ul style="list-style-type: none"> • дунд хугацааны хөрөнгө оруулалтын хөтөлбөрт тусгах Засгийн газрын зээллэгийн хөрөнгөөр санхүүжүүлэх болон өрийн баталгаа гаргах төсөл, арга хэмжээний саналыг нэгтгэн боловсруулах (9.1.19) • Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн

		<p>төрийн захиргааны төв байгууллага төсвийн ерөнхийлөн захирагчдаас ирүүлсэн Засгийн газрын зээллэгийн хөрөнгө, өрийн баталгааны хүрээнд хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний саналыг хянаж, Төсвийн тухай хуульд заасны дагуу эрэмбэлж, улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрт тусган Засгийн газарт хүргүүлнэ. (9.3)</p> <ul style="list-style-type: none"> • Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь Олон улсын гэрээний тухай хууль болон холбогдох хууль тогтоомжид заасны дагуу улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрт үндэслэн гадаад зээлийн хөрөнгөөр санхүүжүүлэх төсөл, арга хэмжээний саналыг зээлдүүлэгч талд тавьж, хэлэлцээр хийнэ. (25.1) • Энэ хуулийн 33.3-т заасан шаардлагыг хангасан төсөл, арга хэмжээг санхүүжүүлэх зээллэгт Засгийн газрын өрийн баталгаа гаргуулах хүсэлтийг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрт тусгана. (33.6)
--	--	---

Эх сурвалж: Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хууль, Төсвийн тухай хууль, Өрийн удирдлагын тухай хуульд тулгуурлан ЖАЙКА-ийн судалгааны баг боловсруулав

Нөгөөтэйгүүр 2015 оны 11 сард батлагдсан Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хууль буюу Ерөнхий сайдын 249-р тушаалын дагуу бодлогын бичиг баримтыг шинэчлэх шаардлагатай байгаа бөгөөд одоогоор мөрдөгдөж буй хүчинтэй 270 гаруй бодлогын бичиг баримт байна.

Мөн 2016 оны 7 сард Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулийн нэмэлт өөрчлөлтөөр салбарын яам, тамгын газар буюу орон нутгийн захиргаадтай зохицуулалт хийн боловсруулах “Бүсчилсэн хөгжлийн бодлого” боловсруулах асуудал Сангийн яамнаас Үндэсний хөгжлийн яаманд шилжин (дээрх хуулийн 13.2), Үндэсний хөгжлийн газар нь холбогдох төрийн байгууллагуудтай хамтран бүсчилсэн хөгжлийн бодлого боловсруулан Засгийн газраар батлуулна (дээрх хуулийн 13.5) гэсэн заалт байгаа, түүнчлэн Сангийн яам нь салбар хоорондын түвшинд хэрэгжүүлэх төрөөс баримтлах бодлогыг холбогдох төрийн захиргааны төв байгууллагатай хамтран боловсруулна хэмээн заагдсан (дээрх хуулийн 8.2) байгаа тул Сангийн яам ч мөн адил хөгжлийн бодлого төлөвлөлтөд оролцох үүрэг хариуцлагатай. Нөгөөтэйгүүр хөгжлийн бодлого төлөвлөлт буюу төслийн хэрэгжилтийн хяналт- шинжилгээний эрх үүргийн тухайд хуулиасаа хамааран

хариуцагч байгууллага нь өөр байна. Үндэсний хөгжлийн газар нь улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөр (PIP)-д тулгуурласан хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэрэгжилт талаас (Ерөнхий сайдын 2016-64 тоот тушаал), Сангийн яам төсвийн гүйцэтгэлийн талаас (Ерөнхий сайдын 249 тоот тушаал) мөн холбогдох яам, нутгийн захиргааны байгууллага хэрэгжүүлэгчийн байр суурьнаас (Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулийн 20 зүйл) , бодлогын хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхээр заагдсан байна. Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөр (PIP) болон бусад бодлого төлөвлөлтийн төсөл боловсруулах, хэрэгжилтийн хяналт шинжилгээ, үнэлгээ гэсэн бүхий л шатанд холбогдох хууль эрх зүйн орчинг бэхжүүлэх шаардлагатай зүйлүүд олон байгаа бөгөөд хамтын ажиллагааны төслөөр тодорхой авч хэлэлцэх хэрэгтэй.

Түүнчлэн, 5 сард өргөн барихаар Үндэсний хөгжлийн газар бэлтгэл ажил хийж буй улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрийн хувьд Үндэсний хөгжлийн газар болон Сангийн яам хооронд, мөн Үндэсний хөгжлийн газар болон салбарын яамд хоорондын дараах асуудлууд тодорхой эрх зүйн зохицуулалт хийгдээгүй байна.

- Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрт (PIP) тусгагдах төслийн мөнгөн дүнгээс өөр ухагдахуун тодорхой тусгагдаагүй (олон тооны барилга байгууламжаас бүрдэх төслийг нэгтгэж болох уу?)
- Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөр (PIP) боловсруулахад чиглэгдсэн Үндэсний хөгжлийн газар болон салбарын яамд хоорондын хэлэлцүүлэг, зөвлөгөөний талаар журамлагдаагүй
- 2016 оны 12 сард гарсан Сангийн сайдын 415 тушаалаар батлагдсан төслийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт, санхүүжилт, хяналт, тайлагналтын журам (Улсын болон төсвийн хөрөнгө оруулалт, төсвөөс эргэн төлөгдөх нөхцөлтэй бүх хөрөнгө оруулалт мөнгөн дүн хамаарахгүй Сангийн сайдын тушаалыг мөрдлөг болгоно)
- Барилгын хөгжлийн төв болон Эрчим хүчний хөгжлийн төвийн дүрэм, журамтай уялдуулах
- Үндэсний хөгжлийн газар болон Сангийн яам хооронд мэдээлэл солилцох нууцыг хадгалах

3.5 Сургалт, сургалтын хөтөлбөр, хэрэгжүүлэх бүтэц

(1) Монгол улсын боловсролын байгууллага

Улаанбаатар хотын боловсролын байгууллага (их сургууль, сургалтын байгууллага) Сангийн Яам, Удирдлагын академид сургалт, сургалтын хөтөлбөрийн мэдээлэл цуглуулах судалгаа хэрэгжүүлсэн. Тус судалгаанд доор дурдагдсан 5 их сургууль хамрагдсан.

- Монгол Улсын их сургууль
- Монгол Улсын шинжлэх ухаан технологийн их сургууль
- Монгол Улсын хөдөө аж ахуйн сургууль
- Санхүү эдийн засгийн дээд сургууль
- Монгол Улсын бизнесийн их сургууль

Худалдаа үйлдвэрлэлийн сургууль нь МУИС-ийн Эдийн засгийн сургуультай нэгдсэн. Мөн Монгол Улсын бизнесийн дээд сургууль нь голчлон мэргэжлийн нягтлан бодогчийн чиглэлээр боловсон хүчнийг бэлтгэдэг ба бусад сургуультай харьцуулахад харьцангуй бага цар хүрээтэй хувийн сургууль байсан тул судалгаанд хамруулаагүй.

Одоогоор ажиллаж буй төрийн албан хаагч нарыг хамруулсан сургалтын хөтөлбөр хэрэгжүүлж байгаа нь зөвхөн ШУТИС, ХААИС байсан. ШУТИС дээр Сангийн яамны удирдах албаны ажилтнууд, худалдан авах газрын ажилтнуудад зориулсан сургалтыг хэрэгжүүлж байсан. ХААИС нь ХАА болон байгаль орчны салбарт богино хугацааны сургалтыг хэрэгжүүлж ирсэн.

Асуулга судалгаанд хамрагдсан бүх их сургууль нь төрийн захиргааны байгууллагаас хүсэлт ирсэн тохиолдолд тухайн сургуулийн тэнхим, сургалтын хөтөлбөр дагуу байх юм бол богино хугацааны сургалтын хөтөлбөрийг боловсруулан сургалтыг хэрэгжүүлэх боломжтой хэмээн хариулсан.

ШУТИС нь Сангийн яамны хүсэлтээр сургалтын хөтөлбөрийг шинэчлэсэн. Мөн өнгөрсөн хугацаанд Сангийн Яамны удирдах албаны ажиллагсадыг хамруулсан эрсдлийн үнэлгээ, үл хөдлөх хөрөнгийн үнэлгээ, хөрөнгө оруулалтын барьцаа зэрэг богино хугацааны сургалтыг хэрэгжүүлсэн.

СЭЗДС мөн адил тухайн байгууллагын хүсэлтэд нийцсэн сургалтын хөтөлбөрийг боловсруулж, сургалт зохион байгуулдаг. Тус сургууль нь өнгөрсөн хугацаанд Сангийн Яам, Татварын Ерөнхий Газар, Нийгмийн Даатгалын Ерөнхий Газар болон Монгол банкаас сургалт явуулах хүсэлт хүлээн авсан байна.

МУИС-ын салбар сургуулиудад хөгжлийн бодлого төлөвлөлттэй холбогдох сургалтын хөтөлбөр байдаггүй боловч ШУТИС болон бусад их сургуулиудад ч мөн адил хэд хэдэн хичээлийн хөтөлбөрт бүсчилсэн хөгжил, газар ашиглалтын төлөвлөгөө зэрэг

сэдэвчилсэн хичээлийг заадаг. МУИС нь хөгжлийн бодлого төлөвлөлтийн хууль батлагдсантай уялдуулан тус хуульд суурилсан хичээлийн хөтөлбөрийн боловсруулж байгаа.

Улсын төсвийн удирдлагын талаар холбогдох сургалтын хөтөлбөр нь зөвхөн МУИС-д байдаг. Бизнесийн сургуулийн санхүүгийн тэнхимд улсын төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын хичээлүүдийг заадаг. Голдуу төсөв, татварын бодлого, санхүүгийн талаар заадаг. Эдийн засгийн тэнхимд макро, микро эдийн засгийн тухай заахаас гадна төсвийн хууль эрх зүйн орчныг заадаг. Нягтлан бодохын тэнхимийн хувьд хяналт шинжилгээний хичээлүүдийг илүүтэй заадаг.

Мэргэжлийн салбарын багш нарын үзэж буйгаар хөгжлийн бодлого төлөвлөлт, улсын хөрөнгө оруулалтын салбарын чиглэлээр мэргэшсэн багш, профессор гэх мэт боловсон хүчин хангалттай байгаа тул сургалт зохион байгуулахад хүндрэл үүсэхгүй. Өнгөрсөн хугацаанд Сангийн Яам нь их сургуулиудад хүсэлт илгээж ирсэн бөгөөд багаар бодоход энэхүү судалгааны субъект болж буй салбарын мэргэжилтэн хангалттай бий гэж үзэж байна.

Сургалтын шаардлагын хувьд бүх их дээд сургуулиудын холбогдох хүмүүс сургалтыг зохион байгуулах хэрэгцээтэй гэж хариулсан. Шалтгаан нь яамд болон бусад тамгын газруудад 4 жил тутамд хүний нөөцийн шилжилт хөдөлгөөн хийгддэг тул төрийн албан хаагчдын бодлого болон хариуцсан салбарын цогц мэдлэг дутмаг эсвэл салбарын яам, тамгын газруудын мэдлэг чадвар дутмаг, яамдууд бие даан хэрэгжүүлдэг ур чадвар мэргэжлийн сургалт бараг байхгүйгээс болж албан хаагчдын мэдлэг чадавхийг дээшлүүлэх боломж тэр болгон олддоггүй гэж маш олон холбогдох албаны хүмүүс хэлж байсан. Ялангуяа улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрийг боловсруулах туршлагагүйгээс яамдын бодлого төлөвлөлтийг боловсруулахад гар бие оролцдог төрийн албан хаагчдыг бэлтгэх зайлшгүй шаардлагатай гэж үзэж байна.

Одоо ажиллаж байгаа төрийн албан хаагч нарт зориулсан бодлого, хөгжлийн хөтөлбөр, хөрөнгө оруулалтын хөтөлбөрийг боловсруулахтай холбогдуулан холбогдох сургалтыг загварчлах тохиолдолд, их сургуулийн сургалтын хөтөлбөр болон сэдэвчилсэн хөтөлбөрийг боловсруулж, хэрэгжилтийг их сургуулийн багш нар болон тэтгэвэрт гарсан туршлагатай төрийн албан хаагчдыг урьж онолын болон практик хичээлийг хослуулан хэрэгжүүлж, өнгөрсөн хугацаанд ямар асуудлууд байсан болон захиргааны саад байсныг ойлгуулах боломжтой гэсэн саналууд ирсэн.

(2) Төрийн байгууллага

Сангийн Яамны хүний нөөц хариуцсан мэргэжилтэний хэлснээр тус яам боловсон хүчний сургалт зохион байгуулах төсөв багатай байдгаас ихэвчлэн хандивлагч байгууллагын дэмжлэг авдаг байна. Ялангуяа, сургалтын хөтөлбөр (магистр, гадаадын сургалт) нь албан хаагчид нь хувиараа шууд хүсэлтээ гаргаж, тэтгэлэг авах кейс болон хандивлагчдын зарласан хөтөлбөрт хувиараа хүсэлтээ илгээх зэргээр явагдаж, харин

яамны зүгээс хэнийг ямар сургалтанд хамруулах вэ гэсэн яамны төлөвлөгөө бол байдаггүй. Тийм учраас бүгд хувь хүний хүсэл дээр үндэслэгдэн явагдаж буй учраас, зайлшгүй тус яамны хүний нөөцийн хуваарилалт болон дутагдаж буй хүний нөөцийн бүрдүүлэлт зэрэг шаардлагад нийцсэн сургалт байдаггүй.

Сангийн яаманд жил бүр боловсон хүчний сургалтад хамруулах төлөвлөгөө боловсруулж сангийн сайдын зөвшөөрлийг авч байгаа ч төсвийн боломжгүй учраас төлөвлөгөө нь хэрэгждэггүй.

Нөгөө талаас олон улсын хурал, богино хугацааны сургалт болон бусад айлчлал зэргийг багтаавал 1 жилд ойролцоогоор 100 (давхацсан тоогоор) гаруй хүн гадны улс орнуудыг зорьж байна. Тэдгээрийн ихэнх нь хандивлагч байгууллагын дэмжлэг эсвэл зохион байгуулагч нарын урилгаар байдаг. Албан хаагчдын ойролцоогоор 30 хувь нь дор хаяж жилд 1 удаа гадаадад зохион байгуулагдах хурал, айлчлалд оролцдог ба мөн 30 хувь нь ижил шалтгаанаар нэгээс дээш удаа гадаадад зорчиж, үлдсэн 30 хувь нь хэлний бэрхшээл болон хандивлагч байгууллагуудтай харьцаа байхгүй хэлтэст байдаг зэргээс гадагш явах боломж байдаггүй.

Сангийн яаманд албан тушаал дээшлүүлэх сургалт болон нарийн мэргэжлийн сургалт байдаггүй. Шинэ төгсөгч нарт анхан шатны сургалтыг явуулдаг боловч, яамны гаднаас ажлын туршлагатай хүмүүсийг ажилд авах, эсвэл Сангийн Яаманд томилогдон ажиллаж буй албан хаагч зэрэг хүмүүсд төдий л тиймэрхүү сургалтын боломж байхгүй учраас төрийн албан хаагчийн ёс зүй, төр захиргааны үйл ажиллагааны явцыг мэдэхгүй албан хаагч цөөнгүй байдаг нь ихээхэн асуудал болоод байна.

Удирдлагын академи нь ЗГХЭГ-ын харьяа байгууллага бөгөөд үйл ажиллагааны зардал нь ЗГ-ын төсвөөс байдаг боловч, санхүүгийн хэмнэлт хийж, тус сургууль бие даасан тогтолцоотой болох шаардлага урган гарч ирж байна.

Удирдлагын академийн үндсэн орлого нь сурагчдын сургалтын төлбөр болон хандивлагч байгууллагуудын дэмжлэг тусламж байлаг. Яамдуудад сургалт зохион байгуулах төсөв байхгүйн улмаас салбарын яамдаас албан хаагчдаа сургах хүсэлт эрс багассан байна.

Удирдлагын академи нь одоо ажиллаж байгаа төрийн албан хаагч нарын хүсэл сонирхолд нийцсэн сургалтыг (магистр, доктор) , богино хугацааны сургалтыг зохион байгуулдаг. 2016 оны 12 сарын байдлаар тус сургуульд бүтэц зохион байгуулалтын өөрчлөлт хийж байсан.

Удирдлагын академи нь үндсэн сургалт болон судалгааны хэсэгт хуваагдана.

Удирдлагын академи дээр НҮБХХ дэмжлэгээр орон нутгийн байгууллагуудад зориулсан хөгжлийн бодлого, орлого зарлагын төсвийн төлөвлөлтийн талаар сургалт зохион байгуулагдсан.

Сургалт нь хүсэлтийн дагуу явагдах сургалт, томилолт сургалт (яам, газрууд дээр очиж хийгдэх) онлайн гэсэн 3 төрөлд хуваагдана. Удирдлагын академи нь яам, тамгын газруудын шаталсан сургалт зохион байгуулахаар хөтөлбөр боловсруулж эхэлсэн байна. Яам, тамгын газруудын хөгжлийн бодлого, хөрөнгө оруулалтын хөтөлбөр зэргийг хариуцсан ажиллагсадыг хамруулж “хөгжлийн бодлого төлөвлөлт, улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөр боловсруулах онол” нэртэй 1 долоо хоногийн модуль сургалтыг зохион байгуулж, ЖАЙКА-ийн япон мэргэжилтэнтэй хамтрах хүсэлтийг Удирдлагын академийн хариуцсан ажилтан нь санал болгоод байна.

Удирдлагын академи дээр хэрэгжүүлэхийн ач холбогдол нь бүтцийн бүрэн эрхийнхээ дагуу одоогийн төрийн албан хаагчдын боловсрол, сургалтыг хэрэгжүүлэх үүрэгтэй, төв, орон нутгийн төрийн байгууллагын албан хаагчдад өнөөг хүртэл сургалт явуулж ирсэн туршлагатай, мөн их сургуулийн хариуцсан албаны хүмүүсийг болон одоо ажиллаж буй албан хаагчид, туршлагатай багш нарыг урьж сургалт явуулж байсан зэрэг гүйцэтгэлүүд байгаа юм.

4 Үндэсний хөгжлийн газрын бодлого зохицуулалт, үйл ажиллагааны чиг үүргийн ерөнхий агуулга

4.1 Монгол улсын хөгжлийн бодлого төлөвлөлтийн бүтэц, төсөв санхүүгийн тогтолцоо, сургамж

(1) Хөрөнгө оруулалтын бодлогогүй орчинд хөрөнгө оруулалтын хөтөлбөрийг нэвтрүүлсэн нь

Өнөөг хүртэл Монгол улсад хөрөнгө оруулалтын цогц бодлого боловсруулагдаж байгаагүй. 1995 онд тухайн үеийн Үндэсний Хөгжлийн Газар, Азийн Хөгжлийн Банкны тусламжаар анхны улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрийг боловсруулсан. Цогц хөрөнгө оруулалтын бодлого байгаагүйгээс гадна туршлага хомс байснаас үүдэн тухайн үеийн улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөр нь төслүүдийн жагсаалт бүхий “Хүслийн жагсаалт”-тай маш төстэй байсан. Үүний дараа улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөр нь 2001 оноос Санхүү, Эдийн Засгийн яамны харьяа Төсвийн Удирдлагын Газрын нэг хэсэг болон харьяалагдах болсон. 2009 онд Үндэсний Хөгжил, Шинэтгэлийн хороо (NDIC : National Development and Innovation Committee) байгуулагдсанаар улсын тэргүүлэх ач холбогдолтой төслүүдийг хамруулсан шинэ улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрийг боловсруулж эхэлсэн. Үндэсний хөгжил, шинэтгэлийн хороонд (уул уурхай, газар тариалан, дэд бүтэц, хүний нөөцийг хөгжүүлэх орчин, Засаглал)-ын гэсэн 5 салбар 26 тэргүүлэх хөрөнгө оруулалтын төслийн жагсаалт (мега төсөл)-ыг боловсруулсан.

(2) Үндэсний хөгжил, шинэтгэлийн хороо, Гадаад харилцааны яамны харьяа бүтцээс улсын хөрөнгө оруулалтын үе шат, тодорхой санхүүгийн эх үүсвэрийн эрх бүхий Эдийн Засаг Хөгжлийн Яамны бүтэц

Тухайн үед төсвийн санхүүжилтэд суурилсан улсын хөрөнгө оруулалтыг Үндэсний Хөгжил, Шинэтгэлийн Хороо, харин гадаадын шууд хөрөнгө оруулалтыг Гадаад харилцааны яамны харьяа хэрэгжүүлэгч агентлаг болох Гадаадын хөрөнгө оруулалт, гадаад худалдааны газар (FIFTA : Foreign Investment and Foreign Trade Agency) тус тусад нь салган хөрөнгө оруулалтын бодлогыг хэрэгжүүлж байсан. Тийм учир боловсруулсан хөрөнгө оруулалтын хөтөлбөр нь цогц болж чадаагүй юм.

2012 онд Засгийн Газар солигдсоны дараа Үндэсний хөгжил, шинэтгэлийн хороо, Гадаад харилцааны яамны харьяа Гадаадын хөрөнгө оруулалт, гадаад худалдааны газар нь тухайн үеийн Засгийн газрын бүтэц зохион байгуулалтаар шинээр байгуулагдсан Эдийн засгийн хөгжлийн яамтай нэгдэж, гадаадын хөрөнгө оруулалт, гадаад худалдааны агентлагын нэг хэсэг Гадаадын хөрөнгө оруулалтын зохицуулалт, бүртгэлийн газар (DFIRR : Department of Foreign Investment Regulation and Registration) газар нэртэйгээр Эдийн засгийн хөгжлийн яаманд нэгдсэн. Тухайн үед Эдийн засаг хөгжлийн яам нь Хөгжлийн банкаар дамжуулан үнэт цаас гаргах, түүчлэн

мега төсөл, концессын төсөл арга хэмжээний санхүүгийн эх үүсвэрийг шийдвэрлэх эрх мэдэлтэй байсан учраас улсын төсвийн хяналтаас гадуур санхүүгийн эх үүсвэрийг барих болсон.

2013 онд дотоодын болон гадаадын хөрөнгө оруулалтын тухай хуулийг нэгтгэн “Хөрөнгө оруулалтын тухай хууль” батлагдсан. Эдийн засгийн хөгжлийн яам нь Гадаадын хөрөнгө оруулалт зохицуулалт, бүртгэлийн газрыг дахин зохион байгуулж, яам дотроо Хөрөнгө оруулалт, бизнесийн хөгжлийн газрыг бий болгосон. Гадаад, дотоодын хөрөнгө оруулалтын бодлого зохицуулалтыг нэг яам хариуцан ажиллаж улсын төсвөөс гадна санхүүгийн эх үүсвэрийн хэт их эрх мэдэлтэй орчинд 4 жил болсон. Үндэсний хөгжил, шинэтгэлийн хорооны үед боловсруулсан улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрийг шинэчлэн боловсруулсан. Тухайн үед боловсруулагдсан улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөр нь концессын гэрээний жагсаалтад тусгагдсан дэд бүтцийг хөгжүүлэх төсөл, аймаг, сумдын хэмжээний орон нутгийн иргэдийн хурлаар батлагдсан төсөл зэрэг нь ямар ч ТЭЗҮ хийгдээгүй бүх төслүүд жагсаалтад тусгагдсанаар 11,000 орчим төслийн санал, энэ нь 45 их наяд хэмжээнд хүрч бодит бус хөрөнгө оруулалтын хөтөлбөр болсон.

2014 оны 12 сараас Ч.Сайханбилэг Ерөнхий сайдын Засгийн Газар ажиллаж эхэлсэнтэй холбогдуулан Эдийн засгийн хөгжлийн яамыг татан буулган, зарим үйл ажиллагааг Аж үйлдвэрийн яаманд хувиарлан өөрчилсөн. Ингэснээр Эдийн засгийн хөгжлийн яамны харьяа газар болох Хөрөнгө оруулалт бизнесийн хөгжлийн газрыг Хөрөнгө оруулалтын газар (ИМА : Invest Mongolia Agency) болгон Ерөнхий сайдын удирдлага дор тохируулагч агентлаг болгосноор хөрөнгө оруулалтын үе шат, тодорхой хөрөнгийн эх үүсвэрийн эрх мэдэл хэт төвлөрсөн гэж хэлж болно.

(3) Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хууль “Урт хугацааны тогтвортой хөгжлийн үзэл баримтлал”-д нийцсэн улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөр боловсруулах үе шатны эхлэл

2016 онд Засгийн эрх солигдсоны дараа Үндэсний хөгжлийн газар нь өнөөг хүртэл цогц хөрөнгө оруулалтын бодлогогүй орчинд хөрөнгө оруулалтын үе шатны үр ашиггүй байдал, хэт төвлөрсөн эрх мэдлээс үүссэн хяналтын хүндрэлийг давж, тодорхой яам газрын харьяалал дор бус Ерөнхий сайдын шууд харьяал дор байгуулагдсан. Мөн хөрөнгө оруулалтын хөтөлбөрийг боловсруулахад чухал ач холбогдол бүхий цогц хөрөнгө оруулалтын бодлого байхгүй байгаа хэдий ч 2016 онд батлагдсан Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хууль болон 2016 оны төсвийн тухай хуулийн нэмэлт өөрчлөлт зэрэг нь Үндэсний хөгжлийн Газар нь цаашид урт хугацааны хөгжлийн үзэл баримтлалд нийцсэн улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрийг боловсруулах, хэрэгжүүлэх ажлуудыг зохион байгуулах шаардлагатай байгааг харуулж байна.

Одоогийн байдлаар улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөр боловсруулах, хэрэгжүүлэх үе шатыг дахин эхлүүлж байгаатай холбогдуулан нэг хэсэгтээ хөрөнгө оруулалтын бодлогыг орлуулах хэлбэрээр хөгжлийн бодлого төлөвлөлт буюу урт хугацааны үзэл баримтлалыг улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрийн үнэлгээний шалгуур болгон, шинэ хөрөнгө оруулалтын хөтөлбөр боловсруулах мөн хэрэгжилтийг дэмжих шаардлагатай. Цаашид эдгээр хөтөлбөрт тодотгол хийнгээ хөрөнгө оруулалтын бодлогыг боловсруулахад шаардлагатай тогтолцоог бүрдүүлэх хэрэгцээтэй байна.

4.2 Бүтэц зохион байгуулалт, үйл ажиллагааны чиг үүрэг

(1) Бүтэц зохион байгуулалт

Үндэсний хөгжлийн газар нь 2016 оны 7 сарын 7-ны өдөр байгуулагдсан шинэ Засгийн газрын буюу Ерөнхий Сайдын шууд харьяалалын агентлаг юм. 2016 оны 9 сарын 28-ны өдрийн Ерөнхий сайдын 64-р захирамжаар тус агентлагийн чиг үүргийг нарийвчлан зааж өгсөн. Уг захирамжаар Ерөнхий сайдын шууд удирдлага доор байх Засгийн газрын тохируулагч агентлаг юм. Үндэсний Хөгжлийн газрын даргын удирдлаган доор 55 хүний бүрэлдэхүүнтэй байхаар захирамжинд тусгагдсан ба бүтэц зохион байгуулалтыг зурагт үзүүлсэнчлэн 5 хэлтэстэй, түүнээс 3 хэлтсийн доор мэргэшлийн алба байхаар зохион байгуулсан. 2017 оны 2 сарын 4-ны өдрийн байдлаар нийт 52 ажилтантай байна.



Жич : Хүснэгтэд байгаа тоо нь ажиллагсадын тоо. Хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн () нд байгаа тоо нь захирамжинд заасан ажилтаны тоо болно.

Эх сурвалж: 2016 оны Ерөнхий сайдын 64-р захирамжид үндэслэн ЖАЙКА-ийн судалгааны баг боловсруулав.

Зураг 4.2.1 Үндэсний хөгжлийн газрын бүтэц зохион байгуулалт

(2) Үйл ажиллггааны чиг үүрэг

2016 оны 7 сард Үндэсний хөгжлийн газар байгуулахтай холбогдуулан “Монгол улсын хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хууль”-д нэмэлт өөрчлөлт оруулсан. Тус хуулинд улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөр (11-зүйл 4-р хэсэг), бүсчилсэн хөгжлийн бодлого (13- зүйл 2,5-р хэсэг), Үндэсний хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь хөгжлийн бодлогыг уялдуулан зохицуулах хөгжлийн

бодлого төлөвлөлтийн мэдээллийн нэгдсэн санг үүсгэж, эрхлэн хөтлөх (22- зүйл 3-5-р хэсэг) эрх үүргийг “Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв” гэснийг “Үндэсний хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны” гэж тус тус өөрчилсүгэй гэж заасан нь Үндэсний хөгжлийн газрын үйл ажиллагааг илүү тодорхой болгож өгсөн.

Мөн хөрөнгө оруулалтын хөтөлбөр (30 тэрбумаас дээш улсын хөрөнгө оруулалтын төсөл) холбогдох Монгол улсын төсвийн тухай хуулийн 28-р зүйл 2, 3, 4, 6, 9, 29-р зүйлийн 1-т (2016 оны 7 срын 21-нд нэмэлт өөрчлөлт) хөрөнгө оруулалтыг дэмжихтэй холбогдуулан хуучин хөрөнгө оруулалтын газарт байсан эрх үүргийг Монгол улсын төсвийн тухай хуулийн 8-р зүйл, 9-зүйлийн 1-р хэсэг, 17, 18, 19, 22-р зүйлүүдэд тус тус “Хөрөнгө оруулалт”ыг “Үндэсний хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргаа” хариуцна гэж заасан байгаа нь үндэсний хөгжлийн газрыг хэлж байна гэж ойлгогдож байна.

Ерөнхий сайдын 64-р захирамжаар илүү нарийвчлан бүх салбарын бодлого төлөвлөлт, хэрэгжилт, мөн ерөнхий сайдын эрхэлсэн асуудлын хүрээнд бодлогын хэрэгжилтэд хяналт тавих, үнэлгээ хийх, дэмжлэг үзүүлэх асуудлыг Үндэсний хөгжлийн газрын эрх үүргийн хүрээнд доорх хүснэгтээр заасан.

Хүснэгт 4.2.1 Үндэсний хөгжлийн газрын үйл ажиллагаа

Үйл ажиллагааны эрх үүрэг	Бодлогын салбар
- Эдийн засгийн тэргүүлэх салбарын тодорхойлон, төрөөс дэмжих бодлого боловсруулах	Аж үйлдвэрийг дэмжих салбар
- Бүсчилсэн хөгжлийн бодлого боловсруулах	Бүсчилсэн хөгжлийн салбар
- Дэд бүтэц, дэд бүтэц хариуцсан төрийн захиргааны байгууллагын уялдаа холбоог оновчтой болгох	
- Цогц хөрөнгө оруулалтын бодлого, гадаадын хөрөнгө оруулалтын бодлого болон холбогдох заалт журам, концесс, төр хувийн хэвшлийн түншлэлийн бодлого боловсруулах - Бүсчилсэн хөгжлийн хөрөнгө оруулалтыг дэмжих бодлого болон “Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал 2030”д суурилсан хүн амын нутагшил, суурьшлын ерөнхий төсөл, бүсчилсэн хөгжлийн бодлого, салбарын хөгжлийн бодлого болон тус тус үзэл баримтлалын уялдааг хангах замаар улсын хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг боловсруулах - Дотоод, гадаадын шууд хөрөнгө оруулалтыг татахад чиглэсэн цогц үйл ажиллагааг явуулах - Хөрөнгө оруулалтын тухай хууль, Концессын тухай хууль болон холбогдох хууль эрх зүйн орчинг бүрдүүлэх, зохицуулалтыг хэрэгжүүлэх	Хөрөнгө оруулалтыг дэмжих салбар
- Хөгжлийн бодлого төлөвлөлт болон хөрөнгө оруулалтыг дэмжихтэй холбогдох судалгаа шинжилгээг бэхжүүлэх - Хөгжлийн бодлого төлөвлөлт болон хөрөнгө оруулалтыг дэмжих мэдээллийн санг бий болгож тогтвортой хэрэгжүүлэх	Хөгжлийн бодлого төлөвлөлтийн мэдээллийн хяналт
- Ерөнхий сайдын эрхлэх асуудлын хүрээн дэхь бодлогын хэрэгжилтийн хяналт, үнэлгээ, сурталчилгаа	Засаглал

Эх сурвалж: 2016 оны Ерөнхий сайдын 64-р тогтоолоос ЖАЙКА-ийн судалгааны баг боловсруулав.

4.3 Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөр (PIP : Public Investment Program)-ийг боловсруулах хууль эрх зүйн орчин

Үндэсний хөгжлийн газрын улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрийг (PIP : Public Investment Program) боловсруулах, хэрэгжүүлэх үе шатны үндсэн эрх үүргийг Монгол улсын төсвийн тухай хуулийн 121-р зүйлд заасан. Энэхүү заалтад “Улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийн төслийн талаар санал, дүгнэлт боловсруулж, санхүү төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хөргүүлэх” гэж заасан ба тус заалтын 1.2-т “улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрийн төсөл боловсруулах гэж тодорхой зааж өгсөн байгаа тул үндэсний хөгжлийн газар нь улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөр боловсруулах тухай эрх, үүрэгтэй гэдгийг тодорхой зааж өгсөн.

Төсвийн тухай хуулийн 28-р зүйлийн 1-р хэсэгт “Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрт эдийн засаг, нийгмийн хөгжлийг урт хугацаанд хангахад чиглэгдсэн, нэгээс дээш жилийн хугацаанд хэрэгжих 30 тэрбум төгрөгөөс дээш өртөг бүхий дэд бүтэц, хөгжлийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг хамруулна” гэсэн заалтад үндэслэн улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрийг Үндэсний хөгжлийн газар хариуцах нь төсөлд тодорхой заагдах болно.

Тус хуулийн 28-р зүйлийн 4, 6-р хэсэгт улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрт тусгагдах төсөл арга хэмжээнд техник эдийн засгийн үндэслэлийн урьдчилсан судалгаа, эдийн засгийн үр ашиг, нийгмийн ач холбогдлыг харгалзан үзэхэд үр дүнтэй болох нь урьдчилсан судалгаагаар тогтоогдсон нөхцөлд зураг төсөв, техник, эдийн засгийн үндэслэлийн тооцоог Үндэсний хөгжлийн газар бүрэн эрхийнхээ хүрээнд хийнэ гэж заасан. Мөн Үндэсний хөгжлийн газар нь жил бүрийн 5 дугаар сарын 15-ны дотор тухайн жилд хийгдэх улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрийн тодотголын төслийг Засгийн газарт хүргүүлнэ гэж тус хуулийн 28-р зүйлийг 9- хэсэгт зааж өгсөн байна.

Монгол улсын Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулийн 11-р зүйлийн 4-р хэсэгт “Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрийн гүйцэтгэлд үндэсний хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага хоёр жил тутам хяналт-шинжилгээ, үнэлгээ хийнэ” гэж заасны дагуу хяналт-шинжилгээ, үнэлгээг хийх шаардлагатай.

Үндэсний Хөгжлийн газар нь 2009 онд хуучнаар Үндэсний хөгжил, шинэтгэлийн хороо байхад боловсруулагдсан хөрөнгө оруулалтын хөтөлбөрөөс хойш анхны хөрөнгө оруулалтын хөтөлбөрийг боловсруулах үе шатыг хэрэгжүүлж байгаа ба дараах төлөвлөгөөний дагуу зохицуулалт хийгдэж байна.



Эх сурвалж: ҮХГ-ын илтгэлийн материалаас

Зураг 4.3.1 2017 оны улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөр боловсруулах төлөвлөгөө

4.4 Үндэсний хөгжлийн газарт тулгарч буй өнөөгийн асуудал

(1) Сангийн яам болон Үндэсний хөгжлийн газрын ажил үүргийн хуваарилалт, хамтын ажиллагаа

Улсын хөрөнгө оруулалтын салбарын төсөл арга хэмжээний үнэлгээ, төлөвлөлтийн хувьд Үндэсний хөгжлийн газар нь хөгжлийн бодлогын хэрэгжилтийн 30 тэрбумаас дээш улсын хөрөнгө оруулалтын төслийг хамруулсан улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөр боловсруулах, хэрэгжүүлэх үе шат болон өнөөгийн төсөв санхүүгийн нөхцөл байдалд суурилсан Сангийн Яамнаас төсвийн сахилга батыг харгалзан үзсэний үндсэн дээр улсын төсвийн менежментийн талаас тухайн жилийн төсөв, төсөв боловсруулах үе шатны хувьд улсын хөрөнгө оруулалтын эрэмбэ¹, түүний үнэлгээний аргачлал нь өөр өөр байна. Одоогийн байдлаар Үндэсний Хөгжлийн газар, Сангийн яам хоёрт үнэлгээ хийх нэгдсэн стандарт байхгүй байгаа хэдий ч цаашид хоёр тал энэ асуудалд дээр анхаарал хандуулж нэгдсэн стандарт боловсруулж, тэрхүү стандартыг мөрдлөг болгож өөрсдийн өнцгөөс үнэлгээ, төлөвлөгөө бий болгох зэрэг шийдвэрүүдийг гаргах шаардлагатай болов уу.

Хөрөнгийн эх үүсвэрийн хувьд хөрөнгө оруулалтын хөтөлбөрт хуваарилагдах ёстой төсвийн хязгаар нь Үндэсний хөгжлийн газарт тодорхой бус байна. Цаашид улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрийг боловсруулахтай холбогдуулан төсвийн эх үүсвэрийг хэтрүүлсэн хэсгийн санхүүжилт, түүнийг төлөвлөх бодлогод асуудал үүсэх магадлал санаа зовоож байна. 2017 оны төсөвт улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 250,654 сая, Хөгжлийн банканд 172,794 сая, мөн барих- шилжүүлэх концессын төрлөөр хэрэгжүүлэх төсөл арга хэмжээнд 71,518 сая төсөвлөгдсөн хэдий ч хөрөнгө оруулалтын хөтөлбөрийн тооцоолол хийгдсэн эсэх нь тодорхой бус байна. Мөн аль хэдийн төсөвт тусгагдсан барих- шилжүүлэх концессын төрлөөр хэрэгжүүлэх төсөл арга хэмжээнд санхүүжилт үзүүлэх тал дээр төсвөөс гаргах боломж байгаа хэдий ч, цаашид хөрөнгө оруулалтын төслийг төр, хувийн хэвшлийн түншлэлийн хэмжээнд хийнэ гэж үзсэн тохиолдолд ирээдүйгээ харсан төсвийн төлөвлөлт, төсвийн хязгаар зэрэг тодорхой болгох шаардлагатай асуудлууд байгаа.

Нөгөө талаас хөгжлийн бодлого болон одоогийн салбарын яамдын бодлогыг эргэн харах тал дээр хоёр талаас ихээхэн анхаарал хандуулж байгаа. Энэхүү салбарт ч хөгжлийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах Үндэсний хөгжлийн газар болон улсын төсвийн менежмент дэхь улсын хөрөнгө оруулалтын байр суурийг тодорхой болгох зорилго бүхий Сангийн яам эцсийн шатны бодлогын үнэлгээний шалгуур ялгаатай байх хэмээн төсөөлөгдөж буй ч суурь дүн шинжилгээ хийх хэсэг нь хоёр тал хамтран ажиллаж шийдвэрлэх боломжтой юм.

¹ Хөрөнгө оруулалтын төслийн дарааллын ялгаа Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хууль, Төсвийн тухай хуульд Үндэсний Хөгжлийн Газар нь Хөгжлийн бодлого төлөвлөлтийг хариуцсан эрх үүргийг “Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв” гэснийг “Үндэсний хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны” гэж тус тусын үйл ажиллагааны эрх үүргийн ялгааг заасан.

(2) Салбарын хөгжлийн бодлого, хөрөнгө оруулалтын хөтөлбөрийн нэгдсэн зохицуулалт, эрх үүрэг

Дээр дурдсанчлан, Үндэсний хөгжлийн газар нь хууль эрх зүйн хүрээнд улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөр боловсруулах, хэрэгжүүлэхтэй холбоотой бүхий л ажлыг бүрэн эрхийн хүрээнд зохион байгуулах нь тодорхой байгаа. Нөгөө талаар салбарын бодлого, түүнд суурилсан хөрөнгө оруулалтын хөтөлбөрийн саналын үнэлгээг салбарын яамдын мэргэжлийн мэдлэг, мэдээлэл шаардлагатай байгаа. Гэвч Үндэсний хөгжлийн газар бүх салбарын мэргэжлийн мэдлэг, мэдээлэлд хариу өгөх нь хүндрэлтэй юм. Тодорхой бодлого төслийн саналын үнэлгээнд хязгаарлагдалгүйгээр хөрөнгийн эх үүсвэрийг бүрдүүлэх аргачлал, салбарын яам хоорондын зохицуулалтыг ч мэргэжлийн өндөр түвшинд хийх шаардлагатай. Цаашид дээрх асуудлуудад дэмжлэг үзүүлэх шаардлагатай.

Техникийн талын асуудлаас гадна өнөөгийн Үндэсний хөгжлийн газрын төрийн захиргааны байр суурийг шийдвэрлэх шаардлагатай. Яамдын бодлого, улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрт тусгагдах төслүүдийг зохицуулах байгууллага болох Үндэсний хөгжлийн газрын төрийн захиргааны байр суурь нь агентлагын түвшнийх, бүтэц зохион байгуулалтын хувьд зохицуулалт хийгдэх яамны доор байх бүтэцэд багтаж байна. Ерөнхий сайдын шууд удирдлаганд байдаг тохируулагч агентлаг нь яамдын хөрөнгө оруулалтын хөтөлбөрийн зохицуулалтыг хийдэг байгууллагын хувьд багаар бодоход яамтай ижил түвшинд байх талаар шийдвэрлэх шаардлагатай.

(3) Үндэсний хөгжлийн газрын хэлтсүүдийн захиргааны чадавхийг бэхжүүлэх, шаардлага

Өнөөдөр эрх зүйн хувьд Үндэсний хөгжлийн газрын эрх, үйл ажиллагааны чиг үүрэг нь үндэсний хөгжлийн бодлогын хөрөнгө оруулалтын харилцаа, бүс нутгийн хөгжлийн харилцааны бодлого боловсруулалт болон хэрэгжилтийн хяналт юм. Гэвч бодлогын салбарын бодлого төлөвлөлт, хэрэгжилтийн үе шатыг бүхэлд нь зохицуулахад бүтэц бүрэлдэхүүний хувьд туршлага хомс байна.

“Салбарын хөгжлийн бодлого, зохицуулалтын хэлтэс” нь улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрийг боловсруулах үе шатны ажлыг хариуцаж байгаа. Энэхүү хэлтсийн харьяа судалгаа шинжилгээний алба нь төслийн саналын үнэлгээ, судалгаатай холбоотой мэдээллийг нэгтгэн цуглуулж дүн шинжилгээг хийнэ. Тус хэлтсийн дарга түүнчлэн голлох мэргэжилтэнүүд өмнөх Засгийн газрын үед улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөр болон хөрөнгө оруулалтын хөтөлбөрийг боловсруулж байсан Үндэсний хөгжил, шинэтгэлийн хороо, Эдийн засгийн хөгжлийн яам, Аж үйлдвэрийн яаманд холбогдох ажил үүргийг тасралтгүй гүйцэтгэж ирсэн туршлагатай мэргэжилтэнүүд бөгөөд Үндэсний хөгжлийн газрын удирдлагын хэрэгжүүлэх түвшинд дадлага туршлагатай гол цөм болж байгаа хэдий ч бусад хэрэгжүүлэх түвшний бүтэц бүрэлдэхүүн, туршлага хомс байгаа нь бодит байдал юм. Цаашид салбарын бодлого,

улсын хөрөнгө оруулалтын саналын үнэлгээ, ялангуяа яам хоорондын зохицуулалтын чадавхийг сайжруулах нь хамгийн наад захын асуудал гэж хэлж болно. Одоогийн нөхцөлд 5 сарын 15 хүртэл боловсруулах улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрийн төслийн саналд чиглэсэн үе шат ихээхэн чухал Үндэсний хөгжлийн газрын чадавхийг бэхжүүлэх хэрэгцээ ихтэй байгаа гэж ойлгож болох ч урт хугацааны байр сууриас харан хэрэгжилтийн үйл ажиллагааны үнэлгээ, гүйцэтгэлийн үнэлгээ, хөрөнгө оруулалтын хөтөлбөрийн дүн шинжилгээ зэрэг үе шатны чадавхийг хөгжүүлэх тал дээр яаралтай арга хэмжээ авах хэрэгтэй байна.

Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрт хамрагдсан улсын хөрөнгө оруулалтын төслийн хэрэгжилтэд чиглэгдсэн чухал асуудлын нэг болох төр, хувийн хэвшлийн түншлэл зэрэг хувийн аж ахуй нэгжийн хөрөнгө оруулалттай холбоотой бодлого зохицуулалтыг “Хөрөнгө оруулалтын нэгдсэн бодлогын хэлтэс” хариуцаж байгаа ч цаашид (өмнөх Засгийн газар хүртэл) энэхүү үйл ажиллагааг хариуцаж байсан Хөрөнгө оруулалтын газраас хэрэгжүүлэх түвшний 3 мэргэжилтэнг томилсон ба хуучин хөрөнгө оруулалтын газраас шилжсэн чиг үүргийг багтаагаад тус хэлтсийн боловсон хүчний чадавхийг сайжруулах тал дээр ихээхэн хүлээлттэй байгаа.

Энэ он гарсанаар бодлого төлөвлөлтийн үнэлгээний маш их туршлагатай шинэ хэлтсийн даргатай болсон “Хөгжлийн бодлогын төлөвлөлтийн хэлтэс” нь 8 мэргэжилтэний орон тоотой боловч одоогоор 5 мэргэжилтэнтэй, 3 орон тоо сул байгаа. Хэрэгжилтийн түвшинд 3 залуу мэргэжилтэн үйл ажиллагааг гардан хэрэгжүүлж байгаа ба бүтэц бүрэлдэхүүнийг өргөжүүлэх, чадавхийг бэхжүүлэх шаардлага их байна.

(4) Хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтыг хамруулсан цогц хөрөнгө оруулалтын бодлогын хэрэгцээ шаардлага

Дээр дурдсанчлан 2016 оны Ерөнхий сайдын 64-р захирамжид Үндэсний хөгжлийн газар нь “Цогц хөрөнгө оруулалтын бодлого, гадаадын хөрөнгө оруулалтын бодлого болон холбогдох заалт журам, концесс төр хувийн хэвшлийн түншлэлийн бодлогын боловсруулалт”-ын эрх бүхий байгууллага гэж заасан. Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөр нь хөгжлийн бодлоготой нийцсэн цогц хөрөнгө оруулалтын бодлогыг хэрэгжүүлэхэд зориулсан төлөвлөгөө юм. Хөрөнгө оруулалтын хөтөлбөрт хамрагдах төслийн үнэлгээнээс гадна хэрэгжүүлэх төлөвлөгөөг боловсруулахад суурь үнэлгээний үзүүлэлтийг цогц хөрөнгө оруулалтын бодлогыг боловсруулах ажлыг яаралтай хийх шаардлагатай.

Одоогийн байдлаар Үндэсний хөгжлийн газарт хөрөнгө оруулалтын хөтөлбөрийг хэлэлцэх ажлын хэсгийг байгуулж, хөрөнгө оруулалтын ерөнхий зураглалыг боловсруулах ажлыг нэгтгэн зохион байгуулах ба мэргэжилтэн, холбогдох хүмүүсийг оролцуулан мэргэжлийн түвшинд хэлэлцэх ажлыг ойрын хугацаанд хэрэгжүүлэх шаардлагатай.

(5) Хуульд суурилсан нарийвчилсан заалт журмын хэрэгцээ шаардлага

Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулийн нэмэлт өөрчлөлт, төсвийн тухай хуулийн нэмэлт өөрчлөлт, Ерөнхий сайдын захирамж, Үндэсний хөгжлийн газрын үйл ажиллагааны үндсэн чиглэлийг баталгаажуулах хууль эрх зүйн тогтолцоог боловсруулах шатанд байгаа. Цаашид улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрийг боловсруулах, хэрэгжүүлэх үе шатаар шаардлагатай хууль эрх зүйн тогтолцоог сайжруулах боломжтой гэж үзэж байгаа хэдий ч одоогийн хууль эрх зүйн дагуу Үндэсний хөгжлийн газар нь тохирсон үйл ажиллагаа явуулж чадахуйц байх шаардлагатай. Төсвийн тухай хуулийн 28-р зүйлийн 4-р хэсэгт зааснаар Үндэсний хөгжлийн газар нь улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрийн техник эдийн засгийн үндэслэлийг хийх эрхтэй. Гэвч Үндэсний хөгжлийн газар нь мэргэжлийн чадамж хараахан бүрэлдэж амжаагүй тул мэргэжлийн чадамжтай салбар яамдын техник эдийн засгийн үндэслэл хийгдчихсэн төслийг хэрхэн техник эдийн засгийн үндэслэлийг хийх ёстой вэ, гуравдагч этгээдэд даалган хийлгэх тохиолдолд хэрхэн үнэлгээ хийх, механизмтай байх вэ гэдгийг тодруулах шаардлагатай.

Цаашилбал тус зүйлийн 6-р хэсэгт урьдчилсан ТЭЗҮ-д суурилсан хэрэгжих боломжийг үндэслэн, Үндэсний хөгжлийн газар нь төслийн саналыг шинээр боловсруулах, ТЭЗҮ-г хэрэгжүүлж болно гэж заасан ч яаманд боловсруулагдсан төслийн саналыг дахин боловсруулах нь бодитой эсэхийг авч хэлэлцэх хэрэгтэй. Төслийн саналын зохицуулалтыг жишээ нь хэд хэдэн яам агентлагаас салбарын төслийн саналаас бүрэлдэхүүнийг сонгож, хөрөнгө оруулалтын төслийн санал болгон дахин боловсруулах тохиолдолд боловсруулах явцыг 6-р бүлэгт заасан боловсруулах гэдэгт оруулж болох эсэх, мөн хэд хэдэн яам, агентлагийн салбарын төслийн хэлбэр агууламж нь бодит байдалд нийцэх эсэх гэх мэтчилэн, олон эргэлзээтэй асуудал, тэдгээрийн хариулт, бүтэц зохион байгуулалтыг баталгаажуулах дүрэм журмыг зохицуулах шаардлагатай.

5 Улсын хөрөнгө оруулалтын мөчлөг дэхь асуудал, шийдвэрлэх арга хэмжээний чиглэл

Уг бүлэгт Монгол улсын Засгийн газрын хэрэгжүүлж буй улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөр боловсруулах үе шат буюу төслийн хэрэгжилт, хяналт-шинжилгээ, үнэлгээ зэрэг улсын хөрөнгө оруулалтын нийт мөчлөгт (5.1 бүлэг) тулгарах гол асуудлыг сонгож, шийдвэрлэх арга хэмжээний талаар авч үзнэ (5.2 бүлэг). Улмаар улсын хөрөнгө оруулалтын мөчлөгийн үе шат бүрт хамтран ажиллах шаардлагатай Үндэсний хөгжлийн газар болон Сангийн яамны хооронд зохицуулалт хийвэл зохих асуудал, хоёр байгууллагын цаашдын хамтын ажиллагаа, зохицуулалтын системийн зохистой хувилбарын талаар авч үзнэ (5.3 бүлэг).

5.1 Улсын хөрөнгө оруулалтын мөчлөгийг цэгцлэх

Энэ хэсэгт Монгол улсын хөрөнгө оруулалтын стандарт мөчлөгийг хөрөнгө оруулалтын удирдлага, зохион байгуулалтын процессийн хүрээнд авч үзнэ. Бодитой байр суурьнаас харахын тулд Дэлхийн банкны “Улсын хөрөнгө оруулалтын удирдлага, зохион байгуулалтын 8 үзүүлэлт”¹-тэй харьцуулна.

(1) Улсын хөрөнгө оруулалтын жишиг үе шат

Юуны өмнө Монгол улсын хууль журамд заасан улсын хөрөнгө оруулалтын удирдлага, зохион байгуулалтын жишиг үе шат, холбогдох байгууллагын чиг үүрэг, хариуцах ажлыг цэгцэлж тодорхойлов.

1) Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөр (PIP) боловсруулах

Монгол улсын Засгийн газар 2010 онд тухайн үед хөгжлийн бодлого төлөвлөлтийн асуудал хариуцаж байсан Үндэсний хөгжил, шинэтгэлийн хороо (National Development Innovation Committee:NDIC) Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөр (PIP) боловсруулах тухай мэдэгдэл гарган, 2011 онд хуулийн төсөл боловсруулсан. 2012 онд Засгийн газар солигдон, ардчилсан намын Засгийн газар байгуулагдсан. Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрийг Засгийн газар баталсан хэдий ч УИХ-аар батлагдаагүй, хуулийн төсөл ч 2013 он хүртэл батлагдаагүй.

Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрийг (PIP) Монгол улсын Төсвийн тухай хуулийн 28.9 зүйлд тулгуурлан 5 дугаар сарын 15-ны дотор Үндэсний Хөгжлийн Газар эцэслэн боловсруулж, Засгийн газарт хүргүүлж батлуулна. 2010-2011 онд Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөр боловсруулах ажлыг хариуцаж байсан зарим ажилтан Үндэсний Хөгжлийн Газарт томилогдож ажиллаж байгаа бөгөөд одоогийн байдлаар үндсэндээ өмнөх туршлагад тулгуурлан хөтөлбөр боловсруулж байна. Гэхдээ өмнөх үетэй харьцуулахад дараах нөхцөл бүрэлдээд байна.

¹ “Must-Have” Features of a Public Investment Management, A Unified Framework for Public Investment Management, Chapter 2, Power of Public Investment Management, Anand Rajaram et al, World Bank Group 2014

- **Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хууль:** Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулийн (2016 оны 7 сард шинэчлэгдсэн) 11 дүгээр зүйлд улсын хөрөнгө оруулалтын төлөвлөлт, хяналт-шинжилгээний талаарх заалт тусгасан байдаг.
- **Монгол улсын төсвийн тухай хууль :** Монгол улсын төсвийн тухай хуулийн (2015 оны 12 сард шинэчлэгдсэн) 28 дугаар зүйлд улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөр боловсруулах тухай заалт тусгагдсан байдаг бөгөөд Үндэсний Хөгжлийн Газар улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөр боловсруулах ажлыг хариуцана хэмээн тодорхой заасан байдаг.
- **Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030:** Урт хугацааны хөгжлийн зорилго, үндсэн чиглэл тодорхойлогдсон. Уг үзэл баримтлалд нийцүүлэн Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрийг боловсруулах боломжтой болсон. Иймд тогтвортой хөгжлийн үзэл баримтлал нь улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөр боловсруулах шатанд, хөтөлбөрт тусгагдах төслийн оновчтой байдал, тэргүүлэх зэрэглэлийг тодорхойлох хэмжүүр болдог.
- **2016-2020 оны Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр:** 2016 оны 6 сард байгуулагдсан шинэ Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр нь дунд хугацааны төлөвлөгөө бөгөөд Монгол улсын төсвийн тухай хуулийн 28.8 дугаар зүйлд заасанчлан улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөртэй адил 4 жилийн хугацаатай (2017 оны 6 сар-2021 оны 5 сар) боловсруулагддаг. Энэ нь дараагийн сонгууль хүртэлх хугацаа юм.

Улсын хөрөнгө оруулалтыг төлөвлөх процесс 2017 оны 1 сарын сүүлийн байдлаар дараах шат дарааллаар хийгдэж байна.

- 2016 оны 11 сард аймаг (18 өдөр), салбарын яам, тамгын газруудыг (25 өдөр) оролцуулан Үндэсний Хөгжлийн Газар эхний зөвлөлдөх уулзалтыг зохион байгуулсан.
- 2017 оны 1 сарын дунд хүртэл салбарын яамд, тамгын газар тус бүр 10 орчим хөрөнгө оруулалтын төслийг эцэслэн шалгаруулж, Үндэсний Хөгжлийн Газарт хүргүүлсэн
- 2017 оны 1 сарын 27-28 өдөр салбарын яам, тамгын газруудыг оролцуулан Үндэсний Хөгжлийн Газар хоёр дахь удаагийн зөвлөлдөх уулзалтыг зохион байгуулсан.

Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөр боловсруулах үе шат нь дээр дурдсанчлан үндсэндээ 2010-2011 оны процедур дагуу хийгдэж байгаа бөгөөд өмнөх алдааг засч сайжруулсан зүйл бий. 2010-2011 онд боловсруулсан улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрийн төсөл 11 мянга давж гарсанаас гадна тэргүүлэх эрэмбэ тодорхой бус, санхүүгийн эх үүсвэрийн үндэслэл бодитой бус байв. Энэ мэт алдаа дутагдалд дүгнэлт хийн, Үндэсний Хөгжлийн Газар салбарын яам, тамгын газраас тодорхой хэмжээнд

тэргүүлэх зэрэглэлээр эрэмблэсэн 10 орчим төслийн санал гаргуулахаар болсон. Улмаар 11, 1 сард Үндэсний Хөгжлийн Газар санаачлан бүх салбарын яам, тамгын газруудыг оролцуулан зөвлөлдөх уулзалт зохион байгуулсан. Үүний дүнд салбарын яамд, тамгын газар зөвхөн өөрсдийн үйл ажиллагаа төдийгүй бусад салбарт хийгдэж буй ажлын талаар мэдээлэл авч, салбар дамнасан цогц арга хэмжээ, хамтын ажиллагааны талаар хэлэлцсэн. Хөрөнгө оруулалтын төслийг хэрхэн сонгон шалгаруулах талаар Үндэсний Хөгжлийн Газраас гаргасан тодорхой удирдамж байхгүй тул салбарын яамд, тамгын газар улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрт тусгах төслийг сонгон шалгаруулахад эдгээр уулзалт, хэлэлцүүлэг чухал ач холбогдолтой. Үндэсний Хөгжлийн Газар 2017 оны 2 сараас хойш улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөр боловсруулах үе шатыг дараах байдлаар төлөвлөж байна.

- 2017 оны 2 сар дотор Үндэсний Хөгжлийн Газар хөрөнгө оруулалтын төслийг сонгон шалгаруулж (салбарын яам, тамгын газар бүрээс 5 төсөл), шаардлагатай тохиолдолд салбарын яам, тамгын газруудтай зохицуулалт хийнэ.
- 2017 оны 3 сард улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрийн саналыг боловсруулж, Засгийн газарт өргөн барьж, Засгийн газартай хамтран эцсийн зохицуулалт хийнэ.
- 2017 оны 5 сарын 15-ний өдөр албан ёсоор өргөн барина.

Одоогийн байдлаар 5 сарын 15-ний өдөр хүртэл улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөр боловсруулахаар ажиллаж байна.

2) Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрийн хэрэгжилт, хяналт-шинжилгээ, үнэлгээ

Засгийн газраар батлагдсаны дараах улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрийн хэрэгжилт, хяналт-шинжилгээ, үнэлгээний үе шатны талаар Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хууль, Монгол улсын төсвийн тухай хуулинд дараах байдлаар заасан байдаг.

Хүснэгт 5.1.1 Хэрэгжилт, хяналт-шинжилгээ, үнэлгээний үе шатанд хамаарах хууль журам

Хураангуй	Хуулийн үндэслэл
Засгийн газар улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрийг дөрвөн жилд нэг удаа баталж, жил бүр тодотгоно.	Монгол улсын төсвийн тухай хуулийн 28.8 дугаар зүйл
Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрийн гүйцэтгэлд үндэсний хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага хоёр жил тутам хяналт-шинжилгээ, үнэлгээ хийнэ.	Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулийн 11.4 дүгээр зүйл
Хөрөнгө оруулалтын эдийн засгийн үр ашиг, нийгмийн ач холбогдлыг харгалзан үр дүнг тооцох аргачлалыг Сангийн яам батлана.	Монгол улсын төсвийн тухай хуулийн 28.11 дугаар зүйл

Эх сурвалж: Монгол улсын төсвийн тухай хууль, Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хууль

Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөр нь 4 жилийн хугацаатай бөгөөд жил бүр “тодотгоно”. Улмаар “хяналт-шинжилгээ”, “үнэлгээ” 2 жил тутам хийнэ. “Тодотгол” “хяналт-шинжилгээ”, “үнэлгээ”-ний талаар тодорхой ухагдахуун, арга хэмжээний талаар тусгагдаагүй байна. Мөн Монгол улсын төсвийн тухай хуулийн 28.11 дугаар зүйлд Сангийн яам “хөрөнгө оруулалтын эдийн засгийн үр ашиг, нийгмийн ач холбогдлыг харгалзан үр дүнг тооцох аргачлалыг батлана” гэж заасан байдаг. Уг 11 дүгээр заалт нь 28 дугаар зүйлийн “улсын хөрөнгө оруулалт”-нд хамаарах тул “улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөр, төсөл хэрэгжсэний дараах нийгэм эдийн засгийн үр өгөөжийг Сангийн яам үнэлнэ” гэж тайлбарлаж болно. Гэхдээ уг заалтад “үнэлгээ” нь урьдчилсан үнэлгээ эсэх, хэрэгжиж дуусах үеийн үнэлгээ эсэх хэрэгжилтийн хугацаа тодорхой тусгагдаагүй байна.

Энэ мэтээр улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрийн мөчлөгийг авч үзэхэд хуулийн үндэслэл хангалттай цэгцрээгүй байна. Боловсруулах ажлыг өмнөх туршлагад тулгуурлан, 5 сарын 15-ний өдөр өргөн барихаар ажиллаж байгаа хэдий ч өргөн барьсаны дараа тодорхой үе шаттай процедурын дагуу боловсруулах болно гэж үзэж байна. Үүний зэрэгцээ жил бүр тодотгон (Монгол улсын төсвийн тухай хуулийн 28.8 дугаар зүйл), хяналт-шинжилгээ(Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулийн 11.4 дүгээр зүйл), үнэлгээ хийж (Монгол улсын төсвийн тухай хуулийн 28.11 дүгээр зүйл), эдгээр мөчлөгт хийгдэх ажлыг тодорхойлж, холбогдох аргачлалыг авч хэлэлцэх шаардлагатай байна.

(2) Дэлхийн банкны “Улсын хөрөнгө оруулалтын менежментэд заавал байх ёстой 8 үзүүлэлт”-ийг Монгол улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрт дүйцүүлж хэрэглэх нь

Дэлхийн банк өндөр хөгжилтэй болон бусад орнуудын туршлагад тулгуурлан улсын хөрөнгө оруулалтын удирдлага, менежментийг сайжруулахад шаардлагатай “Улсын хөрөнгө оруулалтын менежментэд заавал байх ёстой 8 үзүүлэлт”-ийг боловсруулсан байдаг². Эдгээр 8 үзүүлэлт бүрийн функцийн талаар дараах зурагт тодорхой тусгав.

² A Unified Framework for Public Investment Management, Chapter 2, The Power of Public Investment Management, Rajaram Anand et al, (World Bank 2014)



Эх сурвалж: The Power of Public Investment Management, Anand Rajaram et al, WB 2014

Зураг 5.1.1 Дэлхийн банкны “Улсын хөрөнгө оруулалтын менежментийн 8 үзүүлэлт”

Тус судалгаагаар дээр дурдсан 8 шатлалт үзүүлэлтийг Монгол улсын хөрөнгө оруулалтын мөчлөгт дүйцүүлж буулган, мөчлөг бүрт тулгарч буй болон цаашид гарч болзошгүй асуудлыг авч үзэв. Юуны өмнө Дэлхийн банкны 8 шатлалт үзүүлэлт нь Монголын нөхцөлд нийцэх эсэхийг судлах шаардлагатай. Уг судалгаанд тодорхой асуудлыг авч хэлэлцэхдээ Монголын өнөөгийн тогтолцоонд эдгээр 8 шатлалт үзүүлэлт нийцэх эсэх, хэрэглэх боломжтой эсэхийг авч үзэв. Дараах хүснэгтэнд 8 үзүүлэлтийн агуулга болон Монгол улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөртэй хэрхэн нийцэх талаар тайлбарлав.

Хүснэгт 5.1.2 Дэлхийн банкны “Улсын хөрөнгө оруулалтын менежментийн 8 үзүүлэлтийг Монголын тогтолцоонд нийцүүлэх”

Үзүүлэлт	Монгол улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрт нийцүүлэх
<p>1. Guidance & Screening</p> <p>Энэхүү мөчлөгийн үндэслэл болох хууль, журам, хөгжлийн бодлого, төлөвлөлт, зорилт</p>	<p>4 жил тутам улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөр боловсруулна (Монгол улсын төсвийн тухай хуулийн 28 дугаар зүйл). Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр (2016-2020), улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөр хоорондын уялдааг шалгана.</p>
<p>2. Formal Project Appraisal</p> <p>Салбарын яам газрын түвшинд хийгдэх улсын хөрөнгө оруулалтын төслийн дүгнэлт, F/S, загвар, Cost-Benefit Analysis хамаарна.</p>	<p>Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрт тусгагдах шинэ төслийн саналыг (30.0 тэрбум төгрөгөөс дээш хэмжээний) салбарын яам боловсруулж, Үндэсний Хөгжлийн Газарт хүргүүлнэ. (Монгол улсын төсвийн тухай хуулийн 28 дугаар зүйл) .</p>
<p>3. Independent Review of Appraisal</p> <p>Хөтөлбөрт тусгахаар санал тавигдаж буй хөрөнгө оруулалтын төслийг бие даасан байгууллага урьдчилан үнэлнэ. Хөндлөнгийн байгууллагаар үнэлгээ хийлгэн Optimism Bias (өндөр өртөг, илүү зардал) үүсэхээс сэргийлнэ.</p>	<p>Улсын төсвийн хөрөнгө оруулалтыг төлөвлөх шатанд хөрөнгө оруулалтын хөтөлбөрт тусгах төсөл, арга хэмжээний саналыг Үндэсний Хөгжлийн Газар үнэлнэ (Монгол улсын төсвийн тухай хуулийн 28.6 дугаар зүйл). Хөрөнгө оруулалтын эдийн засгийн үр ашиг, нийгмийн ач холбогдлыг харгалзан, төслийн үр дүнг тооцох аргачлалыг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална. (Монгол улсын төсвийн тухай хуулийн 28.11 дүгээр зүйл) .</p>
<p>4. Project Selection and Budgeting</p> <p>Хязгаарлагдмал санхүүгийн эх үүсвэрийг ашиглахдаа төслийг тэргүүлэх зэрэглэлээр эрэмбэлэх, дунд урт хугацааны санхүүгийн эх үүсвэрийг хуваарилах, төслийн санхүүгийн эх үүсвэрийг хангана.</p>	<p>Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрт төсөв, гадаад зээллэг, тусламж болон концессын гэрээ, Засгийн газрын өрийн баталгаа, Хөгжлийн банкны санхүүжилтээр хэрэгжих төсөл, арга хэмжээ хамаарна. (Монгол улсын төсвийн тухай хуулийн 28.10 дугаар зүйл) . Монгол улсын төсвийн тухай хуульд улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрийг төлөвлөх үед тэргүүлэх зэрэглэлээр эрэмбэлэх хэмжүүр, санхүүгийн эх үүсвэрийг хэрхэн хангах талаар тодорхой заагдаагүй байна.</p>
<p>5. Implementation</p> <p>Төсөл хэрэгжүүлэх нарийвчилсан төлөвлөгөө боловсруулах, мониторинг хийх</p>	<p>Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрийн гүйцэтгэлд үндэсний хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага хоёр жил тутам хяналт-шинжилгээ, үнэлгээ хийнэ. (Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулийн 11.4 дүгээр зүйл)</p>
<p>6. Project Adjustment</p> <p>Төслийн зардал талаас хяналт, зохицуулалт хийнэ.</p>	<p>Улсын улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрийг жил бүр тодотгоно.</p>

Үзүүлэлт	Монгол улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрт нийцүүлэх
Төслийн зардалд өөрчлөлт орсон тохиолдолд авах арга хэмжээ, төслийн үр өгөөж, төсвийн эх үүсвэрийг судлана.	Төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын тухай “Улсын хөрөнгө оруулалтын санхүүжилтийн журам”-д (Сангийн сайдын 2012 оны 290 дугаар тушаалын хавсралт) заасан байдаг.
<p>7. Facility Operation</p> <p>Төсөл хэрэгжсэний дараах 1)урсгал зардал, засвар үйлчилгээний хяналт, ашиглалт хариуцагч байгууллагад шилжсэн байх, 2) урсгал зардал төсөвт тусгагдсан байх, (3) хөрөнгийн хяналт тодорхой байх шаардлагатай.</p>	<p>Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрийн түвшинд төсвийн хөрөнгө оруулалт хэрэгжсэний дараах засвар үйлчилгээнд хамаарах тодорхой заалт байхгүй.</p> <p>Улсын хөрөнгө оруулалтын төслийн төлөвлөлтийн үе шатанд хөрөнгийн ашиглалттай холбоотой зардал, орон тоог санхүүжүүлэх шаардлагатай гэсэн заалт холбогдох хуульд бий (Монгол улсын төсвийн тухай хуулийн 29.2 дугаар зүйл).</p>
<p>8. Completion, Review and Evaluation</p> <p>Төсөл хэрэгжсэний дараа, төслийн дараах үнэлгээг хийнэ. Хөтөлбөр, төслийн гүйцэтгэл, тогтвортой байдал, үр дүнг тооцож үнэлнэ.</p>	Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрийн гүйцэтгэлд хоёр жил тутам хяналт-шинжилгээ, үнэлгээ хийнэ. (Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулийн 11.4 дүгээр зүйл) .

Эх сурвалж: The Power of Public Investment Management-д тулгуурлан судалгааны баг боловсруулав.

5.2 Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөр боловсруулах үе шат бүрт тулгарах асуудал, шийдвэрлэх арга хэмжээ

Энэхүү хэсэгт дээр дурдсан Монгол улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрийн мөчлөгт дүйцүүлэн Дэлхийн банкны “Улсын хөрөнгө оруулалтын менежментийн 8 үзүүлэлт” тус бүрээрх өнөөгийн байдал, цаашид гарч болзошгүй үндсэн асуудлыг сонгов. Судалгааны баг эдгээр асуудлыг сонгохдоо баримт бичиг судлах, холбогдох хүмүүстэй ярилцлага хийх, төрөл бүрийн семинарт оролцох зэргээр хуримтлуулсан мэдээлэл, 2017 оны 1 сарын 31-ний өдөр судалгааны багаас зохион байгуулсан “Улсын хөрөнгө оруулалтад тулгарч буй асуудал, шийдвэрлэх арга зам” семинарын үеэр хэлэлцсэн асуудлыг нэгтгэж боловсруулав. Мөн эдгээр асуудлыг шийдвэрлэх арга хэмжээний хувилбарыг (төсөл) авч үзэв. Хэрэгжүүлэх арга хэмжээг тодорхойлохдоо судалгааны багийн санал зөвлөмжөөс гадна “Улсын хөрөнгө оруулалтад тулгарч буй асуудал, шийдвэрлэх арга зам” семинарын үеэр оролцогчид хэлэлцсэн санал, уг семинарын үр дүнд тулгуурлан судалгааны багаас гаргасан дүгнэлт зэргийг тусгасан болно. Семинарын үеэр шалтгаан үр дагаварын диаграмд тулгуурлан тодорхой асуудал, шийдвэрлэх арга хэмжээг цэгцэлж тодорхойлохдоо Problem-Driven Iterative Adaption (PDIA) аргачлалыг ашиглав. Семинарын үеэр ашигласан схем зургийг дор тусгав.



Эх сурвалж: ЖАЙКА судалгааны баг


Зураг 5.2.1 Улсын хөрөнгө оруулалтын менежментийн тогтолцоог бүрдүүлэхэд тулгарах асуудал, арга хэмжээ

(1) Guidance and Screening

Guidance and Screening шатанд хууль журам, эрхэм зорилго, хөгжлийн төлөвлөгөө, эрх зүйн орчин нь улсын хөрөнгө оруулалтын удирдлага, зохион байгуулалтыг хэрэгжүүлэхэд гол хэмжүүр болдог эсэхийг авч үзнэ. Монгол улсад 6.1 (1)-д дурдсанчлан улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрийн удирдлага, зохион

байгуулалтын тухай холбогдох хууль бий. Монгол улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030, 2016-2020 оны Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр нь улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөр боловсруулах гол чиглэл болдог. 2016-2020 оны Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, одоо боловсруулагдаж буй улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөр нь 2017 оны 5 сарын 15-ний өдрөөс хойш 4 жилийн хугацаанд хүчин төгөлдөр байх бөгөөд цаг хугацааны хувьд хоорондоо уялдаатай байна.

Энэ шатны асуудал, шийдвэрлэх арга хэмжээний хувилбарын хураангуйг дор дурдав.



Эх сурвалж: ЖАЙКА-ийн судалгааны баг

Зураг 5.2.2 Guidance and Screening шатны асуудал, арга хэмжээний хувилбар

【Асуудал】 Уг асуудлын талаар дор дэлгэрэнгүй тайлбарлав.

- **“Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөр”-ийн тодорхойлолт тодорхой бус байна:**
Энэ асуудлыг дээр дурдсан семинарын үеэр Үндэсний Хөгжлийн Газрын ажилтнуудын зүгээс хөндөж байсан юм. Монгол улсын төсвийн тухай хуулийн 28.1 дүгээр зүйлд заасанчлан улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрт “эдийн засаг, нийгмийн хөгжлийг урт хугацаанд хангахад чиглэгдсэн, нэгээс дээш жилийн хугацаанд хэрэгжих 30.0 тэрбум төгрөгөөс дээш өртөг бүхий дэд бүтэц, хөгжлийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ”-г хамруулдаг. Монгол улсын төсвийн тухай хуулийн 28.10 дугаар зүйлд “улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрт төсөв, зээл, тусламж болон концессын гэрээ, Хөгжлийн банкны санхүүжилтээр хэрэгжих төсөл, арга хэмжээ хамаарна” гэж заасан байдаг. Гэхдээ уг тодорхойлолт нь тодорхой жишээгээр Засгийн газрын байгууллагууд дунд нэгдсэн ойлголттой болоогүй байгаа тул салбарын яам газраас боловсруулах улсын хөрөнгө

оруулалтын хөтөлвөрт тусгагдах төсөл дотор дээр дурдсан нөхцлийг хангахгүй төсөл олон гардаг.

Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрийн ухагдахуун тодорхой бус тул хөрөнгө оруулалтын хөтөлвөрт тусгахад хангалттай эсэхийг шийдэхэд хүндрэлтэй санал гардаг. Тухайлбал 30.0 тэрбум төгрөгөөс доош дэд бүтцийн төслийг олон тооны бүс нутагт хэрэгжүүлж, эдгээрийг нэгтгэн нийт 30.0 тэрбум төгрөгөөс дээш төсөл болгож хөтөлвөрт тусгах тохиолдолд үүнийг улсын хөрөнгө оруулалтын төсөл гэж үзэж болох эсэх, эсвэл бүс нутгаар нь хувааж, тусдаа төсөл гэж санал оруулах эсэхийг цаашид хэлэлцэх шаардлагатай.

- **Улсын хөрөнгө оруулалтын хөтөлвөрт тусгах төсөл нь тогтвортой хөгжлийн үзэл баримтлал, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд үр өгөөжтэй аргачлал эсэхийг шалгахад хүндрэлтэй:** Тогтвортой хөгжлийн үзэл баримтлалд 2030 он хүртэлх хөгжлийн зорилго тусгагдсан байдаг. Тогтвортой хөгжлийн үзэл баримтлалын 1-р шатны зорилгот хугацаа болох 2020 он хүртэлх Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн зорилго, үйл ажиллагааны төлөвлөгөө юм. Улсын төсвийн хөрөнгө оруулалт нь Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх чухал арга хэрэгсэл хэдий ч Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлвөрт ямар үр өгөөж үзүүлэхийг хэмжихэд амаргүй. Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр талаас авч үзвэл улсын хөрөнгө оруулалтын хөтөлвөрт тусгагдсан нэгж төслийн үр өгөөжөөр Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтэнд хувь нэмэр оруулахад амаргүй. Нөгөө талаар улсын хөрөнгө оруулалтын төслийн талаас авч үзвэл Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн зорилготой адил улсын хөрөнгө оруулалтын төслийн саналуудыг тэргүүлэх зэрэглэлээр эрэмбэлж харьцуулахад амаргүй байдаг.

Энэ нь Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр болон улсын хөрөнгө оруулалтын төслийн хооронд логик ялгаа их байдагтай холбоотой. Салбарын яам, тамгын газар болон аймгийн бодлогын бичиг баримтаар уг зөрүүг шийдвэрлэдэг хэдий ч өнөөгийн байдлаар 200 гаруй бодлогын бичиг баримтын ихэнхи нь Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал, 2016-2020 оны Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр боловсруулагдахаас өмнөх бодлого тул улсын хөрөнгө оруулалтын хөтөлвөрт тусгагдах төслийг тэргүүлэх зэрэглэлээр эрэмбэлэхэд эдгээр баримт бичгийг хэрэглэхэд амаргүй.

- **Улсын хөрөнгө оруулалтын хөтөлвөрт тусгагдах төсөл болон өмнө төлөвлөгдсөн “мега төсөл”-ийн уялдаа тодорхой бус байна. “Мега төсөл” нь улсын хөрөнгө оруулалтын төслөөр сонгогдсон тохиолдолд одоогийн нөхцөлд нийцэх эсэхийг шалгах шаардлагатай:** Өнөөг хүртэл Засгийн газар эдийн засагт өндөр үр өгөөжтэй гэж үзсэн төслийг “мега төсөл” гэж нэрлэн, жагсаалт гаргаж,

эдгээр төслийг хэрэгжүүлэхээр судалж ирсэн. Төлөвлөгдөж буй дийлэнхи мега төсөл их үр нөлөөтэй болох нь гарцаагүй юм. Гэхдээ тогтвортой хөгжлийн үзэл баримтлал, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөртэй тулгаж харьцуулан, эдгээр төслөөс тодорхой ямар үр өгөөж гарсаныг тооцдоггүй. Мөн мега төслийн ихэнхи нь хувийн секторын хөрөнгө оруулалт, гадаадын хөрөнгө оруулалтын оролцоотой төсөл хөтөлбөр байдаг. Одоогийн хууль журмын дагуу улсын хөрөнгө оруулалтын төсөл гэж үзэх боломжгүй зүйл ч бий. 2016 оны 11 сар, 2017 оны 1 сард Үндэсний Хөгжлийн Газраас зохион байгуулсан салбарын яам газрын зөвлөгөөний үеэр нэлээд салбарын яам газарт мега төслийг улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрт оруулахаар судалж байгаа талаар дурдаж байв. Иймд мега төслийн ач холбогдол, улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрт тусгах эсэхийг судлах шаардлагатай.

【 Шийдвэрлэх арга хэмжээ 】 дээрх 3 асуудлыг шийдвэрлэх арга хэмжээний хувилбарыг дор авч үзэв. Эдгээр арга хэмжээ нь дээрх асуудалд нийтэд нь хамаарна.

- **“Улсын хөрөнгө оруулалт”-ын тодорхойлолтыг тодорхой болгож, Улсын их хурал, Засгийн газар нэгдсэн ойлголттой болох:** Улсын хөрөнгө оруулалтын тодорхойлолт, хөтөлбөрт тусгах төсөл, арга хэмжээний хамрах хүрээг тодорхойлох шаардлагатай. 30.0 тэрбум төгрөгөөс дээш төслийн талаарх заалтыг дахин судалж, 30.0 тэрбум төгрөгөөс дээш гэсэн хязгаар (sealing) зохистой эсэх (уг шатлалыг нэмэх, багасгах, эсвэл илүү уян хатан “баримжаа хэмжүүр” болгох эсэх), төслийн нийгэм, эдийн засгийн нөлөө, нэн яаралтай хэрэгжүүлэх шаардлагатай төслийг хэрхэн сонгох зэрэг үзүүлэлтийг судлах шаардлагатай.
- **Салбарын яам газар, аймгийн бодлогын бичиг баримтыг цэгцэлж, улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрт тусгагдах төслийн уялдаа хамаарлыг шалгах боломжтой болгох:** одоогийн байдлаар боловсруулагдаад буй 200 гаруй салбарын яам газар, аймгийн бодлогын бичиг баримтыг судлах, тогтвортой хөгжлийн үзэл баримтлал, 2016-2020 оны Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн уялдаа хамаарлыг шалгах. Улсын хөрөнгө оруулалтын уялдааг шалгах уг үе шат нь улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөр боловсруулахын өмнө дууссан байх ётой. Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрийг өргөн барих 2017 оны 5 сарын 15-ний өдөр хүртэл Үндэсний Хөгжлийн Газар, Сангийн яам дараах үе шаттай арга хэмжээг судалж байна.
 - Монгол улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал 2030-д холбогдох үзүүлэлтийг Sustainable Development Goal (SDG) зорилготой тулгаж шалган, үзүүлэлт бүрийг 5 жил тутам үнэлэх гол хэмжүүрийг боловсруулах
 - Дээр дурдсан тогтвортой хөгжлийн үзэл баримтлалын гол хэмжүүр, 2016-2020 оны Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн 2020 оны зорилгын уялдааг шалгах

- 200 гаруй бодлогын бичиг баримтыг судалж, 2016-2020 оны Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн уялдааг шалган, шаардлагатай бичиг баримтыг засч сайжруулах ажлыг салбарын яам газар, аймгаар гүйцэтгүүлэх


Эдгээр арга хэмжээ нь улсын хөрөнгө оруулалтын уялдаа хамаарлыг шалгах үе шат тул уг нь улсын хөрөнгө оруулалтын төлөвлөлтийн өмнө дуусан байх хэрэгтэй. Гэхдээ улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөр боловсруулж дуусах хугацаа нь 2017 оны 5 сарын 15-ний өдөр тул уг үе шат нь 2018 оны улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрийн тодотгол хийх хүртэл хэрэгжиж дуусна. Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал болон Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөртэй уялдаатай бодлогын бичиг баримтанд тулгуурлан улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрийг шалган, шаардлагатай бол засч сайжруулна.

- **Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, салбарын яам газар, аймгийн бодлогын бичиг баримттай уялдуулан улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөр боловсруулах тодорхой удирдамж (Үндэсний Хөгжлийн Газар, Сангийн яамнаас салбарын яам, тамгын газар болон аймагт хандсан зааварчилгаа) боловсруулах:** Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөр боловсруулах үе шатанд дээр дурдсан улсын хөрөнгө оруулалтын тодорхойлолт, эрхэм зорилгын уялдаа хамаарлын талаар салбарын яам газрын түвшинд нэгдсэн ойлголттой болох зорилгоор улсын хөрөнгө оруулалтын төслийн санал боловсруулахын өмнө Үндэсний Хөгжлийн Газар, Сангийн яамнаас удирдамж гаргах. Ингэснээр төслийн саналуудыг тэргүүлэх зэрэглэлээр эрэмбэлэн, хэлэлцэх ажил Үндэсний Хөгжлийн Газар, Сангийн яамны удирдлагын дор саадгүй хэрэгжих боломжтой болно.

(2) **Formal Project Appraisal**

Formal Project Appraisal шатанд салбарын түвшинд хөрөнгө оруулалтын төслийн санал боловсруулах, дотоод үнэлгээ, ТЭЗҮ (feasibility studies: F/S) боловсруулах, зураг төсөл гаргах зэрэг хөрөнгө оруулалтын төсөл боловсруулах үе шат, эдгээр үе шатны ажлын чанарыг шалгана. Монголын улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрийн мөчлөгт, боловсруулалтын шатанд салбарын яам, тамгын газраас тавигдсан төслийн саналууд зөв процедурын дагуу шаардлагатай ТЭЗҮ, зураг төслийн хамт хавсаргасан байхыг шаарддаг.

Уг шатны асуудал, шийдвэрлэх арга хэмжээний хувилбарын хураангуйг дор тусгав.



Эх сурвалж: ЖАЙКА-ийн судалгааны баг боловсруулав

Зураг 5.2.3 Formal Project Appraisal шатны асуудал, шийдвэрлэх арга хэмжээний хувилбар

【Асуудал】 Уг үе шатны асуудлыг дор дэлгэрэнгүй тайлбарлав.

- **Салбарын яам газрын улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрт тусгах төслийн загвар жигд бус байдаг:** энэ нь (1)-д дурдсан улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрийн ухагдахуунтай холбоотой. Салбарын яам, тамгын газрын улсын хөрөнгө оруулалтын төслийн санал нэгдсэн загварт ороогүй янз бүр байдаг нь улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрт тусгах шаардлагатай төсөл, арга хэмжээ эсэхийг шийдэхэд хүндрэлтэй болгодог. Бодит байдалд ийм жишээ олон бий. 30.0 тэрбум төгрөгөөс доош хэмжээний төслийг “чухал ач холбогдолтой төсөл” хэмээн хөтөлбөрт тусгасан тохиолдол нэлээд бий. Мөн дээр дурдсанчлан бага хэмжээний дэд бүтцийн төслийг олон бүс нутагт хэрэгжүүлэх, эсвэл нэг бүс нутагт шууд хамааралгүй олон барилга байгууламжийг нэгтгэн, 30.0 тэрбум төгрөгөөс дээш төсөл болгон санал оруулсан жишээ олон бий.
- **Салбарын яам, тамгын газар төслийн санал гаргах үед санхүүгийн эх үүсвэр баталгаатай болоогүй байдаг:** Салбарын яам, тамгын газар улсын хөрөнгө оруулалтын төслийн санал гаргах үед санхүүгийн эх үүсвэрийг хэрхэн хангах, эсвэл ямар санхүүгийн эх үүсвэр ашиглах талаар судлаагүй тохиолдол олон байна. Санхүүгийн эх үүсвэрийг судалсан зарим төслийн хувьд ч одоогийн эдийн засгийн нөхцөлд төсвөөр хангах, концессын баталгаа гаргах боломжгүй, ХАЁТ-ийн хүрээнд хандивлагч нь баттай болоогүй төсөл олон байна.

【Шийдвэрлэх арга хэмжээ】 дээр дурдсан 2 асуудлыг дараах арга хэмжээгээр шийдвэрлэнэ.

- **Төслийн санал боловсруулах стандарт аргачлал боловсруулах:** улсын хөрөнгө оруулалтын төслийн ТЭЗҮ, хэрэгжүүлэх загвар зэргийг тусгасан хөрөнгө оруулалтын төсөл боловсруулах аргачлалыг стандартжуулах шаардлагатай. Ү ТЭЗҮ боловсруулах аргачлалын талаар 2009 онд гарсан удирдамж байдаг. Гэхдээ


уг аргачлал нь энэ үе шатанд шаардагдах үзүүлэлттэй нийцэхгүй тул шинэчлэх шаардлагатай. Энэ үе шатанд төслийн саналыг улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрт тусгах эсэх, төслийн үр өгөөжийг хэмжих боломжтой хөрөнгө оруулалтын төсөл боловсруулах шаардлагатай байдаг. Түүнчлэн төслийн зардлын ерөнхий тооцоонд тулгуурлан эдийн засаг, санхүүгийн анализ хийж, эдийн засаг, санхүүгийн тал дээр төслийн үр өгөөжийг тодорхойлох шаардлагатай. Хөрөнгө оруулалтын төсөл боловсруулах уг стандарт аргачлал нь (3)-д дурдсан төслийн дүгнэлттэй холбогдох тул бусад үе шаттай уялдаатай аргачлал боловсруулах шаардлагатай.

- **Салбарын яам газар, улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөр, арга хэмжээ тус бүрээр төлөвлөгдөж буй төсвийн хүрээг танилцуулах:** Салбарын яам газар тогтвортой хөгжлийн үзэл баримтлал, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, бодлогын бусад бичиг баримттай уялдуулан хөрөнгө оруулалтын төсөл боловсруулна. Салбарын бодлогод тусгагдсан зорилгыг хэрэгжүүлэх төсөл боловсруулах үед төслийн санхүүгийн эх үүсвэрийн баримжаа тоон үзүүлэлт шаардлагатай болдог. Үндэсний Хөгжлийн Газар, Сангийн яам аль болох нийт санхүүгийн эх үүсвэр болон бүх салбарт (эсвэл аймаг) хуваарилах төсвийг хамтран хэлэлцэж, (1)-д дурдсан удирдамж гаргахын зэрэгцээ салбарын яам газарт хандан санхүүгийн эх үүсвэр бүрээрх “урьдчилсан төсөв”-ийн талаар тодорхой мэдээлвэл зохистой. Эдийн засгийн янз бүрийн хүчин зүйл, хязгаарлалтын улмаас өндөр нарийвчлалтай “урьдчилсан төсөв” гаргах хүндрэлтэй тохиолдолд улсын хөрөнгө оруулалтын төслийн саналууд дотор тэргүүлэх зэрэглэл өндөр төслийг Үндэсний Хөгжлийн Газар, Сангийн яам, салбарын яамдтай хамтран хэлэлцсэний үндсэн дээр санхүүгийн эх үүсвэрээр хангах арга хэмжээ авах шаардлагатай.

(3) Independent Review of Appraisal

Independent Review of Appraisal шатанд яамд газраас санал болгосон төслийг бие даасан байгууллага урьдчилан үнэлэнэ. Энэ шатанд (1)-д дурдсан эрхэм зорилгын уялдаа хамаарлыг шалгахаас гадна зардал тооцон, эдийн засгийн үр өгөөжийг шалгах шаардлагатай. Яам газраас ирсэн төслийн саналууд нь зориуд эсвэл санамсаргүй тооцсон эсэхээс үл хамааран, Optimism Bias (өндөр өртөг, илүү зардал) үүсч, эдийн засгийн үр өгөөжийг хэтрүүлж үнэлэх магадлалтай байдаг. Ийм асуудлыг хөндлөнгийн байгууллагаар үнэлүүлэх замаар сэргийлдэг. Монгол улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөр боловсруулах процесст жагсаалтанд орсон төслийн үр ашиг, өгөөжийн үнэлгээг Үндэсний Хөгжлийн Газар хийж (Монгол улсын төсвийн тухай хуулийн 28.3 дугаар зүйл), төсвийн үр дүнг тооцох аргачлалыг Сангийн яам батална (Монгол улсын төсвийн тухай хуулийн 28.11 дүгээр зүйл).

Уг шатны асуудал, шийдвэрлэх арга хэмжээний хувилбарын хураангуйг дор тусгав.



Эх сурвалж: ЖАЙКА-ийн судалгааны баг

Зураг 5.2.4 Independent Review of Appraisal шатны асуудал, шийдвэрлэх арга хэмжээний хувилбар

【Асуудал】 Уг асуудлын талаар дор дэлгэрэнгүй тайлбарлав.

- **Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрт тусгах төслийг дүгнэх стандарт аргачлал тодорхой тусгагдаагүй байна:** салбарын яам газар улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрт тусгах төслийн саналыг Үндэсний Хөгжлийн Газарт хүлээлгэж өгсөний дараа Үндэсний Хөгжлийн Газар тэргүүлэх ач холбогдолтой төслийг сонгон шалгаруулдаг. Төслийг дүгнэх стандарт аргачлал байхгүй тул төслийн саналыг бодитой үнэлж чадахгүй байна.
- **Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрт тусгасан саналыг төсөл болгож хэрэгжүүлэх, төсөв тооцох үед дүгнэлт хийх нарийвчилсан аргачлал тодорхой бус байна:** улсын хөрөнгө оруулалтыг төлөвлөх процесст хөтөлбөрт тусгагдсан саналыг төсөл болгож хэрэгжүүлэхэд нарийн F/S анализ, загвар төлөвлөж, хөрөнгө оруулалтын саналыг төсөл болгож, төсөвлөн санал оруулдаг. Энэ шатанд Үндэсний Хөгжлийн Газар төсөлд дүгнэлт хийх шаардлагатай. Optimism bias (өндөр өртөг, илүү зардал) үүсэхээс сэргийлэхийн тулд улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрт тусгах төслийн саналыг дүгнэх хэмжүүрээс илүү нарийн дүгнэлт шаардлагатай болдог. Төслийг дүгнэх аргачлал одоогийн байдлаар гараагүй байгаа тул нэгж төслүүдэд бодитой байр сууринаас нарийн үнэлгээ хийж чадахгүй байна.

【Шийдвэрлэх арга хэмжээ】 дээр дурдсан 2 асуудлыг шийдвэрлэхийн тулд дараах 4 арга хэмжээг авч үзэв. Эдгээр арга хэмжээ нь дээрх асуудалд нийтэд нь хамаарна.

- **Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөр боловсруулах үед төслийг урьдчилан дүгнэх стандарт тогтолцоо (үе шат, хэрэглүүр) боловсруулж, бодитой байр сууринаас төслийн үр өгөөж, ашгийг тооцох:** улсын хөрөнгө оруулалтын

хөтөлбөрт тусгах төслийн саналуудыг бодитой дүгнэх үнэлгээний стандарт аргачлалыг боловсруулах. Уг аргачлал нь (2)-д дурдсан төслийн санал гаргах аргачлалтай уялдсан стандарт аргачлал бөгөөд төслийн саналуудыг сонгон шалгаруулахад шаардлагатай үзүүлэлтийг тусгасан байна. Иймд төслийн эрхэм зорилгын уялдааг голлож шалган, зардал, эдийн засгийн үр өгөөжийг санхүүгийн бичиг баримтын хөрөнгийн үзүүлтэнд тулгуурлан шалгана.

- **Төслийн төсөв бүрдүүлэлтийг урьдчилан дүгнэх тогтолцоо боловсруулж, бодитой байр суурьнаас төслийн үр өгөөж, ашгийг тооцож хэмжих:** төслийг дүгнэх стандарт аргачлал боловсруулна. Төслийг дүгнэх зорилго нь улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрөөр хэрэгжүүлэхээр тогтсон төслийн ТЭЗҮ, нарийвчилсан зураг төсөл нь төсөв бүрдүүлэхэд хангалттай хэмжээнд хийгдсэн эсэх, салбарын яам газрын зүгээс илүү зардал, өндөр өртөг байгаа эсэхийг шалгах зэрэг асуудлыг хамрах тул маш нарийн хийх шаардлагатай. Иймд зардал, эдийн засаг, нийгмийн үр өгөөжөөс гадна байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ, төсөл хэрэгжсэний дараах урсгал зардал, засвар үйлчилгээний хяналтын төлөвлөгөө зэрэг өргөн хүрээнд дүгнэнэ.
- **Үндэсний Хөгжлийн Газар, Сангийн яамыг гол нэгж болгосон төслийн үнэлгээний хороо байгуулах:** Дээр дурдсан төслийг дүгнэх аргачлал боловсруулах зорилгод нийцүүлэн хөгжлийн бодлого төлөвлөлтийн уялдаа, эдийн засаг нийгэм, төсвийн бүхий л нөхцлийг харгалзан Үндэсний Хөгжлийн Газар, Сангийн яам хамтран төсөлд дүгнэлт өгөх шаардлагатай. Төслийн агуулгатай нийцүүлэн бусад эрдэмтэн мэргэжлийн хүмүүс болон салбарын яам газрын холбогдох хүмүүсийг оролцуулан төслийг үнэлэх нь зүйтэй. Үндэсний Хөгжлийн Газар, Сангийн яам улсын хөрөнгө оруулалтын бүх төслийн үнэлгээнд оролцох талаар Монгол улсын төсвийн тухай хуульд заасан байдаг тул хоёр байгууллагыг гол нэгж болгосон төслийн үнэлгээний хороо байгуулах шаардлагатай.
- **Урьдчилсан дүгнэлт хийх хүний нөөцийг бэлтгэх:** Үндэсний Хөгжлийн Газар, Сангийн яамны ажилтнуудад төвлөрөн төслийн үнэлгээний технологи, менежментийн мэдлэгтэй хүний нөөцийг бэлтгэх шаардлагатай.

(4) **Project Selection and Budgeting**

Project Selection and Budgeting шатанд улсын хөрөнгө оруулалтын санхүүгийн эх үүсвэрийн хэмжээг магадлан, уг эх үүсвэрийн хүрээнд төслийг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмблэнэ. Санхүүгийн эх үүсвэрийн хүрээг тооцоходоо дунд урт хугацаанд улсын төсөв, ХАЁТ (буцалтгүй тусламж, хөнгөлттэй зээл), концесс, хөгжлийн сан зэрэг санхүүгийн эх үүсвэр бүрээр төсвийн төсөөлөл боловсруулна. Мөн дунд урт хугацааны санхүүгийн эх үүсвэрт тулгуурлан жилийн эцсийн төсвийг тооцох үед төслийн санхүүгийн эх үүсвэрийг хангана. Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрт тусгагдсан төслийг төсөв, гадаад зээллэг, тусламж болон концессын гэрээ,

Хөгжлийн банкны санхүүжилтээр хэрэгжүүлнэ гэж заасан байдаг. (Монгол улсын төсвийн тухай хуулийн 28.10 дугаар зүйл).

Уг шатны асуудал, шийдвэрлэх арга хэмжээний хувилбарын хураангуйг дор тусгав.



Эх сурвалж: ЖАЙКА-ийн судалгааны баг


Зураг 5.2.5 Project Selection and Budgeting шатны асуудал, шийдвэрлэх арга хэмжээний хувилбар

【Асуудал】 Уг асуудлын талаар дор дэлгэрэнгүй тайлбарлав.

- **Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөртэй холбогдох санхүүгийн төлөвлөгөө байдаггүй:** Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрийг 4 жил тутам шинэчлэх бодлогын бичиг баримтанд санхүүгийн эх үүсвэрийг төлөвлөх, хангахад хамаарах тодорхой удирдамж байдаггүй. Сангийн яам боловсруулдаг дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэл нь 3 жил буюу нэлээд хугацааг хамарсан санхүүгийн төлөвлөгөө (rolling plan) хэдий ч улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрийн санхүүгийн эх үүсвэр болох хөгжлийн төсөв, ХАЁТ зэргийн зарцуулалтын талаар тодорхой (төсөл бүрээр) тусгагддаггүй.
- **Санхүүгийн эх үүсвэрийг салбаруудад хэрхэн хуваарилах, Үндэсний Хөгжлийн Газар, Сангийн яам ямар зохицуулалт хийх талаарх хэмжүүр тодорхой бус байна:** Дээр дурдсанчлан дунд урт хугацааны төсвийн эх үүсвэрийн төлөвлөгөө, удирдамж байхгүй нөхцөлд Үндэсний Хөгжлийн Газар, Сангийн яам улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрийг эцэслэн батлахдаа төсөв, санхүүгийн эх үүсвэрийн талаар хэлэлцдэг. Энэ үед ямар эх үүсвэрийг ямар хэмжүүрээр салбар, төслүүдэд хуваарилах, ер нь улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрийн санхүүгийн эх үүсвэрийг хангах ажил нь Үндэсний Хөгжлийн Газрын санаачлагаар хийгдэх ажил эсэх, Сангийн яам төсвөөр хангах шаардлагатай эсэх зэрэг асуудлыг ямар функцээр хэрхэн зохицуулах нь тодорхой бус байна.

【Шийдвэрлэх арга хэмжээ】 дээр дурдсан 2 асуудлыг шийдвэрлэхийн тулд дараах 3 арга хэмжээг авч үзэв. Эдгээр арга хэмжээ нь дээрх асуудалд ерөнхийд нь хамаарна.

- **Хөрөнгө оруулалтын ерөнхий зураглалыг тодорхойлж, улсын хөрөнгө оруулалтанд ашиглах:** Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн зорилгыг хэрэгжүүлэхэд хувь нэмэр болохуйц улсын төсөв, ХАЁТ, концесс, хөгжлийн банк, хувийн секторын болон гадаадын хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын цогц бодлого (ерөнхий зураглал) боловсруулах шаардлагатай. Хөрөнгө оруулалтын ерөнхий зураглалд улсын хөрөнгө оруулалтыг хамруулна. Хөрөнгө оруулалтын ерөнхий зураглал нь Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, салбар, аймгийн бодлогын бичиг баримтыг хэрэгжүүлэх стратеги болохын зэрэгцээ Засгийн газар төсвийн эх үүсвэрийг төлөвлөхөд суурь баримт болно.



Эх сурвалж: ЖАЙКА-ийн судалгааны баг боловсруулав.

Зураг 5.2.6 Хөрөнгө оруулалтын ерөнхий зураглалын ач холбогдол

Хөрөнгө оруулалтын ерөнхий зураглал боловсруулахад хөрөнгийн эх үүсвэрээр хэрхэн хангах асуудал чухлаар тавигддаг. Энэ нь шийдэхэд хүндрэлтэй асуудал юм. Үүний зэрэгцээ санхүүгийн эх үүсвэрийг төрөл бүрийн түвшний хөгжлийн зорилгыг хэрэгжүүлэх арга хэрэгсэл болгон зүй зохистой ашиглахын тулд хөрөнгө оруулалтын төслийг зөв сонгон шалгаруулж, ангилах ажил чухлаар тавигддаг. Хөрөнгө оруулалтын арга хэрэгслийг судлахад шаардлагатай хөрөнгө оруулалтыг үндсэн үзүүлэлтийн жишээг дараах хүснэгтэнд тусгав.

Хүснэгт 5.2.1 Хөрөнгө оруулалтын арга хэрэгслийг судлах үндсэн үзүүлэлтийн жишээ

Хөрөнгө оруулалтын арга хэрэгсэл	Хөрөнгө оруулалтын төслийг сонгон шалгаруулахад судлах үндсэн үзүүлэлт
Улсын төсөв	<ul style="list-style-type: none"> ➤ Хөгжлийн төсөв хэрэглэх эсэх, төсвийн зарим хэсгийг урсгал төсөвт хуваарилах эсэх? ➤ Төсөл хэрэгжих явцад жил бүр хөгжлийн төсөв хуваарилагдах эсэх? ➤ Дунд хугацааны хөгжлийн төлөвлөгөөний хүрээнд хөрөнгө оруулалтын (төсөл) үр өгөөжийг хүртэх боломжтой эсэх?
ХАЁТ	<ul style="list-style-type: none"> ➤ Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, салбар, аймгийн бодлоготой уялдаатай эсэх? ➤ Хандивлагчдын үйл ажиллагаанд (хөрөнгө оруулалт) давхардал бий эсэх?
Хөгжлийн банк PPP/BT	<ul style="list-style-type: none"> ➤ Ирээдүйд Хөгжлийн банкны санхүүжилт, PPP, BOT зүй зохистой хэрэгжих орчин боловсронгуй болох эсэх?
Дотоодын хувийн секторын хөрөнгө оруулалт	<ul style="list-style-type: none"> ➤ Одоогийн эдийн засгийн нөхцөл байдалд хувийн секторын хөрөнгө оруулалт боломжтой эсэх?
Гадаадын хөрөнгө оруулалт	<ul style="list-style-type: none"> ➤ Хэрхэн гадаад дотоодын хувийн секторын хөрөнгө оруулалтыг татах? ➤ Дэд бүтцэд урьдчилсан хөрөнгө оруулалт шаардлагатай эсэх? ➤ Хувийн секторын гадаадын хөрөнгө оруулалтаар төлөвлөж буй төсөл үр өгөөжтэй хэрэгжих эсэх?

Эх сурвалж: ЖАЙКА-ийн судалгааны баг


- **Дунд, урт хугацааны улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөр боловсруулах :** Салбарын яам, тамгын газрын байр суурьнаас үзэхэд улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрт 30 тэрбум төгрөгөөс дээш төсөл тусгах боломжтой тул улсын хөрөнгө оруулалт нь Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, салбарын зорилгыг хэрэгжүүлэх чухал боломж олгох хэдий ч цорын ганц арга хэрэгсэл биш юм. 30 тэрбум төгрөгөөс доош төсөл, хөтөлбөрийг нэгтгэн, хөрөнгө оруулалтын төлөвлөгөө боловсруулж, хэрэгжүүлж байж хөгжлийн нийт дүр зургыг харах боломжтой. Иймд салбарын яам газар, аймаг бодлогын бичиг баримт дурдсан дунд урт хугацааны зорилгод нийцүүлэн дунд хугацааны улсын хөрөнгө оруулалт төлөвлөгөөг боловсруулахыг зөвлөж байна. Дунд хугацааны улсын хөрөнгө оруулалтын төлөвлөгөө боловсруулахдаа хөрөнгө оруулалтын хөтөлбөрт тусгагдсан том хэмжээний төслөөс гадна цаашид хэрэгжүүлэхээр төлөвлөж буй 30 тэрбум төгрөгөөс доош хэмжээний төслийг тусгаж, дээр дурдсан хөрөнгө оруулалтын ерөнхий зураглал, Сангийн яамнаас гаргасан төсвийн хязгаар (sealing), санхүүгийн эх үүсвэр, төсвийн хуваарилалтыг харгалзана.
- **Үндэсний Хөгжлийн Газар, Сангийн яам хамтран төсөв санхүүгийн талаар хэлэлцэх уулзалтыг тогтмол зохион байгуулах:** Дээр дурдсан хөрөнгө оруулалтын ерөнхий зураглал боловсруулж, түүнд тулгуурлан дунд хугацааны

санхүүгийн эх үүсвэрийг хуваарилахын тулд Үндэсний Хөгжлийн Газар, Сангийн яам тогтмол мэдээлэл солилцох, хамтран асуудлыг хэлэлцэх шаардлагатай. Ингэхдээ тус бүрдээ асуудлыг урьдчилан тодорхойлсоны дараа хэлэлцүүлэг зохион байгуулна. Хэлэлцэх асуудлын хувилбарыг 6.3 бүлэгт дурдав.

(5) Implementation

Implementation шатанд төсөл хэрэгжүүлэх нарийвчилсан төлөвлөгөө боловсруулж, хяналт-шинжилгээ хийнэ. Үндэсний Хөгжлийн Газар нь улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрийг жил бүр тодотгож (Монгол улсын төсвийн тухай хуулийн 28.8 дугаар зүйл), 2 жил тутам хяналт-шинжилгээ, үнэлгээ хийдэг.

Улсын хөрөнгө оруулалт нь өнөөг хүртэл албан ёсны бодлогын бичиг баримт болж хэрэгжиж ирээгүй. Иймд энэ үе шатанд цаашид үүсч болзошгүй асуудал, шийдвэрлэх арга хэмжээний хувилбарыг дор товч дурдав.



Эх сурвалж: судалгааны баг боловсруулав

Зураг 5.2.7 Implementation шатны асуудал, шийдвэрлэх арга хэмжээний хувилбар

【Асуудал】 Уг асуудлын талаар дор дэлгэрэнгүй тайлбарлав.

- **Холбогдох хуулинд Үндэсний Хөгжлийн Газар улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрийн тодотгол, 2 жил тутам хяналт-шинжилгээ үнэлгээ хийнэ гэж заасан байдаг ч тодорхой аргачлал боловсруулагдаагүй байна:** Тодотгол, хяналт-шинжилгээ, үнэлгээ нь тухайн зорилгоос хамааран ялгаатай аргачлалтай байдаг. Одоогийн байдлаар дээрх аргачлал боловсруулагдаагүй байгаа тул эдгээр ажил үр өгөөжтэй хэрэгждэггүй байх магадлалтай.
- **Улсын хөрөнгө оруулалтын нэгж төслийн хяналт-шинжилгээний арга болон дүнг улсын нийт хөрөнгө оруулалт, салбарын бодлогын бичиг баримтанд тусгах аргачлал боловсруулагдаагүй байна:** ерөнхийдөө хөрөнгө оруулалтын нийт хөтөлбөрөөс ялгаатай байр сууринаас нэгж төслийн үр өгөөжийн хяналт-шинжилгээг хийдэг. Хяналт-шинжилгээг улсын хөрөнгө оруулалтын

хөтөлбөрийг хэрэгжүүлсэнээр хийх боломжтой. Гэхдээ хяналт-шинжилгээний дүнг нэгтгэх аргачлалыг хэрхэн нийт улсын хөрөнгө оруулалт болон салбарын бодлогын бичиг баримтанд тусгах механизм тодорхой бус байна. Тухайлбал хөрөнгө оруулалтын нэгж төсөл удаашралтай хэрэгжих тохиолдолд бусад төсөлд нөлөөлж, үр өгөөжийг нь бууруулах зэрэг асуудал үүсч болзошгүй байдаг тул зөвхөн тухайн төсөл төдийгүй бусад төслийн нөлөөлөл, хариу арга хэмжээг судлах шаардлага гардаг. Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрийн дотоод зохицуулалтыг Үндэсний Хөгжлийн Газар хэрхэн хэрэгжүүлэхийг тодорхойлсон механизм одоогийн байдлаар хангалттай бус байна.

【Шийдвэрлэх арга хэмжээ】 дээр дурдсан 2 асуудлыг шийдвэрлэхийн тулд дараах 2 арга хэмжээг авч үзэв. Эдгээр арга хэмжээ нь дээрх асуудалд нийтэд нь хамаарна.

- **Улсын нийт хөрөнгө оруулалтын хөтөлбөрт хяналт-шинжилгээ хийх аргачлал боловсруулах, хяналт-шинжилгээ хийх хүний нөөцийг хөгжүүлж бэлтгэх:** Юуны өмнө дээр дурдсан 3 арга хэмжээг хэрэгжүүлэх үе шатны зорилгыг тодорхойлж, уг зорилгод нийцсэн аргачлал, процессийг боловсруулж, хүний нөөцийг хөгжүүлнэ. Төлөвлөж болох зорилго, аргачлалыг дор тусгав.
 - **Жил бүр тодотгол хийх:** зарчмын хувьд жил бүр төсөв бүрдүүлэх зорилгоор тодотгол хийдэг. Өөрөөр хэлбэл өмнөх жилд төсөвлөгдсөн төслийн хэрэгжилтийн байдал, төсвийн гүйцэтгэлийг шалгаж, дараа жилийн төсвийн төлөвлөгөөнд өөрчлөлт оруулах эсэхийг шалгана. Үүний зэрэгцээ дараа оноос хэрэгжиж эхлэх шинэ төслийн нарийвчилсан төлөвлөгөөг төсвийн төлөвлөгөөтэй тулгаж, зөрүү гарах эсэхийг шалган, хөрөнгө оруулалтын хөтөлбөрт тусгана. Мөн дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэл болон Сангийн яамны мэдээлэлд үндэслэн улсын хөрөнгө оруулалтын төслийн хэрэгжилтийн явцад төсвийн хүрээ өөрчлөгдсөн эсэхийг шалгасны үндсэн дээр бүх төслийн хэрэгжилтийн явц, төсвийн хуваарилалтанд өөрчлөлт оруулах эсэхийг судлана.
 - **2 жил тутмын хяналт-шинжилгээ:** улсын хөрөнгө оруулалтын ерөнхий төлөвлөгөөнд тулгуурлан бүх төслийн гүйцэтгэлийг шалгадаг. Удаашралтай төсөл хэрэгжиж буй төслийн хүчин зүйлд шинжилгээ хийж, зөвлөмж боловсруулан бусад төслийн уялдааг (төсвийн арга хэмжээг авах) шалгана.
 - **2 жил тутмын үнэлгээ:** энэ нь хөрөнгө оруулалтын хөтөлбөрийн үнэлгээ тул улсын хөрөнгө оруулалтын зохистой байдал, хөтөлбөр боловсруулах үеийн үр өгөөжийг хэмжихэд чиглэгддэг. Ийм үед зайлшгүй Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, бусад бодлогын бичиг баримтын уялдааг шалгах болдог тул улсын хөрөнгө оруулалт


төдийгүй хөгжлийн хувилбарын (scenario) үнэлгээг хамтатган хэрэгжүүлвэл зохистой.

- **Улсын хөрөнгө оруулалтын нэгж төслийн хяналт-шинжилгээний аргачлал боловсруулах:** хөрөнгө оруулалтын нэгж төслийн хяналт-шинжилгээг зарчмын хувьд хөрөнгө оруулалтын төслийн зохих мөчлөгийн дагуу хэрэгжүүлнэ. Хяналт шинжилгээний дүнг эргэн мэдээлэхдээ (feedback) төсвийн мөчлөг, хөрөнгө оруулалтын хөтөлбөрийн хяналт-шинжилгээ, үнэлгээний мөчлөгт нийцүүлэн хэрэгжүүлэх шаардлагатай. Эдгээр үе шатыг харгалзсан аргачлал, үе шатлалыг боловсруулвал зохистой.

(6) Project Adjustment

Project Adjustment шатанд улсын хөрөнгө оруулалтын төслийн зардлын удирдлагыг зохицуулах асуудал хамаарна. Төслийн зардал өөрчлөгдсөн тохиолдолд хариу арга хэмжээ, санхүүгийн эх үүсвэрийн хангамж, төслийн үр өгөөжийг дахин шалгах асуудлыг судалдаг. Энэ нь дээр (5)-д дурдсан “улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрт жил бүр тодотгол хийх” болон “улсын хөрөнгө оруулалтын нэгж төслийн хяналт-шинжилгээ”-тэй харилцан хамааралтай, нэгж төслийн түвшний зохицуулалт юм.

Үүсч болзошгүй асуудал болон шийдвэрлэх арга хэмжээний хувилбарыг дор тусгав.



Эх сурвалж: ЖАЙКА-ийн судалгааны баг

Зураг 5.2.8 Project Adjustment шатны асуудал, шийдвэрлэх арга хэмжээний хувилбар

【Асуудал】 Уг асуудлын талаар дор дэлгэрэнгүй тайлбарлав.

- **Улсын хөрөнгө оруулалтын нэгж төслийн хяналт-шинжилгээний дүнд зардалд өөрчлөлт гарсан тохиолдолд Үндэсний Хөгжлийн Газар төсөлд дахин дүгнэлт хийх аргачлал боловсруулагдаагүй байна:** Монгол улсын төсвийн тухай хуульд улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрт тусгагдсан нэгж төслийг хэрэгжүүлэх үед зардал хэтэрсэн тохиолдолд ямар хариу арга хэмжээ авах талаар заагаагүй байдаг. Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрийн төсөл өргөн цар

хүрээнд хэрэгждэг тул зардал өсөх нь төслийн үр өгөөж, санхүүгийн эх үүсвэрт нөлөөлөх магадлалтай байдаг.

- **Улсын хөрөнгө оруулалтын нэгж төслийн зардал өссөн тохиолдолд төсвийн төлөвлөгөөг өөрчлөх аргачлал (Сангийн яамны хариу арга хэмжээ) боловсруулагдаагүй байна:** зардал өсөлт санхүүгийн эх үүсвэрт ямар нөлөө үзүүлэхийг судлахад Сангийн яам ямар чиг үүрэгтэй оролцох нь одоогийн байдлаар холбогдох хууль тогтоомжинд тодорхой тусгагдаагүй байна.


【Шийдвэрлэх арга хэмжээ】 дээр дурдсан 2 асуудлыг шийдвэрлэхийн тулд дараах 2 арга хэмжээг авч үзэв. Эдгээр арга хэмжээ нь дээрх асуудалд нийтэд нь хамаарна.

- **Үндэсний Хөгжлийн Газар төслийг дүгнэх тогтвортой аргачлал боловсруулж, дүгнэлт хийх хүний нөөцийг хөгжүүлж бэлтгэх:** зардлын хүлээн зөвшөөрөх дээд хэмжээг давсан нэгж төсөлд Үндэсний Хөгжлийн Газраас дахин дүгнэлт хийх механизмыг бүрдүүлж, зардлын хүчин зүйлийн шинжилгээ, төслийн үр нөлөө, улсын нийт хөрөнгө оруулалт, санхүүгийн төлөвлөгөөнд үзүүлэх нөлөөг шалгаж, хариу арга хэмжээг шийдвэрлэнэ. Үүнийг хэрэгжүүлэхэд дүгнэлт хийх хүний нөөцийг хөгжүүлэх шаардлагатай.
- **Үндэсний Хөгжлийн Газар, Сангийн яам санхүүгийн эх үүсвэрийн зохицуулалтыг хэлэлцэх зөвлөгөөнийг тогтмол зохион байгуулах:** (4)-д дурдсан хөрөнгө оруулалтын ерөнхий зураглал боловсруулах, хяналт-шинжилгээ, төслийн санхүүгийн эх үүсвэрийн зохицуулалтыг хамтран хэлэлцэх уулзалтыг тогтмол зохион байгуулах шаардлагатай.

(7) Facility Operation

Facility Operation шатанд төсөл хэрэгжиж дууссаны дараах урсгал зардал, засвар үйлчилгээний хяналт хамаарна. Төслийн урсгал зардал, засвар үйлчилгээний хяналт хариуцах байгууллага, этгээдэд зохих журмын дагуу шилжиж очсон байх, урсгал зардал, засвар үйлчилгээний хяналт шаардлагатай төсвөөр хангагдсан байх, хөрөнгийн ашиглалтыг зохих ёсоор удирдаж буй эсэхийг шалгана. Монгол улсын төсвийн тухай хуулийн 29.2 дугаар зүйлд хөрөнгө оруулалтын төслийн саналд үндсэн хөрөнгийн ашиглалттай холбоотой урсгал зардал, орон тоо, санхүүжүүлэх эх үүсвэр зэргийг тооцож хавсаргах шаардлагатай гэж заасан байдаг.

Үүсч болзошгүй асуудал болон шийдвэрлэх арга хэмжээний хувилбарыг дор тусгав.



Эх сурвалж: ЖАЙКАИйн судалгааны баг

Зураг 5.2.9 Facility Operation шатны асуудал, шийдвэрлэх арга хэмжээний хувилбар

【Асуудал】 Уг асуудлын талаар дор дэлгэрэнгүй тайлбарлав.

- **Улсын хөрөнгө оруулалтын нэгж төслийн төлөвлөгөө боловсруулах үе шатанд төсөл хэрэгжсэний дараах урсгал зардал, засвар үйлчилгээний хяналтыг дүгнэх тодорхой үзүүлэлт тусгагдаагүй байна:** дээр дурдсанчлан улсын хөрөнгө оруулалтын дараах ашиглалтын талаар холбогдох хуульд ерөнхий заалт байх боловч томоохон хэмжээний улсын хөрөнгө оруулалтын төсөлд хамаарах заалт байхгүй. Ердийн улсын хөрөнгө оруулалтын төслийн урсгал зардал, засвар үйлчилгээний хяналтанд дээрх заалтыг хэрэглэх боломжтой гэж үзэж болно. Гэхдээ урсгал зардал, засвар үйлчилгээний хяналтын зардал их гардаг төсөлд төсвийн арга хэмжээ асуудалтай болвол бусад төслийн үр өгөөж, гүйцэтгэлд сөрөг нөлөө үзүүлэх магадлалтай байдаг.

【Шийдвэрлэх арга хэмжээ】 дээр дурдсан асуудлыг шийдвэрлэх 2 арга хэмжээг сонгов. Эдгээр арга хэмжээний хувилбарыг дор тусгав.

- **Улсын хөрөнгө оруулалтын нэгж төслийн санал боловсруулах үе шатанд шаардагдах урсгал зардал, засвар үйлчилгээний хяналтын төлөвлөгөө (framework) боловсруулна.** Салбарын яам, тамгын газар улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрт тусгагдах төслийн санал гаргахдаа урсгал зардал, засвар үйлчилгээний хяналтын төлөвлөгөө боловсруулна: том хэмжээний улсын хөрөнгө оруулалтын төсөлд урсгал зардал, засвар үйлчилгээний хяналтын нарийвчилсан төлөвлөгөө зайлшгүй шаардлагатай. Иймд урсгал зардал, засвар үйлчилгээний хяналтын төлөвлөгөө (framework) боловсруулж, төслийн санал гаргахыг үүрэг болгох шаардлагатай. Монгол улсын төсвийн тухай хуулийн 28


дугаар зүйлд урсгал зардал, засвар үйлчилгээний хяналтын үзүүлэлтийг нэмж тусгах талаар судлах хэрэгтэй.

- **Үндэсний Хөгжлийн Газар, Сангийн яам улсын хөрөнгө оруулалтын төслийг дүгнэхдээ урсгал зардал, засвар үйлчилгээний хяналтын төлөвлөгөө, бэлэн болсон төслийн тогтвортой байдлыг (төсөв, зохион байгуулалт, технологи) шалгах:** (3)-д дурдсан төслийг дүгнэх үзүүлэлтэнд тогтвортой байдлын үзүүлэлтийг нэмж тусгана. Мөн төслийг дүгнэхэд шаардагдах урсгал зардал, засвар үйлчилгээний хяналтын төлөвлөгөөний агуулга, санхүү, бүтэц зохион байгуулалтын тогтолцоо, технологийн тогтвортой байдлыг бодитой хэмжих үзүүлэлтийг нэмж тусгана.

(8) Completion Review and Evaluation

Completion Review and Evaluation шатанд төсөл хэрэгжиж дуусах эсвэл хэрэгжсэний дараах үнэлгээгээр дамжуулан улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөр, төслийн гүйцэтгэл, тогтвортой байдал, үр өгөөжийг тооцно. (5)-д дурдсанчлан улсын хөрөнгө оруулалтын гүйцэтгэлд 2 жил тутам хяналт-шинжилгээ, үнэлгээ хийнэ.

Үүсч болзошгүй асуудал болон шийдвэрлэх арга хэмжээний хувилбарыг дор дурдав.



Эх сурвалж: ЖАЙКА-ийн судалгааны баг

Зураг 5.2.10 Completion Review and Evaluation шатны асуудал, арга хэмжээний хувилбар

【Асуудал】 Уг асуудлын талаар дор дэлгэрэнгүй тайлбарлав.

- **Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрийн үнэлгээний аргачлал, үнэлгээний дүнг эргэн мэдээлэх (feedback) аргачлал боловсруулагдаагүй байна:** Уг үе шатыг 2 жил тутам хэрэгжүүлэх бөгөөд улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөр хэрэгжиж дуусах үед хийх хоёр дахь удаагийн үнэлгээ гэж үзэж болно. Уг үнэлгээний аргачлал нь (5)-д заасантай адил боловсруулагдаагүй байна.

- **Улсын хөрөнгө оруулалтын нэгж төсөл хэрэгжиж дуусах болон хэрэгжсэний дараах үнэлгээний аргачлал боловсруулагдаагүй байна:** Томоохон хэмжээний улсын хөрөнгө оруулалтын төсөл хэрэгжиж дуусах болон хэрэгжсэний дараах үнэлгээ нь төслийн үр өгөөжийг тооцоход маш чухал хэдий ч одоогийн байдлаар үнэлгээний аргачлал боловсруулагдаагүй байна.

【Шийдвэрлэх арга хэмжээ】 дээр дурдсан асуудлыг дараах 3 арга хэмжээ авч шийдвэрлэнэ. Эдгээр арга хэмжээний хувилбарыг дор тусгав..

- **Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрийн үнэлгээний аргачлал боловсруулах:** Хөтөлбөрийн үнэлгээ нь дараагийн улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөр төдийгүй Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, бодлогын бичиг баримтад чухал нөлөө үзүүлдэг. Иймд үнэлгээний аргачлал боловсруулахдаа дээрх бичиг баримтанд нийцүүлэхээс гадна Монгол улсын төсвийн тухай хуульд заасан 2 жил тутам үнэлгээ хийх хугацааг (улсын хөрөнгө оруулалт хэрэгжиж дуусах үе) дараагийн хөгжлийн төлөвлөгөө боловсруулахад хэрэгтэй асуудлыг тодорхойлох үүднээс бага зэрэг наашлуулж, эрт шатнаас хэрэгжүүлэх хэрэгтэй. Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөр хэрэгжиж дуусах үеийн хөтөлбөрийн үнэлгээ болон дараагийн хөгжлийн төлөвлөгөө боловсруулах ажлыг нэг үе шат дотор авч үзэх нь зохистой. Хөтөлбөрийн үнэлгээг Үндэсний Хөгжлийн Газар, Сангийн яам хамтран хийнэ.
- **Улсын хөрөнгө оруулалтын нэгж төсөл хэрэгжиж дуусах үе болон хэрэгжсэний дараа хийх үнэлгээний аргачлал боловсруулах:** Улсын хөрөнгө оруулалтын төсөл хэрэгжиж дуусах болон хэрэгжсэний дараах үнэлгээний аргачлалыг боловсруулна. Улсын хөрөнгө оруулалтын төсөл хэрэгжиж дуусах үеийн үнэлгээнд (7)-д дурдсан урсгал зардал, засвар үйлчилгээний хяналтын төлөвлөгөөг шалгах, төслийн тогтвортой байдлын үнэлгээ хийхэд голлон анхаарч, хэрэгжсэний дараах үнэлгээнд голлон үр өгөөжийг тооцож үнэлнэ.
- **Хөтөлбөр, төслийн үнэлгээ хийх хүний нөөцийг хөгжүүлэх:** Улсын хөрөнгө оруулалтын мөчлөг, хөрөнгө оруулалтын нэгж төслийн үе шат бүрт хэрэгжүүлэх төслийн дүгнэлт, үнэлгээ хийж чадвартай хүний нөөцийг Үндэсний Хөгжлийн Газар, Сангийн яам бэлтгэнэ. Эдгээр ажилд хамаарах мэргэжлийн ур чадвар, мэдлэг төдийгүй төслийн үнэлгээнд нарийн шинжилгээ хийж, дараагийн хөтөлбөр, төсөлд тусгах чадавхитай хүний нөөцийг хөгжүүлэх шаардлагатай.

5.3 Үндэсний Хөгжлийн Газар, Сангийн яамны хамтын ажиллагаа, зохицуулалтын тогтолцоог боловсронгуй болгох

Энэхүү тайлангийн 3.4 болон 4.4-т бүлэгт дурдсан арга хэмжээнээс харахад Үндэсний Хөгжлийн Газар, Сангийн яам олон талаар хамтран ажиллаж, зохицуулалт хийх шаардлагатай нь тодорхой юм. Хоёр байгууллагын хамтын ажиллагаа, зохицуулалтанд эдгээр байгууллага анхаарч ажилладаг. Гэхдээ уг хамтын ажиллагаа, зохицуулалтыг хэзээ, ямар түвшинд, юуг зорилго болгож хэрэгжүүлэн, хоёр талын хамтын ажиллагааг зохион байгуулсанаар ямар үр дүн гарах, уг ажиллагаанд юу шаардагдаж буйг тодорхойлох шаардлагатай. Энэ үзүүлэлт тодорхой бус бол хамтын ажиллагааг зохистой хэрэгжүүлэх боломжгүй юм. 5.2 бүлэгт дурдсан арга хэмжээг цэгцлэн, тодорхой арга хэмжээ, хүлээгдэж буй үр дүнг дор нэгтгэж бичив.

Хүснэгт 5.3.1 PIP-н мөчлөг дэх ҮХГ, СЯ-ны уялдаа хамтран ажиллах санал

Хамтран ажиллах шаардлага	Тодорхой хийх зүйс
1.Guidance & Screening Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал, Засгийн Газрын мөрийн хөтөлбөр, салбарын яам, Аймгуудын бодлогын бичиг баримттай нийцсэн Хөрөнгө оруулалтын хөтөлбөр боловсруулахын тулд тодорхой удирдамж (ҮХГ, СЯ хоёроос салбарын яам, аймгуудад зориулсан)-ийг боловсруулах.	Дунд хугацааны төсвийн эх үүсвэрийг тодорхойлох урьдчилсан хэлэлцүүлэг. Хөрөнгө оруулалтын хөтөлбөрийн хөрөнгийн эх үүсвэрийн мөчлөгийг ҮХГ тогтоох, СЯ-аас МТFF-ийн дээд хэмжээг тогтоох
3. Independent Review of Appraisal Хөрөгө оруулалтын боловсруулах үеийн үйл ажиллагаан дахь хяналт хяналтыг хэрэгжүүлэх.	Хөрөнгө оруулалтын боловсруулах үеийн хэрэгжилтийн үйл ажиллагааны хяналт. Энэ үе шатанд Хөрөнгө оруулалтын хөтөлбөрт тусгагдах төслийг сонгох зорилготой, урьдчилсан ТЭЗҮ, эдийг засаг төсөв санхүүгийн дүн шинжилгээний агуулгыг хянах. ҮХГ нь хөгжлийн бодлоготой уялдаа холбоог анхаарах, СЯ нь төслийн төслүүдийн эдийн засгийн үр ашгийн хяналтыг хийх.
3. Independent Review of Appraisal Хөрөгө оруулалтын боловсруулах үйл ажиллагааны явцад төсөвлөх үеийн хяналтыг хэрэгжүүлэх.	Дунд хугацааны төсөв санхүүгийн төлөвлөгөө болон тухай жилийн төсөвт тусгагдсан хэрэгжүүлэх төслийн нарийвчилсан хяналт. ТЭЗҮ, эдийн засаг төсөв санхүүгийн дүн шинжилгээний агуулга нь ҮХГ, СЯ аль аль хатуу хяналт тавих.
4. Project Selection and Budgeting (1) Хөрөнгө оруулалтын хөтөлбөрийн хөрөнгө оруулалтын Ерөнхий зураглалыг боловсруулах, зөвлөгөөнийг тогтмол зохион байгуулах.	Хөрөнгө оруулалтын ерөнхий зураглалын боловсруулах, шинэчлэх зорилготой ҮХГ, СЯ хоорондын зөвлөгөөн тогтмол зохион байгуулах
4. Project Selection and Budgeting (2) Дунд хугацааны улсын хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг боловсруулах	Салбарын яамдад хөрөнгө оруулалтын хөтөлбөрт тусгагдах төсөл, төсвийн хөрөнгө оруулалтын төсөлд хамрагдсан дунд хугацааны хөрөнгө оруулалтын төлөвлөгөө боловсруулахад ҮХГ,СЯ аль аль нь дэмжих. Бүх салбарын хөгжлийн бодлоготой уялдсан төсвийн мөчлөгийн мэдээллийг бүх яамтай солилцох.

<p>6. Project Adjustment Тогтвортой хөрөнгө оруулалтын хөтөлбөрийн төслийн үйл ажиллагааны хяналтын хэрэгжилт, зардлын өөрчлөлтийг төсөвт тохируулан зөвлөлдөх.</p>	<p>Тогтвортой хөрөнгө оруулалтын хөтөлбөрт тусгагдсан төсөлд томоохон өөрчлөлт орох тохиолдолд үйл ажиллагааны хяналтыг төсөв санхүүгийн зөвлөгөөн ҮХГ, СЯ хамтран зохион байгуулах.</p>
<p>7. Facility Operation Урсгал зардлын төлөвлөгөөний хяналт төсвийн эх үүсвэрийг хангах.</p>	<p>Хөрөнгө оруулалтын хөтөлбөрт тусгагдсан төслийн үйл ажиллагааны урсгал зардлын төлөвлөгөөний хяналт, төсөв санхүүгийн эх үүсвэрийг хэлэлцэх (Хөгжлийн төсөв, улсын төсөв, хөрөнгө босгох) төсөв, санхүүжилтийг хэлэлцэх ҮХГ, СЯ-ны зөвлөгөөн хэрэгжүүлэх.</p>
<p>8. Completion Review and Evaluation (1) Хөрөнгө оруулалтын хөтөлбөрийн үнэнлэгээ</p>	<p>Хөрөнгө оруулалтын хөтөлбөрийн үнэнлэгээ. Дараагийн хөрөнгө оруулалтын хөтөлбөрийг боловсруулахад ашиглах. Хөгжлийн бодлогын үр өгөөжийг хэмжих ҮХГ, төсвийн төлөвлөгөөтэй СЯ-уялдуулах зөвлөгөөнийг зохион байгуулж хэлэлцэх.</p>
<p>8. Completion Review and Evaluation (2) Хөрөнгө оруулалтын хөтөлбөрт тусгагдсан төслийн хэрэгжилтийн дараах ба ашиглалтын үеийн үнэнлэгээ</p>	<p>Хөрөнгө оруулалтын хөтөлбөрт тусгагдсан төслүүд хэрэгжсэний дараах үнэнлэгээ, үйл ажиллагааны хяналтыг тогтвортой хэрэгжүүлэх.</p>

Эх сурвалж: ЖАЙКА-ийн судалгааны баг

(1) Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөр боловсруулахын өмнө хөрөнгө оруулалтын ерөнхий зураглал, удирдамж боловсруулах

Дээр дурдсан арга хэмжээг хэрэгжүүлэхдээ улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөр боловсруулахын өмнөх үе шатанд хөрөнгө оруулалтын ерөнхий зураглал (5.2 бүлэг(4)) боловсруулахыг зөвлөж байна. Уг хөрөнгө оруулалтын ерөнхий зураглалыг боловсруулахад Үндэсний Хөгжлийн Газар, Сангийн яамны хамтын ажиллагаа зайлшгүй чухал. Хөрөнгө оруулалтын ерөнхий зураглал боловсруулахад Үндэсний Хөгжлийн Газар хөгжлийн зорилго, үзүүлэлтийг төлөвлөж, гол хэмжүүр (milestones), гүйцэтгэл, хувийн хэвшлийн болон гадаадын хөрөнгө оруулалт, гэрээний хэрэгжилтийн талаар мэдээлэл гаргаж өгөх боломтой. Сангийн яам макро эдийн засаг болон санхүүгийн нөхцөл байдал, хэтийн төсөөллийн талаар мэдээлэл гаргаж өгөх боломжтой. Хөрөнгө оруулалтын ерөнхий зураглалыг Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрийн үнэнлэгээтэй нэгэн адил Үндэсний Хөгжлийн Газар, Сангийн яам хамтран үнэлж, тухайн нөхцөлд тохируулан засч сайжруулдаг байвал зохистой.

Мөн улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөр боловсруулах, шинэчлэх үед Үндэсний Хөгжлийн Газар, Сангийн яам хамтран салбарын яам газарт хандсан удирдамж боловсруулахыг (5.2 бүлэг(1)) зөвлөж байна. Уг удирдамжинд дээр дурдсан хөрөнгө оруулалтын ерөнхий зураглалын үнэнлэгээний гол хэмжүүрээс (milestones) гадна санхүүгийн эх үүсвэр тус бүрээр төсвийн хуваарилалтыг тусгана. Ингэснээр улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөр боловсруулах шатанд салбарын яам газартай төслийг

хэрэгжүүлэх боломж, тэргүүлэх зэрэглэлээр эрэмбэлэх үед илүү тодорхой хэлэлцүүлэг хийх боломжтой болно.

(2) Улсын хөрөнгө оруулалтын төслийг дүгнэх, давтан дүгнэлт хийх, төсөл хэрэгжиж дуусах үед болон хэрэгжсэний дараа үнэлгээ хийх

Дээр дурдсан арга хэмжээг хэрэгжүүлэх үе шатанд улсын хөрөнгө оруулалтын нэгж төслийг шалгаж үнэлэх шаардлагатай байдаг. Үндэсний Хөгжлийн Газар хөрөнгө оруулалтын төсөл болон хөгжлийн төлөвлөгөөний уялдаа, төслийн үр өгөөжийг шалгаж, Сангийн яам төслийн эдийн засгийн үр ашигт шинжилгээ хийнэ (Монгол улсын төсвийн тухай хуулийн 28.5, 28.11 дугаар зүйл). Эдгээр дүнд тулгуурлан төслийн дүгнэлт, үнэлгээ хийгдэнэ. Иймд бүх үе шатны дүгнэлт, үнэлгээг төлөвлөгөөтэй хэрэгжүүлэхийн тулд хамтарсан үнэлгээний хороо байгуулахыг зөвлөж байна. Хамтарсан хороонд Үндэсний Хөгжлийн Газар, Сангийн яамны ажилтнуудаас гадна холбогдох мэргэжлийн байгууллага, судлаач, эрдэмтэдийн төлөөлийг тухай бүр оролцуулна.

(3) Жилийн төсөвт хязгаар (sealing) тогтоох, зохицуулалт хийх

Дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэл, жилийн төсөв боловсруулдаг Сангийн яам дунд хугацааны үзүүлэлт бүрээр хөгжлийн төсвийг авч үздэггүй. Дээр (1)-д дурдсан хөрөнгө оруулалтын ерөнхий зураглал боловсруулан, хөгжлийн төсвийн стратегийг тодорхой болгоно. Уг стратегид тулгуурлан жилийн төсвийн санхүүгийн эх үүсвэрийг хэлэлцэх боломжтой болно. Үндэсний Хөгжлийн Газрын улсын хөрөнгө оруулалтын төслийн хяналт-шинжилгээний дүнд тулгуурлан шаардлагатай тохиолдолд төсвийн хүрээнд зохицуулалт хийх боломжтой болно.


Улмаар Сангийн яамны хувьд анхаарал татсан асуудал болох төслийн дараах урсгал зардал, засвар үйлчилгээний хяналтын ажилд шаардлагатай төсвийг хангах асуудлыг дээр дурдсан (2)-р дамжуулан хэрэгжүүлж, төслийн дүгнэлт, үнэлгээнд тугуурлан нарийн мэдээлэл олж авах боломжтой болно.

(4) Хөтөлбөрийн үнэлгээ

Дээр (8)-д дурдсан улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрийн үнэлгээгээр хөрөнгө оруулалтын хөтөлбөрт тусгагдсан төслийн эдийн засгийн үр өгөөж, гүйцэтгэлийг шалгах боломжтой болно. Үүний зэрэгцээ Засгийн газрын дараагийн үйл ажиллагааны хөтөлбөр боловсруулахын тулд хөрөнгө оруулалтын ерөнхий зураглалыг шинэчлэх, санхүүгийн эх үүсвэрийн төлөвлөгөө боловсруулахад хялбар болно. Мөн эдгээр мэдээллийн талаар Үндэсний Хөгжлийн Газар, Сангийн яам нэгдсэн ойлголттой болсоноор эрт үе шатнаас дараагийн улсын хөрөнгө оруулалтын процессийн удирдлага, зохион байгуулалтын төлөвлөгөө боловсруулах боломжтой болно.

5.4 Төсвийн менежмент дахь улсын хөрөнгө оруулалтын эх үүсвэрийн хамрах хүрээ

Уг бүлэгт төсвийн менежмент дахь улсын хөрөнгө оруулалтын эх үүсвэрийн хүрээнд хэрэгжих хөрөнгө оруулалтын нөхцөл байдал, асуудлыг төсвийн эх үүсвэр тус бүрээр авч үзнэ. 3.1 бүлэгт дурдсанчлан 2017-2019 оны дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлээс үзвэл 2017 оноос хойш 3 жилийн төсвийн зарлага тус бүр 1 их наяд 483 тэрбум 900 сая, 1 их наяд 517 тэрбум 600 сая, 1 их наяд 540 тэрбум 600 сая төгрөг байна. Энэ нь 2012-2013 оны төсвийн зардалтай ойролцоо дүн юм.



Эх сурвалж: Сангийн яамны MTFF2017-2019 ЖАЙКА-ийн судалгааны баг

Зураг 5.4.1 Хөрөнгийн орлого, зарлагын эзлэх хувь

УИХ-аас батласан 2017 оны төсөвт тулгуурлан эх үүсвэр, хөрөнгө оруулалтын төсөл тус бүрээрх улсын хөрөнгө оруулалтыг авч үзвэл улсын төсөв 250 тэрбум 700 сая, Хөгжлийн банк 72 тэрбум 800 сая, концесс 1, 71 тэрбум 500 сая төгрөг, нийт 495 тэрбум төгрөг байна.

Мөн 5.2, 5.3 бүлэгт дурдсанчлан цаашид төр хувийн хэвшлийн түншлэл, концессын болон хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтын үндсэн чиглэлийг тодорхойлох, гадаадын хөрөнгө оруулалтыг татахад чухал үүрэг гүйцэтгэх хөрөнгө оруулалтын цогц бодлого, ерөнхий зураглалын хамрах хүрээ тодорхой бус байгаа тул уг бүлэгт зөвхөн санхүүгийн эх үүсвэр бүрээрх улсын хөрөнгө оруулалтын хувилбарыг авч үзэв.

(1) Улсын төсвийн эх үүсвэрээс гарах зардал

2018, 2019 оны санхүүгийн эх үүсвэр бүрээр боловсруулсан төсвийн төсөөлөлд тус бүр 168 тэрбум 900 сая, 41 тэрбум 900 сая төгрөгийн төсвийн зардал төлөвлөгдсөн байна.

УИХ-ын даргын 2016 оны 47 дугаар захирамжаар төсвийн тодотгол хийсний дараа улсын төсвөөр спорт, соёлын барилга байгууламж шинээр барихыг хориглож, боловсролын барилга байгууламжийг худалдах, буцаан түрээслэх замаар үр өгөөжгүй хөрөнгө оруулалтыг хязгаарлахаар болсон.

Дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлээс үзвэл 2017 онд төсвийн тэнцвэржүүлсэн орлого хамгийн их буурч, 2018 оноос хойш төсвийн орлого сэргэхээр байна. Төсвийн нэмэгдсэн орлогын ихэнхийг өр төлөх зэргээр урсгал зардалд зарцуулахаар төлөвлөж байгаа бөгөөд улсын төсвөөр том хэмжээний хөрөнгө оруулалт ойрын хугацаанд хийгдэхгүй байх төлөвтэй байна.

(2) Хөгжлийн банкны хөгжлийн зээл, төслийн санхүүжилтаас (Project Finance) эх үүсвэртэй төсвийн зардал

Санхүүгийн эх үүсвэр бүрээр боловсруулсан төсвийн төсөөлөлд 2018 онд 109 тэрбум 100 сая төгрөгийн улсын төсөв төлөвлөгдөж байна. 2019 оны төсөв гараагүй байна. Үүний шалтгаан нь 3.1 бүлэгт дурдсанчлан одоогийн байдлаар УИХ-д Хөгжлийн банкны хуулийг шинэчлэх, үйл ажиллагааг нь сайжруулах асуудлыг хэлэлцэж байгаатай холбоотой.

Хөгжлийн банкны хуулийн төсөлд УИХ, Засгийн газрын эрх мэдлийн тухай заалтыг шинэчилж, уг хуулийн 27 дугаар зүйлд зээл болон зээлийн баталгааны нийт дүн нь өөрийн хөрөнгийг 50 дахин нэмэгдүүлснээс хэтрэхгүй байна гэж заасан. УИХ, Засгийн газар хөндлөнгөөс хэт оролцоонд хязгаарлалт хийж, Хөгжлийн банкны хараат бус байдлыг бэхжүүлэх зэргээр уг банканд өнөөг хүртэл гарч байсан алдаа дутагдлыг засч залруулахад анхаарч байна.

Эдийн засгийн сэргээх хөтөлбөрт “эдийн засгийн хөгжлийг дэмжих том хэмжээний төслийг хэрэгжүүлэх урт хугацааны хөрөнгийг хангах Хөрөнгө оруулалтын сан байгуулах” гэсэн заалт орсон байна. Хөгжлийн банк үүнийг хэрэгжүүлэхээр бэлтгэж байна.

Хөгжлийн банк цаашид 1) хөдөө аж ахуй, 2) төлбөртэй зам, 3) төмөр зам, 4) эрчим хүч, 5) уул уурхайн салбарт төслийн санхүүжилт хийх, арилжааны банкаар дамжуулж зээл олгохоор төлөвлөж байна. Хөгжлийн банкны хууль шинэчлэгдэж, хараат бус байдал сайжирвал эдийн засгийн үр өгөөж багатай хөрөнгө оруулалт хийж чадахгүйд хүрэх давуу талтай. Хөрөнгө босгох хүндрэлтэй үед санхүүгийн эх үүсвэр гаргаж чадахгүй болох тул цаашид хэвийн ажиллан, тогтвортой менежменттэй байж, улсын хөрөнгө оруулалтын санхүүгийн эх үүсвэрийн нэг багана болохын тулд

хандивлагч, гадны санхүүгийн байгууллагаас хөрөнгө, технологийн дэмжлэг авах чухал шаардлагатай.

(3) Төр, хувийн хэвшлийн түншлэлд тулгуурласан хувийн секторын хөрөнгө оруулалт

Санхүүгийн эх үүсвэр бүрээр боловсруулан төсвийн төсөөлөлд 2018 онд 709 тэрбум 600 сая, 2019 онд 394 тэрбум 500 сая төгрөгийн улсын хөрөнгө оруулалтыг концессоор хийхээр төлөвлөж байна.

Эдийн засгийг сэргээх хөтөлбөрт концессын журмаар хэрэгжсэн төсөл, эсвэл одоо хэрэгжиж буй төсөл, хөтөлбөрийн үнэлгээ, цаашид хэрэгжүүлэх төсөл, бодлогыг батлах, хэрэгжүүлэх аргачлалыг (механизм) тодорхой болгох талаар заасан байдаг. Иймд барьж, хүлээлгэн өгөх (BT) схемд тулгарч буй асуудлыг шийдвэрлэхгүйгээр богино хугацаанд ийм их хэмжээний улсын хөрөнгө оруулалт концессын журмаар хийгдэнэ гэж үзэхгүй байна. Гэхдээ дунд болон урт хугацаанд барьж, ажиллуулж, хүлээлгэн өгөх (BOT) схемд тулгуурлан төр, хувийн хэвшлийн түншлэлийг үр ашигтай хэрэгжүүлвэл, улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрийг санхүүжилтийн эх үүсвэрийн нэг багана болгох боломжтой.

Одоо үйлчилж буй концессын тухай хууль нь 2020 он хүртэл шинэчлэх 259 хуулийн жагсаалтанд багтсан байдаг. Шинэчлэх хуулийн жагсаалтыг өнгөрсөн жил УИХ-аар баталсан. Засгийн газар төслийн тендер, концессын систем, хуулийн хэрэгжилтийг хангах хороо байгуулж, улсын төсвийн зохицуулалтыг шинэчилж сайжруулахаар төлөвлөж байна.

(4) Хандивлагчдын тусламж (ХАЁТ)

3-р бүлэгт дурдсанчлан олон улсын байгууллага, гадаад улсын Засгийн газраас хөнгөлттэй зээл, буцалтгүй тусламжийг Монгол улсад хэрэгжүүлж байна. Цаашид ч уг хамтын ажиллагаа үргэлжлэх төлөвтэй байна. Мөн дээр өгүүлсэнчлэн IMF-аас тусламж авах нь шийдэгдвэл IMF-ийн бодлогын дагуу бусад хандивлагчид ч улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөр, төлөвлөгөөг их хэмжээгээр засах магадлалтай тул анхаарах шаардлагатай.

(5) Сан

2006 онд батлагдсан Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд (2016 оны 11 сарын 10-ний өдөр шинэчилсэн) заасанчлан одоогийн байдлаар дараах сан ажиллаж байна. Эдгээр сангийн зарим нь төсвөөс ангид үйл ажиллагаа явуулдаг. Мөн уг тайлангийн 3-р бүлэгт дурдсан орон нутгийн хөгжлийн сан нь улсын хөрөнгө оруулалтанд хамаарах хэдий ч Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд тусгагдаагүй байна. Эдгээрээс улсын хөрөнгө оруулалтанд хамаарах боломжтой нь Ирээдүйн ав сан юм. FHF нь 2016 оны 2 сарын 5-ний өдөр батлагдсан. Ирээдүйн өв сангийн тухай хууль 2017 оны 1 сарын 1-ний өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болно. Ирээдүйн өв сан нь

төсвийн орлогыг ирээдүй хойч үед хуваарилахын тулд байгуулагдсан сан юм. 2016 оны сүүлээр татан буугдсан Хүний хөгжлийн сантай адил, санхүүгийн эх үүсвэрийн 65%-ийг ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр бүрдүүлнэ. Гэхдээ Хүний хөгжлийн саны өр байгаа тул 2017 оны төсвийн тухай хуулийн төслөөс үзвэл 2022 он хүртэл нийт орлогыг нь улсын төсөвт шилжүүлэхээр төлөвлөж байна. Иймд Үрээдүйн өв саны хувьд улсын хөрөнгө оруулалт одоогийн байдлаар төлөвлөгдөөгүй гэж үзэж болно.

Хүснэгт 5.4.1 Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн дагуу боловсруулсан сангийн жагсаалт

Сангийн нэр	Санхүүгийн эх үүсвэр
Онцгой байдлын сан	Зөвхөн улсын төсөв
Засгийн газрын нөөц сан	
Соёл, урлагийг дэмжих сан	
Боловсролын зээлийн сан	
Хилийн чанадад байгаа Монгол Улсын иргэдэд туслах сан	
Байгаль хамгаалах сан	
Шинжлэх ухаан, технологийн сан	
Сэргээгдэх эрчим хүчний сан	
Зэвсэгт хүчний хөгжлийн сан	
Гэмт хэргийн хохирогчид нөхөн төлбөр олгох сан	
Монгол судлалыг дэмжих сан	
Засгийн газрын өрийн баталгааны сан	
Спортыг дэмжих сан	
Эрүүл мэндийг дэмжих сан	
Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сан	
Тариалан эрхлэлтийг дэмжих сан	Зонхилох хэсгийг буцалтгүй тусламж, хандиваар бүрдүүлэх сан. Бие даасан санхүүгийн бүртгэлтэй. • Тусгай хууль, олон улсын гэрээнд заасны дагуу олгох Засгийн газрын буцалтгүй тусламж • Олон улсын тусламжийн мөнгөн хөрөнгө, тоног төхөөрөмж, бараа материал, бусад эд зүйл зэрэг • Олон улсын байгууллага, хандивлагч орнууд, гадаад дотоодын байгууллага болон ард иргэдийн өгсөн тусламж, хандив • Тусгай сангийн үйл ажиллагаанаас олсон орлого • Бусад
Бүх нийтийн үйлчилгээний үүргийн сан	
Мал хамгаалах сан	
Олон улсын хамтын ажиллагааны сан	Санхүүгийн эх үүсвэрийг нь тусгай хуулиар зохицуулагддаг.
Нийгмийн даатгалын сан	
Нийгмийн халамжийн сан	
Авто замын сан	
Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан	
Мэргэжлийн боловсрол, сургалтыг дэмжих сан	
Ирээдүйн өв сан (2016 он хүртэл Хүний хөгжлийн сан байв)	
Төсвийн тогтворжуулалтын сан	
Эрүүл мэндийн даатгалын сан	
Үйлдвэрлэлийг хөгжүүлэх сан	
Тэтгэврийн нөөцийн сан	
Байгалийн гамшгийн үүдсэн хохирлыг сэргээн босгоход чигэлсэн тусламж олон улсын байгууллага, донор улс, гадаадын болон Монголын иргэд, хуулийн этгээдүүдээс авах тусламж, хандив	

Эх сурвалж: Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд тулгуурлан ЖАЙКА-ийн судалгааны баг боловсруулав.

(6) Бусад

Гадаадын шууд хөрөнгө оруулалтыг (FDI) санхүүгийн эх үүсвэрийн нэг хувилбар гэж үзэх шаардлагатай. Үүний тулд хөрөнгө оруулалтын бодлогоо огцом өөрчилж ирсэнээс болж үүссэн алдааг засч, гадаадын хөрөнгө оруулагчдийн итгэлийг сэргээхэд анхаарах хэрэгтэй. Эдийн засгийг сэргээх хөтөлбөрт гадаадын шууд хөрөнгө оруулалт татахын тулд эрх зүйн орчинг сайжруулах, гадаадын хөрөнгө оруулагчийн эрх ашгийг хамгаалах зөвлөл байгуулж, хөрөнгө оруулагчийн эрх ашгийг хамгаалахын тулд эрх зүйн орчинг сайжруулах талаар бичсэн байдаг. Эдгээр ажлыг гол хариуцах газар нь Үндэсний Хөгжлийн Газар юм.

6 Хөгжлийн бодлого төлөвлөлт, улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөр боловсруулах чадавхийг бэхжүүлэх хамтын ажиллагааны чиг хандлага (туслалцааны хувилбар)

6.1 Хамтын ажиллагааны төслийн зорилго, хүлээгдэж буй үр дүн

Өнгөрсөн 2016 оны 8 сарын байдлаар, Монгол улсын Засгийн газраас албан ёсоор тавигдсан төслийн саналд дараах 3 техникийн хамтын ажиллагааны хүсэлт гаргасан.

<Тухайн төслийн саналын хамтын ажиллагааны төслийн зорилго>

- i) **Хөгжлийн бодлого төлөвлөлтийн салбарын хүний нөөцийн хөгжилд үзүүлэх дэмжлэг** : Хөгжлийн бодлогын зорилго, зорилт, үзүүлэлт зэргийг тодорхой болгох, бодлого төлөвлөлтийн чадавхийг сайжруулах зорилгоор холбогдох яам, тамгын газар, орон нутгийн түвшний ажилтануудад зориулсан сургалт, семинар зохион байгуулах.
- ii) **Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөр (PIP) боловсруулахад үзүүлэх дэмжлэг** : Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулинд заагдсан улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрт (PIP) тусгагдах төслийн үнэлгээ болон боловсруулахад чиглэгдсэн арга зүйн дэмжлэг, холбогдох хөрөнгө оруулалтын төлөвлөгөө, хүний нөөцийг бэлдэх.
- iii) **Одоо байгаа салбарын хөгжлийн бодлого төлөвлөлтийн уялдаа холбоог хангах, үнэлэх ажилд үзүүлэх дэмжлэг** : Улсын хөрөнгө оруулалтын оновчтой хөтөлбөр боловсруулах механизм бүрдүүлэхийн тулд, хөгжлийн бодлого (тогтвортой хөгжлийн үзэл баримтлал 2030 : урт хугацааны үзэл баримтлал) дахь Монгол улсын хөгжлийн зарчим болон одоо байгаа салбарын бодлоготой уялдуулахад чиглэсэн үнэлгээ

Энэхүү судалгаанд бүтцийн өөрчлөлт, холбогдох мэдээлэл, санал дээр тулгуурлан дээрх агуулгыг тусган дараах байдлаар цэгцэлж байна.

<Тус судалгаанд тулгуурласан хамтын ажиллагааны зорилго>

- i) **Салбарын бодлого буюу (PIP-д тусгагдах) улсын хөрөнгө оруулалтын төслийн хөгжлийн бодлого (урт хугацааны үзэл баримтлал) уялдаа холбоог хангах, үнэлэхэд үзүүлэх дэмжлэг** : улсын хөрөнгө оруулалттай холбогдох бүх яамд, тамгын газар (салбар бүрийн) бодлого болон холбогдох улсын хөрөнгө оруулалтын төслийг дахин авч хэлэлцэх, зохицуулалт хийх, ”урт хугацааны үзэл баримтлал”-тай уялдаатай байгаа эсэхэд үнэлгээ, дүгнэлт өгөхөд дэмжлэг үзүүлнэ.
- ii) **Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөр (PIP) боловсруулахад үзүүлэх дэмжлэг** : ”урт хугацааны үзэл баримтлал”, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, Эдийн засгийг сэргээх хөтөлбөр (ERP) хэрэгжүүлэх нэгдсэн хөрөнгө

оруулалтын бодлого буюу ерөнхий зураглал боловсруулах, түүнд тулгуурласан улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрийн (PIP) нэгдсэн цогц боловсруулалтад дэмжлэг үзүүлэх зорилготой. (Энэхүү боловсруулалтад үзүүлэх дэмжлэгт, төслийн үнэлгээ, хэрэгжилтийн хяналт-шинжилгээний арга зүй, улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрийн (PIP) үнэлгээ, нарийвчилсан тодотголын үе шат, өөрөөр хэлбэл салбарын төслүүд хоорондын зохицуулалт, төсвийн эх үүсвэр бүрдүүлэх зэрэг тогтолцоо, механизм бий болгоход чиглэсэн хамтын ажиллагаа)

- iii) **Хөгжлийн бодлого төлөвлөлтийн салбарын хүний нөөцийн хөгжил дээшлүүлэхэд үзүүлэх дэмжлэг** : Бодлого төлөвлөлтийн үнэлгээнээс улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөр (PIP) боловсруулалт, хяналт-шинжилгээ хүртэлх нэгдсэн үе шатанд шаардлагатай чадавхийг дээшлүүлэхэд (Capacity Development) зорилготой.

6.2 Хамтран ажиллагч байгууллага сонгох тухай

(1) Сангийн яамтай хамтарсан бүтэц

Өмнөх 5 дугаар бүлэгт дурдсан Үндэсний хөгжлийн газрын үүрэг хариуцлагад тодорхой байсанчлан өнгөрсөн жилийн Засгийн эрх солигдсоны дараах Засгийн газрын бүтцийн өөрчлөлт хүртэлх улсын хөрөнгө оруулалтын салбарт бүх салбарын (яамд) бодлогын үнэлгээ буюу улсын хөрөнгө оруулалт боловсруулах асуудлыг Сангийн яам хариуцдаг байсан. Гэвч хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэрэгжилтийн улсын хөрөнгө оруулалтын талаас бодлого төлөвлөлтийн үнэлгээ, зохицуулалт буюу улсын хөрөнгө оруулалт боловсруулах асуудлыг Үндэсний хөгжлийн газар, улсын төсвийн хөрөнгө оруулалт талын хөгжлийн төлөвлөлтийн үнэлгээ, зохицуулалт буюу төсвийн төлөвлөлт боловсруулалтыг Сангийн яам хариуцах үүрэгтэй байна.

Иймд дээрх зорилгоос авч үзэхэд улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөр боловсруулах Үндэсний хөгжлийн газрыг хамтран ажиллагчаар сонгох нь оновчтой. Нөгөө талаас улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрийн санхүүгийн эх үүсвэр болон улсын төсвийг салгаж ойлгох боломжгүй, түүнчлэн улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрийг нягтлан шалгах байр суурьтай Сангийн яам нь энэхүү хөтөлбөрийг боловсруулах, хэрэгжүүлэх үе шатанд Үндэсний хөгжлийн газартай салшгүй холбоотой. Үндэсний хөгжлийн газар хамтран ажиллагч болсон ч Сангийн яамтай хамтран ажиллах зайлшгүй шаардлагатай бөгөөд төслийн хэрэгжүүлэх үйл ажиллагаа, хамтын ажиллагааны агуулгаас шалтгаалан Сангийн яамтай хамтарсан бүтцийг урьдчилсан нөхцөл болгох шаардлагатай.

Тухайлбал, салбарын яамдын хөгжлийн төсөл болон улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрийн төслүүдийн хоорондын уялдааг ханган сонгон шалагаруулалт, үнэлгээ хийх стандарт (урт хугацааны үзэл баримтлал, салбарын яамдын бодлого, төлөвлөлттэй уялдуулан) тодорхой болгох, улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрт (PIP) тусгагдах төслийн төсвийн хуваарилалтын талаар тодруулах, төсвөөс гадуурх хөрөнгө санхүүжилт, жишээлбэл, хувийн хэвшлийн хөрөнгө оруулалт, Хөгжлийн банкны хөгжлийн зээл, ХАЁТ-ын тусламж зэрэг хөрөнгийн эх үүсвэрийн талаар авч хэлэлцэн, зохицуулалт хийх шаардлагатай. Сангийн яам болон Үндэсний хөгжлийн газар нэгдсэн ойлголтын үндсэн дээр, хэрэгтэй тохиолдолд яамны дотоод журам, сайдын тушаал зэргээр зохицуулах шаардлагатай хэсэг байгаа бөгөөд 2 талаас хамтарсан зөвлөл болон хэлэлцэх асуудал, салбар бүрийн ажлын хэсэг байгуулах зэргээр зохицуулах боломжтой.

(2) Аймаг болон сумдын нутгийн захиргааны байгууллагатай хамтарсан бүтэц

Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрт тусгагдах төслийн ихэнхи нь аймаг болон сум орон нутгийг хамарсан байх ба аймгуудын хөгжлийн бодлого төлөвлөлттэй уялдуулах, зохицуулалт хийх ажил зайлшгүй шаардлагатай. Үндэсний хөгжлийн газар аймгууд болон хэсэг сумдтай Хамтран ажиллах санамж бичиг солилцон, хамтын ажиллагаагаа

бататгаж байгаа бөгөөд иймэрхүү харилцааг ашиглан аймаг болон сумдын хөгжлийн бодлого төлөвлөлт хариуцсан газрууд хамтран ажиллах бүтэц (ажлын хэсэг гм) байгуулах талаар авч хэлэлцэх асуудал чухал.

(3) Хөндлөнгийн зөвлөх хороо зэрэг сонирхлын бүлгийн оролцоог хангасан бүтэц

Дээр дурдсан дээр нэмэлт болгон тусламжийн агуулгаас шалтгаалан, УИХ-ын Төрийн байгуулалтын байнгын хороо, төрийн өмчит судалгаа шинжилгээний хүрээлэн, их дээд сургууль, хандивлагч улсууд, олон улсын байгууллага, түүнчлэн Үндэсний хөгжлийн газар байгуулахаар төлөвлөж буй тинк-танкийн тогтолцоо зэрэг дээрх зорилгод хүрэхийн тулд байж болох бүтэц, зохион байгуулалт, байгууллагуудын хамтын ажиллагааг бүрдүүлэх хэрэгтэй.

6.3 Хэрэгжүүлэх бүтэц, тогтолцооны хэм хэмжээ

(1) Хэрэгжүүлэх тогтолцоо

Удирдах зөвлөлийн (ЖСС) Монголын талын бүрэлдэхүүнд Үндэсний хөгжлийн газрын даргаар ахлуулсан УИХ-ын Төрийн байгуулалтын байнгын хорооны дарга, Үндэсний хөгжлийн газрын хэлтсийн дарга нар, Сангийн яамны холбогдох газрын дарга нар, холбогдох яам, тамгын газрын дэд сайд зэрэг байхаар бодолцож байна. Гэхдээ Сангийн яамны хувьд холбогдох талуудтай зөвшилцсөний дээр хамтарч ахлах маягаар оролцох тал дээр авч хэлэлцэх шаардлагатай. Одоогоор Үндэсний хөгжлийн газрын байр суурийн хувьд Ерөнхий сайдын шууд удирдлага доорхи тохируулагч агентлаг тул яамдтай ижил түвшин, статустай биш хэдий ч статусыг яамны түвшинд өөрчлөх асуудал ч яригдаж байгаа тул нөхцөл байдлаас шалтгаалан Монголын талтай хэлэлцсэний дүнд эцсийн байдлаар удирдах зөвлөлийн бүрэлдэхүүнийг тогтох хэрэгтэй.

Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрт дэмжлэг үзүүлэх төслийн хувьд, салбарын яамд, тамгын газруудын оролцоог хангасан “төслийн нэгж” байгуулах нь зүйтэй¹. Шаардлагатай тохиолдолд “төслийн нэгж” байгуулах үед удирдах зөвлөлийн дор салбар бүр дээр ажлын хэсэг байгуулан, салбар бүрийн мэргэжлийн зөвлөгөөн, хэлэлцүүлэг зохион байгуулах ажлыг авч хэлэлцэх нь чухал. (Гэхдээ төслийн нэгжийн тухайд Үндэсний хөгжлийн газрын удирдлага дор байх ба эрх, үүргийг тодорхойлох шаардлагатай болно.)

ЖАЙКА-ийн техникийн хамтын ажиллагааны төслийн багийн хувьд Удирдах зөвлөлийн хариуцах бодлого төлөвлөлтийн үнэлгээ, улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөр боловсруулах буюу хөрөнгийн эх үүсвэр баталгаажуулах механизм, функцийн талаар тус бүрийн мэргэжлийн дэмжлэг туслалцаа, чадавхийг бэхжүүлэх чиглэлийн олон мэргэжилтэний бүрэлдэхүүнтэй бүтэц байх болно. Түүнчлэн, шаардлагатай тохиолдолд төлөвлөгдөж буй “зөвлөл”, “тинк-танк” үйл ажиллагаанд оролцох боломжтой байдлаар зохицуулалт хийнэ.

(2) Хэрэгжилтийн хугацаа

Хамтын ажиллагааны хугацаа нь 2017 оны 9 сараас (төлөвлөгөө) 2021 оны 6 сар (нийт 34 сар) хүртэл төлөвлөж, дараагийн сонгууль явагдах 2020 оны 7 сараас 8 сар хүртэлх 2 сарын хугацааг оруулан, эхний 2017 оны 9 сараас 2020 оны 8 сар хүртэлх (нийт 22 сар) хугацаанд төслийн зорилгод чиглэсэн, урт хугацааны хөгжлийн үзэл баримтлалтай уялдсан, хэрэгжилтийн хяналт шинжилгээний дэмжлэг зэрэг улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрийн боловсруулалт. Хэрэгжилтэд дэмжлэг үзүүлэн, хүлээгдэж буй үр дүнд (output) хүрнэ. Дараагийн 2020 оноос 9 сарын 6 сар хүртэлх

¹ Одоо хэрэгжиж буй улсын хөрөнгө оруулалтын төслүүд чинь (жишээлбэл, Багануурын нүүрс шингэрүүлэх төсөл) салбарын яам болон холбогдох газруудын төлөөллөөс бүрдсэн ажлын хэсэг, төслийн нэгж байгуулагдан ажиллаж байна.

(нийт 10 сар) хугацаанд сонгуулийн дараах шинэ бүтэц тогтолцоонд шилжсэн тохиолдолд төслийн залгамж байдлыг хадгалан үлдээхийн тулд шаардлагатай зохицуулалт буюу шинэ бүтцийн чадавхийг дээшлүүлэх үйл ажиллагааг үргэлжлүүлэн явуулна. Гэхдээ сонгуулийн хугацаанд шаардлагатай тохиолдолд бүтцийн шинэчлэл, зохион байгуулалт гарсан эсэх талаар тодруулан мэдээлэл цуглуулж, дараагийн шатны үйл ажиллагаанд даруй тусгаж ажиллах орчин бүрдүүлж, хамтын ажиллагааны бүтцийн талаар дахин авч хэлэлцэнэ.

6.4 Хамтын ажиллагааны бүтэц бүрдүүлэхэд чиглэсэн хамтын ажиллагааны салбар (хамтын ажиллагааны бүрэлдэхүүн хэсэг)

Хамтын ажиллагааны салбарын хувьд энэ судалгааны явцад Үндэсний хөгжлийн газрын зүгээс дараах 5 хамтын ажиллагааны тал дээр санал нэг байгаа бөгөөд Сангийн яамны зүгээс бодлого төлөвлөлтийн үнэлгээний чадавхийг дээшлүүлэх тал дээр ихээхэн ач холбогдол өгч, хүлээлт ихтэй байгаа.

(1) “Урт хугацааны хөгжлийн үзэл баримтлал”-тай уялдааг хангахад чиглэгдсэн бодлого төлөвлөлтийн үнэлгээ буюу улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрт тулгуурласан зохицуулалтын дэмжлэг

Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрт тусгагдах төслийн үндэслэл болох салбарын бодлогын тухайд “урт хугацааны үзэл баримтлал”-ын хөгжлийн зарчимтай уялдаж буй эсэхэд үнэлэлт, дүгнэлт өгч улсын хөрөнгө оруулалтад тусгагдах төслүүд дээр тулгуурлан салбар тус бүрийн бодлого төлөвлөлтийн зохицуулалт хийхэд шаардагдах техникийн удирдамж (Technical Guidance) буюу шинэ аргачлал гаргахад дэмжлэг үзүүлнэ.

Энэхүү хамтын ажиллагааны хэсэгт өнөөгийн байдлаар Үндэсний хөгжлийн газар болон Сангийн яам аль аль нь “урт хугацааны үзэл баримтлал” болон салбар түүнчлэн орон нутгийн бодлого төлөвлөлтийн уялдаанд үнэлгээ өгөх ажлыг эхлүүлээд байгаа билээ. (Үндэсний хөгжлийн газар 4 мэргэжилтэн, Сангийн яам 8 мэргэжилтэн хариуцаж байна.) Холбогдох салбарын мэргэжилтэнүүдэд хандан тодорхой хөгжлийн бодлогын үнэлгээ, бодлого хоорондын зохицуулалтад шаардлагатай стандарт, аргачлал, бичи баримт бүрдүүлэлт зэрэг техникийн дэмжлэг үзүүлэхээс гадна нэгдсэн үнэлгээ, зохицуулалтын үе шатад тулгуурласан асуудал тус бүр дээр (тухайлбал, улсын хөрөнгө оруулалтын төслийн тэргүүлэх дараалал тогтоох аргачлал, салбар яамдтай улсын хөрөнгө оруулалтын төсөл хоорондын зохицуулалт хийхэд тодруулах шаардлагатай процедур зэрэг) богино хугацааны сургалт, гарын авлага бэлдэх, салбарын яамд тус бүрд зөвлөгөө өгөх зэргээр сургалт, семинар зохион байгуулах боломжтой. Төрийн албан хаагчдад зориулсан сургалтын тухайд ЖАЙКА-ийн төслийн хүрээнд, шаардлагатай үед нь МУИС (Бизнес санхүүгийн сургууль дээр төсвийн менежмент, Эдийн засгийн сургууль дээр нягтлан бодох бүртгэлийн факультет дээр хяналт-үнэлгээний хичээл ордог) хамтран богино хугацааны сургалт зохион байгуулан, ШУТИС, СЭЗИС-тай хамтран тусгай сургалтын хөтөлбөр боловсруулах боломжтой. Хамтран ажиллагч байгууллагын зүгээс төсөв санхүүжилтийг хариуцах хэрэгтэй.

Нөгөөтэйгүүр, бодлого төлөвлөлтийг цэгцлэн, үнэлгээ хийн, хөгжлийн бодлогод нийцсэн улсын хөрөнгө оруулалтын төслийн агуулга ижил хэдий ч авах арга хэмжээ нь дараах байдлаараа ялгаатай.

Үндэсний хөгжлийн газрыг гол хамтран ажиллагчаар сонгосон тохиолдолд үндэсний хэмжээний хөгжлийн бодлого төлөвлөлтийг хэрэгжүүлэхэд чиглэсэн улсын хөрөнгө оруулалтын төслүүдийн тэргүүлэх дарааллыг тодорхойлох асуудал голлох бөгөөд үүнд зарцуулагдах хөрөнгийн эх үүсвэрийг бүрдүүлэх аргачлал зэргийг авч хэлэлцэхэд холбогдох бүх процедурыг хамрана.

Сангийн яамыг гол хамтрагчаар сонгосон тохиолдолд улсын төсөв боловсруулалтад тулгуурласан үр дүнтэй, үр өгөөжтэй төсөл хэрэгжүүлэх улсын хөрөнгө оруулалтын төсөл тодорхойлох асуудал голлох бөгөөд улсын хөрөнгө оруулалтын зардал төдийгүй төсвийн менежментийн талаас нийт улсын төсөв дэхь улсын хөрөнгө оруулалтын байр суурийг тодорхой болгоход чиглэсэн дэмжлэг болно. Улсын төсвийн менежментийн бүрэлдэхүүн хэсэг болох улсын хөрөнгө оруулалтын төсөв боловсруулалтын нэг хэсэг болно.

(2) Хөрөнгө оруулалтын цогц бодлого, ерөнхий зураглал боловсруулахад үзүүлэх дэмжлэг

“Урт хугацааны үзэл баримтлал”-д тулгуурлан дунд хугацааны хөгжлийн хөтөлбөр боловсруулах асуудал нэн тэргүүнд хийгдэх шаардлагатай нөхцөл байдалд байгаа хэдий ч бодит байдалд энэ оны 5 сарын 15 хүртэл боловсруулах хөрөнгө оруулалтын хөтөлбөр буюу нийт улсын хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний үндэс суурь болох “урт хугацааны үзэл баримтлал”-тай нийцсэн дунд хугацааны хөрөнгө оруулалтын бодлогыг (бодлого/стратегийг) боловсруулах хэрэгтэй. Хөгжлийн хөрөнгө оруулалтын бодлого (төлөвлөгөө) боловсруулах талаас Үндэсний хөгжлийн газрын хариуцсан салбар хэдий ч түүний үндсэн суурь болох дунд хугацааны хөгжлийн хөтөлбөр боловсруулах асуудлыг Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулийн дагуу Сангийн яам хариуцана². Энэхүү дунд хугацааны бодлого боловсруулах ажил (Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал 2030 тулгуурласан эхний 5 жилийн төлөвлөгөө) нь шинэ Засгийн газар байгуулагдсаны дараа Үндэсний хөгжлийн газрын хийх ажил үүрэг болон тусгагдсан ч Хөгжлийн бодлого төлөвлөлтийн хуулинд Сангийн яам эрхлэх хариуцах заалт хэвээр байгаа бөгөөд цаашид хуулинд өөрчлөлт оруулан, ажил үүргийн давхардлыг арилган, тодорхой болгох бэлтгэл ажил хийгдэж байгаа. Тус тусын дэмжлэг, хамтын ажиллагааны агуулгын талаар дор дурдав.

Үндэсний хөгжлийн газрыг голлох хамтран ажиллагч болгосон тохиолдолд, Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөр боловсруулах суурь болох хөрөнгө оруулалтын бодлого боловсруулахад дэмжлэг үзүүлэх арга хэмжээ болно. Хөрөнгө оруулалтын бодлогогүй Монгол улсын хувьд энэхүү салбарын дэмжлэг нь зөвхөн улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөр боловсруулалт төдийгүй цаашид төр, хувийн хэвшлийн түншлэл, концесс хөгжүүлэх чиг чандлага, гадаадын хөрөнгө оруулалтыг татах, хувийн

² Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулийн 8 зүйлийн 2-т Салбар хоорондын түвшинд хэрэгжүүлэх төрөөс баримтлах бодлогыг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага холбогдох төрийн захиргааны төв байгууллагатай хамтран боловсруулна.

хэвшлийн хөрөнгө оруулалтын чиглэл зэргийг тодорхойлоход маш чухал ач холбогдолтой бодлого юм. Гэхдээ хэдийнээ Үндэсний хөгжлийн газар дээр улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөр боловсруулах ажлын хэсэг байгуулагдсаны хажуугаар хөрөнгө оруулалтын ерөнхий зураглалын талаар хэлэлцээд эхэлсэн байгаа тул, үүн дээр дэмжлэг үзүүлэхийн хамт улсын хөрөнгө оруулалтын эзлэх байр суурь, түүнчлэн хөрөнгийн эх үүсвэрийн чиг хандлагыг тодорхой болгох асуудал дээр хамтран ажиллах шаардлагатай (Хариуцах хэлтэс: Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтэс, Салбарын хөгжлийн бодлого зохицуулалтын хэлтэс).

Сангийн яамыг голлох хамтран ажиллагч болгосон тохиолдолд, Хөгжлийн бодлого төлөвлөлтийн хуулийн 8-р зүйлд орсон нэмэлт өөрчлөлт оруулан дунд хугацааны хөгжлийн хөтөлбөрийг Үндэсний хөгжлийн газрын боловсруулах болсон тохиолдолд, хөрөнгө оруулалтын асуудлыг хамруулсан төсвийн хүрээг шийдэх байр сууринаас улсын хөрөнгө оруулалтын салбарыг улсын төсвийн менежментийн нэг хэсэг болгон авч хэлэлцэнэ (Хариуцах газар: Эдийн засгийн бодлогын газар, Хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтэс, Төсвийн хөрөнгө оруулалтын газар).

(3) Улсын хөрөнгө оруулалтын төслийн үнэлгээний арга технологи буюу хөрөнгийн эх үүсвэр хуваарилах, зохицуулалт хийх чадавхийг сайжруулах тогтолцоо бүрдүүлэхэд үзүүлэх дэмжлэг бэхжүүлэх

Тус чадавхийг дээшлүүлэх дэмжлэг нь дээр дурдсан хамтын ажиллагааны төслийн 2 дахь зорилго болгон санал тавигдсан салбар билээ. Хамтын ажиллагааны хамрах хүрээ нь улсын хөрөнгө оруулалтын салбарын төслийн үнэлгээ, хэрэгжилтийн хяналт-шинжилгээний аргачлал, үнэлгээний шалгуур үзүүлэлт тогтоох, тэргүүлэх дарааллыг тогтоох зэрэг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулах үе шатыг бодитой, тодорхой болгох зэрэг тогтолцоог бүрдүүлэх ажил орно.

Үндэсний хөгжлийн газрыг голлох хамтран ажиллагч болгосон тохиолдолд, Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрт тусгагдах хөрөнгө оруулалтын төслийн үнэлгээ, тэргүүлэх зэрэглэл тогтоох буюу төслийн үнэлгээнд чиглэсэн чадавхийг сайжруулах, механизм бүрдүүлэхэд дэмжлэг үзүүлнэ. Энэ жилийн хувьд 5 сард улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөр боловсруулагдах тул бодитоор цаашдын тодотгол болон нарийвчлах үе шат, салбарын яамд хоорондын төслийн зохицуулалт, хөрөнгийн эх үүсвэр олох зэрэг хэрэгжилтийн шатны тогтолцоо, механизмыг бүрдүүлэхэд чиглэсэн дэмжлэг үзүүлнэ. Гэхдээ улсын төсвөөс хэтэрсэн төсөв олгох асуудлын хувьд Сангийн яамтай зөвшилцөх процедурыг тодорхой болгож, салбарын яамдтай хамтарсан тогтсон зохицуулалтын функцыг бодолцох хэрэгтэй (Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрт тусгагдсан төр, хувийн хэвшлийн түншлэл (PPP), хөрөнгө оруулалтын сан зэрэг хөрөнгийн эх үүсвэрийг зохицуулах болон Үндэсний хөгжлийн газрын ажил үүргийн хуваарилалтыг тодорхой болгосон тогтолцоо бүрдүүлэх).

Сангийн яамыг голлох хамтран ажиллагч болгосон тохиолдолд, улсын төсвөөр хэрэгжүүлдэг хөгжлийн төслийг хамруулан салбарын бодлогод тулгуурласан төслийн төсвийн шийдвэр гаргахад шаардагдах үнэлгээ, тэргүүлэх зэрэглэлийг авч хэлэлцэн, салбарын яамдын төсөвт тусгагдана. Хөгжлийн бодлого төлөвлөлтийн хуульд заагдсан улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөр бус, улсын төсөв, дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэл боловсруулахад улсын төсвийн менежмент, ялангуяа төсвийн хөрөнгө оруулалтын салбарт түлхүү анхаарна.

(4) Үндэсний хөгжлийн газрын улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөр боловсруулах, хэрэгжүүлэх үйл явцад дэмжлэг үзүүлэх зөвлөх хороо, тинк-танк байгуулах

1) Зөвлөх хороо (advisory committee) байгуулахад үзүүлэх дэмжлэг

Үндэсний хөгжлийн газрын хариуцах улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрийн боловсруулалт, хэрэгжилтийн үе шатыг анхааралтай хянаж, Үндэсний хөгжлийн газарт зөвлөх шаардлагатай үед макро талаас нь өргөн хүрээнд авч хэлэлцэх эрдэмтэн, судлаач зэрэг олон талын оролцоотой Японы “Эдийн засаг, төсвийн зөвлөх хороо”-той дүйцэх функц байгуулах асуудал хүлээгдэж байна. Ерөнхий сайдын дэргэд байгуулагдсан “Эдийн засгийн зөвлөл”-д тулгуурлах санал байгаа хэдий ч зөвлөх хороонд тавигдах шаардлагыг авч хэлэлцэн, улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөр боловсруулах, хэрэгжүүлэх шат дараалалд тусган, үйл ажиллагааны функцийг тодорхой тусгасан тогтолцоо болон менежмент бүрдүүлэхэд дэмжлэг шаардлагатай.

2) «Тинк-танк» байгуулахад үзүүлэх дэмжлэг

Дээр дурдагдсан зөвлөх хороо нь өргөн хүрээнд ерөнхий дүгнэлт өгөх бөгөөд мэргэжлийн салбар бүр дээр арга зүйн зөвлөх үйлчилгээ үзүүлэх байгууллага (функц) байх хэрэгтэй. Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрт тусгагдах төслийн үнэлгээ, бодлого төлөвлөлтийн талаас хэрэгжилтийн явцын үнэлгээний талаар олон талын салбарын мэргэжлийн мэдлэг, мэдээлэл шаардагдах бөгөөд Үндэсний хөгжлийн газарт энэ талын дэмжлэг хэрэгтэй. Үндэсний хөгжлийн газар олон улсын байгууллагын мэргэжилтэн, зөвлөхүүдээс бүрдсэн Тинк-танк байгуулах ажил хэлэлцэгдэж байгаа бөгөөд тавигдах шаардлагыг авч хэлэлцэн, тогтолцоо болон менежментийн дэмжлэг шаардлагатай.

(5) Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөртэй холбогдох хууль эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох

Одоо байгаа үндсэн механизм нь хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тухай хууль, төсвийн тухай хууль, хөрөнгө оруулалтын тухай хууль зэргээр хууль, эрх зүйн орчин бүрдсэн байгаа хэдий ч, илүү нарийн тодорхой зохицуулалтыг холбогдох дүрэм, журмаар боловсронгуй болгох шаардлагатай юм (Үндэсний хөгжлийн газрын статус, улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрийн бүхий л үе шат дахь Үндэсний хөгжлийн газар, Сангийн яамны ажил үүргийн хуваарилалт, яамдуудаас санал хүлээн авах

процедурыг тодорхой зааж журамлах, төслийн хөндлөнгийн үнэлгээний арга зүй бэхжүүлэх зэрэг) . Түүнчлэн Үндэсний хөгжлийн газрын санаачлагаар зохион байгуулагдаж буй хөгжлийн бодлого төлөвлөгчдийн зөвлөлдөх уулзалт, хэлэлцүүлэг нь төслийн боловсруулалт, үнэлгээний шатанд чухал ач холбогдолтой байгаа хэдий ч иймэрхүү үйл ажиллагаа нь яамдын журам, удирдамжид хараахан тусгагдаагүй байгаа тул цаашид боловсронгуй болгох шаардлагатай хэмээн үзэж байна. Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөр боловсруулах үе шат болон дараагийн тодотгол хийх үе шатыг харгалзан, шаардлагатай байгаа дүрэм журам боловсруулах тал дээр дэмжлэг хэрэгтэй байна.

6.5 Хандивлагчдын хамтын ажиллагааны тойм

Хандивлагчдын хамтын ажиллагааны талаар өмнөх “3.3 Хандивлагчдын хамтын ажиллагааны төсөл” бүлэгт тоймлон дурдсан байгаа бөгөөд одоогоор Үндэсний хөгжлийн газартай GiZ, UNDP, IFC, Сангийн яамтай АХБ, Европын холбоо, КОЙКА, Дэлхийн банк хамтран ажиллан дэмжлэг үзүүлж байна.

(1) Үндэсний хөгжлийн газрын хамтын ажиллагаа

Германы техникийн хамтын ажиллагааны байгууллага нь 2020 он хүртэл хэрэгжүүлэхээр хугацаа нь сунгагдсан “Integrated Mineral Resource Initiative” хөтөлбөрийн хувьд ашигт малтмалын баялагт түшиглэсэн хөдөө орон нутгийг хөгжүүлэх загвар болгон 4 аймагт дэмжлэг үзүүлэн ажиллаж байна. Энэхүү төслийн хувьд улсын хэмжээний хөрөнгө оруулалтын бодлого хэрэгжилтийн нэг хэсэг болох орон нутгийн бодлогын уялдааг хангах механизм болох ба холбогдох орон нутгийн засаглалд дэмжлэг үзүүлэхээр ажиллаж буй GiZ-тай дэмжлэг үзүүлэх салбараа хуваан, хамтран ажиллах боломжтой. GiZ зүгээс ЖАЙКА-тай хамтран ажиллах санамж бичиг зурах сонирхолтой байгаа. Канадын Засгийн газартай орон нутгийн хөгжлийн чиглэлээр хамтран ажиллахаар хэлэлцэж буй.

НҮБХХ нь Тогтвортой хөгжлийн зорилт SDG17 чиглэсэн аймгийн түвшний хөгжлийн бодлого боловсруулахад дэмжлэг үзүүлэх тал дээр анхаарал хандуулах чиг хандлагатай байгаа. Төвөөс гадагш чиглэсэн үйл ажиллагаа явуулдаг ЖАЙКА-ийн дэмжлэг, хамтын ажиллагааг сонирхож буй. Нөгөөтэйгүүр, SDG хэрэгжүүлэх ажилд НҮБХХ-ийн өөрсдийн гэрээт зөвлөхийг (Ч.Хашчулуун профессор) Үндэсний хөгжлийн газарт зөвлөхөөр ажиллуулахаар тохиролцоод байгаа бөгөөд, улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөр боловсруулах, хэрэгжүүлэх шат дараалалд дэмжлэг үзүүлэх ЖАЙКА-тай харилцан үр дүнтэйгээр хамтран бололцоотой.

Олон улсын санхүүгийн байгууллага (IFC) нь Үндэсний хөгжлийн газартай энэ жилийн 7 сард хамтран ажиллах санамж бичиг зуран, салбарын яамдын зөвлөлдөх уулзалт болон сургалт семинар зохион байгуулах, үндэсний буюу олон улсын зөвлөх томилон ажиллуулах 5 сарын 15-нд өргөн барих улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрийн эхний шатнаас бодлого төлөвлөлтийн буюу төслийн үнэлгээн дээр техникийн дэмжлэг үзүүлж ажиллана. ЖАЙКА-ийн хамтын ажиллагаа нь 7 сараас хойш энэхүү хамтын ажиллагааг үргэлжлүүлэн, дээрх хамтын ажиллагааг өргөжүүлсэн хэлбэрээр явагдах хэдий ч Үндэсний хөгжлийн газрын зүгээс IFC-д 5 сарын 15-нд өргөн барих ажилд болон түүний дараагийн арга хэмжээнд дээр дэмжлэгт мөн найдлага тавьж буй бөгөөд ЖАЙКА-д үүнтэй зэрэгцэн дунд урт хугацаанд хэрэгжих бололцоотой тогтолцоо бүрдүүлэх, чадавхийг дээшлүүлэхэд чиглэсэн дэмжлэгийг нэн тэргүүнд эхлүүлэх санал тавиад байгаа билээ. Түүнчлэн IFC-ийн зүгээс мөн ЖАЙКА хамтран энэ салбарт дэмжлэг үзүүлэх явдалд ихээхэн найдлага тавьж байгаа. Эдгээрээс үзэхэд техникийн хамтын ажиллагааны төсөл эхлэх

хүртэл хугацаанд бодлого төлөвлөлтийн болон төслийн үнэлгээ гэсэн 2 талаас богино хугацааны мэргэжилтэн томилон ажиллуулах хүсэлтэд хариу өгөн, техникийн хамтын ажиллагаанд бэлдэх ажил чухал ач холбогдолтой.

(2) Сангийн яамны хамтын ажиллагаа

АХБ-аас төсвийн хөрөнгө оруулалтын менежментийн мэдээлэл, технологийн орчин бүрдүүлэх зорилготой суурь судалгаа хэрэгжүүлж байгаа бөгөөд, хөгжлийн төсвийн төлөвлөгөө боловсруулах, зарлагын шат дараалал, Шилэн дансны тухай хуульд тулгуурласан улсын төсвийн хөрөнгө оруулалтын төслийн үйл ажиллагаанд хяналт шинжилгээ хийх, холбогдох сургалт семинар зохион байгуулах зэрэг ажлуудыг хийж байна. Татварын тогтолцоонд ухаалаг систем нэвтрүүлэх судалгааг явуулж байгаа бөгөөд 2017 онд 15 сая ам. долларын хөнгөлөлттэй зээлийн төсөл эхлүүлэхээр төлөвлөж буй. Сангийн яам, Үндэсний хөгжлийн яам аль нэгийг нь хамтран ажиллагчаа болгосон ч ЖАЙКА-ийн хувьд улсын хөрөнгө оруулалтын төслийн үнэлгээ зэрэгт дэмжлэг үзүүлэх тохиолдолд системн хувьд дэмжлэг авах зэргээр хамтран ажиллах асуудлыг авч хэлэлцэж болно.

Европын холбооны хувьд “Эдийн засгийн тэгш өсөлтийг хангах сайн засаглал (Economic Governance for Equitable Growth Project)” төслийг 3 дахь жилдээ хэрэгжүүлж буй бөгөөд, 3 шатны ажлын төлөвлөгөөг Annual Work Plan 2 сарын 14-нд шийдвэрлэсэн. (Төсвийн үлдэгдэл 2.5 сая евро). Тус төслөөр Сангийн яамны хөгжлийн бодлого төлөвлөлт болон хяналт шинжилгээ, үнэлгээний шатны чадавхийг дээшлүүлэх зорилгоор бодлого төлөвлөлтийг дунд хугацааны төсвийн төлөвлөлттэй (MTFF) уялдуулах, хөгжлийн бодлогын хэрэгжилтийн шатны хяналт-шинжилгээ, үнэлгээ, бодлого болон төсвийн төлөвлөлтийн үйл явц дахь УИХ-ын оролцоо, хуулийн хэрэгжилтэнд үнэлгээ хийх чадваржуулахад чиглэсэн сургалт зэрэг ажил төлөвлөгдөөд байна.

КОЙКА нь 10-аад мэргэжилтэний бүрэлдэхүүнтэй чадавхийг дээшлүүлэх тал дээр хамтран ажиллаж байгаа (2 сарын байдлаар хөдөлмөр, нийгмийн халамжийн мэргэжилтэн ажиллаж байна), техникийн хамтын ажиллагааны талаас тодорхой мэдээлэл Сангийн яамнаас тодруулж чадаагүй. Гэхдээ дунд хугацааны төслийн хүрээний мэдэгдэл боловсруулахад техник, тоног төхөөрөмжийн туслалцаа үзүүлсэн байна.

Дэлхийн банкнаас ”MSTAP : Multi-Sectoral Technical Assistance Project” I шатанд төсвийн хөрөнгө оруулалтын портфолио нэгтгэх, хөрөнгө оруулалтын тэргүүлэх дарааллыг оновчтой эрэмбэлэх, төр хувийн хэвшлийн түншлэлд (PPP) Сангийн яамны оролцооны талаар дэмжлэг үзүүлж байгаа бөгөөд үргэлжлүүлэн энэ оны 7 сараас II шатыг хэрэгжүүлэхээр болсон. Гэхдээ тус төслөөр Дэлхийн банкнаас Сангийн яам 20 мэргэжилтэний цалинг олгон ажиллуулж байгаа бөгөөд яамны өдөр тутмын ажилд оролцож байна. ЖАЙКА-тай хамтын ажиллагааны хувьд Үндэсний хөгжлийн газарт

дэмжлэг үзүүлэх тохиолдолд, хөрөнгө оруулалтын тэргүүлэх дарааллыг оновчтой болгох, төр хувийн хэвшлийн түншлэл (PPP) хамтрах боломжтой хэдий ч шууд Сангийн яаманд үзүүлэх дэмжлэг гэхээр давхцах асуудлууд их гарах тул зохицуулалт хийх шаардлагатай.

6.6 Хэрэгжүүлэхэд анхаарах асуудал

(1) Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрт тусгагдах төслийн төсвийн тухайд

Өнөөгийн төсвийн болон эдийн засгийн нөхцөл байдлыг тун анхааралтай ажиглах шаардлагатай. Дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэлд (MTFF) бага зэрэг өөдрөгөөр төсөөлсөн байгаа бөгөөд улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөр (PIP) боловсруулахад хөрөнгийн эх үүсвэрийн үндэслэлийг хянах шаардлагатай. Үндэсний хөгжлийн газрын хувьд улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрт (PIP) тусгагдах төслийн улсын төсвөөс илүү гарах хэсгийн хөрөнгийн тухайд тусад нь арга хэмжээ авах шаардлагатай хэдий ч иймэрхүү төсвийн төслийн хүрээ тодорхой бус байгаа, мөн Хөгжлийн банкны хөгжлийн санд хир найдлага тавьж буй зэрэг асуудлууд бүрхэг хэвээр байна. Цаашид Сангийн яамны хувьд ч улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрт (PIP) тусгагдах төслөөс орох орлогод найдсан дунд хугацааны төслийн хүрээний мэдэгдэл (MTFF) боловсруулж байгаа хэдий ч өнөөг хүртэлх барих-шилжүүлэх (BT) төсөлд авсан арга хэмжээ, улсын хөрөнгө оруулалтын төслийг төр хувийн хэвшлийн түншлэлийн (PPP) жагсаалтад оруулах боломж зэрэг төсвийн зарцуулалтыг бүрэн дүүрэн авч хэлэлцээгүй байгаа тал дээр анхаарах хэрэгтэй. Олон улсын валютын сангаас (IMF) хэрэгжүүлэхээр тохирсон өргөжүүлсэн санхүүгийн хөтөлбөрөөс (EFF) цаашид хэдэн жилийн улсын хөрөнгө оруулалтын хөрөнгийн хүрээнд ихээхэн нөлөө үзүүлэх тал дээр анхаарах шаардлагатай.

(2) Тогтвортой тогтолцоо бүрдүүлэх, чадавхийг дээшлүүлэх

Засгийн газар солигдсон ч үйл ажиллагаа хэвийн үргэлжлэх механизм бүрдүүлэх хэрэгтэй гэдэг нь тодорхой, хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хууль батлагдсанаас хойш энэхүү хуулийн хэрэгжилтийн бодит байдлыг хангах асуудал чухал. Үүний тулд хамтын ажиллагааны төслийг хэрэгжүүлэхэд, хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хууль, тогтвортой хөгжлийн үзэл баримтлал боловсруулах үе шатнаас санаачлага гарган, удирдан зохион байгуулж ирсэн УИХ-ын Төрийн байгуулалтын байнгын хорооны тогтвортой оролцоо, дэмжлэгийг авч ажиллах хэрэгтэй. Түүнчлэн Засгийн газар солигдох болгонд яам, тамгын газрын бүтцийн өөрчлөлт, төрийн албан хаагчдын халаа сэлгээ их байдаг тул, ноухау болон мэдээллийн залгамж байдлыг хадгалах тал дээр цаашдын хамтын ажиллагаанд анхаарал тавин, хувь хүнд бус албан байгууллагад үлдэх тогтолцоо, механизм бүрдүүлэх (мэдлэгийн сан бүрдүүлэх) шаардлагатай.

(3) Өнөөг хүртэлх ЖАЙКА-ийн тусламжийн үр дүнг ашиглах нь

Өнөөг хүртэл ЖАЙКА-ийн хувьд хөгжлийн бодлого төлөвлөлт, улсын төсвийн менежмент (PFM) зэрэг засаглалын салбар дээр техникийн хамтын ажиллагаа үзүүлж ирсэн. Гэхдээ “Гадаадын шууд хөрөнгө оруулалтын дэмжихэд чиглэсэн чадавхийг дээшлүүлэх төсөл” (2010 оны 11 сараас 2015 оны 5 сар), “Монгол улсын төр хувийн хэвшлийн түншлэлийн чадавхи бэхжүүлэх төсөл” (2014 оны 5 сараас 2016 оны 4

сар), ”Монгол улсын хөрөнгө оруулалтын орчин, хөгжлийн суурь судалгаа” (2015 оны 11 сараас 2016 он) зэрэг төслүүдэд төслийн хэрэгжилтийн хугацаанд Засгийн газрын бүтцийн өөрчлөлт гарч, дэмжлэг үзүүлсэн байгууллага, хамтран ажиллаж, сургалтанд хамрагдсан төрийн албан хаагчид солигдон, тусламжийн үр дүнг бодитоор дүгнэхэд хүндрэлтэй байдалтай тулгарч ирсэн. Эдгээр туршлага дээр тулгуурлан, тогтвортой байх тогтолцоо бүрдүүлэхэд чиглэсэн арга хэмжээ авах тал дээр анхаарал хандуулахын хамт эдгээр хамтын ажиллагааны үр дүнг хувь хүний, дан ганц нэг байгууллагын, тогтолцооны хэмжээнд тодорхойлон, үр ашигтайгаар уялдуулан, дараагийн хамтын ажиллагаатай холбох явдал чухал. Үндэсний хөгжлийн газар, Сангийн яам болон бусад холбогдох газруудаас дээрх төслүүдийн үр дүнг тодруулах хэрэгтэй.

Түүнчлэн, Сангийн яам дээр үргэжлэн хэрэгжиж буй “Дотоод аудит болон хэрэгжилтийн хяналт-шинжилгээний чадавхийг сайжруулах төсөл” (I шат : 2012 оны 1 сараас 2014 оны 7 сар, II шат : 2014 оны 8 сараас 2017 оны 8 сар), улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөртэй нягт холбоотой орон нутгийн хөгжлийн салбарын ”Монгол улсын бүсчилсэн хөгжлийн нэгдсэн судалгаа (MONDEP)” (2015 оны 2 сараас 2016 оны 10 сар) зэрэг судалгаа, төслийн үр дүнг ашиглах тал дээр сайтар авч хэлэлцэх шаардлагатай. Ялангуяа MONDEP судалгааны хувьд өмнөх Засгийн газар төдийгүй өнөөгийн Засгийн газарт хөрөнгө оруулалтын чиглэлийн зөвлөмж өндрөөр үнэлэгдэж байгаа.

(4) “Үндэсний хөгжлийн цогц хөтөлбөр” боловсруулахад чиглэсэн дэмжлэгтэй уялдуулах нь

Өнгөрсөн жил ЖАЙКА-д албан ёсоор санал тавигдсан “Үндэсний хөгжлийн цогц хөтөлбөр боловсруулах судалгаа”-ны хувьд Үндэсний хөгжлийн газар болон холбогдох яам, тамгын газруудаас хамтын ажиллагааг эртхэн эхлүүлэх тал дээр найдлага тавигдаж байгаа билээ. Тогтвортой хөгжлийн үзэл бароимтлал 2030 болон түүнтэй уялдсан улсын хөгжлийн төлөвлөлт боловсруулах ажил зайлшгүй хамт хийгдэх ёстой ажил гэдгийг анхаарах хэрэгтэй. 2017 оны 1 сарын 10 ны байдлаар Засгийн газрын тогтоолоор ”Монгол улсын хүн амын нутагшил суурьшлын хөгжлийн ерөнхий төсөл” боловсруулан батлуулах ажлыг удирдан зохион байгуулах Үндэсний хороо байгуулагдсан. “Үндэсний хөгжлийн цогц хөтөлбөр” боловсруулах ажлын гол багана болох нутагшил суурьшлын төлөвлөлт бөгөөд боловсруулах шатанд эдийн засаг, нийгмийн дэд бүтцийн асуудалд холбогдох салбарын яам, тамгын газар бүрэлдэхүүнээр оролцоно. Үндэсний хөгжлийн газар үүрэг хариуцлагын дагуу голлох бүрэлдэхүүнд орж байгаа гэдгийг анхаарч үзэх хэрэгтэй.

7 Дүгнэлт

7.1 Монгол улсын шинэ хөгжлийн бодлогын тогтолцоо бүрдүүлэхэд дэмжлэг үзүүлэх ач холбогдол

Энэхүү судалгааны хүрээнд УИХ-ын Төрийн байгуулалтын байнгын хорооны дарга Н.Энхболдтой уулзаж ярилцахад тэрээр, Монгол улс социалист тогтолцооноос чөлөөт зах зээлийн эдийн засгийн тогтолцоонд шилжсэнээс хойш олон жил өнгөрсөн хэдий ч, засаглалын хувьд хамгийн чухал тогтолцоо болон хууль эрх зүйн орчныг хараахан гүйцэд бүрдүүлж амжаагүй ирсэн нь томоохон алдаа байсан бөгөөд одоо макро эдийн засаг уналтад ороод байгаа хэдий ч хөгжлийн дараагийн эринд бэлдэх маш чухал цаг үе ирээд байгаа хэмээн дурдсан. Түүнчлэн шинэ хөгжлийн үе шатанд найдвартай шилжихийн тулд 2015 оны 11 сард Хөгжлийн бодлого төлөвлөлтийн хууль батлуулан, энэхүү хуульд үндэслэсэн Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал 2030 боловсруулагдсан. Тус хөгжлийн үзэл баримтлалд нийцүүлэн сонгуульд нэр дэвшигч болон сонгуульд оролцох улс төрийн нам, эвсэл мөрийн хөтөлбөрөө боловсруулна хэмээн хуульчлан зааж өгсөн ба 2016 оны 6 сард болсон УИХын сонгуульд оролцсон улс төрийн нам, намуудын эвслийн мөрийн хөтөлбөр нь Монгол улсын хөгжлийн үзэл баримтлалд нийцсэн эсэхийг Үндэсний аудитын газар хянаж, Сонгуулийн ерөнхий хороонд хүргүүлэн хяналт хийсэн билээ. 2015 оноос хойш урт хугацааны хөгжлийн бодлого боловсруулах, хэрэгжүүлэх үндэсний тогтолцоог бүрдүүлэх ажилд гар бие оролцож ирсэн УИХ-ын Төрийн байгуулалтын байнгын хороон дарга Н.Энхболд судалгааны багийг хандаж дараах хүсэлтийг тавьсан билээ.

“Тогтвортой хөгжлийн үзэл баримтлалыг хэрэгжүүлэх эхний үе шат болох 2020 он хүртэлх дунд хугацааны хөгжлийн хөтөлбөрийг боловсруулан, хэрэгжүүлэх шаардлагатай. Энэхүү хөгжлийн бодлого төлөвлөлтийн тогтолцоог бодитоор бүрдүүлэх зорилгоор Ерөнхий сайдын шууд удирдлаган дор Үндэсний хөгжлийн газар шинээр байгуулагдсан. Урт болон дунд хугацааны хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд салбар хоорондын бодлого зохицуулалт чухал ач холбогдолтой бөгөөд өмнөх туршлагаас суралцан энэхүү үүрэг хариуцлага бүхий агентлагийг Ерөнхий сайдын шууд удирдлага дор байгуулсан. Гэвч хүний нөөцийн хөгжил, хууль эрх зүйн орчныг бэхжүүлэх асуудал чухал шаардлагатай. УИХ-ын зүгээс энэ тал дээр дэмжиж ажиллах тул ЖАЙКА-д хандан энэхүү хөгжлийн бодлого бодитоор биелэлээ олж, хэрэгжихэд дэмжлэг үзүүлэн хамтран ажиллахыг хүсэж байна. “

Судалгааны багийн зүгээс шинэ асуудалд ул суурьтай хандаж буй улс төрч болон төрийн албан хаагчид, урт хугацааны үзэл баримтлал боловсруулсан дэд ажлын хэсгийн гишүүд болон холбогдох хүмүүстэй уулзаж ярилцах явцад нэгэн бодол улам тод томруун болсон. Энэ нь Монгол улс өнгөрсөн туршлагаас сургамж аван, шинэ оновчтой хөгжлийн бодлого төлөвлөлтийн механизм бүтээх хэрэгцээтэйг ухамсарлан, өөр өөрсдийн байр суурьнаас идэвхи санаачлага гарган ажиллаж буй яг энэ цаг үед

хамтын ажиллагааг хэрэгжүүлэн, дэмжлэг үзүүлэх нь нүдээ олсон тусламж болно гэсэн бодол юм. 2017 оны 1 сарын 26,27-ий өдөр Үндэсний хөгжлийн газартай хамтран зохион байгуулсан Салбарын бодлого төлөвлөгчдийн зөвлөгөөн дээр судалгааны багийг төлөөлөн дараах мэндчилгээг хүргэснээ дахин энд онцолмоор байна.

“Өнгөрсөн 11 сард зохион байгуулагдсан салбарын бодлого төлөвлөгчдийн анхны уулзалтаас хойш, өнөөдөр дахин цугларч 2 дахь зөвлөгөөнийг зохион байгуулж байна. Энэхүү чухал цаг үед ЖАЙКА, Үндэсний хөгжлийн газартай хамтран та бүхэнтэй ийнхүү санал солилцох болсонтой баяртай байна.

Шинэ Засгийн газар байгуулагдлаа, шинэ он ч гарлаа, урт хугацааны үзэл баримтлалын шинэ эхлэлийн энэ шатанд улсын хөрөнгө оруулалтыг үр дүнтэй хэрэгжүүлэх нь улам бүр ач холбогдол өндөртэй болоод байна. Өнгөрсөн оноос нүүрсний зах зээлийн үнийн баг зэрэг өсөх хандлагатай байгаа хэдий ч олон улсын эдийн засгийн нөхцөл байдлаас шалтгаалан Монгол улсын эдийн засаг хүндрэлтэй хэвээр байна. Дараагийн хөгжлийн шат руу чиглэсэн шинэ эдийн засгийн хүчин чадал бүрдүүлэх шаардлагатай давтах хэрэггүй байх. Төсвийн хүндрэлтэй одоо л цаашдын ирээдүйд хамгийн үр ашигтай хөрөнгө оруулалтыг хаана хийх вэ гэдгийг сайтар тунгаан, хэрэгжүүлэхэд шаардагдах орчинг бүрдүүлэх хэрэгтэй. Иймэрхүү орчинд бүх салбарын яамд мэдлэг, туршлагаа хуваалцан, хамгийн оновчтой, үр ашигтай улсын хөрөнгө оруулалтын чиг хандлагыг хэлэлцэх нь маш онцгой ач холбогдолтой. Төслийн харилцан үр дүн, тэргүүлэх дарааллыг яамд хамтран хэлэлцэх нь энэхүү цаг үед урт хугацааны үндэсний хөгжлийг дэмжих чухал арга хэмжээний нэг билээ.

Энэхүү семинар 2 өдрийн турш, яамдууд хамгийн хэрэгцээтэй гэж үзэж буй 『хөгжлийн бодлого』 болон тэргүүлэх эрэмбэ өндөр 『хөгжлийн хөрөнгө оруулалт』 ын чиг хандлагын талаар холбогдох яамдууд мэдээлэл солилцон, үүндээ тулгуурлан төсөв санхүүгийн боломжийг харгалзан, бодит улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөр (PIP) ийн санал боловсруулагдана гэдэгт итгэлтэй байна.

Энэхүү улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрийн саналыг хуулийн дагуу энэ жилийн 5 сарын 15 хүртэл эцэслэн нэгтгэх шаардлагатай, тэр хугацаа хүртэл ийм зөвлөлдөх уулзалтыг олон удаа зохион байгуулах байх. Оногдсон хугацаа маш бага байгаа тул энэхүү уулзалт үр дүнтэй хэлэлцүүлэг болно гэж найдаж байна.

Гэхдээ ЖАЙКА ийн судалгааны баг Монгол улсын хөгжлийн бодлого төлөвлөлтөд үр дүнтэй бөгөөд тохиромжтой хэрэгжүүлэх тогтолцоо бүрдүүлэх зорилгоор засаглалыг бэхжүүлэх салбарт үргэлжүүлэн хамтын ажиллагаа өргөжүүлэх асуудлыг хэлэлцэж байна. Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрийг 4 жилд нэг удаа шинэчлэх хэдий ч, жил бүрийн тодотголыг оновчтой явуулах талаас нь Үндэсний хөгжлийн газар, Сангийн яам болон холбогдох яамдтай хамтран дунд болон урт хугацааны үзэл баримтлалд нийцсэн, бодит хамтын ажиллагааны хөтөлбөрийг судалгааны багийн

зүгээс санал болгох бодолтой байна.” (2017 оны 1 сарын 26-27 өдрийн Үндэсний хөгжлийн газар, ЖАЙКА хамтран зохион байгуулсан Салбарын хөгжлийн бодлого төлөвлөгчдийн зөвлөлдөх уулзалт дээр ЖАЙКА судалгааны багийн ахлагчийн хэлсэн мэндчилгээнээс).

7.2 Техникийн хамтын ажиллагааны төсөл хэрэгжүүлэхэд анхаарах асуудал

Энэхүү судалгаа нь 2016 оны 9 сард шинэ Засгийн газар байгуулагдахаас өмнө Сангийн яамнаас албан ёсоор санал тавигдсан “Улсын хөгжлийн бодлого төлөвлөлт, улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөр боловсруулахад чиглэсэн хүний нөөцийг бэхжүүлэх” зорилготой техникийн хамтын ажиллагааны агуулгыг хэлэлцэхэд шаардлагатай мэдээлэл цуглуулах, тодруулах зорилготой хэдий ч энэхүү саналын цаана орших улс төр, засаг захиргаа, төсөв санхүүгийн нөхцөл байдлын хүндрэлтэй байдлыг ойлгох, шийдвэрлэх шаардлагатай чухал асуудлуудын талаар өмнөх 5 болон 6 дугаар бүлэгт дурдсан.

Цаашид техникийн хамтын ажиллагааны төслийн хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулахад, анахарах шаардлагатай асуудлын талаар өмнөх бүлгүүдэд дурдсан асуудал дээр тулгуурлан дараах байдлаар дүгнэж байна.

(1) Дунд хугацааны макро эдийн засгийн хөгжил буюу төсвийн таамаглалд анхаарал хандуулах

2020 он хүртэлх дунд хугацааны улсын төсвийн хүрээ болон хөрөн оруулалтын төсвийн зарлагын хүрээний тухайд, макро эдийн засгийн таамаглал болон өрийг бууруулахад чиглэсэн бодлогын хувилбар энэхүү хүрээг тогтоох үндэс суурь нь болно. Энэ утгаараа одоогийн төсвийн болон эдийн засгийн нөхцөл байдалд ихээхэн анхаарал хандуулах шаардлагатай хэдий ч 2016 онд Засгийн газраас баталсан Дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэл (MTFF) болон Эдийн засгийг сэргээх хөтөлбөрт (ERP) бага зэрэг амархан эдийн засгийг сэргээх таамаглалд тулгуурлан байгаа бөгөөд аль болох хамгийн ойр эдийн засгийн үзүүлэлтийг анхааран, тогтмол улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрийн санхүүгийн эх үүсвэрийн баталгааг анхааралтай хянан, мониторинг хийх шаардлагатай. Ялангуяа 2017 оны 1 сарын сүүлээр ОУВС-тай хэлэлцэгдэж буй “Станд бай хөтөлбөр (Stand-by Arrangement)” аль эсвэл “Extended Fund Facility: EFF) зээлийн нөхцөл, түүнтэй зэрэгцэн хандивлагч орнуудын ХАЁТ нэмэгдсэнээр улсын хөрөнгө оруулалтын зарлагын хэмжээ нэмэгдэх магадлалтай. Тиймэрхүү нөхцөл байдлыг харгалзан үзвэл, 2017 оны 5 сарын 15 хүртэл Үндэсний хөгжлийн газар боловсруулах үүрэгтэй улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөр (PIP) нь 2018 он хүртэл үндсэндээ тодотгол хийгдэх шаардлагатайг харгалзан үзэх хэрэгтэй.

(2) Үндэсний хөгжлийн газар болон Сангийн яамны зохицуулалтын асуудал

Техникийн хамтын ажиллагааны төслийн хамтран ажиллагчийн талаар өмнөх бүлэгт дурдсанчлан, Үндэсний хөгжлийн газар эсвэл Сангийн яам байхаар хувилбар байгаа хэдий ч дунд хугацааны хөгжлийн бодлого боловсруулах, мөн яам агентлаг хоорондын зохицуулалт буюу тогтсон хэмжээнээс (30 тэрбум төгрөг) дээш төсөл хамрагдах улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөр боловсруулах үүрэгтэй Үндэсний хөгжлийн газар голлох хамтран ажиллагч байгууллага байх нь энэхүү төслийн зорилго болох оновчтой

шийдвэр болно хэмээн үзэж байна. Гэсэн хэдий ч Сангийн яамтай хамтран ажиллах, зохицуулалт хийх ажил мэдээж шаардлагатай бөгөөд энэ утгаараа хоёр байгууллагын үүрэг хариуцлагын хуваарилалтыг цэгцлэх шаардлагатай болно. Хуулиар үндсэн үүрэг хариуцлагыг тусгаж өгсөн хэдий ч бодит хэрэгжилтийн шатанд бодлогын аль асуудал дээр, хэдий хэмжээний бодлогын хэлэлцүүлэгт 2 талын санал, зөвшилцөл хэрэгтэй болох зэрэг тухай цаашдын боловсруулах шатанд тодорхой болгох хэрэгтэй. Гол нь урьдчилж үүрэг, хариуцлагыг тодорхой болгон хуваарилах гэхээсээ илүү 2 тал зохицуулалт хийн, хамтран ажиллах шаардлагатай бүсийг төсөөлж чадахуйц болох нь чухал юм.

(3) Бодлогын залгамж чанарыг хадгалахад чиглэгдсэн Төрийн байгуулалтын байнгын хороотой харилцааг бэхжүүлэх

2020 оны УИХ-ын сонгуулийн үр дүнд засаг солигдлоо гэхэд тэр хүртэл хичээл, зүтгэл гарган бүтээсэн хөгжлийн бодлогын тогтолцоо буюу улсын хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт зогсолтгүй, суурь үндэс нь баттай үйл ажиллагаа явуулах механизмыг бүрдүүлэх шаардлагатай байна. Үүний тулд УИХ-ын Төрийн байгуулалтын байнгын хороотой тогтвортой оролцоо болон аль болох дэмжлэг аван ажиллах хэрэгтэй. Өнөөг хүртэл засаг солигдох бүр яам тамгын газарт бүтцийн өөрчлөлт хийн, төрийн албан хаагчдыг олноор нь солин, ноухау болон мэдээлэл дараагийн үедээ залгамжлагдаж үлддэггүй асуудал өнөөг хүртэл олон удаа тохиолдож ирсэн. Цаашдын хамтын ажиллагаанд энэ тал дээр анхаарч, ноухау болон мэдээлэл хувь хүнд биш тухайн албан байгууллагад үлдэх механизм (мэдээллийн бааз бүрдүүлэх) бий болгоход онцгой анхаарал хандуулах шаардлагатай.

(4) Бусад хандивлагчдын хэрэгжүүлэх техникийн туслалцаатай уялдуулах

Олонхи хандивлагчид ижил салбарт дэмжлэг, туслалцаа үзүүлэх саналаа илэрхийлээд байна. Үндэсний хөгжлийн газарт НҮБХХ, Германы техникийн хамтын ажиллагааны байгууллага (GIZ), Олон улсын санхүүгийн корпораци (IFC) зэрэг байгууллагаас дэмжлэг үзүүлж эхэлсэн байгаа, Сангийн яаманд олон жилийн өмнөөс Европын холбоо, Дэлхийн банк, АХБ, КОЙКА зэрэг байгууллагуудаас туслалцаа үзүүлж байна. Дараагийн төслийг хэрэгжүүлэхэд энэхүү төслүүдтэй агуулга давхцалгүй байлгах, төслөө уялдуулан хамтран ажиллах боломжтой холбогдох хандивлагч нартай урьдчилсан байдлаар мэдээлэл солилцсон, аль ч хандивлагчид өөрсдийн сонирхож буй салбартаа хязгаарлагдаж байгаа бөгөөд Үндэсний хөгжлийн газрын чадавхи бэхжүүлэх тал дээр нэгдсэн цогц дэмжлэг үзүүлэхээр төлөвлөж буй байгууллага одоогоор алга. Тиймд агуулга өөрчлөх зэрэг асуудал гарахгүй хэдий ч GIZ 2014 оны 8 сараас эхлэн хэрэгжүүлж буй 「Integrated Mineral Resource Initiative II」 төслийн хамтран ажиллагч байгууллага Үндэсний хөгжлийн газар тул ЖАЙКА-аас хэрэгжүүлэхээр хэлэлцэгдэж буй техникийн хамтын ажиллагааны төсөлтэй ижил төстэй зүйл гарах магадалтай. Энэхүү төсөл нь уул уурхай голлох салбар нь болох 4

аймагт (Баянхонгор, Сэлэнгэ, Увс, Өвөрхангай) уул уурхайн компани, нутгийн иргэд, нутгийн жижг дунд үйлдвэр, нутгийн захиргааны 4 талын хамтын ажиллагааг дэмжих хамтын нийгэмлэг (community) хөгжүүлэх төсөл юм. 2020 он хүртэл төслийн хугацааг сунгахаар шийдвэрлэгдсэн, төсөл хэрэгжүүлэх орон нутгийг өргөжүүлэх бодолгүй байгаа. Үндэсний хөгжлийн газрын хувьд бүсчилсэн хөгжлийн бодлогын загвар болгон тус төслийн туслалцааг үргэлжлүүлэх саналтай байгаа.

Нөгөөтэйгүүр ”Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал 2030” боловсруулах шатнаас эхлэн дэмжлэг үзүүлж ирсэн НҮБХХ нь үргэлжлүүлэн Үндэсний хөгжлийн газарт дэмжлэг үзүүлж буй бөгөөд цаашид урт хугацааны үзэл баримтлалд тусгагдсан Тогтвортой хөгжлийн зорилтыг (SDGs) хэрэгжүүлэхэд Монгол улсын хөгжлийн бодлого, төсвийн болон хөгжлийн нөөц баялаг бодитоор чиглэж чадаж байгаа эсэхэд ихээхэн анхаарал хандуулж байгаа бөгөөд үүн дотроо Үндэсний хөгжлийн газрын чадавхийг бэхжүүлэх дэмжлэгийг авч хэлэлцэж байна. Энэ дундаа хөдөө орон нутгийн захиргааны чадавхийг бэхжүүлэх тал дээр анхаарал хандуулж буй тул, нэгдсэн цогц байдлаар хөгжлийн бодлого төлөвлөлтийг авч үзэх ЖАЙКА-ийн техникийн хамтын ажиллагааны төсөлтэй нэг бодлын хамтран ажиллах боломжтой.

Олон улсын санхүүгийн корпораци (IFC) нь Үндэсний хөгжлийн газрын хариуцаж буй ажил үүрэг дундаас ялангуяа хувийн хэвшлийн хөрөнгө оруулалт, төр хувийн хэвшлийн хамтын ажиллагаа (PPP) тэр дундаа эрчим хүчний салбарын дэд бүтцийн хөрөнгө оруулалтын төсөлд хамтран ажиллах сонирхолтой байгаа. Хөрөнгө оруулалт, санхүүгийн байгууллага болох IFC нь бодлого төлөвлөх чадавхийг бэхжүүлэх болон засаглал зэрэг салбарт анхаарал хандуулах нь ховор хэдий ч Үндэсний хөгжлийн газар энэхүү үйл ажиллагааг бүрэн дүүрэн гүйцэтгэх байгууллага болох тул дөнгөж байгуулагдаж буй энэ цаг үе маш чухал гэдэг утгаараа 2017 оны 7 сар хүртэл зөвлөх үйлчилгээ үзүүлж бие даасан технологийн загварчлал (TACD) хэрэгжүүлэх төлөвлөгөөтэй байна. Энэ нь ч ЖАЙКА-ийн төсөлтэй хамтран харилцаатай байна.

(5) “Улсын хөгжлийн цогц хөтөлбөр боловсруулах судалгаа”-тай уялдуулах

Өнгөрсөн жил ЖАЙКА-д албан ёсоор хүсэлт тавигдсан “Улсын хөгжлийн цогц хөтөлбөр боловсруулах судалгаа”-ны хувьд Үндэсний хөгжлийн газар болон холбогдох яам, тамгын газруудаас аль болох эртхэн эхлүүлэх тал дээр ихээхэн хүлээлттэй байгаа. Урт хугацааны хөгжлийн үзэл баримтлал болон түүнтэй уялдсан Улсын хөгжлийн цогц хөтөлбөр боловсруулах нь улсын хөгжлийн бодлого төлөвлөлтийн хувьд зайлшгүй хийгдэх ёстой асуудал билээ.

Барилга, хот байгуулалтын яамны (MCUD) тэргүүлэх бодлого болох “Монгол Улсын хүн амын нутагшилт, суурьшлын хөгжлийн ерөнхий төсөл боловсруулах тухай (Formulation of General Plan for Mongolia’s Population Settlement)” Засгийн газрын 2017 оны 1 сарын 4-ний өдрийн 5 дугаар тогтоол батлагдсан (хавсралтыг үзнэ үү). Уг тогтоолд дараах зүйлүүдийг баталсан.

- (i) “Монгол Улсын хүн амын нутагшилт, суурьшлын хөгжлийн ерөнхий төсөл ийг боловсруулан батлуулах ажлыг удирдан зохион байгуулах үүрэг бүхий Үндэсний хорооны бүрэлдэхүүнийг батласан.
- (ii) Монгол Улсын хүн амын нутагшилт, суурьшлын хөгжлийн ерөнхий төсөл-ийг боловсруулах ажлыг шуурхай зохион байгуулж, Үндэсний хороогоор хэлэлцүүлэхийг Барилга, хот байгуулалтын сайд Г.Мөнхбаярт даалгасан.
- (iii) Энэхүү төслийг боловсруулахад шаардагдах хөрөнгийг 2018, 2019 оны улсын төсөвт тусган гадаад орон, олон улсын байгууллагаас хэрэгжүүлэх төсөл, хөтөлбөрт хамруулж, холбогдох бусад эх үүсвэрээс санхүүжүүлэх арга хэмжээ авахыг Сангийн сайд Б.Чойжилсүрэн, Барилга, хот байгуулалтын сайд Г.Мөнхбаяр нарт даалгасан.

Барилга, хот байгуулалтын яам тэргүүлэн хэрэгжүүлэх “Хүн амын нутагшилт, суурьшлын хөгжлийн ерөнхий төсөл” боловсруулах энэхүү ажлыг Барилга хот байгуулалтын яамны зүгээс ЖАЙКА-д албан ёсоор хүсэлт гаргасан Улсын хөгжлийн цогц хөтөлбөр боловсруулах судалгаа” хэрэгжүүлэн, түүний нэг агуулга болгон хэрэгжүүлэх тал дээр найдлага тавьж байгаа. Гэхдээ улсын хөгжлийн цогц хөтөлбөр боловсруулахад мэдээж Барилга, хот байгуулалтын яам хариуцаж буй хот, суурин газрын төлөвлөлт, газар зохион байгуулалтын хяналт, төлөвлөлтийн асуудал үндэс суурь нь болох хэдий ч зөвхөн үүгээр хангалтгүй. Зам тээврийн тогтолцоо, байгаль орчны нөөцийн хяналт, аж үйлдвэр, эдийн засгийн систем, нийгмийн дэд бүтэц зэрэг бүхий л салбарыг нийтэд нь хамарсан асуудал шаардлагатай. Үүний тулд, Барилга хот байгуулалтын яамд голлон хариуцуулах хэдий ч салбар тус бүр дээр ажлын хэсэг байгуулан, тухайн салбар бүр дээрх хөгжлийн бодлогыг орон зайн төлөвлөлтөд орчуулан буулгах ажлыг зохион байгуулах хэрэгтэй. Түүнчлэн, эдгээр салбарын төлөвлөлтийг нэгтгэсэн хэлбэрээр улсын хөгжлийн цогц хөтөлбөр боловсруулагдах боловч тэрхүү нэгдсэн асуудлыг Засгийн газрын тогтоолоор зохион байгуулагдсан “Үндэсний хороо” -ны функцыг тэр чигт нь ажиллуулах боломжтой. Энэ тохиолдолд, нарийн бичгийн даргын үүргийг Барилга, хот байгуулалтын яам, Үндэсний хөгжлийн газраас бүрдсэн байдлаар зохион байгуулах нь зүйтэй. Хөгжлийн бодлого төлөвлөлт хариуцсан агентлаг болон салбарын бодлого хариуцсан яам хамтарсан байдлаар оролцох нь туйлын ач холбогдолтой гэж үзэж байна.


(6) Техникийн хамтын ажиллагааны төсөл эхэлтэл шаардагдах дэмжлэг тусалцаа

Өмнөх бүлэгт дурдсанчлан Төсвийн тухай хуулинд тулгуурласан анхны Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрийг Үндэсний хөгжлийн газар 2017 оны 5 сарын 15-нд эцэслэн нэгтгэж Засгийн газарт хүргүүлэх ёстой. Нөгөө талаас ЖАЙКА албан ёсоор хамтын ажиллагааны төсөл эхлүүлэх хугацаа нь эртдээ л 2017 оны 8 сараас гэж таамаглаж байна. Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөр боловсруулах ажилд үзүүлэх

дэмжлэгийг нэг зорилгоо болгох бол эхний төслийн санал боловсруулах шатанд дэмжлэг үзүүлэх боломжгүй тул харамсалтай нь энэхүү зорилгодоо бүрэн дүүрэн хүрч чадахгүйд хүрнэ. 2017 оны эхний улиралд хамтын ажиллагааны төсөл эхэлтэл Үндэсний хөгжлийн газар болон Сангийн яаманд туйлын чухал үүрэгт ажил ногдож байгаа бөгөөд үүнд л ЖАЙКА-ийн туслалцаа маш ихээр шаардагдана. Иймд ЖАЙКА-аас богино хугацааны мэргэжилтэн томилох зэргээр цаг хугацааны хувьд завсар гаргахгүй байх байдлаар зохицуулах боломжтой эсэхийг дараагийн техникийн хамтын ажиллагааны төслийн үр дүнг нэмэгдүүлэх үүднээс ч авч хэлэлцэх шаардлагатай асуудал юм.

Хавсралт

Хавсралт: Сангийн Яамны
Бүтэц зохион байгуулалт





**МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ
ТӨСВИЙН ТУХАЙ
/Шинэчилсэн найруулга/**

**НЭГДҮГЭЭР БҮЛЭГ
НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ**

1 дүгээр зүйл.Хуулийн зорилт

1.1.Энэ хуулийн зорилт нь төсөв, түүний зарчим, тогтолцоо, бүрэлдэхүүн, ангиллыг тогтоож, төсвийн тусгай шаардлагыг хэрэгжүүлэх, төсвийн харилцаанд оролцогчийн эрх, үүрэг, хариуцлагыг тодорхойлж, төсөв боловсруулах, батлах, зарцуулах, бүртгэх, тайлагнах, хяналт тавихтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

2 дугаар зүйл.Төсвийн тухай хууль тогтоомж

2.1.Төсвийн тухай хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль^[1], Төсвийн тогтвортой байдлын тухай хууль^[2], Өрийн удирдлагын тухай хууль, энэ хууль болон эдгээр хуультай нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

[/Энэ хэсэгт 2015 оны 02 дугаар сарын 18-ны өдрийн хуулиар нэмэлт оруулсан/](#)

3 дугаар зүйл.Хуулийн үйлчлэх хүрээ

3.1.Энэ хууль нь төсвийн байгууллага, түүний албан тушаалтан, Засгийн газрын болон орон нутгийн тусгай сан, төрийн чиг үүрэгт хамаарах ажил, үйлчилгээг гэрээний үндсэн дээр хэрэгжүүлдэг болон хууль тогтоомжийн дагуу төсөвт орлого төвлөрүүлэх үүрэг хүлээдэг төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдэд хамаарна.

3.2.Энэ хуульд заасан хөтөлбөрийн төлөвлөлт, үр дүнгийн гэрээ, түүний гүйцэтгэл, тайлагналтай холбогдсон зохицуулалт нь хууль тогтоомжийн дагуу улсын аюулгүй байдлыг хангахтай холбогдсон гүйцэтгэх ажил эрхлэх эрх бүхий байгууллагын гүйцэтгэх ажилд хамаарахгүй.

3.3.Энэ хуульд заасан ил тод байдалтай холбогдсон зохицуулалт нь хууль тогтоомжийн дагуу төрийн нууцад хамаарах төсөвт болон энэ хуулийн 3.2-т заасан гүйцэтгэх ажилд хамаарахгүй.

3.4.Төсвийн харилцааг зөвхөн энэ хуулиар зохицуулах бөгөөд орон нутаг, салбарын үйл ажиллагаанд санхүүжилтийн эх үүсвэрийн хэмжээг хуульчлан тогтоох, түүнийг хуваарилах аливаа харилцаа үүнд нэгэн адил хамаарна.

3.5.Засгийн газар, орон нутаг өр үүсгэх замаар зээллэг хийх, Засгийн газрын өрийн баталгаа гаргах, дамжуулан зээлдүүлэх, бүртгэх, тайлагнах, хяналт тавихтай холбогдсон харилцааг Өрийн удирдлагын тухай хуулиар зохицуулна.

/Энэ хэсгийг 2015 оны 02 дугаар сарын 18-ны өдрийн хуулиар нэмсэн/

4 дүгээр зүйл.Хуулийн нэр томъёоны тодорхойлолт

4.1.Энэ хуульд хэрэглэсэн дараах нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно:

4.1.1.“төсвийн тусгай шаардлага” гэж Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасныг;

4.1.2.“дунд хугацаа” гэж Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 4.1.9-д заасныг;

4.1.3.“дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэл” гэж Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 4.1.10-т заасныг;

4.1.4.“төсвийн төсөл” гэж дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэлд үндэслэн, хуульд заасан шаардлагын дагуу төсвийн шатлал бүрээр төсвийн ангилал ашиглан Засгийн газраас Улсын Их Хуралд, түүнчлэн бүх шатны Засаг даргаас тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд өргөн мэдүүлсэн төсвийн саналыг;

4.1.5.“төсөв” гэж төрийн чиг үүргийг хэрэгжүүлэхэд шаардагдах санхүүгийн эх үүсвэрийг бий болгох зорилгоор төрийн мэдэлд хуримтлуулан хуваарилж, зарцуулах хөрөнгө, орлого, зарлага, өр, төлбөр, санхүүгийн амлалт болон үүрэг, тэдгээртэй холбогдсон санхүүгийн үйл ажиллагаа, хэрэгжүүлэх арга хэмжээ, түүнд шаардагдах орц, хүрэх үр дүнгийн нийлбэр цогцыг;

4.1.6.“улсын төсөв” гэж Улсын Их Хурлаас баталсан, Засгийн газар болон улсын төсөвт харьяалагдах төсвийн ерөнхийлөн захирагчийн бүрдүүлж, хуваарилан зарцуулах төсвийг;

4.1.7.“суурь түвшинд үндэслэсэн төсөв” гэж макро эдийн засгийн таамаглалд нийцүүлж, тухайн төсөв хэрэгжих жилд хууль тогтоомж, эсхүл төрийн бодлогод өөрчлөлт орохгүй байхаар тооцсон төсвийн тооцоог;

4.1.8.“жилийн төсвийн хязгаар” гэж төсвийн тусгай шаардлага, дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэлд нийцүүлэн төсвийн ерөнхийлөн захирагчийн тухайн жилийн төсөв боловсруулахад баримтлах орлогын доод хэмжээ, зарлагын дээд хэмжээг;

4.1.9.“төсвийн орлого” гэж хууль тогтоомжийн дагуу улсын болон орон нутгийн төсөв бүрдүүлэх орлого, төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг;

4.1.10.“төсвийн зарлага” гэж төсөв захирагчийн үйл ажиллагаа, хэрэгжүүлэх хөтөлбөр, төсөл, арга хэмжээг санхүүжүүлэхээр батлагдсан төсвөөс хуваарилан, зарцуулах хөрөнгийг;

4.1.11.“төсвийн тэнцэл” гэж тухайн төсвийн жилийн төсвийн нийт орлого, зарлагын зөрүүг;

4.1.12.“төсвийн ашиг” гэж төсвийн зарлагаас давсан орлогыг;

4.1.13.“төсвийн алдагдал” гэж төсвийн орлогоос давсан зарлагыг;

4.1.14."орлого" гэж тухайн этгээдийн дотоод гүйлгээнээс бусад гаднаас хүлээн авах бүх төрлийн гүйлгээг;

4.1.15."зарлага" гэж тухайн этгээдийн дотоод гүйлгээнээс бусад гадагш чиглэсэн бүх төрлийн гүйлгээг;

4.1.16.“хөтөлбөр” гэж төсөв хуваарилах зорилгоор үр дүнг нь тооцож, тайлагнаж болохуйц өөр хоорондоо уялдаа бүхий төрийн чиг үүргийг хангахад чиглэсэн багц арга хэмжээг;

4.1.17.“арга хэмжээ” гэж хөтөлбөрийн бүрэлдэхүүнд багтах, тоо хэмжээ, цаг хугацаа, чанарын шалгуур үзүүлэлтээр тодорхойлогдох ажил, үйлчилгээг;

4.1.18.“орц” гэж тухайн ажил, үйлчилгээг хэрэгжүүлэхэд шаардагдах эд хөрөнгө болон эдийн бус хөрөнгийг;

4.1.19.“эдийн засгийн томгосон ангилал” гэж эдийн засгийн дэлгэрэнгүй ангиллын хэд хэдэн зүйлийг нэгтгэн бүлэглэснийг;

4.1.20.“эдийн засгийн дэлгэрэнгүй ангилал” гэж эдийн засгийн ангиллын анхдагч зүйлийг;

4.1.21.“санхүүгийн дэмжлэг” гэж төсвийн алдагдлыг нөхөх зорилгоор олгох хөрөнгийг;

4.1.22.“орлогын шилжүүлэг” гэж орон нутгийн төсвийг дэмжих зорилгоор дээд шатны төсвийн орлогоос орон нутгийн төсөвт тооцож олгох хөрөнгийг;

4.1.23.“тусгай зориулалтын шилжүүлэг” гэж энэ хуулийн 61.1-д заасан чиг үүргийг санхүүжүүлэх зорилгоор тусгайлан тогтоосон зориулалт, нөхцөл, шаардлагын дагуу аймаг, нийслэлийн төсөвт улсын төсвөөс олгох хөрөнгийг;

4.1.24."хөрөнгө оруулалт" гэж төсвөөс санхүүжүүлж, тухайн шатны төсөвт хамаарах хуулийн этгээдийн өмчлөлд шилжих хөрөнгийн зарлагыг;

4.1.25.“татварын зарлага” гэж татварын хуулиар тухайн жилд татвар төлөгчид олгох татварын хөнгөлөлт, чөлөөлөлтийг;

4.1.26.“төсвийн тодотгол” гэж тухайн жилийн төсвийг баталсан эрх бүхий байгууллагын шийдвэрт нэмэлт, өөрчлөлт оруулахыг;

4.1.27.“орон нутгийн төсөв” гэж аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас баталсан, тухайн шатны төсөвт харьяалагдах ерөнхийлөн захирагчийн бүрдүүлж, хуваарилан зарцуулах төсвийг;

4.1.28.“орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан” гэж орон нутгийн хөгжлийг дэмжих, бүс нутгийн тэнцвэртэй байдлыг хангах зорилгоор улсын төсвөөс орон нутгийн төсөвт олгохоор дахин хуваарилалт хийх хөрөнгийг;

4.1.29.“орон нутгийн төсвийн суурь орлого” гэж тухайн шатны төсөвт орох татварыг доод хувь, хэмжээгээр тооцсон орлого болон татварын бус орлогын нийлбэрийг;

4.1.30.“орон нутгийн төсвийн суурь зарлага” гэж энэ хуулийн 58.1.1, 58.2.1, 58.3.1, 58.4.1-д заасан чиг үүрэгтэй холбогдох урсгал болон хөрөнгийн зарлага, энэ хуулийн 58.1.4, 58.1.14, 58.2.4, 58.2.13, 58.3.2, 58.3.5, 58.4.2, 58.4.6-д заасан чиг үүрэгтэй холбогдох урсгал зарлагын нийлбэрийг;

4.1.31.“орон нутгийн төсвийн үндсэн тэнцлийн алдагдал” гэж орон нутгийн төсвийн суурь орлогоос давсан орон нутгийн төсвийн суурь зарлагыг;

4.1.32.“Нийгмийн даатгалын сангийн төсөв” гэж Нийгмийн даатгалын тухай хуулийн[3] дагуу бүрдүүлж, зарцуулах, тухайн жилд Улсын Их Хурлаас баталсан төсвийг;

4.1.33.“Хүний хөгжил сангийн төсөв” гэж Хүний хөгжил сангийн тухай хуулийн[4] дагуу бүрдүүлж, зарцуулах, тухайн жилд Улсын Их Хурлаас баталсан төсвийг;

[/Энэ заалтыг 2016 оны 02 дугаар сарын 05-ны өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон/](#)

4.1.34.“төсвийн байгууллага” гэж баталсан төсвийн дагуу төрийн чиг үүрэгт хамаарах ажил, үйлчилгээг хэрэгжүүлдэг, Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуульд заасны дагуу улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад бүртгүүлсэн төрийн болон орон нутгийн өмчит, ашгийн төлөө бус хуулийн этгээдийг;

[/Энэ заалтыг 2015 оны 01 дүгээр сарын 29-ний өдрийн хуулиар өөрчлөн найруулсан/](#)

4.1.35.“төсвийн захирагч” гэж төсвийн ерөнхийлөн захирагч, төсвийн төвлөрүүлэн захирагч болон төсвийн шууд захирагчийг;

4.1.36.“төсвийн ерөнхийлөн захирагч” гэж өөрийн эрхлэх асуудлын хүрээний төсвийг төлөвлөх, батлагдсан төсвийг хууль тогтоомжийн дагуу хуваарилах, хяналт тавих, захиран зарцуулах, гүйцэтгэлийг тайлагнах эрх бүхий этгээдийг;

4.1.37.“төсвийн төвлөрүүлэн захирагч” гэж төсвийн ерөнхийлөн захирагчаас хуваарилсан чиг үүргийн төсвийг төлөвлөх, төсвийн шууд захирагчид хуваарилах, хяналт тавих, хууль тогтоомжийн дагуу захиран зарцуулах, гүйцэтгэлийг тайлагнах эрх бүхий этгээдийг;

4.1.38. “төсвийн шууд захирагч” гэж төсвийн ерөнхийлөн захирагч болон төсвийн төвлөрүүлэн захирагчаас хуваарилсан чиг үүргийн төсвийг төлөвлөх, хууль тогтоомжийн дагуу захиран зарцуулах, гүйцэтгэлийг тайлагнах эрх бүхий этгээдийг;

4.1.39. “төрийн чиг үүрэгт хамаарах ажил, үйлчилгээг гүйцэтгэгч” гэж төрийн чиг үүрэгт хамаарах ажил, үйлчилгээг гэрээний дагуу гүйцэтгэж, тухайн ажил, үйлчилгээний чанар, тоо хэмжээ, хүрэх үр дүнгийн талаарх хариуцлагыг бие даан хүлээх этгээдийг;

4.1.40. “төрийн сангийн үйл ажиллагаа” гэж төсөв, мөнгөн хөрөнгө, өр төлбөрийн удирдлагыг хэрэгжүүлэх, төлбөр тооцоог гүйцэтгэх, төсвийн гүйцэтгэлийг тайлагнахыг;

4.1.41. “төрийн сангийн нэгдсэн данс” гэж Засгийн газрын нэгдсэн зохицуулалт бүхий төсвийн ерөнхий данс болон Монгол Улсын нэгдсэн төсөвт хамаарах бүх төсвийн захирагчийн Монголбанкинд байрших мөнгөн хөрөнгийн харилцах дансыг;

4.1.42. “төсвийн ерөнхий данс” гэж тухайн шатны төсвийн мөнгөн гүйлгээг нэгтгэн бүртгэх харилцах дансыг;

4.1.43. “зарцуулалтын эрх” гэж батлагдсан төсвийн хүрээнд төсвийн байгууллагын сар, улиралд зарцуулах төсвийн дээд хязгаарыг;

4.1.44. “Засгийн газрын өрийн удирдлага” гэж Засгийн газрын дунд болон богино хугацааны санхүүгийн зардал, эрсдэлийн түвшинг тодорхойлох стратеги боловруулж, хэрэгжүүлэх үйл ажиллагааг;

[/Энэ заалтыг 2015 оны 02 дугаар сарын 18-ны өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон/](#)

4.1.45. “өр” гэж өрийн хэрэгслээр дамжуулан тухайн этгээдээс бусад этгээдийн өмнө ирээдүйд эргэн төлөх төлбөрийн үүргийг;

[/Энэ заалтыг 2015 оны 02 дугаар сарын 18-ны өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон/](#)

4.1.46. “өрийн хэрэгсэл” гэж бүх төрлийн зээл, үнэт цаас болон өр үүсгэх аливаа гэрээ, хэлцлийг;

[/Энэ заалтыг 2015 оны 02 дугаар сарын 18-ны өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон/](#)

4.1.47. “Засгийн газрын өр” гэж Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 4.1.8-д заасныг;

[/Энэ заалтад 2015 оны 02 дугаар сарын 18-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/](#)

4.1.48. “болзошгүй өр төлбөр” гэж Засгийн газрын гаргасан баталгааг хангах, эсхүл үндэсний аюулгүй байдал, улс төр, нийгэм, эдийн засаг, санхүү, төсвийн тогтвортой байдлыг хангах зорилгоор төрөөс хэрэгжүүлэх бодлогын арга хэмжээтэй холбогдон төсөвт үүсч болзошгүй эрсдэлийг мөнгөн дүнгээр тооцож илэрхийлснийг;

4.1.49. “дотоод аудит” гэж төсвийн хөрөнгийг зүй зохистой, үр ашигтай зарцуулах, эрсдэлийн удирдлагаар хангахад чиглэсэн төсвийн дотоод хяналтын үйл ажиллагааг;

4.1.50.“эргэлтийн сан” гэж үйл ажиллагаа нь нэгээс дээш төсвийн жил дамжин байнга хэрэгжих, өөрийн эх үүсвэрийг хуульд заасан үйл ажиллагаанд зарцуулж, түүнээс орох орлого, эсхүл зарцуулсан хөрөнгийн эргэн төлөлтийг тухайн үйл ажиллагааг дахин санхүүжүүлэх зориулалттай төсвийн тусгай дансыг.

4.1.51.“эрүүл мэндийн даатгалын сангийн төсөв” гэж Нийгмийн даатгалын тухай, Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн дагуу бүрдүүлж, Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн дагуу зарцуулах, тухайн жилд Улсын Их Хурлаас баталсан төсвийг.

[/Дээрх заалтыг 2015 оны 01 дүгээр сарын 29-ний өдрийн хуулиар нэмсэн/](#)

4.1.52.“зээллэг” гэж Өрийн удирдлагын тухай хуулийн 4.1.15-д заасныг.

[/Энэ заалтыг 2015 оны 02 дугаар сарын 18-ны өдрийн хуулиар нэмсэн/](#)

4.1.53.“гадаадын тусламж” гэж олон улсын байгууллага, түнш орноос Засгийн газрын шугамаар, эргэн төлөгдөх нөхцөлгүй, хүмүүнлэгийн болон буцалтгүй, техник туслалцааны хэлбэрээр Монгол Улсад олгож байгаа хөрөнгийн эх үүсвэрийг.

[/Энэ заалтыг 2015 оны 02 дугаар сарын 18-ны өдрийн хуулиар нэмсэн/](#)

4.1.54.“ирээдүйн тэтгэврийн нөөц сангийн төсөв” гэж Ирээдүйн тэтгэврийн нөөц сангийн тухай хуулийн дагуу бүрдүүлж, зарцуулах, тухайн жилд Улсын Их Хурлаас баталсан төсвийг.

[/Энэ хэсгийг 2016 оны 01 дүгээр сарын 22-ны өдрийн хуулиар нэмсэн бөгөөд 2019 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө/](#)

ХОЁРДУГААР БҮЛЭГ ТӨСВИЙН ЗАРЧИМ, ТҮҮНИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ

5 дугаар зүйл.Төсвийн зарчим

5.1.Төсвийг төлөвлөх, батлах, хэрэгжүүлэх, тайлагнахад дараах зарчмыг баримтална:

5.1.1.төсвийн тогтвортой байдлыг хангасан байх;

5.1.2.төсвийн иж бүрэн, үнэн зөв байдлыг хангасан байх;

5.1.3.санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх;

5.1.4.ил тод байдлыг хангасан байх;

5.1.5.хариуцлагатай байх.

6 дугаар зүйл.Төсвийн зарчмыг хэрэгжүүлэх

6.1.Төсвийг төлөвлөх, батлах, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

6.2.Энэ хуулийн 5.1.1-д заасан төсвийн тогтвортой байдлыг хангасан байх зарчмыг дараах байдлаар хэрэгжүүлнэ:

6.2.1.Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан тусгай шаардлагыг хангах;

6.2.2.жил бүрийн төсвийн зарлагыг орлого болон санхүүжүүлэх бусад эх үүсвэрээр нь бүрэн нөхдөг байхаар төлөвлөн баталж, хэрэгжүүлэх;

6.2.3.урьдчилан тооцоолох боломжгүй нөхцөл байдлын улмаас төсвийн орлого буурах, эсхүл зарлага нэмэгдсэнээр төсвийн алдагдал нэмэгдэхээр бол төсвийн зарлагыг бууруулах, эсхүл орлогын эх үүсвэрийг нэмэгдүүлэх замаар тухайн жилийн төсөвт тодотгол хийж, төсвийг тэнцвэржүүлэх;

6.2.4.Монгол Улсын Ерөнхийлөгч, Улсын Их Хурал, нутгийн өөрөө удирдах байгууллага, Засгийн газар, Засаг даргын аливаа шийдвэр нь төсөвт үзүүлэх нөлөөллийн талаарх дүгнэлтэд үндэслэсэн байх;

6.2.5.төсвийн жилийн дундуур орлого бууруулах, зарлага нэмэгдүүлэх үр дагавартай бодлогын аливаа шийдвэр гаргасан бол түүнийг дараагийн төсвийн жилээс хэрэгжүүлдэг байх.

6.3.Энэ хуулийн 5.1.2-г заасан төсвийн иж бүрэн, үнэн зөв байдлыг хангасан байх зарчмыг дараах байдлаар хэрэгжүүлнэ:

6.3.1.төсвийн орлого, зарлага, хөрөнгө, өр төлбөрийн гүйлгээг бууруулах бичилт хийхгүйгээр нийт дүнгээр нь төлөвлөж, тайлагнах;

6.3.2.санхүүгийн аливаа үйл ажиллагааг нягтлан бодох бүртгэлийн олон улсын болон үндэсний стандартын дагуу, цаг хугацаанд нь, үнэн зөв, үндэсний мөнгөн тэмдэгтээр илэрхийлэн бүртгэж, тайлагнах;

6.3.3.төсвийн орлогоор баталгаажсан Засгийн газрын өрийн баталгаа, гадаад зээл, бүх төрлийн санхүүгийн үүрэгтэй холбогдсон гэрээ, хэлцэл, үйл ажиллагааг төсөвт тусгах;

[/Энэ заалтад 2015 оны 02 дугаар сарын 18-ны өдрийн хуулиар нэмэлт оруулсан/](#)

6.3.4.төсвийн жилийн явцад шинээр бий болсон аливаа орлого, эх үүсвэр, зээл, хандив, тусламж, тэдгээрээр санхүүжүүлсэн үйл ажиллагааны зарлага нь төсвийн бүрэлдэхүүн байх.

6.4.Энэ хуулийн 5.1.3-г заасан санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх зарчмыг дараах байдлаар хэрэгжүүлнэ:

6.4.1.төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах;

6.4.2.төрийн чиг үүрэгт хамаарахгүй хөтөлбөр, арга хэмжээг санхүүжүүлэхгүй байх;

6.4.3.иргэн, аж ахуйн нэгж, төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэх боломжтой хөтөлбөр, арга хэмжээг тэдгээрээр гүйцэтгүүлэх чиглэл баримтлах;

6.4.4.хуульд өөрөөр заагаагүй бол бараа нийлүүлэх, ажил гүйцэтгэх, үйлчилгээ үзүүлэх этгээдийг чөлөөт өрсөлдөөн, нээлттэй сонгон шалгаруулалтын аргаар сонгох;

6.4.5.төсвийн захирагч төсвийн орлогыг барьцаалах, түүгээр баталгаа гаргахгүй байх;

6.4.6.хуульд өөрөөр заагаагүй бол төсвийн орлогыг аль нэг этгээд, эсхүл үйл ажиллагаанд тусгайлан оноохгүй байх;

6.4.7.төрөөс хэрэгжүүлэх аливаа үйл ажиллагаа, хөтөлбөр, арга хэмжээ, татвар ногдуулалт, эсхүл хөнгөлөлт, баталгаа, зээл, өр төлбөр, санхүүгийн үйл ажиллагаа, болзошгүй өр төлбөр, тэдгээрийн үр дүн нь өнөө болон ирээдүй үеийн хооронд тэгш бус байдал үүсгэхгүй байх;

6.4.8.төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх.

6.5.Энэ хуулийн 5.1.4-т заасан төсвийн ил тод байдлыг хангасан байх зарчмыг дараах байдлаар хэрэгжүүлнэ:

6.5.1.төсөв хэлэлцэх, батлах үйл ажиллагааг нийтэд нээлттэй байлгаж, төсвийн төлөвлөгөө, гүйцэтгэл, тайлагналын талаар тогтоосон хугацаанд нийтэд ойлгомжтой, хүртээмжтэй байдлаар мэдээлэх;

6.5.2.төсвийг төлөвлөх, бүрдүүлэх, хуваарилах, тайлагнах үйл ажиллагаанд олон нийтийн оролцоог хангах;

6.5.3.төсвийн гүйцэтгэл, зарцуулалт нь батлагдсан төлөвлөгөөний дагуу хэрэгжиж байгаа эсэхэд олон нийт хяналт тавих боломжоор хангах;

6.5.4.төрөөс үзүүлж байгаа аливаа ажил, үйлчилгээ, хэрэгжүүлж байгаа арга хэмжээ, тэдгээрийн хүрээнд худалдан авч байгаа бараа, ажил, үйлчилгээнд олон нийт хяналт тавих боломжоор хангах;

6.5.5.хөтөлбөр, төсөл, арга хэмжээний ач холбогдлын эрэмбэ, хэрэгжүүлэх дараалал, арга замыг тодорхойлох шийдвэрт олон нийтийн саналыг харгалзан үзэх;

6.5.6.төсвийн асуудлаар иргэд, төрийн бус байгууллагаас гаргасан санал, дүгнэлтийг эрх бүхий этгээд нь шийдвэртээ хэрхэн тусгасан тухай, төсвийн үйл ажиллагаан дахь олон нийтийн оролцоог хангаж ажилласан дүнг тэдэнд тухай бүр мэдээлж байх.

6.6.Энэ хуулийн 5.1.5-д заасан хариуцлагатай байх зарчмыг дараах байдлаар хэрэгжүүлнэ:

6.6.1.төсвийн захирагч нь түүнийг томилсон байгууллага, албан тушаалтны өмнө, эсхүл дээд шатныхаа төсвийн захирагчийн өмнө төсвийн талаар хариуцлага хүлээдэг байх;

6.6.2.төсвийн захирагч нь төсвийн асуудлаа өөрийн харьяалагдах дээд шатны төсвийн захирагчаар дамжуулан шийдвэрлүүлдэг байх;

6.6.3.төсвийн захирагч нь өөрийн эрх, үүргээ доод шатны төсвийн захирагчид шилжүүлж болох боловч энэ нь түүнийг хариуцлагаас чөлөөлөх үндэслэл болохгүй байх;

6.6.4.төсвийн захирагч нь төсвийн жилийн дундуур энэ хуулиар олгогдсон бүрэн эрхийнхээ хүрээнд тухайн жилийн төсөвтөө өөрчлөлт оруулж, зохицуулалт хийсэн бол гүйцэтгэлийг нь анхны батлагдсан зорилт, хүрэх үр дүнтэй харьцуулж тайлагнадаг байх;

6.6.5.орон нутгийн төсвөөр хэрэгжүүлэхээр энэ хуульд заасан чиг үүргээс бусад чиг үүргийг өөр хууль тогтоомжоор тогтоосон бол тухайн чиг үүргийг санхүүжилтийнх нь хамт шийдвэрлэн, шилжүүлдэг байх;

6.6.6.тухайн шатны төсвөөс санхүүжүүлэхээр хуулиар тогтоосон чиг үүргийг зөвхөн тухайн шатны төсвийн санхүүжилтээр хэрэгжүүлэх.

7 дугаар зүйл.Төсвийн жил

7.1.Төсвийн жил нь тухайн оны 1 дүгээр сарын 01-ний өдөр эхэлж, тухайн оны 12 дугаар сарын 31-ний өдөр дуусгавар болно.

7.2.Төсвийн жил нь сар, улирал, хагас жил, бүтэн жил гэсэн үед хуваагдана.

7.3.Төсвийг нэг жилээр баталж, тайлагнах бөгөөд батлагдсан төсвийг сар, улирлаар хуваарилан, хэрэгжилтийг зохион байгуулна.

7.4.Төсвийн гүйцэтгэлийн мэдээг сар бүрээр, санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайланг улирал, хагас жил, бүтэн жилээр бэлтгэж, тайлагнана.

7.5.Батлагдсан төсвийг хэрэгжүүлэх бэлтгэл ажлыг тухайн жилийн төсвийг эрх бүхий байгууллагаас баталсан өдрөөс эхлэн зохион байгуулж болно.

7.6.Төсвийн жил эхлэхэд төсвийн захирагчийн тухайн төсвийн жилийн батлагдсан төсвийг зарцуулах эрх нь нээгдэнэ.

7.7.Энэ хуулийн 43 дугаар зүйлд зааснаас бусад тохиолдолд төсвийн жил дуусахад төсвийн захирагчийн төсөв зарцуулах эрх нь дуусгавар болох бөгөөд төсвийн захирагчийн төсвийн зарцуулагдаагүй үлдэгдлийг тухайн шатны төсвийн ерөнхий дансанд татан төвлөрүүлнэ.

7.8.Салбарын үйл ажиллагааны онцлогоос хамаарч төсвийн хэрэгжилтийн хугацаа нь төсвийн жилээс зөрүүтэй бол төсвийн төлөвлөлтийг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний баталсан аргачлалын дагуу зохицуулна.

7.9.Энэ хуулийн 7.7 дахь хэсэг төрийн болон орон нутгийн өмчийн төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, нэгдсэн эмнэлгийн төсвийн захирагчид хамаарахгүй.

[/Энэ хэсгийг 2016 оны 04 дүгээр сарын 22-ны өдрийн хуулиар нэмсэн/](#)

8 дугаар зүйл. Төсвийн цаглабар

8.1. Засгийн газрын өрийн удирдлагын дунд хугацааны стратегийн баримт бичиг /цаашид “Стратегийн баримт бичиг” гэх/, Дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлийг дараах цаглабарын дагуу боловсруулж, батална:

[/Энэ хэсэгт 2015 оны 02 дугаар сарын 18-ны өдрийн хуулиар нэмэлт оруулсан/](#)

8.1.1. Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага Стратегийн баримт бичиг, дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлийн төслийг боловсруулж, жил бүрийн 4 дүгээр сарын 15-ны дотор Засгийн газарт хүргүүлэх;

[/Энэ заалтад 2015 оны 02 дугаар сарын 18-ны өдрийн хуулиар нэмэлт оруулсан/](#)

8.1.2. Засгийн газар Стратегийн баримт бичиг, дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлийн төслийг хэлэлцэн жил бүрийн 5 дугаар сарын 01-ний дотор Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх;

[/Энэ заалтад 2015 оны 02 дугаар сарын 18-ны өдрийн хуулиар нэмэлт оруулсан/](#)

8.1.3. Улсын Их Хурал Стратегийн баримт бичиг, дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлийн төслийг жил бүрийн 6 дугаар сарын 01-ний дотор хэлэлцэж, батлах;

[/Энэ заалтад 2015 оны 02 дугаар сарын 18-ны өдрийн хуулиар нэмэлт оруулсан/](#)

8.1.4. Улсын Их Хурал Стратегийн баримт бичиг, дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлийг баталснаас хойш ажлын долоон өдрийн дотор хэвлэн нийтлэх.

[/Энэ заалтад 2015 оны 02 дугаар сарын 18-ны өдрийн хуулиар нэмэлт оруулсан/](#)

8.2. Улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийг дараах цаглабарын дагуу боловсруулж, батална:

8.2.1. Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийн төслийг жил бүрийн 4 дүгээр сарын 01-ний дотор боловсруулж, Засгийн газарт хүргүүлэх;

[/Энэ заалтад 2012 оны 08 дугаар сарын 17-ны өдрийн хуулиар нэмэлт оруулсан/](#)

[/Энэ заалтад 2014 оны 10 дугаар сарын 16-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/](#)

8.2.2. Засгийн газар энэ хуулийн 8.2.1-д заасан эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийн төслийг дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэлд нийцүүлэн хянаж, Улсын Их Хуралд жил бүрийн 5 дугаар сарын 01-ний дотор өргөн мэдүүлэх;

8.2.3. Улсын Их Хурал улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийн төслийг жил бүрийн хаврын чуулганаар хэлэлцэн батлах.

[/Энэ хэсгийг 2015 оны 11 дүгээр сарын 26-ны өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон/](#)

8.3. Дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэлд суурилсан төсвийн ерөнхийлөн захирагчийн жилийн төсвийн хязгаарыг дараах цаглабрын дагуу боловсруулж, батална.

8.3.1. төсвийн ерөнхийлөн захирагч дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэлд суурилсан жилийн төсвийн хязгаарын саналаа санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад жил бүрийн 6 дугаар сарын 10-ны дотор хүргүүлэх;

8.3.2. санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага төсвийн ерөнхийлөн захирагчийн жилийн төсвийн хязгаарын саналыг нэгтгэн боловсруулж, жил бүрийн 6 дугаар сарын 20-ны дотор Засгийн газарт хүргүүлэх;

8.3.3. Засгийн газар төсвийн ерөнхийлөн захирагчийн жилийн төсвийн хязгаарын төслийг хэлэлцэн жил бүрийн 7 дугаар сарын 01-ний дотор батлах;

8.3.4. санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага Засгийн газрын баталсан жилийн төсвийн хязгаарыг төсвийн удирдамжийн хамт жил бүрийн 7 дугаар сарын 5-ны дотор төсвийн ерөнхийлөн захирагчид хүргүүлэх.

8.4. Тухайн жилийн улсын төсөв, Нийгмийн даатгалын сангийн төсөв, Эрүүл мэндийн даатгалын сангийн төсөв, *Ирээдүйн тэтгэврийн нөөц сангийн төсвийг* дараах цаглабрын дагуу боловсруулж, батална:

[/Энэ хэсэгт 2015 оны 01 дүгээр сарын 29-ний өдрийн хуулиар нэмэлт оруулсан/](#)

[/Энэ хэсэгт 2016 оны 01 дүгээр сарын 22-ны өдрийн хуулиар “Эрүүл мэндийн даатгалын сангийн төсөв,” гэсний дараа “Ирээдүйн тэтгэврийн нөөц сангийн төсөв,” гэж нэмэлт оруулсан бөгөөд 2019 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө/](#)

[/Энэ хэсэгт 2016 оны 02 дугаар сарын 05-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/](#)

[/Энэ хуульд 2016 оны 11 дүгээр сарын 10-ны өдрийн хуулиар 71.5 дахь хэсгийг нэмж, энэ хэсгийн “төсөв, Эрүүл мэндийн даатгалын сангийн төсөв, Ирээдүйн тэтгэврийн нөөц сангийн” гэснийг 2018 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөхөөр заасан/](#)

8.4.1. төсвийн төвлөрүүлэн захирагчид харьяалагддаг төсвийн шууд захирагч нь жилийн төсвийн төслөө жил бүрийн 7 дугаар сарын 25-ны дотор харьяалах төсвийн төвлөрүүлэн захирагчид хүргүүлэх;

8.4.2. төсвийн төвлөрүүлэн захирагч, төсвийн төвлөрүүлэн захирагчид харьяалагддаггүй төсвийн шууд захирагч жил бүрийн 8 дугаар сарын 01-ний дотор жилийн төсвийн төслөө харьяалагдах төсвийн ерөнхийлөн захирагчид хүргүүлэх;

8.4.3. төсвийн ерөнхийлөн захирагч жилийн төсвийн саналаа жил бүрийн 8 дугаар сарын 15-ны дотор санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлэх;

8.4.4.санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага энэ хуулийн 8.4.3-т заасан жилийн төсвийн саналыг нэгтгэн боловсруулж, жил бүрийн 9 дүгээр сарын 15-ны дотор Засгийн газарт өргөн мэдүүлэх;

8.4.5.Засгийн газар жилийн төсвийн төслийг жил бүрийн 10 дугаар сарын 01-ний дотор Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх;

8.4.6.Засгийн газар жилийн төсвийн төслийг Улсын Их Хуралд өргөн мэдүүлснээс хойш ажлын гурван өдрийн дотор нийтэд мэдээлэх;

8.4.7.төрийн аудитын төв байгууллага жилийн төсвийн төслийн талаарх дүгнэлтийг Улсын Их Хуралд жил бүрийн 10 дугаар сарын 15-ны дотор хүргүүлэх;

8.4.8.Улсын Их Хурал жилийн төсвийн төслийг хэлэлцэн жил бүрийн 11 дүгээр сарын 15-ны дотор батлах.

8.5.Аймаг, нийслэлийн жилийн төсвийг дараах цаглабрын дагуу боловсруулж, батална:

8.5.1.аймаг, нийслэлийн Засаг дарга тухайн шатны жилийн төсвийн төслийг жил бүрийн 11 дүгээр сарын 25-ны дотор тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд өргөн мэдүүлэх;

8.5.2.аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал тухайн шатны жилийн төсвийн төслийг хэлэлцэн жил бүрийн 12 дугаар сарын 05-ны дотор батлах;

8.5.3.сум, дүүргийн Засаг дарга тухайн шатны жилийн төсвийн төслийг жил бүрийн 12 дугаар сарын 10-ны дотор тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд өргөн мэдүүлэх;

8.5.4.сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал тухайн шатны жилийн төсвийн төслийг хэлэлцэн жил бүрийн 12 дугаар сарын 20-ны дотор батлах;

8.5.5.аймаг, нийслэлийн Засаг дарга тухайн шатны жилийн батлагдсан төсвийг 12 дугаар сарын 31-ний дотор санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлэх.

8.6.Улсын төсөв, Нийгмийн даатгалын сангийн төсөв, Эрүүл мэндийн даатгалын сангийн төсөв, *Ирээдүйн тэтгэврийн нөөц сангийн* жилийн төсвийн сар, улирлын хуваарийг дараах цаглабрын дагуу боловсруулж, батална:

/Энэ хэсэгт 2015 оны 01 дүгээр сарын 29-ний өдрийн хуулиар нэмэлт оруулсан/

/Энэ хэсэгт 2016 оны 01 дүгээр сарын 22-ны өдрийн хуулиар “Эрүүл мэндийн даатгалын сангийн төсөв,” гэсний дараа “Ирээдүйн тэтгэврийн нөөц сангийн төсөв,” гэж нэмэлт оруулсан бөгөөд 2019 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө/

/Энэ хэсэгт 2016 оны 02 дугаар сарын 05-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/

/Энэ хуульд 2016 оны 11 дүгээр сарын 10-ны өдрийн хуулиар 71.5 дахь хэсгийг нэмж, энэ хэсгийн “төсөв, Эрүүл мэндийн даатгалын сангийн төсөв, Ирээдүйн тэтгэврийн нөөц сангийн” гэснийг 2018 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөхөөр заасан/

8.6.1.төсвийн төвлөрүүлэн захирагч болон төсвийн төвлөрүүлэн захирагчид харьяалагддаггүй төсвийн шууд захирагч төсвийн хуваарийн саналаа жил бүрийн 12 дугаар сарын 15-ны дотор харьяалагдах төсвийн ерөнхийлөн захирагчид хүргүүлэх;

8.6.2.төсвийн ерөнхийлөн захирагч төсвийн хуваарийн саналаа жил бүрийн 12 дугаар сарын 25-ны дотор санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлэх;

8.6.3.санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн улсын төсөв, Нийгмийн даатгалын сангийн төсөв, Эрүүл мэндийн даатгалын сангийн төсөв, *Ирээдүйн тэтгэврийн нөөц сангийн* жилийн төсвийн хуваарийг жил бүрийн 01 дүгээр сарын 01-ний дотор батлах.

/Энэ заалтад 2015 оны 01 дүгээр сарын 29-ний өдрийн хуулиар нэмэлт оруулсан/

/Энэ заалтад 2016 оны 01 дүгээр сарын 22-ны өдрийн хуулиар “Эрүүл мэндийн даатгалын сангийн төсөв,” гэсний дараа “Ирээдүйн тэтгэврийн нөөц сангийн төсөв,” гэж нэмэлт оруулсан бөгөөд 2019 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө/

/Энэ заалтад 2016 оны 02 дугаар сарын 05-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/

/Энэ хуульд 2016 оны 11 дүгээр сарын 10-ны өдрийн хуулиар 71.5 дахь хэсгийг нэмж, энэ заалтын “төсөв, Эрүүл мэндийн даатгалын сангийн төсөв, Ирээдүйн тэтгэврийн нөөц сангийн” гэснийг 2018 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөхөөр заасан/

8.7.Аймаг, нийслэлийн жилийн төсвийн сар, улирлын хуваарийг дараах цаглабрын дагуу боловсруулж, батална:

8.7.1.аймаг, нийслэлийн Засаг дарга тухайн шатны жилийн төсвийн сар, улирлын хуваарийг жил бүрийн 12 дугаар сарын 25-ны дотор батлах;

8.7.2.аймаг, нийслэлийн Засаг дарга тухайн шатны жилийн төсвийн сар, улирлын батлагдсан хуваарийг жил бүрийн 12 дугаар сарын 31-ний дотор санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлэх.

8.8.Улсын төсөв, Нийгмийн даатгалын сангийн төсөв, Эрүүл мэндийн даатгалын сангийн төсөв, *Ирээдүйн тэтгэврийн нөөц сангийн төсөв*, аймаг, нийслэлийн төсвийн сарын гүйцэтгэлийн мэдээг дараах цаглабрын дагуу боловсруулж, батална.

/Энэ хэсэгт 2015 оны 01 дүгээр сарын 29-ний өдрийн хуулиар нэмэлт оруулсан/

/Энэ хэсэгт 2016 оны 01 дүгээр сарын 22-ны өдрийн хуулиар “Эрүүл мэндийн даатгалын сангийн төсөв,” гэсний дараа “Ирээдүйн тэтгэврийн нөөц сангийн төсөв,” гэж нэмэлт оруулсан бөгөөд 2019 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө/

/Энэ хэсэгт 2016 оны 02 дугаар сарын 05-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/

/Энэ хуульд 2016 оны 11 дүгээр сарын 10-ны өдрийн хуулиар 71.5 дахь хэсгийг нэмж, энэ хэсгийн “Эрүүл мэндийн даатгалын сангийн төсөв, Ирээдүйн тэтгэврийн нөөц сангийн төсөв,” гэснийг 2018 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөхөөр заасан/

8.8.1.төсвийн шууд захирагч төсвийн сарын гүйцэтгэлийн мэдээг сар бүрийн 02-ны дотор харьяалагдах төсвийн төвлөрүүлэн захирагчид хүргүүлэх;

8.8.2.төсвийн төвлөрүүлэн захирагч тусгай сан, төсвийн сарын гүйцэтгэлийн мэдээг сар бүрийн 04-ний дотор харьяалагдах төсвийн ерөнхийлөн захирагчид хүргүүлэх;

8.8.3.төсвийн ерөнхийлөн захирагч төсвийн сарын гүйцэтгэлийн мэдээг сар бүрийн 06-ны дотор санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлэх;

8.8.4.санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нэгдсэн төсвийн сарын гүйцэтгэлийн мэдээг сар бүрийн 08-ны дотор нэгтгэн гаргах;

8.8.5.санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нэгдсэн төсвийн сарын гүйцэтгэлийн мэдээг сар бүрийн 15-ны дотор нийтэд хэвлэн мэдээлэх.

/Энэ заалтыг 2014 оны 07 дугаар сарын 01-ний өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон/

8.9.Улсын төсөв, Нийгмийн даатгалын сангийн төсөв, Эрүүл мэндийн даатгалын сангийн төсөв, Ирээдүйн тэтгэврийн нөөц сангийн төсөв, орон нутгийн төсвийн улирал, хагас, бүтэн жилийн төсвийн гүйцэтгэл, төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайланг дараах цаглабрын дагуу боловсруулна:

/Энэ хэсэгт 2015 оны 01 дүгээр сарын 29-ний өдрийн хуулиар нэмэлт оруулсан/

/Энэ хэсэгт 2016 оны 01 дүгээр сарын 22-ны өдрийн хуулиар “Эрүүл мэндийн даатгалын сангийн төсөв,” гэсний дараа “Ирээдүйн тэтгэврийн нөөц сангийн төсөв,” гэж нэмсэн бөгөөд 2019 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө/

/Энэ хэсэгт 2016 оны 02 дугаар сарын 05-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/

/Энэ хуульд 2016 оны 11 дүгээр сарын 10-ны өдрийн хуулиар 71.5 дахь хэсгийг нэмж, энэ хэсгийн “Эрүүл мэндийн даатгалын сангийн төсөв, Ирээдүйн тэтгэврийн нөөц сангийн төсөв,” гэснийг 2018 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөхөөр заасан/

8.9.1.төсвийн шууд захирагч улирлын төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланг дараа улирлын эхний сарын 15-ны дотор гаргаж харьяалагдах дээд шатны төсвийн захирагчид, жилийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланг дараа оны 01 дүгээр сарын 25-ны дотор төрийн аудитын байгууллагад хүргүүлж, аудит хийсэн санхүүгийн тайланг 02 дугаар сарын 25-ны дотор харьяалагдах дээд шатны төсвийн захирагчид хүргүүлэх;

8.9.2.төсвийн төвлөрүүлэн захирагч хагас жилийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн нэгтгэсэн тайланг жил бүрийн 7 дугаар сарын 25-ны дотор гаргаж төсвийн ерөнхийлөн захирагчид, жилийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн нэгтгэсэн тайланг дараа оны 3 дугаар сарын

05-ны өдрийн дотор төрийн аудитын байгууллагад хүргүүлж, аудит хийсэн тайланг жил бүрийн 3 дугаар сарын 25-ны өдрийн дотор төсвийн ерөнхийлөн захирагчид хүргүүлэх;

8.9.3.сум, дүүргийн төрийн сан нь тухайн шатны төсвийн хагас жилийн гүйцэтгэл, санхүүгийн нэгтгэсэн тайланг жил бүрийн 7 дугаар сарын 25-ны дотор гаргаж дээд шатны төсвийн ерөнхийлөн захирагчид, жилийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн нэгтгэсэн тайланг дараа оны 3 дугаар сарын 05-ны дотор төрийн аудитын байгууллагад хүргүүлж, аудит хийсэн тайланг жил бүрийн 3 дугаар сарын 25-ны дотор дээд шатны төсвийн ерөнхийлөн захирагчид хүргүүлэх ба аудит хийсэн тайланг нийтэд мэдээлэх;

/Энэ заалтын “ба аудит хийсэн тайланг нийтэд мэдээлэх” гэснийг 2014 оны 07 дугаар сарын 01-ний өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон/

8.9.4.аймаг, нийслэлийн төсвийн ерөнхийлөн захирагч жилийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланг жил бүрийн 4 дүгээр сарын 01-ний дотор төрийн аудитын байгууллагад хүргүүлж, аудит хийсэн тайланг 4 дүгээр сарын 20-ны дотор санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлэх ба аудит хийсэн тайланг нийтэд мэдээлэх;

/Энэ заалтын “ба аудит хийсэн тайланг нийтэд мэдээлэх” гэснийг 2014 оны 07 дугаар сарын 01-ний өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон/

8.9.5.төсвийн ерөнхийлөн захирагч хагас жилийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн нэгтгэсэн тайланг жил бүрийн 8 дугаар сарын 15-ны дотор санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад, жилийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн нэгтгэсэн тайланг дараа оны 4 дүгээр сарын 05-ны дотор төрийн аудитын төв байгууллагад хүргүүлж, аудит хийсэн тайланг жил бүрийн 4 дүгээр сарын 25-ны дотор санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлэх;

8.9.6.санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төсвийн ерөнхийлөн захирагч хагас жилийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн нэгтгэсэн тайланг жил бүрийн 8 дугаар сарын 25-ны дотор гаргах;

8.9.7.санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төсвийн ерөнхийлөн захирагч жилийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн нэгтгэсэн тайланг дараа оны 4 дүгээр сарын 15-ны дотор гаргаж, төрийн аудитын төв байгууллагад хүргүүлэх ба төрийн аудитын төв байгууллага 5 дугаар сарын 05-ны дотор аудит хийж, санал дүгнэлт гаргах;

8.9.8.Төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээд жилийн эцсийн санхүүгийн тайлангаа дараа жилийн 02 дугаар сарын 15-ны дотор төрийн аудитын байгууллагад хүргүүлж, аудит хийсэн тайланг 3 дугаар сарын 15-ны дотор харьяалагдах төсвийн ерөнхийлөн захирагч болон санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлэх.

/Энэ заалтад 2015 оны 11 дүгээр сарын 10-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/

8.10.Нэгдсэн төсвийн гүйцэтгэл, Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайланг дараах цаглабын дагуу боловсруулна:

8.10.1.санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нэгдсэн төсвийн гүйцэтгэл, Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайланг жил бүрийн 5 дугаар сарын 10-ны дотор төрийн аудитын төв байгууллагад хүргүүлэх;

8.10.2.төрийн аудитын төв байгууллага нэгдсэн төсвийн гүйцэтгэл, Засгийн газрын өрийн тайлан, Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайланд нэг сарын дотор аудит хийж, Засгийн газар, Улсын Их Хуралд хүргүүлэх;

/Энэ заалтад 2015 оны 02 дугаар сарын 18-ны өдрийн хуулиар нэмэлт оруулсан/

8.10.3.Засгийн газар энэ хуулийн 8.10.2-т заасан аудитын дүгнэлт гарснаас хойш ажлын долоон өдрийн дотор нэгдсэн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн нэгтгэсэн тайланг аудитын дүгнэлтийн хамт Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх;

8.10.4.Улсын Их Хурал нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайланг хаврын чуулганаар хэлэлцэн, улсын төсвийн гүйцэтгэлийг батлах;

~~8.10.5.санхүү, төсвийн асуудал эрхэлэн төрийн захиргааны төв байгууллага төсвийн гүйцэтгэл болон аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайланг нийтэд хэвлэн мэдээлэх.~~

/Энэ заалтыг 2014 оны 07 дугаар сарын 01-ний өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон/

ГУРАВДУГААР БҮЛЭГ ТӨСВИЙН ТАЛААРХ ТӨРИЙН БАЙГУУЛЛАГА,

АЛБАН ТУШААЛТНЫ БҮРЭН ЭРХ

9 дүгээр зүйл.Улсын Их Хурлын бүрэн эрх

9.1.Улсын Их Хурал төсвийн талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

9.1.1.Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 9.1.1-д заасны дагуу дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлийг батлах;

9.1.2.дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэлд нийцүүлж улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл, улсын төсөв, Нийгмийн даатгалын сангийн төсөв, Эрүүл мэндийн даатгалын сангийн төсөв, *Ирээдүйн тэтгэврийн нөөц сангийн төсөв*, тэдгээрийн тодотголыг хэлэлцэж, батлах;

/Энэ заалтад 2015 оны 01 дүгээр сарын 29-ний өдрийн хуулиар нэмэлт оруулсан/

/Энэ заалтад 2016 оны 01 дүгээр сарын 22-ны өдрийн хуулиар “Эрүүл мэндийн даатгалын сангийн төсөв,” гэсний дараа “Ирээдүйн тэтгэврийн нөөц сангийн төсөв,” гэж нэмэлт оруулсан бөгөөд 2019 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө/

/Энэ заалтад 2016 оны 02 дугаар сарын 05-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/

/Энэ хуульд 2016 оны 11 дүгээр сарын 10-ны өдрийн хуулиар 71.5 дахь хэсгийг нэмж, энэ заалтын “Эрүүл мэндийн даатгалын сангийн төсөв, Ирээдүйн тэтгэврийн нөөц сангийн төсөв,” гэснийг 2018 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөхөөр заасан/

9.1.3.нэгдсэн төсвийн гүйцэтгэлийг хэлэлцэн, улсын төсвийн гүйцэтгэлийг батлах;

9.1.4.төсвийн хөрөнгийн зарцуулалт, үр дүнд хяналт тавих;

~~9.1.5.Засгийн газрын үнэт цаас гаргах зөвшөөрөл олгох.~~

/Энэ заалтыг 2015 оны 02 дугаар сарын 18-ны өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон/

10 дугаар зүйл.Засгийн газрын бүрэн эрх

10.1.Засгийн газар төсвийн талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

10.1.1.дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлийн төслийг Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх;

10.1.2.Улсын Их Хурлаас баталсан дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэлд багтаан төсвийн ерөнхийлөн захирагч бүрээр жилийн төсвийн хязгаар батлах;

10.1.3.Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэлд нийцсэн улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл, жилийн төсвийн төсөл, төсвийн тодотголын төслийг Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх;

10.1.4.төсвийн ерөнхийлөн захирагч бүрийн худалдан авах бараа, ажил, үйлчилгээний төлөвлөгөөг батлах;

10.1.5.улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөр батлах;

10.1.6.төсвийн төсөл нь Өрийн удирдлагын тухай хууль болон энэ хуулийн 27 дугаар зүйлд заасан шаардлагыг хангаж байгаа эсэхийг хянах;

/Энэ заалтад 2015 оны 02 дугаар сарын 18-ны өдрийн хуулиар нэмэлт оруулсан/

10.1.7.төсвийн хэрэгжилтэд хяналт тавих;

10.1.8.нэгдсэн төсвийн гүйцэтгэлийг Улсын Их Хуралд тайлагнах;

~~10.1.9.Улсын Их Хурлын зөвшөөрөноор Засгийн газрын үнэт цаас гаргах;~~

/Энэ заалтыг 2015 оны 02 дугаар сарын 18-ны өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон/

10.1.10.Улсын Их Хурлын шийдвэрээр байгуулахаар хуульд зааснаас бусад тохиолдолд төсвийн байгууллагыг шинээр байгуулах, өөрчлөн байгуулах, татан буулгах;

10.1.11.төсвийн хөрөнгийг үр ашигтай захиран зарцуулж, улсын төсвийн байгууллагаас нийлүүлэх арга хэмжээний чанарын шаардлагыг хангуулах;

~~10.1.12.Засгийн газрын эзэл болон улсын өрийн удирдлага, түүний стратегийг төдөрхөйлж, хэрэгжүүлэх;~~

/Энэ заалтыг 2015 оны 02 дугаар сарын 18-ны өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон/

10.1.13.улсын хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төслийг боловсруулах, хэрэгжүүлэх, санхүүжүүлэх, хяналт тавих журмыг батлах;

10.1.14.тухайн жилийн төсвийн хуулиар батлагдсан хөрөнгө оруулалтын арга хэмжээний жагсаалтад шинэ арга хэмжээ нэмж тусгахгүйгээр, тэдгээрийн гүйцэтгэлийн явц байдалтай уялдуулан, төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн багцын дүнд багтаан хөрөнгийн зохицуулалт хийх.

10.1.15.улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрт тусгах төсөл, арга хэмжээний саналыг хүлээн авч үнэлэх, сонгон шалгаруулах журмыг батлах

/Энэ заалтыг 2015 оны 02 дугаар сарын 18-ны өдрийн хуулиар нэмсэн/

10.2.Төсөв, санхүү, эдийн засгийн бодлогын төлөвлөлтийг сайжруулах, түүний тайлагналт, ил тод байдлыг хангах, олон нийтийн хяналтыг хэрэгжүүлэх зорилготой татвар төлөгчдийн төлөөлөл бүхий төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоод болон салбарын эрдэмтдээс бүрдсэн 9 гишүүний бүрэлдэхүүнтэй орон тооны бус төсөв, санхүү, эдийн засгийн үндэсний зөвлөлийг Ерөнхий сайдын дэргэд байгуулж ажиллуулна.

10.3.Энэ хуулийн 10.2-т заасан үндэсний зөвлөл нь төсвийн төсөл болон улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийн төслийг хэлэлцэж, санал, дүгнэлтээ Засгийн газарт хүргүүлнэ.

10.4.Энэ хуулийн 10.2-т заасан үндэсний зөвлөлийн дүрмийг Засгийн газар батална.

11 дүгээр зүйл.Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн

газрын гишүүний бүрэн эрх

11.1.Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн төсвийн удирдлагын талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

11.1.1.дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэл, төсвийн төсөл, төсвийн тодотголын төсөл болон жилийн төсвийн хязгаарыг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэх;

11.1.2.санхүү, төсвийн удирдлагын асуудлаар өөрийн эрх хэмжээний хүрээнд заавар, журам батлан гаргах;

11.1.3.төсвийн зарлагын норм, норматив болон төсвийн байгууллагын бүтцийн болон орон тооны жишиг, хязгаарыг тогтоох;

11.1.4.төсөв, санхүүгийн удирдлага, төлөвлөлт, зохицуулалтыг боловсронгуй болгох санал боловсруулан, эрх бүхий байгууллагаар шийдвэрлүүлэх;

11.1.5.төсвийн дэлгэрэнгүй ангиллыг батлах;

~~11.1.6.Засгийн газраас эрх олгосноор зохих хууль тогтоомжид заасны дагуу Засгийн газрын нэрийн өмнөөс өр үүсгэх, өрийн баталгаа гаргах, өр үүсгэх зөвшөөрлийг энэ хуулийн 62.6.2-т заасны дагуу олгох;~~

/Энэ заалтыг 2015 оны 02 дугаар сарын 18-ны өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон/

11.1.7.төсөв, татварын харилцааг зохицуулах хуулийн төсөл нь төсөв, санхүүгийн бодлогын баримт бичигтэй нийцэж байгаа эсэх талаар дүгнэлт гаргах;

11.1.8.зээл, тусламжийн санхүүжилт, зээл, тусламжийн нэгдсэн бодлого, зохицуулалтын удирдлагыг хэрэгжүүлэх, үйлчилгээ, бүртгэлийн үйл ажиллагаа эрхлэх;

/Энэ заалтыг 2012 оны 10 дугаар сарын 25-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан/

/Энэ хэсэгт 2014 оны 10 дугаар сарын 16-ны өдрийн хуулиар нэмэлт оруулсан/

11.1.9.өрийн удирдлага, түүний стратегийг боловсруулж, хэрэгжүүлэх;

/Энэ заалтыг 2015 оны 02 дугаар сарын 18-ны өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон/

11.1.10.төрийн сангийн үйл ажиллагааг удирдлагаар хангах;

11.1.11.төсөв, санхүүгийн дотоод аудит, хяналт шалгалтыг зохион байгуулж, удирдлагаар хангах;

11.1.12.төсвийн гүйцэтгэлийн үйл ажиллагааг нэгдсэн удирдлагаар хангах;

11.1.13.энэ хуулийн 8.6.3-т заасан төсвийн хуваарийг батлан мөрдүүлэх, түүнд өөрчлөлт оруулах;

~~11.1.14.төсвийн алдагдлыг санхүүжүүлэх зорилгоор гаргасан Засгийн газрын үнэт цаасны нөхцөлийг тогтоох, тухайн жилийн төсвийн болон төсвийн нэмэлт, өөрчлөлттэй нь хамт баглуулах;~~

/Энэ заалтыг 2012 оны 10 дугаар сарын 25-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан/

/Энэ заалтыг 2015 оны 02 дугаар сарын 18-ны өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон/

11.1.15.хөрөнгө оруулалтын зорилгоор гаргасан Засгийн газрын үнэт цаасны нөхцөл, төлбөрийн хуваарийг тогтоох;

/Энэ заалтыг 2014 оны 10 дугаар сарын 16-ны өдрийн хуулиар нэмсэн/

11.1.16.төсвийн ерөнхийлөн захирагч, төсвийн байгууллага, бусад этгээдэд улсын төсвөөс санхүүжүүлэх хөтөлбөрийн санхүүжилтийг батлагдсан төсвийн дагуу олгох;

/Энэ хэсгийн дугаарт 2014 оны 10 дугаар сарын 16-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/

11.1.17.төрийн өмчийн эд хөрөнгө ашигласны төлбөрийн хэмжээг тогтоох;

[/Энэ хэсгийн дугаарт 2014 оны 10 дугаар сарын 16-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/](#)

11.1.18.орон нутгийн төсвийн төсөл боловсруулах журам батлах;

[/Энэ хэсгийн дугаарт 2014 оны 10 дугаар сарын 16-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/](#)

11.1.19.Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журмыг тогтоох;

[/Энэ хэсгийн дугаарт 2014 оны 10 дугаар сарын 16-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/](#)

11.1.20.энэ хуульд заасан бүрэн эрхийг хэрэгжүүлэхэд шаардлагатай мэдээллийг төсвийн байгууллага, бусад этгээдээс гаргуулан авах.

[/Энэ хэсгийн дугаарт 2014 оны 10 дугаар сарын 16-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/](#)

11.1.21.Засгийн газраас тусгайлан эрх олгосноос бусад тохиолдолд гадаадын тусламж авах гэрээ, хэлэлцээрт Монгол Улсын Засгийн газрыг төлөөлж гарын үсэг зурах.

[/Энэ заалтыг 2015 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн хуулиар нэмсэн/](#)

11.1.22.Орон нутгийн хөгжлийн сангийн төлөвлөлт, санхүүжилт, зарцуулалт, бүртгэлтэй холбоотой журам батлах.

[/Энэ заалтыг 2016 оны 09 дүгээр сарын 09-ний өдрийн хуулиар нэмсэн/](#)

11⁺ дүгээр зүйл.Эдийн засгийн хөгжлийн асуудал эрхэлэн

—————Засгийн газрын гишүүний бүрэн эрх

~~11⁺.1.Эдийн засгийн хөгжлийн асуудал эрхэлэн Засгийн газрын гишүүн төсвийн удирдлагын талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:~~

~~—————11⁺.1.1.хоронго оруулалтын зорилгоор гаргасан Засгийн газрын үнэт цаасны нөхцөлийг тогтоох, уг үнэт цаасны төлбөрийн хуваарийг төсвийн асуудал эрхэлэн Засгийн газрын гишүүнтэй зөвшилцөн шийдвэрлэх;~~

~~—————11⁺.1.2.ээл, тусламжийн нэгдсэн бодлого, зохицуулалтын удирдлагын хэрэгжүүлэх.~~

[/Энэ зүйлийг 2012 оны 10 дугаар сарын 25-ны өдрийн хуулиар нэмсэн/](#)

[/Энэ зүйлийг 2014 оны 10 дугаар сарын 16-ны өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон/](#)

12 дугаар зүйл.Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн

захиргааны төв байгууллагын бүрэн эрх

12.1. Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага төсвийн удирдлагын талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

12.1.1. дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлийн төсөл, түүнд тусгах эдийн засаг, төсвийн таамаглалыг боловсруулах;

12.1.2. улсын төсөв, Нийгмийн даатгалын сангийн төсөв, Эрүүл мэндийн даатгалын сангийн төсөв, *Ирээдүйн тэтгэврийн нөөц сангийн төсвийн төсөл*, тэдгээрийн тодотголын төслийг боловсруулах;

/Энэ заалтад 2015 оны 01 дүгээр сарын 29-ний өдрийн хуулиар нэмэлт оруулсан/

/Энэ заалтад 2016 оны 01 дүгээр сарын 22-ны өдрийн хуулиар “Эрүүл мэндийн даатгалын сангийн төсөв,” гэсний дараа “Ирээдүйн тэтгэврийн нөөц сангийн төсөв,” гэж нэмэлт оруулсан бөгөөд 2019 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө/

/Энэ заалтад 2016 оны 02 дугаар сарын 05-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/

/Энэ хуульд 2016 оны 11 дүгээр сарын 10-ны өдрийн хуулиар 71.5 дахь хэсгийг нэмж, энэ заалтын “төсөв, Эрүүл мэндийн даатгалын сангийн төсөв, Ирээдүйн тэтгэврийн нөөц сангийн” гэснийг 2018 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөхөөр заасан/

12.1.3. Улсын Их Хурлаас баталсан дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэлд багтаан төсвийн ерөнхийлөн захирагч бүрээр жилийн төсвийн хязгаар боловсруулах;

12.1.4. жилийн төсвийн төсөл боловсруулах удирдамжийг төсвийн цаглабрыг баримтлан бэлтгэж, төсвийн ерөнхийлөн захирагчид хүргүүлэх;

12.1.5. төсвийн тодотгол хийх тухай Засгийн газрын саналыг боловсруулах;

12.1.6. төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн гүйцэтгэлд хяналт тавих;

12.1.7. нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан гаргах;

12.1.8. Засгийн газрын санхүүгийн нэгдсэн тайланг олон улсын нягтлан бодох бүртгэлийн стандартын дагуу гаргах;

12.1.9. олон улсын нягтлан бодох бүртгэлийн стандартын дагуу Монгол Улсын нягтлан бодох бүртгэлийн стандартыг боловсруулж, хэрэгжилтийг хангах;

12.1.10. төсвийн алдагдлыг санхүүжүүлэх зорилгоор гаргасан Засгийн газрын үнэт цаасны нохцолыг өөрчлөх, зээл төлөх санал боловсруулах;

/Энэ заалтыг 2012 оны 10 дугаар сарын 25-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан/

/Энэ заалтыг 2015 оны 02 дугаар сарын 18-ны өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон/

12.1.11.банкинд данс нээх зөвшөөрлийг төсвийн байгууллагад олгох;

~~12.1.12.төлөгдоогүй улсын өрийн үлдэгдэл, дунд хугацааны өрийн үйлчилгээний таамаглалыг хагас жил тутам гаргаж нийтэд хэвлэн нийтлэх;~~

/Энэ заалтыг 2015 оны 02 дугаар сарын 18-ны өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон/

12.1.13.төв төрийн сангийн чиг үүргийг хэрэгжүүлж, төсвийн хөрөнгө, нөөцийн санг байршуулах;

12.1.14.эдийн засаг, төсөв, санхүүгийн асуудал эрхэлсэн албадыг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах;

12.1.15.төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяа төсвийн байгууллагын хэрэгжүүлэх арга хэмжээний гүйцэтгэл болон улсын төсвийн хөрөнгөөр орон нутгийн байгууллагаас худалдан авах арга хэмжээний гүйцэтгэлийн явцад хяналт тавих;

12.1.16.төсвийн дотоод аудит, хяналт шалгалтын үйл ажиллагааг хэрэгжүүлэх;

12.1.17.төсвийн орлогын бүрдэлтэй уялдуулан мөнгөн хөрөнгийн зохицуулалтын хүрээнд санхүүжилтийн болон зарцуулалтын эрхийг бууруулах;

12.1.18.эдийн засаг, санхүү, төсвийн бодлогын шинжилгээ, судалгааны ажлыг эрхлэх чиг үүрэг бүхий бие даасан төвийг байгуулж ажиллуулах асуудлыг эрх бүхий байгууллагад оруулж шийдвэрлүүлэх;

12.1.19.төсвийн төлөвлөлт, төсвийн гүйцэтгэл, нягтлан бодох бүртгэл, тайлагналтын мэдээллийн нэгдсэн тогтолцоог удирдах;

12.1.20.энэ хуульд заасан бүрэн эрхийг хэрэгжүүлэхэд шаардлагатай мэдээллийг төсвийн байгууллага, бусад этгээдээс гаргуулж авах.

12.1.21.гадаадын тусламжаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг татвар, хураамжаас чөлөөлөх, хөнгөлөлт үзүүлэх санал боловсруулах.

/Энэ заалтыг 2015 оны 02 дугаар сарын 18-ны өдрийн хуулиар нэмсэн/

12.2.Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага төсвийн төлөвлөлтийн талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

12.2.1.улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийн төсөл боловсруулж, Засгийн газарт хүргүүлэх;

12.2.2.улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрийн төсөл боловсруулах;

12.2.3.хөрөнгө оруулалтын зорилгоор гаргасан Засгийн газрын үнэт цаасны болон зээлийн нөхцөлийг өөрчлөх санал боловсруулах.

[/Энэ хэсгийг 2014 оны 10 дугаар сарын 16-ны өдрийн хуулиар нэмсэн/](#)

12¹ дүгээр зүйл. Үндэсний хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн

захиргааны байгууллагын бүрэн эрх

12¹.1. Үндэсний хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

12¹.1.1. улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийн төслийн талаар санал, дүгнэлт боловсруулж, санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлэх;

12¹.1.2. улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрийн төсөл боловсруулах.

[/Энэ зүйлийг 2016 оны 07 дугаар сарын 21-ний өдрийн хуулиар нэмсэн/](#)

13 дугаар зүйл. Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн асуудал эрхэлсэн

төрийн захиргааны төв байгууллагын бүрэн эрх

[/Энэ зүйлийн гарчигт 2012 оны 08 дугаар сарын 17-ны өдрийн хуулиар нэмэлт оруулсан/](#)

~~13.1. Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага төсвийн төлөвлөлтийн талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:~~

[/Энэ хэсэгт 2012 оны 08 дугаар сарын 17-ны өдрийн хуулиар нэмэлт оруулсан/](#)

~~13.1.1. улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийн төсөл боловсруулж, Засгийн газарт хүргүүлэх;~~

~~13.1.2. улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрийн төсөл боловсруулах.~~

~~13.1.3. хөрөнгө оруулалтын зорилгоор гаргасан Засгийн газрын үнэт цаасны болон зээлийн нөхцөлийг өөрчлөх санал боловсруулах, уг үнэт цаасны төлбөрийн хуваарийг төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнтэй зөвшилцөн шийдвэрлэх.~~

[/Энэ заалтыг 2012 оны 10 дугаар сарын 25-ны өдрийн хуулиар нэмсэн/](#)

[/Энэ зүйлийг 2014 оны 10 дугаар сарын 16-ны өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон/](#)

14 дүгээр зүйл. Төсвийн ерөнхийлөн захирагч, түүний бүрэн эрх

14.1. Дараах албан тушаалтан төсвийн ерөнхийлөн захирагч байна:

14.1.1.Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга Монгол Улсын Ерөнхийлөгчийн төсвийн;

14.1.2.Улсын Их Хурлын дарга Улсын Их Хурлын төсвийн;

14.1.3.Улсын Их Хуралд ажлаа шууд хариуцан тайлагнадаг байгууллагын дарга тухайн байгууллагын төсвийн;

14.1.4.Ерөнхий сайд түүнд хууль тогтоомжоор харьяалуулсан байгууллагын төсвийн;

~~14.1.5.~~ [/Энэ заалтыг 2012 оны 03 дугаар сарын 07-ны өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон/](#)

14.1.6.Шадар сайд түүнд хууль тогтоомжоор харьяалуулсан байгууллагын төсвийн;

14.1.7.Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Ерөнхий сайдын төсөв, Шадар сайдын ажлын албаны төсөв, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын төсөв болон түүнд хууль тогтоомжоор харьяалуулсан бусад байгууллагын төсвийн;

[/Энэ заалтад 2012 оны 03 дугаар сарын 07-ны өдрийн хуулиар өөрчлөлт орсон/](#)

14.1.8.Засгийн газрын гишүүн холбогдох төрийн захиргааны төв байгууллагын болон түүнд хууль тогтоомжоор харьяалуулсан бусад байгууллагын төсвийн;

14.1.9.Үндсэн хуулийн цэцийн дарга Үндсэн хуулийн цэцийн төсвийн;

14.1.10.Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгч тухайн шүүхийн төсвийн;

14.1.11.Шүүхийн ерөнхий зөвлөлийн дарга нь Шүүхийн ерөнхий зөвлөлийн ажлын алба, аймаг, нийслэл, сум, сум дундын, дүүргийн болон дагнасан шүүхийн төсвийн;

14.1.12.Улсын ерөнхий прокурор прокурорын байгууллагын төсвийн;

14.1.13.Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн нарийн бичгийн дарга тус зөвлөлийн;

14.1.14.Авлигатай тэмцэх газрын дарга тухайн байгууллагын төсвийн;

14.1.15.аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төсвийн;

14.1.16.аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд ажлаа хариуцан тайлагнадаг байгууллагын дарга тухайн байгууллагын төсвийн;

14.1.17.аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга тухайн шатны орон нутгийн энэ хуулийн 14.1.15, 14.1.16-д зааснаас бусад төсвийн.

14.2.Төсвийн ерөнхийлөн захирагч төсвийн удирдлагын талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

14.2.1.жилийн төсвийн хязгаарт багтаан төсвийн төслийг боловсруулах;

14.2.2.өөрийн эрхлэх асуудлын хүрээнд хэрэгжүүлэх хөтөлбөрийн санхүүжилтийг бодитой тодорхойлох;

14.2.3.өөрийн эрхлэх асуудлын хүрээнд төсвийг үр ашигтай удирдах, гүйцэтгэлийг хангах;

14.2.4.өөрийн эрхлэх асуудлын хүрээнд тухайн төсөв хэрэгжих жил болон дунд хугацаанд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын арга хэмжээг жилийн төсвийн хязгаарт багтаан санхүүжилтийн бүх төрлийн эх үүсвэртэй нь уялдуулан боловсруулах;

14.2.5.өөрийн эрхлэх асуудлын хүрээний агентлаг, төсвийн байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангах;

14.2.6.хөтөлбөрийн үр дүн, төсвийн гүйцэтгэлийн тайланг гарган, Засгийн газрын хуралдаанд танилцуулах;

14.2.7.өөрийн эрхлэх асуудлын хүрээний агентлаг, төсвийн бусад байгууллага, Засгийн газрын тусгай сан, гадаадын зээл, тусламжаар хэрэгжсэн төслийн тайлан бүхий хагас жилийн болон жилийн эцсийн санхүүгийн тайланг нэгтгэн, санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлэх;

14.2.8.хөрөнгө оруулалтын арга хэмжээний хэрэгжилтийг төсвийн гүйцэтгэлийн явцад хянаж, санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад улирал бүр тайлагнах;

14.2.9.хөрөнгө оруулалтын арга хэмжээ хэрэгжиж дууссаны дараа хөрөнгө оруулалтын үр дүнгийн талаарх тайланг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлэх;

14.2.10.өөрийн эрхлэх асуудлын хүрээнд дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх.

14.2.11.төсвийн зарцуулалтын үр ашгийг сайжруулах, үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх, чиг үүргийн давхардал, эсхүл хийдлийг арилгах, бүтээмжийг дээшлүүлэх, төрөөс иргэдэд хүргэх үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах зорилгоор өөрийн эрхлэх асуудлын хүрээний агентлаг, төсвийн бусад байгууллагад 3-5 жил тутамд нэг удаа чиг үүрэг, үр дүнгийн иж бүрэн шинжилгээ хийж, үр дүнг Засгийн газарт танилцуулах;

/Энэ заалтыг 2016 оны 11 дүгээр сарын 10-ны өдрийн хуулиар нэмсэн/

14.2.12.эрхлэх асуудлын хүрээнд хамаарах төсөвт байгууллагын үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх, чиг үүргийн давхардлыг арилгах, ажлын ачааллыг нягтруулах, бүтээмжийг дээшлүүлэх зорилгоор чиг үүрэг, зохион байгуулалтын бүтцийг батлагдсан орон тооны хязгаар, төсөвт багтаан шинэчлэн тогтоох.

/Энэ заалтыг 2016 оны 11 дүгээр сарын 10-ны өдрийн хуулиар нэмсэн/

14.3.Төсвийн ерөнхийлөн захирагч өөрийн эрхлэх асуудлын төсвийн орлого, зарлагын зүй зохистой, үр ашигтай байдал, үр дүнгийн гүйцэтгэлийг хангаж, өөрт хамаарах төсвийн гүйцэтгэлийн биелэлтийг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засгийн газар, Улсын Их Хурлын өмнө бүрэн хариуцна.

14.4.Төсвийн ерөнхийлөн захирагч нь төсөв хуваарилах, зарцуулахтай холбогдсон бүрэн эрхээ төсвийн төвлөрүүлэн захирагч, эсхүл харьяалах төсвийн шууд захирагчид шилжүүлж болох бөгөөд ийнхүү шилжүүлсэн нь түүнийг хариуцлагаас чөлөөлөх үндэслэл болохгүй.

14.5.Төсвийн ерөнхийлөн захирагч нь түүнд хамаарах төсвийн асуудлыг хариуцан гүйцэтгэх санхүүгийн нэгж, нягтлан бодогч, ажилтантай байна.

14.6.Энэ хуулийн 14.2.11-т заасан чиг үүрэг, үр дүнгийн иж бүрэн шинжилгээ хийх, чиг үүргийг дахин хуваарилах аргачлалыг Засгийн газар батална.

/Энэ хэсгийг 2016 оны 11 дүгээр сарын 10-ны өдрийн хуулиар нэмсэн/

15 дугаар зүйл.Төсвийн төвлөрүүлэн захирагч, түүний бүрэн эрх

15.1.Төсвийн ерөнхийлөн захирагч нь өөрийн удирдлага дор төсвийн шууд захирагчийг харьяалах эрх бүхий төсвийн төвлөрүүлэн захирагчтай байж болно.

15.2.Энэ хуулийн 39.1-д заасан гэрээгээр тусгай зориулалтын шилжүүлэг хүлээн авсан төсвийн төвлөрүүлэн захирагч нь аймаг, нийслэлийн Засаг дарга байна.

15.3.Төсвийн төвлөрүүлэн захирагч, түүнд харьяалагдах төсвийн шууд захирагчийг Засгийн газар тогтооно.

15.4.Төсвийн төвлөрүүлэн захирагч нь түүнд харьяалагдах төсвийн талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

15.4.1.төсвийн ерөнхийлөн захирагчийн энэ хуулийн 14.2.2, 14.2.3, 14.2.5, 14.2.8–д заасан болон төсвийн шууд захирагчийн энэ хуулийн 16.5-д заасан бүрэн эрхийг хэрэгжүүлэх;

15.4.2.энэ хуулийн 14.2.8-д заасан тайланг нэгтгэн харьяа төсвийн ерөнхийлөн захирагчид хүргүүлэх.

16 дугаар зүйл.Төсвийн шууд захирагч, түүний бүрэн эрх

16.1.Төсвийн байгууллага нь түүний үйл ажиллагааг үр ашигтай удирдлагаар хангаж, ажлын үр дүнг хариуцах үүрэг бүхий төсвийн шууд захирагчтай байна.

16.2.Улсын Их Хуралд ажлаа шууд хариуцан тайлагнадаг байгууллагын төсвийн шууд захирагчийг харьяалах төсвийн ерөнхийлөн захирагч тогтооно.

16.3.Аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд ажлаа хариуцан тайлагнадаг байгууллагын төсвийн шууд захирагчийг харьяалах төсвийн ерөнхийлөн захирагч тогтооно.

16.4.Дараах албан тушаалтан төсвийн шууд захирагч байна:

16.4.1.Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын дэд дарга Монгол Улсын Ерөнхийлөгчийн болон түүний Тамгын газрын төсвийн;

16.4.2.Улсын Их Хурлын Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн дарга Улсын Их Хурлын төсвийн;

16.4.3.Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын тэргүүн дэд дарга Ерөнхий сайдын төсвийн, Шадар сайдын ажлын албаны, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын төсвийн;

[/Энэ заалтад 2012 оны 03 дугаар сарын 07-ны өдрийн хуулиар өөрчлөлт орсон/](#)

16.4.4.төрийн захиргааны төв байгууллагын Төрийн нарийн бичгийн дарга тус байгууллагын төсвийн;

16.4.5.агентлагийн дарга тус агентлагийн төсвийн;

16.4.6.Үндсэн хуулийн цэцийн ажлын албаны дарга Үндсэн хуулийн цэцийн төсвийн;

16.4.7.Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн ажлын албаны дарга тус зөвлөлийн төсвийн;

16.4.8.Улсын дээд шүүхийн Тамгын газрын дарга Улсын дээд шүүхийн төсвийн;

16.4.9.Шүүхийн ерөнхий зөвлөлийн нарийн бичгийн дарга Шүүхийн ерөнхий зөвлөлийн ажлын албаны төсвийн;

16.4.10.Авлигатай тэмцэх газрын Тамгын газрын дарга тус байгууллагын төсвийн;

16.4.11.аймаг, нийслэл, сум, сум дундын, дүүргийн болон дагнасан шүүхийн тамгын хэлтсийн дарга тухайн шатны шүүхийн төсвийн;

16.4.12.Улсын ерөнхий прокурорын газрын Тамгын газрын дарга Улсын ерөнхий прокурорын газрын төсвийн;

16.4.13.аймаг, нийслэлийн прокурорын газрын Тамгын хэлтсийн дарга тухайн шатны прокурорын байгууллагын төсвийн;

16.4.14.аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн дарга тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төсвийн;

16.4.15.аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг даргын Тамгын газрын дарга тухайн шатны Засаг даргын Тамгын газрын төсвийн;

16.4.16.Засгийн газрын шугамаар авч байгаа хөнгөлөлттэй зээл болон буцалтгүй тусламжийн хөрөнгөөр хэрэгжиж байгаа төслийн нэгжийн дарга тухайн төслийн төсвийн;

16.4.17.Засгийн газрын тусгай сангийн захирагч тухайн сангийн төсвийн;

16.4.18.төсвийн бусад байгууллагын дарга (захирал, эрхлэгч) тухайн байгууллагын төсвийн.

16.5.Төсвийн шууд захирагч нь төсвийн талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

16.5.1.төсвийн байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг удирдах;

16.5.2.батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих;

16.5.3.батлагдсан цалингийн сан, орон тооны хязгаарт багтаан төсвийн байгууллагын орон тоо, ажиллагчдын цалин хөлсийг тогтоох;

16.5.4.төсвийн байгууллагын үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх;

16.5.5.батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах;

16.5.6.дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх;

16.5.7.байгууллагын санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн мэдээ, тайлан, үр дүнгийн гэрээний биелэлтийг үнэн зөв гаргах, тогтоосон хугацаанд тайлагнах;

16.5.8.санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас шаардсан мэдээллийг хугацаанд нь гаргаж өгөх.

16.5.9.дээд шатны төсвийн захирагчийн зөвшөөрснөөр үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх, чиг үүргийн давхардлыг арилгах, ажлын ачааллыг нягтруулах, бүтээмжийг дээшлүүлэх зорилгоор байгууллагын дотоод зохион байгуулалтын бүтцийг батлагдсан орон тооны хязгаар, төсвийн хүрээнд шинэчлэн тогтоох.

[/Энэ заалтыг 2016 оны 11 дүгээр сарын 10-ны өдрийн хуулиар нэмсэн/](#)

17 дугаар зүйл.Төсвийн байгууллага

17.1.Олон улсын байгууллага, хандивлагч орноос Засгийн газрын шугамаар Монгол Улсад олгож байгаа зээл, тусламжаар хэрэгжүүлэх төслийн нэгж нь төсвийн байгууллага байна.

~~17.2.Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуульд заасны дагуу төсвийн байгууллагыг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага бүртгэнэ.~~

[/Энэ хэсгийг 2015 оны 01 дүгээр сарын 29-ний өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон/](#)

17.3.Төсвийн захирагчийн нэг удаагийн шинж чанартай, байнгын бус үйл ажиллагаа явуулах чиг үүргийг хэрэгжүүлэх нэгж нь түүнийг шууд харьяалах төсвийн захирагчид харьяалагдаж, төсвийн харилцаанд оролцоно.

18 дугаар зүйл.Тусгай сан

18.1.Төрийн зарим чиг үүргийг хэрэгжүүлэх үйл ажиллагааг тусгай сангаар дамжуулан гүйцэтгэж болно.

18.2.Тусгай сан нь Засгийн газрын тусгай сан, орон нутгийн тусгай сан гэсэн төрөлтэй байна.

18.3.Засгийн газрын тусгай санг байгуулах, түүний үйл ажиллагааны зарчим, хэрэгжүүлэх чиг үүрэг, уг сангийн орлого, түүний зарцуулалтын талаарх харилцааг хуулиар зохицуулна.

18.4.Орон нутгийн тусгай санг байгуулах, түүний үйл ажиллагааны зарчим, хэрэгжүүлэх чиг үүрэг, уг сангийн орлого, түүний зарцуулалтын талаарх харилцааг энэ хуулиар зохицуулна.

18.5.Засгийн газрын тусгай сан нь улсын төсвийн, орон нутгийн тусгай сан нь орон нутгийн төсвийн бүрэлдэхүүн хэсэг байна.

18.6.Энэ хуулийн 4.1.50-д заасан эргэлтийн сангийн үлдэгдлийг төсөвт татан төвлөрүүлэх асуудлыг тухайн жилийн төсвийн тухай хуулиар шийдвэрлэнэ.

18.7.Эргэлтийн сан байгуулах, эргэлтийн сангийн орлого, зориулалт, зарцуулалт, тайлагналттай холбогдсон харилцааг Засгийн газрын тусгай сангийн тухай хуулиар зохицуулна.

19 дүгээр зүйл.Төсвийн ерөнхий нягтлан бодогчийг томилох, чөлөөлөх

19.1.Бүх шатны төсөв нь тухайн шатны төсвийн ерөнхий нягтлан бодогчтой байна.

19.2.Энэ хуулийн 14.1.3, 14.1.7, 14.1.8, 14.1.11, 14.1.12, 14.1.16-д заасан төсвийн ерөнхийлөн захирагч нь төсвийн ерөнхий нягтлан бодогчтой байна.

19.3.Энэ хуулийн 19.1, 19.2-г зааснаас бусад тохиолдолд төсвийн ерөнхийлөн захирагч болон төсвийн төвлөрүүлэн захирагч, шууд захирагч нь төсвийн ахлах нягтлан бодогч, нягтлан бодогчтой байна.

19.4.Энэ хуулийн 14.1.3, 14.1.7, 14.1.8, 14.1.11, 14.1.12-г заасан төсвийн ерөнхийлөн захирагч тухайн төсвийн ерөнхий нягтлан бодогчийг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын Төрийн нарийн бичгийн даргатай зөвшилцөн томилж, чөлөөлнө.

19.5.Сум, дүүргийн төсвийн ерөнхийлөн захирагч нь өөрийн төсвийн ерөнхий нягтлан бодогчийг аймаг, нийслэлийн төсвийн ерөнхийлөн захирагчтай, аймаг, нийслэлийн төсвийн ерөнхийлөн захирагч нь өөрийн төсвийн ерөнхий нягтлан бодогчийг санхүү, төсвийн

асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын төрийн нарийн бичгийн даргатай зөвшилцөн томилж, чөлөөлнө.

19.6.Төсвийн төвлөрүүлэн захирагч болон төсвийн шууд захирагч нь төсвийн ахлах нягтлан бодогчийг дараах байдлаар зөвшилцөн томилж, чөлөөлнө:

19.6.1.улсын төсөв, Нийгмийн даатгалын сангийн төсөв, Эрүүл мэндийн даатгалын сангийн төсөв, *Ирээдүйн тэтгэврийн нөөц сангийн төсөвт* харьяалагдах төсвийн төвлөрүүлэн захирагч болон төсвийн шууд захирагч нь өөрийн төсвийн нягтлан бодогчийг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын Төрийн нарийн бичгийн даргатай;

/Энэ заалтад 2015 оны 01 дүгээр сарын 29-ний өдрийн хуулиар нэмэлт оруулсан/

/Энэ заалтад 2016 оны 01 дүгээр сарын 22-ны өдрийн хуулиар “Эрүүл мэндийн даатгалын сангийн төсөв,” гэсний дараа “Ирээдүйн тэтгэврийн нөөц сангийн төсөв,” гэж нэмэлт оруулсан бөгөөд 2019 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө/

/Энэ заалтад 2016 оны 02 дугаар сарын 05-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/

/Энэ хуульд 2016 оны 11 дүгээр сарын 10-ны өдрийн хуулиар 71.5 дахь хэсгийг нэмж, энэ заалтын “төсөв, Эрүүл мэндийн даатгалын сангийн төсөв, Ирээдүйн тэтгэврийн нөөц сангийн” гэснийг 2018 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөхөөр заасан/

19.6.2.энэ хуулийн 39 дүгээр зүйлд заасан гэрээгээр орон нутагт шилжүүлсэн төсвийн төвлөрүүлэн захирагчид харьяалагдах төсвийн байгууллагын ахлах нягтлан бодогчийг аймаг, нийслэлийн төрийн сангийн хэлтсийн даргатай;

19.6.3.аймаг, нийслэлийн төсөвт харьяалагдах байгууллагын төвлөрүүлэн захирагч болон төсвийн шууд захирагч нь өөрийн төсвийн нягтлан бодогчийг, сумын төсөвт харьяалагдах байгууллагын төсвийн шууд захирагч нь өөрийн төсвийн нягтлан бодогчийг аймаг, нийслэлийн төрийн сангийн хэлтсийн даргатай тус тус;

19.6.4.дүүргийн төсөвт харьяалагдах байгууллагын төсвийн шууд захирагч нь өөрийн төсвийн нягтлан бодогчийг дүүргийн төрийн сангийн хэлтсийн даргатай.

19.7.Төсвийн байгууллага, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгжийн ерөнхий нягтлан бодогчид тавигдах шаардлага, шалгуур журмыг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага тогтооно.

20 дугаар зүйл.Санхүүгийн мэдээллийн нэгдсэн тогтолцоо

20.1.Бүх шатны төсөв боловсруулах, төсвийн гүйцэтгэл, нягтлан бодох бүртгэл, тайлагналтыг төсвийн мэдээллийн нэгдсэн сүлжээгээр дамжуулан хэрэгжүүлнэ.

20.2.Санхүүгийн мэдээллийн нэгдсэн тогтолцоон дахь мэдээлэл нь холбогдох шийдвэр, эрх зүйн акт, нягтлан бодох бүртгэлийн баримтаар баталгаажсан байна.

20.3.Холбогдох байгууллага, албан тушаалтан төсвийн мэдээллийн тогтолцоонд үнэн зөв мэдээллийг цаг хугацаанд нь оруулах, мэдээллийн үндсэн баримтыг бүрдүүлэх, бүртгэх, хадгалах, хамгаалах үүрэгтэй.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ ТӨСВИЙН БҮТЭЦ

21 дүгээр зүйл.Төсвийн шатлал

21.1.Монгол Улсын нэгдсэн төсөв нь улсын төсөв, орон нутгийн төсөв, Нийгмийн даатгалын сангийн төсөв, Эрүүл мэндийн даатгалын сангийн төсөв, *Ирээдүйн тэтгэврийн нөөц сангийн төсвөөс* бүрдэнэ.

/Энэ хэсэгт 2015 оны 01 дүгээр сарын 29-ний өдрийн хуулиар нэмэлт оруулсан/

/Энэ заалтад 2016 оны 01 дүгээр сарын 22-ны өдрийн хуулиар “Эрүүл мэндийн даатгалын сангийн төсөв,” гэсний дараа “Ирээдүйн тэтгэврийн нөөц сангийн төсөв,” гэж нэмэлт оруулсан бөгөөд 2019 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө/

/Энэ хэсэгт 2016 оны 02 дугаар сарын 05-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/

/Энэ хуульд 2016 оны 11 дүгээр сарын 10-ны өдрийн хуулиар 71.5 дахь хэсгийг нэмж, энэ хэсгийн “төсөв, Эрүүл мэндийн даатгалын сангийн төсөв, Ирээдүйн тэтгэврийн нөөц сангийн” гэснийг 2018 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөхөөр заасан/

21.2.Орон нутгийн төсөв нь аймаг, нийслэл, сум, дүүргийн төсвөөс бүрдэнэ.

21.3.Аймаг, нийслэлийн төсвийн дээд шатны төсөв нь улсын төсөв, сум, дүүргийн төсвийн дээд шатны төсөв нь аймаг, нийслэлийн төсөв байна.

21.4.Төсвийн шатлал бүрд ногдох орлого, тухайн шатны төсвөөр хэрэгжүүлэх чиг үүргийг хуулиар тогтооно.

22 дугаар зүйл.Төсвийн ангилал

22.1.Төсвийг тогтоосон ангиллын дагуу төлөвлөж, гүйцэтгэлийг хэрэгжүүлж, бүртгэн, тайлагнана.

22.2.Төсвийг дор дурдсаны дагуу ангилна:

22.2.1.төсвийн шатлалаар;

22.2.2.төсвийн захирагчаар;

22.2.3.эдийн засгийн ангиллаар;

22.2.4.хөтөлбөрөөр;

22.2.5.арга хэмжээгээр;

22.2.6.санхүүжүүлэх эх үүсвэрээр.

22.3.Энэ хуулийн 22.2-т заасан ангилал нь төсвийн анхдагч ангилал байна.

22.4.Шаардлагатай гэж үзвэл санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага төсвийн бусад ангилал болон төсвийн ангиллын дугаарлалт (код)-ын түвшинг тогтоож болно.

22.5.Төсвийн ангиллын зүйлд санаатайгаар буруу мэдээлэл оруулж төсвийн орлого, зарлагын хэмжээг өөрчлөхийг хориглоно.

22.6.Төсвийг төлөвлөх, батлах, хэрэгжүүлэх, тайлагнах үе шат бүрд төсвийн ангиллыг дараах байдлаар хэрэглэнэ:

22.6.1.дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлийн шалгуур үзүүлэлтийг төсвийн шатлал бүрээр тогтоох;

22.6.2.төсвийн зарлагын дээд хязгаарыг төсвийн шатлал, тэдгээрт харьяалагдах төсвийн ерөнхийлөн захирагч бүрээр, зарлагын томсгосон ангиллаар тогтоох;

22.6.3.төсвийн төлөвлөлт, бүртгэл, тайлагналтыг төсвийн ангиллын төрөл тус бүрээр, тэдгээрийн дэлгэрэнгүй ангиллын дагуу бэлтгэх;

22.6.4.төсөв батлах эрх бүхий байгууллага нь төсвийг шатлал бүрээр, түүнд харьяалагдах төсвийн ерөнхийлөн захирагч, тэдгээрийн хэрэгжүүлэх хөтөлбөр, хүрэх үр дүн, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ, тусгай сан, орлого, санхүүжүүлэх эх үүсвэр бүрээр нь батлах;

[/Энэ заалтад 2012 оны 10 дугаар сарын 25-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/](#)

22.6.5.төсвийн ерөнхийлөн захирагч нь өөрийн батлагдсан төсвийг төсвийн төвлөрүүлэн захирагч бүрээр, төсвийн төвлөрүүлэн захирагчид харьяалагдахгүй төсвийг төсвийн шууд захирагч бүрээр, энэ хуулийн 22.2.3-22.2.6-д заасан ангиллаар, хүрэх үр дүнгийн хамт батлах;

22.6.6.төсвийн төвлөрүүлэн захирагч нь өөрийн батлагдсан төсвийг төсвийн шууд захирагч бүрээр, энэ хуулийн 22.2.3-22.2.6-д заасан ангиллаар, хүрэх үр дүнгийн хамт батлах;

22.6.7.төсвийн шууд захирагч нь батлагдсан төсвийг энэ хуулийн 22.2.3-22.2.6-д заасан ангиллаар бүртгэж, тайлагнах;

22.6.8.төсвийн гүйцэтгэлийн явцын хяналтыг энэ хуулийн 22.2-т заасан ангиллаар хийх бөгөөд эдийн засгийн дэлгэрэнгүй ангиллын дотор томсгосон ~~ангиллаар~~ хяналтын түвшинг тогтоож болно.

22.7.Энэ хуулийн 22.2-т заасан төсвийн ангиллын төрөл бүрээр дэлгэрэнгүй ангилал тогтоох, түүнийг төсвийн төлөвлөлт, тайлагналт, гүйцэтгэлд ашиглах журмыг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага тогтооно.

22.8.Төсвийн ангиллыг Засгийн газрын санхүүгийн статистикийн олон улсын стандартад нийцүүлэн хөрвүүлэх аргачлалыг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага тогтооно.

22.9.Энэ хуулийн 22.6.8-д заасан ангиллаар тогтоосон төсвийг зүйл хооронд шилжүүлэн зарцуулах эрхийг төсвийн захирагчийн ангилал бүрээр тогтоох, томсгосон хяналтын түвшинг тогтоох нийтлэг журмыг Засгийн газар тогтоон мөрдүүлнэ.

23 дугаар зүйл.Төсвийн орлого

23.1.Төсвийн орлого нь татварын орлого, татварын бус орлогоос бүрдэнэ.

23.2.Татварын орлого нь Татварын ерөнхий хуулиар^[5] тогтоосон албан татвар, төлбөр, хураамжаас бүрдэнэ.

23.3.Татварын бус орлого нь төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн төрийн болон орон нутгийн өмчид ногдох хувьцааны ногдол ашиг, төрийн болон орон нутгийн өмчийн эд хөрөнгийг ашигласны төлбөр, төрийн болон орон нутгийн өмчийг хувьчилсан, худалдсан, түрээслэсний орлого, торгуулийн орлого, төсвийн байгууллагын туслах үйл ажиллагааны орлого, Засгийн газрын зээллэг, тусламж болон хууль тогтоомжийн дагуу төсөвт төвлөрүүлэх бусад орлогоос бүрдэнэ.

[/Энэ хэсэгт 2015 оны 02 дугаар сарын 18-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/](#)

23.4.Улсын төсвийн татварын орлого дараах орлогоос бүрдэнэ:

23.4.1.аж ахуйн нэгжийн орлогын албан татвар;

23.4.2.нэмэгдсэн өртгийн албан татвар;

23.4.3.онцгой албан татвар;

23.4.4.гаалийн албан татвар;

23.4.5.авто бензин, дизелийн түлшний албан татвар;

23.4.6.ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр;

23.4.7.ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрлийн төлбөр;

23.4.8.агаарын бохирдлын төлбөр;

23.4.9.Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн^[6] 11.2-т заасан улсын тэмдэгтийн хураамж.

23.4.10.ус бохирдуулсны төлбөр.

/Энэ заалтыг 2012 оны 05 дугаар сарын 17-ны өдрийн хуулиар нэмсэн/

23.4.11.газрын тосны нөөц ашигласны төлбөрийн 70 хувь;

/Энэ заалтыг 2014 оны 07 дугаар сарын 01-ний өдрийн хуулиар нэмсэн/

23.4.12.газрын тосны хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрлийн төлбөрийн 70 хувь.

/Энэ заалтыг 2014 оны 07 дугаар сарын 01-ний өдрийн хуулиар нэмсэн/

23.5.Улсын төсвийн татварын бус орлого дараах орлогоос бүрдэнэ:

23.5.1.төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн Ирээдүйн өв сангийн тухай хуулийн 7.1.1-д зааснаас бусад төрийн өмчид ногдох хувьцааны ногдол ашиг;

/Энэ хэсэгт 2016 оны 02 дугаар сарын 05-ны өдрийн хуулиар “Хүний хөгжил сангийн тухай хуулийн 3.2.1-д” гэснийг “Ирээдүйн өв сангийн тухай хуулийн 7.1.1-д” гэж өөрчлөлт оруулахаар заасан бөгөөд үүнийг 2017 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө/

23.5.2.төрийн өмчийн эд хөрөнгийг ашигласны төлбөр болон борлуулсны орлого;

23.5.3.хууль тогтоомжийн дагуу улсын төсөвт төвлөрүүлэх бусад орлого.

23.6.Аймаг, нийслэлийн төсвийн татварын орлого дараах орлогоос бүрдэнэ:

23.6.1.нийслэл хотын албан татвар;

23.6.2.газрын төлбөр;

23.6.3.үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар;

23.6.4.автотээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татвар.

23.6.5.үйлдвэрлэл, үйлчилгээний зориулалтаар ашигласан усны төлбөр;

23.6.6.Хувь хүний орлогын албан татварын тухай[7] хуулийн 8.1.1-д заасан орлогод ногдох албан татвар

23.6.7.өв залгамжлал, бэлэглэлийн албан татвар;

23.6.8.энэ хуулийн 23.4.9-д зааснаас бусад улсын тэмдэгтийн хураамж.

23.6.9.газрын тосны хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрлийн төлбөрийн 20 хувь.

/Энэ заалтыг 2014 оны 07 дугаар сарын 01-ний өдрийн хуулиар нэмсэн/

23.7.Аймаг, нийслэлийн төсвийн татварын бус орлого дараах орлогоос бүрдэнэ:

23.7.1.орон нутгийн өмчит болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн орон нутгийн өмчид ногдох хувьцааны ногдол ашиг;

23.7.2.орон нутгийн өмчийн эд хөрөнгийг ашигласны төлбөр болон борлуулсны орлого, хүү, торгуулийн орлого;

23.7.3.хууль тогтоомжийн дагуу аймаг, нийслэлийн төсөвт төвлөрүүлэх бусад орлого.

23.8.Сум, дүүргийн төсвийн татварын орлого дараах орлогоос бүрдэнэ:

23.8.1.Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 8.1.1-д заасан орлогод ногдох албан татвараас бусад хувь хүний орлогын албан татвар;

23.8.2. галт зэвсгийн албан татвар;

/Энэ заалтад 2015 оны 08 дугаар сарын 07-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/

23.8.3.энэ хуулийн 23.4.9-д зааснаас бусад улсын тэмдэгтийн хураамж;

23.8.4.агнуурын нөөц ашигласны төлбөр, ан амьтан агнах, барих зөвшөөрлийн хураамж;

23.8.5.ашигт малтмалаас бусад байгалийн баялаг ашиглахад олгох эрхийн зөвшөөрлийн хураамж;

23.8.6.байгалийн ургамал ашигласны төлбөр;

23.8.7.ойгоос хэрэглээний мод, түлээ бэлтгэж ашигласны төлбөр;

23.8.8.түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр;

23.8.9.хүн амын унд, ахуйн хэрэгцээний зориулалтаар ус, рашаан ашигласны төлбөр;

23.8.10.орлогыг нь тухай бүр тодорхойлох боломжгүй ажил, үйлчилгээ хувиараа эрхлэгч хувь хүний орлогын албан татвар;

23.8.11.нохойны албан татвар.

23.8.12.хог хаягдлын үйлчилгээний хураамж

/Энэ заалтыг 2012 оны 05 дугаар сарын 17-ны өдрийн хуулиар нэмсэн/

23.8.13.газрын тосны хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрлийн төлбөрийн 10 хувь.

/Энэ заалтыг 2014 оны 07 дугаар сарын 01-ний өдрийн хуулиар нэмсэн/

23.9.Сум, дүүргийн төсвийн татварын бус орлого дараах орлогоос бүрдэнэ:

23.9.1.орон нутгийн өмчит болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн орон нутгийн өмчид ногдох хувьцааны ногдол ашиг;

23.9.2.орон нутгийн өмчийн эд хөрөнгийг ашигласны төлбөр болон борлуулсны орлого, хүү, торгуулийн орлого;

23.9.3.хууль тогтоомжийн дагуу сум, дүүргийн төсөвт орох бусад орлого.

23.10.Энэ хуулийн 25 дугаар зүйлд заасан тусламжийн орлого нь төсвийн орлогын бүрэлдэхүүн хэсэг байна.

23.11.Газар, байгалийн баялгийн нөөцийг хуульд заасан хэлбэрээр эзэмших, ашиглах, захиран зарцуулахтай холбогдон бий болох орлого нь төсвийн орлого байна.

24 дүгээр зүйл.Төсвийн зарлага

24.1.Төсвийн зарлага нь урсгал зардал, хөрөнгийн зардлаас бүрдэнэ.

24.2.Төрийн болон орон нутгийн өмчит аж ахуйн нэгжийн өөрөө санхүүжүүлснээс бусад хэлбэрээр төрийн болон орон нутгийн өмч бий болгох, худалдан авах, хуулийн этгээд үүсгэн байгуулах зардал, хувь оролцоо, дүрмийн санд оруулсан хөрөнгө, түүнтэй холбогдсон бүх төрлийн санхүүгийн хэрэгсэл нь тухайн шатны төсвийн зарлага байна.

24.3.Татварын зарлагыг нэр төрөл, салбар бүрээр нь төлөвлөж, төсвийн гүйцэтгэлд тусган дэлгэрэнгүй тайлагнана.

24.4.Төсвийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээг худалдан авах ажиллагаа хууль тогтоомжийн дагуу зохион байгуулагдаагүй бол төсвөөс санхүүжилт гаргахыг хориглоно.

24.5.Төсвийн ерөнхийлөн захирагчийн болон түүний эрхлэх асуудлын хүрээний агентлаг, харьяа байгууллагын хэрэгжүүлэх арга хэмжээ, ажил, үйлчилгээг тухайн төсвийн ерөнхийлөн захирагчийн хэрэгжүүлэх аль нэг хөтөлбөрт хамруулсан байна.

24¹ дүгээр зүйл.Засгийн газрын зээл олгох

24¹.1.Тухайн жилийн төсвийн хуулиар эх үүсвэр нь батлагдсан тохиолдолд улсын төсвөөс дараах зорилгоор зээл олгож болно:

24¹.1.1.аймаг, нийслэлийн төсвийн улирлын чанартай орлогын дутагдлыг санхүүжүүлэх;

24¹.1.2.Засгийн газрын тусгай сангаас хуульд заасан зориулалтаар;

24¹.1.3.Өрийн удирдлагын тухай хуульд заасны дагуу дамжуулан зээлдүүлэх.

/Энэ зүйлийг 2015 оны 02 дугаар сарын 18-ны өдрийн хуулиар нэмсэн/

25 дугаар зүйл.Тусламжийн орлого, түүгээр санхүүжих зарлага

25.1.Тусламжийн орлого нь дор дурдсан хэлбэртэй байна:

25.1.1.олон улсын гэрээний дагуу авах хөгжлийн тусламж;

25.1.2.төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авах тусламж, хандив.

25.2.Зөвхөн дор дурдсан нийгмийн үйлчилгээ үзүүлдэг төсвийн байгууллага энэ хуульд заасан журмын дагуу хандив, тусламж авч болно:

25.2.1.эмнэлгийн үйлчилгээ;

25.2.2.бүх шатны боловсролын үйлчилгээ;

25.2.3.соёлын үйлчилгээ.

25.3.Төсвийн ерөнхийлөн захирагчийн авах тусламж, хандивын хэмжээ тухайн төсөвт байгууллагын батлагдсан төсвийн 50 хувиас хэтрэхгүй байна.

25.4.Төсвийн байгууллага төсвийн ерөнхийлөн захирагчаараа дамжуулан дараах тохиолдолд төрийн болон орон нутгийн өмчит бус хуулийн этгээдээс мөнгөн хөрөнгө, хөдлөх эд хөрөнгийн хэлбэрээр тусламж, хандив авч болно:

25.4.1.санхүүжүүлэх эх үүсвэр дутагдсан хөтөлбөр, арга хэмжээг үргэлжлүүлэх;

25.4.2.байгууллагын хүний нөөцийн чадавхийг бэхжүүлэхэд чиглэсэн сургалтын хөтөлбөр хэрэгжүүлэх.

25.5.Дараах тохиолдлыг ашиг сонирхлын зөрчилтэй гэж үзэн төсвийн байгууллага хандив, тусламж авахыг хориглоно:

25.5.1.хандив, тусламж өгсөн этгээд нь төсвийн байгууллагын хэрэгцээнд өөрийн барааг худалдах, ажил гүйцэтгэх, үйлчилгээ үзүүлдэг байх;

25.5.2.байгууллагын ажилтны энэ хуулийн 25.4.2-т зааснаас бусад нийгмийн асуудлыг шийдвэрлэх зорилготой байх.

25.6.Тусламжийн орлогоос санхүүжүүлэхэд төсвөөс санхүүжүүлэх арга хэмжээнд тавигдах шаардлагыг нэгэн адил баримтална.

25.7.Тусламж, хандивын орлогыг холбогдох журмын дагуу бүртгэж, гүйцэтгэлийг тайлагнана.

25.8.Төсвийн ерөнхийлөн захирагч тусламж, хандив авсан тухай баримтын хувийг төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, эсхүл аймаг, нийслэл, сум, дүүргийн төрийн санд нэг сарын дотор хүргүүлнэ.

25.9.Хуульд өөрөөр заагаагүй бол төрийн болон орон нутгийн өмчит бус хуулийн этгээд татвар ногдуулсны дараах ашгаас хандив, тусламж өгнө.

25.10.Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд хандив, тусламж өгөхийг хориглоно.

25.11.Гадаадын тусламж авах, зарцуулах, удирдах, бүртгэх, тайлагнахтай холбогдсон харилцааг Засгийн газрын баталсан журмаар зохицуулна.

[/Энэ хэсгийг 2015 оны 02 дугаар сарын 18-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан/](#)

25.12.Монгол Улсын олон улсын гэрээнд өөрөөр заагаагүй бол тусламжийн орлогыг төрийн сангийн нэгдсэн дансанд байршуулна.

25.13.Энэ хуулийн 25.11-д заасан журмыг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас боловруулж, журмын биелэлтийг хангуулна.

[/Энэ хэсгийг 2015 оны 02 дугаар сарын 18-ны өдрийн хуулиар нэмсэн/](#)

25.14.Гадаад улсын Засгийн газар, төрийн бус байгууллага, олон улсын байгууллага болон буяны байгууллагаас буцалтгүй тусламж болон хүмүүнлэгийн тусламжаар авсан барааг нэмэгдсэн өртгийн албан татвар болон гаалийн албан татвараас чөлөөлөх, хөнгөлөлт үзүүлэх үйл ажиллагаатай холбогдсон журмыг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага баталж, хэрэгжилтийг хангуулна.

[/Энэ хэсгийг 2015 оны 02 дугаар сарын 18-ны өдрийн хуулиар нэмсэн/](#)

25¹ дүгээр зүйл.Засгийн газрын өрийн үйлчилгээний төлбөр

25¹.1.Хөрөнгө оруулалтын зориулалт бүхий арилжааны нөхцөлтэй Засгийн газрын гадаад зээл болон үнэт цаасны өрийн үйлчилгээний төлбөр, Засгийн газрын өрийн баталгааны төлбөрийг төсвийн хөрөнгө оруулалтын зардлаас бууруулах замаар төлнө.

25¹.2.Энэ хуулийн 25¹.1-д заасан төлбөрийг дахин санхүүжүүлэх зориулалтаар үүсгэсэн өрийн үйлчилгээний төлбөрийг төсвийн хөрөнгө оруулалтын зардлаас бууруулах замаар төлнө.

[/Энэ зүйлийг 2015 оны 02 дугаар сарын 18-ны өдрийн хуулиар нэмсэн/](#)

26 дугаар зүйл.Санхүүгийн бүртгэл, стандарт

26.1.Төсвийн байгууллага нь нягтлан бодох бүртгэлийн олон улсын болон үндэсний стандартын дагуу бүрэн аккруэл суурьтай нягтлан бодох бүртгэл хөтөлнө.

26.2.Төсвийн бүртгэлийг тохируулсан аккруэл сууриар бүртгэж, тайлагнана.

26.3.Улсын салбар, төсвийн бүртгэлд ашиглах нягтлан бодох бүртгэлийн үндэсний стандартыг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага боловсруулж, мөрдүүлнэ.

ТАВДУГААР БҮЛЭГ ТӨСВИЙН ТӨСӨЛ БОЛОВСРУУЛАХ, ӨРГӨН МЭДҮҮЛЭХ, БАТЛАХ

27 дугаар зүйл.Төсвийн төсөл боловсруулахад тавигдах шаардлага

27.1.Төсвийн төслийг боловсруулахад Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан шаардлагаас гадна дараах шаардлага тавигдана:

27.1.1.төсвийн зарчмыг мөрдлөг болгох;

27.1.2.макро эдийн засгийн төлөв байдал, дүн шинжилгээ, тооцоонд үндэслэсэн байх;

27.1.3.төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлж, төсвийн санхүүжилтийн үр ашгийг дээшлүүлэхэд чиглэсэн байх;

27.1.4.жилийн төсвийн хязгаарт үндэслэсэн байх;

27.1.5.төсвийн төслийг хөтөлбөр, төсвийн ерөнхийлөн захирагч бүрээр тодорхойлсон байх;

27.1.6.төсвөөс санхүүжих бүх байгууллагын төсвийг аль нэг төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн төсөлд хамруулсан байх;

27.1.7.орлого, зарлагыг дотоод гүйлгээнээс бусад нийт гүйлгээний дүнгээр төлөвлөж, бүртгэж, тайлагнах.

27.2.Төсвийн ерөнхийлөн захирагчид хүргүүлэх жилийн төсвийн хязгаар нь дараах шаардлагыг хангасан байна:

27.2.1.төсвийн хязгаарыг урсгал болон хөрөнгийн зардлаар тогтоосон байх;

27.2.2.хөрөнгө оруулалтын хөтөлбөрт тусгагдах шинэ болон үргэлжлэн хэрэгжих төсөл, арга хэмжээг санхүүжүүлэх эх үүсвэрээр ангилан тусгах.

27.3.Улсын төсөвт хамаарах төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн төсөл бэлтгэх нарийвчилсан зааврыг тусгасан төсвийн удирдамжийг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага төсвийн ерөнхийлөн захирагчид хүргүүлнэ.

27.4.Төсвийн удирдамжид дараах зүйлийг тусгана:

27.4.1.дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлийн тооцоо болон гаргасан шийдвэрийн тайлбар;

27.4.2.Засгийн газрын баталсан жилийн төсвийн хязгаар;

27.4.3.улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл болон Засгийн газрын үйл ажиллагааны төлөвлөгөөний талаарх бодлогын удирдамж;

27.4.4.хөрөнгө оруулалтын төсөл боловсруулахад тавигдах ерөнхий болон тусгай шаардлага;

27.4.5.төсвийн төслийн санхүүжилтийн хүсэлт гаргах ерөнхий нөхцөл;

27.4.6.төсвийн төсөл бэлтгэх тусгай маягт, түүний заавар;

27.4.7.төсвийн төсөл хүргүүлэх хугацаа.

27.5.Орон нутгийн төсвийн төсөл бэлтгэх нарийвчилсан зааврыг төсвийн удирдамжид тусган, аймаг, нийслэлийн Засаг даргад хүргүүлнэ.

28 дугаар зүйл.Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрийн төлөвлөлт

28.1.Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрт эдийн засаг, нийгмийн хөгжлийг урт хугацаанд хангахад чиглэгдсэн, нэгээс дээш жилийн хугацаанд хэрэгжих 30.0 тэрбум төгрөгөөс дээш өртөг бүхий дэд бүтэц, хөгжлийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг хамруулна.

[/Энэ хэсэгт 2015 оны 11 дүгээр сарын 26-ний өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/](#)

28.2.Төсвийн ерөнхийлөн захирагч улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрт тусгуулах төсөл, арга хэмжээний саналаа үндэсний хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад хүргүүлнэ.

[/Энэ хэсэгт 2012 оны 08 дугаар сарын 17-ны өдрийн хуулиар нэмэлт оруулсан/](#)

[/Энэ хэсэгт 2014 оны 10 дугаар сарын 16-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/](#)

[/Энэ хэсэгт 2016 оны 07 дугаар сарын 21-ний өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/](#)

28.3.Үндэсний хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрт тусгах төсөл, арга хэмжээний тэргүүлэх ач холбогдол, хэрэгжүүлэх дарааллыг дараах зүйлийг харгалзан тогтооно:

[/Энэ хэсэгт 2012 оны 08 дугаар сарын 17-ны өдрийн хуулиар нэмэлт оруулсан/](#)

[/Энэ хэсэгт 2014 оны 10 дугаар сарын 16-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/](#)

[/Энэ хэсэгт 2016 оны 07 дугаар сарын 21-ний өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/](#)

28.3.1.улсын хөгжлийн урт болон дунд хугацааны бодлого;

28.3.2.эдийн засгийн үр ашиг, хөрөнгө оруулалтын өгөөж;

28.3.3.нийгмийн ач холбогдол;

28.3.4.Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, тэргүүлэх чиглэл;

28.3.5.төрөөс олон нийтэд үзүүлэх үйлчилгээний стандарт;

28.3.6.салбарын хөгжлийн бодлого;

28.3.7.бүсчилсэн хөгжлийн бодлого;

[/Энэ заалтад 2015 оны 11 дүгээр сарын 26-ний өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/](#)

28.3.8.орон нутгийн хөгжлийн хэрэгцээ;

28.3.9.дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэл;

28.3.10.болзошгүй өр төлбөр болон санхүүгийн бусад эрсдэлийн үнэлгээ.

28.3.11.Өрийн удирдлагын тухай хууль болон Стратегийн баримт бичигт заасан шаардлага.

[/Энэ заалтыг 2015 оны 02 дугаар сарын 18-ны өдрийн хуулиар нэмсэн/](#)

28.4.Үндэсний хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага энэ хуулийн 28.3.1-28.3.8-д заасныг харгалзан улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрт тусгагдах 30.0 тэрбум төгрөгөөс дээш хэмжээний төсөл, арга хэмжээнд техник, эдийн засгийн үндэслэлийн урьдчилсан судалгааг хийнэ.

[/Энэ хэсэгт 2012 оны 08 дугаар сарын 17-ны өдрийн хуулиар нэмэлт оруулсан/](#)

[/Энэ хэсэгт 2014 оны 10 дугаар сарын 16-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/](#)

[/Энэ хэсэгт 2016 оны 07 дугаар сарын 21-ний өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/](#)

28.5.Үндэсний хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрт тусгагдах төслийг энэ хуулийн 28.3.9, 28.3.11-т заасан шаардлагыг хангаж байгаа эсэхийг хянан баталгаажуулна.

[/Энэ хэсэгт 2015 оны 02 дугаар сарын 18-ны өдрийн хуулиар нэмэлт, өөрчлөлт оруулсан/](#)

[/Энэ хэсэгт 2016 оны 07 дугаар сарын 21-ний өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/](#)

28.6.Үндэсний хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага энэ хуулийн 28.3.2, 28.3.3-т заасан эдийн засгийн үр ашиг, нийгмийн ач холбогдлыг харгалзан үзэхэд

үр дүнтэй болох нь урьдчилсан судалгаагаар тогтоогдсон нөхцөлд зураг төсөв, техник, эдийн засгийн үндэслэлийн тооцоо хийнэ.

[/Энэ хэсэгт 2012 оны 08 дугаар сарын 17-ны өдрийн хуулиар нэмэлт оруулсан/](#)

[/Энэ хэсэгт 2014 оны 10 дугаар сарын 16-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/](#)

[/Энэ хэсэгт 2016 оны 07 дугаар сарын 21-ний өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/](#)

28.7.Энэ хуулийн 28.4, 28.6-д заасан судалгаа, тооцоо нь дараах төсөл, арга хэмжээнд хамаарахгүй:

28.7.1.үндэсний аюулгүй байдал, улсын батлан хамгаалах үйл ажиллагаатай холбогдсон төсөл, арга хэмжээ;

28.7.2.байгалийн гамшгийн үр дагаврыг арилгах, нөхөн сэргээх төсөл, арга хэмжээ.

28.8.Төрөөс баримтлах бодлого, үндэсний хөтөлбөрийн хүрээнд Засгийн газар улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрийг дөрвөн жилд нэг удаа баталж, жил бүр тодотгоно.

[/Энэ хэсэгт 2015 оны 11 дүгээр сарын 26-ний өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/](#)

28.9.Үндэсний хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага жил бүрийн 5 дугаар сарын 15-ны дотор тухайн жилд хийгдэх хөрөнгө оруулалтын хөтөлбөрийн тодотголын төслийг Засгийн газарт хүргүүлнэ.

[/Энэ хэсэгт 2012 оны 08 дугаар сарын 17-ны өдрийн хуулиар нэмэлт оруулсан/](#)

[/Энэ хэсэгт 2014 оны 10 дугаар сарын 16-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/](#)

[/Энэ хэсэгт 2016 оны 07 дугаар сарын 21-ний өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/](#)

28.10.Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрт төсөв, гадаад зээллэг, тусламж болон концессын гэрээ, Засгийн газрын өрийн баталгаа Хөгжлийн банкны санхүүжилтээр хэрэгжих төсөл, арга хэмжээ хамаарна.

[/Энэ хэсэгт 2015 оны 02 дугаар сарын 18-ны өдрийн хуулиар нэмэлт, өөрчлөлт оруулсан/](#)

28.11.Хөрөнгө оруулалтын эдийн засгийн үр ашиг, нийгмийн ач холбогдлыг харгалзан үр дүнг тооцох аргачлалыг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

[/Энэ хэсэгт 2012 оны 08 дугаар сарын 17-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/](#)

[/Энэ хэсэгт 2014 оны 10 дугаар сарын 16-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/](#)

29 дүгээр зүйл.Хөрөнгө оруулалтын төсөвлөлт

29.1.Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрийн хүрээнд шинээр болон үргэлжлэн хэрэгжих хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний саналыг үндэсний хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн

захиргааны байгууллага бэлтгэнэ. Түүнчлэн энэ хуулийн 28.1-д зааснаас бусад, нийт төсөвт өртөг нь 30.0 тэрбум төгрөгөөс бага өртөгтэй хөрөнгө оруулалтын төслийн саналыг төсвийн ерөнхийлөн захирагч төсвийн удирдамжид заасны дагуу тус тус бэлтгэж үндэсний хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад энэ хуулийн 8.4.3-т заасан хугацаанд ирүүлнэ.

/Энэ хэсэгт 2012 оны 08 дугаар сарын 17-ны өдрийн хуулиар нэмэлт оруулсан/

/Энэ хэсэгт 2014 оны 10 дугаар сарын 16-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/

/Энэ хэсэгт 2016 оны 07 дугаар сарын 21-ний өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/

29.2.Хөрөнгө оруулалтын төслийн саналд үндсэн хөрөнгийн ашиглалттай холбоотой урсгал зардал, орон тоо, санхүүжүүлэх эх үүсвэр зэрэг холбогдох тооцоог хавсаргаж, төсөвт нөлөөлөх ачааллын талаарх дүгнэлтийг гаргасан байна.

29.3.Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, тухайн шатны Засаг дарга хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний нийт саналыг дараах байдлаар жилийн төсвийн төсөлд тусгана:

29.3.1.дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэл болон жилийн төсвийн хязгаарт багтаах;

29.3.2.улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрт багтсан төсөл, арга хэмжээний нийт өртөг, эхлэх болон дуусах хугацаа, төсвийн жилд зарцуулах хэмжээгээр тусгах;

29.3.3.нэг жилийн дотор хэрэгжиж дуусах богино хугацааны хөрөнгийн урсгал засвар, хөрөнгийн шинэчлэл, тоног төхөөрөмж болон бусад хөрөнгийн төслийг хөтөлбөр болон төсвийн ерөнхийлөн захирагчаар тооцож тусгах;

29.3.4.санхүүжүүлэх эх үүсвэрээс үл хамааран төсөл нэг бүрийг бүрэн хэмжээгээр тусгах;

29.3.5.шинээр эхлэх барилга, байгууламж, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний нийт төсөвт өртөгөөс тухайн жилд ногдох хэсэг нь төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх хугацаанд тэнцүү хуваарилсан хэмжээнээс багагүй байхаар тооцож тусгах.

29.4.Хөрөнгө оруулалтын төсөвт техник, эдийн засгийн үндэслэл хийгдсэн, зураг төсвөө батлуулсан, хуульд заасан бусад зөвшөөрөл олгогдсон төсөл, арга хэмжээг тусгана.

29.5.Энэ хуулийн 28.3-т заасан шаардлагыг нийт төсөвт өртөг нь 30.0 тэрбум төгрөгөөс бага өртөгтэй хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээнд нэгэн адил мөрдөнө.

29.6.Нийт төсөвт өртөг нь 30.0 тэрбум төгрөгөөс бага өртөгтэй хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний техник, эдийн засгийн үндэслэлийн тооцоо судалгааг тухайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хариуцан хийх бөгөөд санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага энэ хуулийн 28.6-д заасны дагуу тухайн хөрөнгө оруулалтын төслийн үр дүнтэй болохыг тогтоосон нөхцөлд төсөвт тусгана.

29.7. Үйлдвэрлэлийн түүхий эдийн үнийн индекс нь батлагдсан төсөвт тооцсон хэмжээнээс хоёр дахин өссөн тохиолдолд түүнийг тухайн жилийн төсвийн тодотголд тусган өөрчилнө.

29.8. Гүйцэтгэгч байгууллагын буруутай үйл ажиллагаанаас хамаарч энэ хуулийн 29.7-д заасан нөхцөл байдал үүссэн нь хөрөнгө оруулалтын төсөвт өртгийг өөрчлөх үндэслэл болохгүй.

30 дугаар зүйл. Төр ба хувийн хэвшлийн түншлэл

30.1. Төр ба хувийн хэвшлийн түншлэлийн дараах хэлбэр байна:

30.1.1. төрийн үйлчилгээг хувийн хэвшлийн байгууллагаар гүйцэтгүүлэх;

30.1.2. концессын гэрээгээр гүйцэтгүүлэх.

30.2. Төр ба хувийн хэвшлийн түншлэлийг дараах тохиолдолд хэрэгжүүлнэ:

30.2.1. хувийн хэвшлийн эзэмшиж байгаа техник, технологи, үр ашигтай

удирдлагын арга барилыг төрийн үйлчилгээнд нэвтрүүлэх;

30.2.2. хувийн хэвшил дангаараа хэрэгжүүлэх боломжгүй, төрийн дэмжлэг зайлшгүй шаардлагатай төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх;

30.2.3. төсөл, арга хэмжээ нь эдийн засгийн хувьд үр ашигтай нь техник, эдийн засгийн үндэслэлээр нотлогдсон байх.

30.3. Төсвийн санхүүжилтийн дутагдлыг нөхөх, төсвөөс төлөх төлбөрийг хойшлуулах зорилгоор төр ба хувийн хэвшлийн түншлэлийг хэрэгжүүлэхийг хориглоно.

[30.4. /Энэ хэсгийг 2012 оны 10 дугаар сарын 25-ны өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон/](#)

30.5. Улсын болон орон нутгийн төсвөөс эргэн төлөгдөх нөхцөлтэй концессын гэрээ нь төсвийн бүрэлдэхүүн хэсэг байна.

[/Энэ хэсгийг 2015 оны 02 дугаар сарын 18-ны өдрийн хуулиар нэмсэн/](#)

30.6. Концессын гэрээгээр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээ, тэдгээрийн хүрээнд үүсэх болзошгүй өр төлбөр, эрсдэлийн тооцооллын тухай мэдээллийг Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайланд тодруулга хэлбэрээр оруулж тайлагнана.

[/Энэ хэсгийг 2015 оны 02 дугаар сарын 18-ны өдрийн хуулиар нэмсэн/](#)

30.7. Концессын гэрээтэй холбогдсон харилцааг хуулиар зохицуулна.

[/Энэ хэсгийн дугаар 2015 оны 02 дугаар сарын 18-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/](#)

31 дүгээр зүйл. Төсвийн ерөнхийлөн захирагчийн жилийн төсвийн төсөл

31.1.Төсвийн ерөнхийлөн захирагчийн жилийн төсвийн төсөл дараах шаардлагыг хангасан байна:

31.1.1.санхүүжилтийг үндсэн чиг үүрэгт хамаарах хөтөлбөр, арга хэмжээний хүрээгээр тодорхойлсон байх;

31.1.2.хөтөлбөрийн зорилго, зорилт, хүрэх үр дүнгийн үзүүлэлтийг тодорхойлсон байх;

31.1.3.жилийн төсвийн хязгаарт багтаасан байх;

31.1.4.эрхлэх асуудлын хүрээнд хөрөнгө оруулалтын арга хэмжээ, түүнд шаардагдах хөрөнгийн хэмжээг холбогдох хөтөлбөрт тусгасан байх;

31.1.5.эрхлэх асуудлын хүрээнд төсвөөс санхүүжүүлэх тэтгэвэр, тэтгэмж, бусад санхүүгийн дэмжлэгийн төрөл, хэмжээг холбогдох хөтөлбөрт тусгасан байх;

31.1.6.худалдан авах бараа, ажил, үйлчилгээний төлөвлөгөөний төслийг хавсаргасан байх.

31.2.Төсвийн ерөнхийлөн захирагч нь энэ хуулийн 31.1.3-т заасан хязгаарт багтаагүй саналаа төсвийн төслийн тооцоонд тусгахгүйгээр холбогдох үндэслэл, тайлбарын хамт ирүүлнэ.

31.3.Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь энэ хуулийн 31.1-д заасан шаардлагыг хангаагүй төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн төслийг буцаана.

31.4.Төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн төсөлд дараах тооцоог хавсаргана:

31.4.1.төсөвт төвлөрүүлэх орлогын тооцоо;

31.4.2.төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогын тооцоо;

31.4.3.шинээр хэрэгжүүлэх хөтөлбөр, төсөл, арга хэмжээний тооцоо;

31.4.4.нийгэм, эдийн засгийн хувьд ач холбогдолгүй болсон хөтөлбөр, төсөл, арга хэмжээг зогсоох, эсхүл санхүүжилтийг бууруулах санал, тооцоо;

31.4.5.төсвийн гүйцэтгэлийн дүн шинжилгээний тайлан болон тухайн жилийн төсвийн хүлээгдэж байгаа гүйцэтгэлийн урьдчилсан тооцоо;

31.4.6.төсвийг хэрэгжүүлэхэд шаардагдах орц, төсөв, санхүүжүүлэх эх үүсвэр, хүрэх үр дүнг хөтөлбөрөөр болон эдийн засгийн ангиллаар илэрхийлсэн зарлагын хуваарилалтын тооцоо;

[31.4.7.Энэ заалтыг 2012 оны 10 дугаар сарын 25-ны өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон/](#)

31.5.Засгийн газар болон Засаг даргын зөвлөл нь төсвийн төслийг төсвийн ерөнхийлөн захирагч бүрээр хэлэлцэнэ.

32 дугаар зүйл. Төсвийн төслийг Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх

32.1. Засгийн газар улсын төсөв, Нийгмийн даатгалын сангийн төсөв, Эрүүл мэндийн даатгалын сангийн төсөв *Ирээдүйн тэтгэврийн нөөц сангийн төсвийн төслийг энэ хуулийн 32.2-т заасан танилцуулгын хамт энэ хуулийн 8.4-т заасан цаглабрын дагуу Улсын Их Хуралд өргөн мэдүүлнэ.*

/Энэ хэсэгт 2015 оны 01 дүгээр сарын 29-ний өдрийн хуулиар нэмэлт оруулсан/

/Энэ заалтад 2016 оны 01 дүгээр сарын 22-ны өдрийн хуулиар “Эрүүл мэндийн даатгалын сангийн төсөв,” гэсний дараа “Ирээдүйн тэтгэврийн нөөц сангийн төсөв,” гэж нэмэлт оруулсан бөгөөд 2019 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө/

/Энэ хэсэгт 2016 оны 02 дугаар сарын 05-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/

/Энэ хуульд 2016 оны 11 дүгээр сарын 10-ны өдрийн хуулиар 71.5 дахь хэсгийг нэмж, энэ хэсгийн “төсөв, Эрүүл мэндийн даатгалын сангийн төсөв, Ирээдүйн тэтгэврийн нөөц сангийн” гэснийг 2018 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөхөөр заасан/

32.2. Төсвийн төслийн танилцуулгад дараах зүйлийг тусгана:

32.2.1. макро эдийн засгийн тухайн үеийн нөхцөл байдлын үнэлгээ, ирээдүйн чиг хандлагын төсөөлөл, тооцоо;

32.2.2. макро эдийн засаг, төсвийн тогтвортой байдлыг хангах талаар Засгийн газраас тухайн жилд баримтлах бодлого, тэргүүлэх чиглэл, тэдгээрийг хэрэгжүүлэх асуудлыг төсвийн төсөлд тусгасан байдал;

32.2.3. төсвийн тэнцлийн зорилтот үзүүлэлтийг тооцсон байдал;

32.2.4. төсвийн гүйцэтгэлд нөлөөлж болзошгүй эрсдэлийн үнэлгээ;

32.2.5. төсвийн жилийн татварын зардлын тооцоог татварын орлогын нэр төрөл бүрээр, өмнөх хоёр жилийн гүйцэтгэл, дараагийн хоёр жилийн төсөөлөл;

32.2.6. хөрөнгө оруулалтын арга хэмжээний жагсаалт /нэр төрөл, санхүүжилтийн эх үүсвэрээр/;

32.2.7. санхүүжилтийг нь зогсоох болон багасгах хөтөлбөр, арга хэмжээний жагсаалт, түүний төсөвт үзүүлэх нөлөөлөл, тайлбар;

32.2.8. гадаад зээл, тусламжийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний жагсаалт /нэр төрөл, объект, үнийн дүнгээр/;

32.2.9. тусгай сангийн орлого, зарлагын тооцоо;

32.2.10. төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн төсөвт төлөх ногдол ашгийн хэмжээ;

32.2.11.төсвийн ерөнхийлөн захирагч бүрийн хэрэгжүүлэх хөтөлбөр, арга хэмжээ, түүнд шаардагдах орц, хүрэх үр дүн, гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт, тэдгээртэй холбогдсон тайлбар, танилцуулга;

32.2.12.төсвийн тусгай шаардлагад болон дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэлд нийцэж байгаа талаарх тайлбар;

32.2.13.төсвийн тусгай шаардлагыг түр баримтлахгүй тохиолдолд түүний үндэслэл, санал;

32.2.14.нэгдсэн төсвийн орлого, зарлагын үзүүлэлтийн хураангуй тайлбар;

32.2.15.төсвийн тэнцвэржүүлсэн орлогыг тооцсон байдал;

32.2.16.төсөв алдагдалтай төлөвлөгдсөн бол уг алдагдлыг санхүүжүүлэх тухай санал;

32.2.17.Засгийн газрын өрийн үлдэгдэл, төслийн зээлийн дотоод эх үүсвэрийн хэмжээ, Засгийн газраас гаргасан баталгаа, түүний дүн;

32.2.18.нэгдсэн төсвийн орлогын нэг хувиас хэтэрсэн дүнтэй тэнцэх болзошгүй өр төлбөр, түүнээс учирч болзошгүй эрсдэлийн тооцоо;

[32.2.19./Энэ заалтыг 2012 оны 10 дугаар сарын 25-ны өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон/](#)

32.2.20.төсвийн төсөлтэй холбогдуулан шийдвэрлүүлэх хууль тогтоомжийн төсөл.

33 дугаар зүйл.Улсын Их Хурал төсөв батлах

33.1.Улсын Их Хурал Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан тусгай шаардлагыг хангасан улсын төсөв, Нийгмийн даатгалын сангийн төсөв, Эрүүл мэндийн даатгалын сангийн төсөв болон *Ирээдүйн тэтгэврийн нөөц сангийн төсөв*, Хүний хөгжил сангийн төсвийг энэ хуулийн 8.4-т заасан цаглабарын дагуу хуульчлан батална.

[/Энэ хэсэгт 2015 оны 01 дүгээр сарын 29-ний өдрийн хуулиар нэмэлт оруулсан/](#)

[/Энэ заалтад 2016 оны 01 дүгээр сарын 22-ны өдрийн хуулиар “Эрүүл мэндийн даатгалын сангийн төсөв,” гэсний дараа “Ирээдүйн тэтгэврийн нөөц сангийн төсөв,” гэж нэмэлт оруулсан бөгөөд 2019 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө/](#)

[/Энэ хэсэгт 2016 оны 02 дугаар сарын 05-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/](#)

[/Энэ хуульд 2016 оны 11 дүгээр сарын 10-ны өдрийн хуулиар 71.5 дахь хэсгийг нэмж, энэ хэсгийн “төсөв, Эрүүл мэндийн даатгалын сангийн төсөв болон Ирээдүйн тэтгэврийн нөөц сангийн” гэснийг 2018 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөхөөр заасан/](#)

33.2.Төсөвт дараах зүйлийг тусгаж, батална:

33.2.1.төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяалагдах шатны төсөвтөө тухайн жилд төвлөрүүлэх орлого, харьяалах төсвийн байгууллагын өөрийн орлого;

33.2.2.төсвийн ерөнхийлөн захирагчийн тухайн жилийн төсвийн зарлагын дээд хэмжээ, урсгал болон хөрөнгийн зарлагын дээд хэмжээ, үүнээс тусгай зориулалтын шилжүүлгийн хэмжээ;

33.2.3.төсвийн алдагдлыг санхүүжүүлэх эх үүсвэр, Засгийн газрын шинээр үүсгэх өрийн дээд хэмжээ, мөнгөн гүйлгээтэй холбогдох хязгаарлалт;

/Энэ заалтад 2015 оны 02 дугаар сарын 18-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/

33.2.4.бусад шатны төсөвт олгох орлогын шилжүүлэг, санхүүгийн дэмжлэг;

33.2.5.төсвийн ерөнхийлөн захирагч бүрийн хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн талаарх чанарын болон тоо хэмжээний үзүүлэлтийг хавсралтаар;

33.2.6.хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний жагсаалтыг хавсралтаар /нэр, байршил, хүчин чадал, хэрэгжүүлэх хугацаа, төсөвт өртөг, санхүүжүүлэх эх үүсвэр, тухайн төсвийн жилийн санхүүжилтийн дүн/;

33.2.7./Энэ заалтыг 2012 оны 10 дугаар сарын 25-ны өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон/

33.2.8.төсвөөс эргэн төлөгдөх нөхцөлтэй хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний тухайн жилд санхүүжүүлэх санхүүжилтийн дээд хэмжээг нийт дүнгээр.

/Энэ заалтыг 2015 оны 01 дүгээр сарын 20-ны өдрийн хуулиар нэмсэн/

34 дүгээр зүйл.Төсвийн тодотгол

34.1.Засгийн газар дараах тохиолдолд тухайн жилийн төсвийн тодотголын төслийг боловсруулж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлнэ:

34.1.1.Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан төсвийн тусгай шаардлагыг баримтлахгүй байх нөхцөл байдал үүссэн;

34.1.2.урьдчилан тооцох боломжгүй нөхцөл байдлын улмаас төсвийн орлого буурах, зарлага нэмэгдэж, нэгдсэн төсвийн алдагдал дотоодын нийт бүтээгдэхүүний гурван хувиар нэмэгдэх;

34.1.3.энэ хуулийн 29.7-д заасан үндэслэл бий болсон тохиолдолд батлагдсан хөтөлбөр, төсөл, арга хэмжээний төсөвт өртөгт өөрчлөлт оруулах;

34.1.4.төсвийн ерөнхийлөн захирагч хооронд төсвийн зохицуулалт хийх.

34.1.5.хууль болон гэрээнд зааснаар Засгийн газрын өрийн баталгааны төлбөрийн үүргийг гүйцэтгэхэд Засгийн газрын өрийн баталгааны сангийн хөрөнгө хүрэлцэхгүй болсон.

/Энэ заалтыг 2015 оны 02 дугаар сарын 18-ны өдрийн хуулиар нэмсэн/

34.2.Засаг дарга дараах тохиолдолд тухайн жилийн төсвийн тодотголыг боловсруулж, тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд өргөн мэдүүлнэ:

34.2.1.дээд шатны төсөвт тодотгол хийсний улмаас тухайн шатны төсөвт тодотгол хийх зайлшгүй шаардлага бий болсон;

34.2.2.урьдчилан тооцох боломжгүй нөхцөл байдлын улмаас төсвийн орлого буурах, зарлага нэмэгдэж, орон нутгийн төсөв алдагдалтай болох нөхцөл байдал бий болсон;

34.2.3.энэ хуулийн 29.7-д заасан үндэслэл бий болсон тохиолдолд батлагдсан хөтөлбөр, төсөл, арга хэмжээний төсөвт өртөгт өөрчлөлт оруулах.

34.3.Тухайн жилийн төсөвт тодотгол хийж дуусах хүртэлх хугацаанд дараах хөтөлбөр, төсөл, арга хэмжээний хэрэгжилт, санхүүжилтийг түр зогсоож болно:

34.3.1.санхүүжүүлэх хэмжээ нь багасахаар, эсхүл хасагдахаар төсвийн тодотголын төсөлд тусгасан;

34.3.2.тухайн хөтөлбөр, төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхтэй холбогдсон аливаа гэрээ байгуулагдаагүй.

ЗУРГАДУГААР БҮЛЭГ ТӨСВИЙН ХЭРЭГЖИЛТ, ГҮЙЦЭТГЭЛ

35 дугаар зүйл.Төрийн сангийн нэгдсэн данс

35.1.Санхүүгийн хөрөнгийг Монголбанкинд байрших Төрийн сангийн нэгдсэн дансаар дамжуулан удирдана.

35.2.Төсвийн байгууллага нь төвлөрүүлсэн төсвийн орлого болон өөрийн үйл ажиллагааны орлогыг Төрийн сангийн нэгдсэн дансанд саадгүй байршуулна.

35.3.Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын зөвшөөрлөөр банкинд тусдаа данс нээснээс бусад тохиолдолд төсөвт хамаарах бүх гүйлгээг Төрийн сангийн нэгдсэн дансаар гүйцэтгэнэ.

35.4.Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын бичгээр ирүүлсэн зөвшөөрөлгүйгээр банк аливаа төсвийн байгууллагад данс нээхийг хориглоно.

35.5.Банкинд төрийн сангийн нэгдсэн данснаас гадуур нээсэн төсвийн байгууллагын дансанд тухайн шатны төрийн сан болон төрийн аудитын байгууллага үзлэг, хяналт хийн, энэ хуулийн 35.3-г заасан зөвшөөрөлгүйгээр нээсэн дансыг хаалгах, хөрөнгийг төрийн сангийн нэгдсэн дансанд татан төвлөрүүлнэ.

35.6.Төсвийн байгууллага төрийн сангийн нэгдсэн данснаас гадуур банкинд данс нээх, түүнийг хаахтай холбогдсон журмыг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага Монголбанкттай хамтран батална.

36 дугаар зүйл.Төрийн сангийн тогтолцоо

36.1.Төрийн сангийн тогтолцоо нь төв төрийн сан, аймаг, нийслэлийн төрийн сан, сум, дүүргийн төрийн сан, төрийн захиргааны төв байгууллагын төрийн сангийн нэгж, төсвийн нягтлан бодогч /цаашид “төрийн сан” гэх/-оос бүрдэнэ.

36.2.Төв төрийн сан нь санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад, аймаг, нийслэл, сум, дүүргийн төрийн сан нь тухайн шатны Засаг даргын Тамгын газрын дэргэд байна.

36.3.Сум, дүүрэгт үйл ажиллагаа явуулж байгаа төсвийн байгууллагын үйл ажиллагааны чиглэл болон төсвийн хэмжээг нь харгалзан төрөлжүүлж, тэдгээрт хамаарах төсвийн байгууллагуудад нягтлан бодох бүртгэлийн үйлчилгээ үзүүлэх нэгдсэн алба байгуулж болно.

36.4.Энэ хуулийн 36.3-т заасан нягтлан бодох бүртгэлийн үйлчилгээ үзүүлэх алба байгуулах асуудлыг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын зөвшөөрснөөр аймаг, нийслэлийн Засаг дарга шийдвэрлэнэ.

36.5.Энэ хуулийн 36.3-т заасан алба байгуулсан тохиолдолд төсвийн байгууллагад уг албатай давхардсан чиг үүрэг хэрэгжүүлэх орон тоо бий болгохыг хориглоно.

36.6.Төв төрийн сан нь аймаг, нийслэлийн төрийн сан болон төрийн захиргааны төв байгууллагын төрийн сангийн нэгжийн үйл ажиллагаанд, аймаг, нийслэлийн төрийн сан нь сум, дүүргийн төрийн сангийн үйл ажиллагаанд санхүүгийн дотоод хяналтыг тус тус хэрэгжүүлнэ.

37 дугаар зүйл.Төрийн сангийн нийтлэг чиг үүрэг

37.1.Төрийн сан дараах нийтлэг чиг үүргийг хэрэгжүүлнэ:

37.1.1.төсвийн хэрэгжилтийг зохион байгуулах, түүнд хяналт тавих;

37.1.2.төсвийн орлого, зарлагын өдөр тутмын гүйлгээг хийх;

37.1.3.төсвийн хяналтыг зардлын бүлэглэсэн дүнгээр хэрэгжүүлэх;

37.1.4.төсвийн зарлагын төлбөрийн дарааллыг тогтоох;

37.1.5.төсвийн гүйлгээг цахим системээр хэрэгжүүлж хяналт тавих;

37.1.6.төсвийг бараа, ажил, үйлчилгээ худалдан авах гэрээний бүртгэл болон төлбөрийн даалгавартай харьцуулж төлбөрийн амлалтыг бүртгэх;

37.1.7.төсвийн орлого, зарлага, хөрөнгө, өр төлбөрийг Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн[8] дагуу холбогдох дансанд бүртгэх, тайлагнах;

37.1.8.төсвийн сар, улирлын хуваарьт үндэслэн төсвийн байгууллагын бүртгэлийн дансанд санхүүжилтийн болон зарцуулалтын эрх олгох.

37.2.Төрийн сангийн үйл ажиллагааны журмыг Засгийн газар батална.

38 дугаар зүйл.Төв төрийн сангийн чиг үүрэг

38.1.Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага төв төрийн сангийн дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

38.1.1.төрийн сангийн нэгдсэн дансыг удирдах;

38.1.2.төрийн сангийн үйл ажиллагааны журам, зааврыг төлбөр болон орлогын гүйлгээг гүйцэтгэх журам, заавар боловсруулж хэрэгжүүлэх;

38.1.3.төрийн сангийн ажилтныг мэргэшүүлэх чиглэлээр сургалтын хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлэх;

38.1.4.төрийн сангийн үйл ажиллагааны журам, зааврыг боловсруулж хэрэгжүүлэх;

38.1.5.мөнгөн хөрөнгийн нэгдсэн удирдлагыг хэрэгжүүлэх;

38.1.6.улсын төсвийн зарлагыг тогтмол хугацаанд санхүүжүүлэх мөнгөн хөрөнгийн эх үүсвэрийг санхүүгийн зах зээлээс бүрдүүлэх;

[/Энэ заалтад 2016 оны 02 дугаар сарын 05-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/](#)

38.1.7.улсын төсвийн зарлагыг тогтмол хугацаанд санхүүжүүлэх мөнгөн хөрөнгийн эх үүсвэрийг төрийн сангийн нэгдсэн дансны хүрээнд улсын төсөв болон улсын төсвийн ерөнхийлөн захирагчид тухайн жилийн эцэст хаагдсан байхаар мөнгөн хөрөнгийн өглөг үүсгэн бүрдүүлэх;

[/Энэ заалтад 2016 оны 02 дугаар сарын 05-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/](#)

38.1.8.хөрөнгийн чөлөөт үлдэгдлийг Монголбанкаар дамжуулан богино хугацааны хөрөнгө оруулалтад оруулах асуудлыг шийдвэрлэх;

38.1.9.төсвийн захирагчид санхүүгийн үйлчилгээ үзүүлэх;

38.1.10.санхүүгийн хөрөнгө, өр төлбөрийн нэгдсэн удирдлагыг хэрэгжүүлэх;

38.1.11.нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан, мэдээг нэгтгэн боловсруулах;

38.1.12.төсвийн захирагчид төлбөр тооцооны үйлчилгээ үзүүлэх.

39 дүгээр зүйл.Засгийн газрын зарим чиг үүргийг орон

нутагт төлөөлөн хэрэгжүүлэх гэрээ

39.1.Энэ хуулийн 14.1.6, 14.1.8-д заасан төсвийн ерөнхийлөн захирагч нь аймаг, нийслэлийн Засаг даргатай энэ хуулийн 61.1-д заасан чиг үүргийг орон нутагт төлөөлөн хэрэгжүүлэх гэрээг улсын төсөв батлагдсанаас хойш ажлын 14 өдрийн дотор байгуулна.

39.2.Аймаг, нийслэлийн Засаг дарга сум, дүүргийн Засаг даргатай энэ хуулийн 39.1-д заасан гэрээг сум, дүүргийн түвшинд аймаг, нийслэлийн төсөв батлагдсанаас хойш ажлын 14 өдрийн дотор байгуулна.

39.3.Энэ хуулийн 39.1, 39.2-т заасан гэрээнд дараах нөхцөлийг заавал тусгана:

39.3.1.зарлагын зориулалт;

39.3.2.үйлчилгээний стандартыг хангахад шаардагдах санхүүжилтийг тодорхойлоход ашигласан тоон болон чанарын шалгуур үзүүлэлт;

39.3.3.санхүүгийн болон гүйцэтгэлийн мэдээллийг тайлагнахад тавигдах шаардлага.

39.4.Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга энэ хуулийн 61.1-д заасан чиг үүргийг төлөөлөн хэрэгжүүлэхэд дараах шаардлага тавигдана:

39.4.1.тусгай зориулалтын шилжүүлгийг орон нутгийн төсвийн суурь зарлага болон бусад салбарын санхүүжилтэд шилжүүлэхгүй байх;

39.4.2.өр, авлага үүсгэхгүй байх;

39.4.3.үйлчилгээний стандарт, тоо хэмжээ, чанар, хүртээмжийг бууруулахгүй байх.

39.5.Энэ хуулийн 39.1, 39.2-т заасан гэрээний биелэлтийг холбогдох төсвийн ерөнхийлөн захирагч хагас, бүтэн жилээр дүгнэж, дотоод аудит хийнэ.

40 дүгээр зүйл.Үр дүнгийн гэрээ

40.1.Төсвийн шууд захирагч болон төсвийн төвлөрүүлэн захирагч нь харьяалагдах дээд шатныхаа төсвийн захирагчтай төсвийн жил эхлэхээс өмнө үр дүнгийн гэрээ байгуулна.

40.2.Энэ хуулийн 40.1-д заасан үр дүнгийн гэрээнд байгууллагын төсвийн жилд хэрэгжүүлэх хөтөлбөр, арга хэмжээ, тэдгээрийн төсөв, хүрэх үр дүн, түүнийг дүгнэх талаар тусгасан байна.

40.3.Үр дүнгийн гэрээний биелэлтийг харьяалагдах дээд шатны төсвийн захирагч нь хагас, бүтэн жилээр дүгнэнэ.

40.4.Үр дүнгийн гэрээний биелэлт, хэрэгжилтийн явц байдалд үндэслэн үр дүнгийн гэрээг дүгнэх эрх бүхий этгээд нь дараах арга хэмжээг авна:

40.4.1.төсвийн үр дүнг сайжруулах, хэрэгжилтийг эрчимжүүлэх талаар үүрэг өгч, хяналт тавьж ажиллах;

40.4.2.хуульд заасан бүрэн эрхийнхээ хүрээнд урамшуулах, хариуцлага тооцох.

40.5.Төсвийн ерөнхийлөн захирагч энэ хуулийн 40.1-д заасан үр дүнгийн гэрээний биелэлтийг дүгнэхдээ шилэн дансны тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг харгалзана.

/Энэ хэсгийг 2014 оны 07 дугаар сарын 01-ний өдрийн хуулиар нэмсэн/

41 дүгээр зүйл.Төсвийн хэрэгжилтийг зохион байгуулах

41.1.Батлагдсан төсвийг хэрэгжүүлэх нарийвчилсан хуваарь, төсвийн дэлгэрэнгүй хуваарилалт, төсвийн зарцуулалт болон бүрдүүлэлтэд тавих хяналтыг төсвийн сар, улирлын батлагдсан хуваарийн дагуу хэрэгжүүлнэ.

41.2.Бүх шатны төсвийн захирагч төсвийн хэрэгжилтийн талаар дараах үүрэг хүлээнэ:

41.2.1.хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх;

41.2.2.батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргах;

41.2.3.төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнах;

41.2.4.төсвийн сар, улирлын хуваарийг баримталж ажиллах;

41.2.5.энэ хуулийн 37.1.8-д заасан эрхийн хүрээнд төсвийн байгууллагын зардлыг санхүүжүүлэх;

41.2.6.төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр худалдан авах бараа, ажил, үйлчилгээний гүйцэтгэлийн санхүүжилтийг бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны гэрээ, төлбөрийн хуваарийг үндэслэн санхүүжүүлэх;

41.2.7.хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт тавих, хүрэх үр дүнг хангаж ажиллах.

41.3.Төсвийн сар, улирлын хуваарийг төсвийн ерөнхийлөн захирагчийн саналыг үндэслэн энэ хуулийн 11 дүгээр зүйл, 65.1, 66.1-д заасан эрх бүхий этгээд баталж, мөрдүүлнэ.

41.4.Төсвийн жил эхлэхэд төсөв батлагдаагүй байх нөхцөл байдал үүсвэл төсөв батлагдах хүртэл төсвийн санхүүжилтийн түр горимыг энэ хуулийн 41.6-д заасан эрх бүхий этгээд тогтоож, төсвийн зарлагыг дараах байдлаар санхүүжүүлнэ:

41.4.1.төсвийн байгууллагад ажилтны цалинг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээгээр нь;

41.4.2.нийгмийн халамжийн болон нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмжийг доод хэмжээгээр нь;

41.4.3.Засгийн газрын нөөц сан, Засаг даргын нөөц хөрөнгийг өмнөх оны түвшинд;

41.4.4.батлан хамгаалах, эрүүл мэнд, боловсрол, хил хамгаалах, үндэсний аюулгүй байдлыг хангах, шүүх, прокурорын байгууллага, цагдаа, онцгой байдал, татвар, гааль, мэргэжлийн хяналт болон бусад төрийн захиргааны байгууллагын үндсэн үйл ажиллагааны урсгал зардлыг өмнөх оны түвшинд;

[/Энэ заалтад 2014 оны 01 дүгээр сарын 16-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/](#)

41.4.5.энэ хуулийн 41.4.4-т зааснаас бусад төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны урсгал төсвийг тэдгээрийн өмнөх оны урсгал төсвийн 50 хувиар;

41.4.6.Засгийн газрын зээлийн үндсэн болон хүүгийн төлбөрийг уг зээлийн гэрээнд заасан хугацаа, төлбөрийн хэмжээг баримтлан.

41.5.Доод шатны төсөвт хамаарах үйл ажиллагааны энэ хуулийн 41.4-т заасан санхүүжилтийн дутагдлыг санхүүжүүлэх зорилгоор дээд шатны төсвөөс богино хугацааны зээл олгож болно.

41.6.Санхүүжилтийн түр горим, түүнийг хэрэгжүүлэх төсвийн сар улирлын хуваарийг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, эсхүл аймаг, нийслэлийн Засаг дарга тогтоон, мөрдүүлнэ.

41.7.Төсвийн байгууллагын батлагдсан төсөв, өөрийн орлого, зарлагын хэмнэлт, тэдгээрийн зарцуулалт, гүйцэтгэлийн ил тод байдлыг хангах, олон нийт, байгууллагын хамт олонд нээлттэй байх шаардлага, нөхцөлийг тогтоосон журмыг Засгийн газар батална.

42 дугаар зүйл.Төсвийн захирагчийн төсөвт зохицуулалт хийх

42.1.Төсвийн ерөнхийлөн захирагч хоорондын төсвийн зохицуулалтыг зөвхөн тухайн жилийн төсөвт тодотгол хийж шийдвэрлэнэ.

42.2.Төсвийн захирагч төсөвтөө дараах байдлаар зохицуулалт хийж болно:

42.2.1.төсвийн ерөнхийлөн захирагч нь:

42.2.1.а.өөрийн төсвийн багцад хамаарах хөтөлбөр хооронд;

42.2.1.б.түүнд шууд харьяалагдах төвлөрүүлэн захирагчдын төсөв хооронд;

42.2.1.в.төсвийн төвлөрүүлэн захирагч болон төсвийн шууд захирагчдын төсөв хооронд;

42.2.1.г.түүнд шууд харьяалагдах төсвийн шууд захирагчдын төсөв хооронд.

42.2.2.төсвийн төвлөрүүлэн захирагч нь түүнд хамаарах төсвийн шууд захирагчдын төсөв хооронд;

42.2.3.төсвийн шууд захирагч нь зөвхөн өөрийн урсгал зардалд.

42.3.Төсвийн шууд захирагчийн төсөвтөө зохицуулалт хийх асуудлыг дараах байдлаар шийдвэрлэнэ:

42.3.1.төсвийн захирагч нь төсөвт зохицуулалт хийх саналаа харьяалагдах төсвийн төвлөрүүлэн захирагчид, төсвийн төвлөрүүлэн захирагчид харьяалагддаггүй бол төсвийн ерөнхийлөн захирагчид хүргүүлэх;

42.3.2.төсвийн төвлөрүүлэн захирагч нь саналаа харьяалагдах төсвийн ерөнхийлөн захирагчид хүргүүлэх;

42.3.3.зохицуулалт хийх санал нь улсын төсөв, Нийгмийн даатгалын сангийн төсөв, Эрүүл мэндийн даатгалын сангийн төсөв, Ирээдүйн тэтгэврийн нөөц сангийн төсөвт хамаарахаар бол төсвийн ерөнхийлөн захирагч нь саналаа санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад, орон нутгийн төсөвт хамаарахаар бол саналаа аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг даргад тус тус хүргүүлэх;

[/Энэ заалтад 2015 оны 01 дүгээр сарын 29-ний өдрийн хуулиар нэмэлт оруулсан/](#)

[/Энэ заалтад 2016 оны 01 дүгээр сарын 22-ны өдрийн хуулиар “Эрүүл мэндийн даатгалын сангийн төсөв,” гэсний дараа “Ирээдүйн тэтгэврийн нөөц сангийн төсөв,” гэж нэмэлт оруулсан бөгөөд 2019 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө/](#)

[/Энэ заалтад 2016 оны 02 дугаар сарын 05-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/](#)

[/Энэ хуульд 2016 оны 11 дүгээр сарын 10-ны өдрийн хуулиар 71.5 дахь хэсгийг нэмж, энэ заалтын “төсөв, Эрүүл мэндийн даатгалын сангийн төсөв, Ирээдүйн тэтгэврийн нөөц сангийн” гэснийг 2018 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөхөөр заасан/](#)

42.3.4.энэ хуулийн 42.3.3-т заасан байгууллага, эсхүл албан тушаалтан нь энэ хуулийн 42.2-т заасан төсвийн ерөнхийлөн захирагчдын саналыг хянаж, зөвшөөрсний дагуу төсвийн сар, улирлын хуваарьт өөрчлөлт оруулан шийдвэрлэх.

42.4.Энэ хуулийн 42.2-т заасан төсвийн зохицуулалтыг хийхэд дээд шатны төсвийн захирагчийн зөвшөөрлийг авна.

42.5.Энэ хуулийн 15.2-т заасан төсвийн төвлөрүүлэн захирагч нь түүнд харьяалагдах төсвийн шууд захирагчийн төсөвт зохицуулалт хийх асуудлыг өөрийн баталсан төсвийн сар, улирлын хуваарьт өөрчлөлт оруулан шийдвэрлэнэ.

42.6.Төсвийн захирагчийн төсөвт зохицуулалт хийх хязгаар, нөхцөл, журмыг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

42.7.Төсөвт зохицуулалт хийхдээ хөрөнгийн болон урсгал зардлыг хооронд нь шилжүүлэх, төсөвт тусгагдаагүй шинэ хөтөлбөр, арга хэмжээг санхүүжүүлэхийг хориглоно.

43 дугаар зүйл.Төсвийн жил дамжин хэрэгжих

арга хэмжээний зохицуулалт

43.1.Тухайн төсвийн жилд ашиглагдаагүй төсвийн дараах үлдэгдлийг төсвийн дараагийн жилд үргэлжлүүлэн зарцуулж болно:

43.1.1.Засгийн газрын өрийн бичиг, зээлийн үндсэн болон хүүгийн төлбөр;

~~43.1.2.төсөл, арга хэмжээний онцлогөө шалтгаалан түүнийг хэрэгжүүлэх мөчлөг нь төсвийн жилээ зөрүүтэй хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний төсөв;~~

[/Энэ заалтыг 2013 оны 11 дүгээр сарын 07-ны өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон/](#)

43.1.3.Улсын Их Хурлаас соёрхон баталсан, Засгийн газар хоорондын гэрээгээр болон олон улсын байгууллагын хөнгөлөлттэй зээлээр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний төсөв;

~~43.1.4.энэ хуулийн 44.6-д зааснаас бусад төсвийн урамшуулал;~~

[/Энэ заалтыг 2016 оны 11 дүгээр сарын 10-ны өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон/](#)

43.1.5.төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан тусламж, хандив.

43.2.Зарцуулах эрх нь дараагийн төсвийн жилд дамжсан, энэ хуулийн 43.1.3-т зааснаас бусад төсвийн нийт дүн нь төсвийн ерөнхийлөн захирагчийн тухайн жилийн төсвийн гурван хувиас хэтрэхгүй бөгөөд түүнээс давсан хэсгийг тухайн шатны төсвийн ерөнхий дансанд татан төвлөрүүлнэ.

43.3.Төсвийн жил дуусахад Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд^[9] заасан эргэлтийн сангийн үлдэгдэл хөрөнгийг төсөвт татан төвлөрүүлэх асуудлыг энэ хуулийн 18.6-д заасны дагуу шийдвэрлэх бөгөөд тухайн хөрөнгийг дараагийн жилийн батлагдсан төсвийн дагуу зарцуулна.

~~43.4.Төсвийн захирагч нь энэ хуулийн 43.1.2-т заасан төсвийг дараагийн төсвийн жилийн 3 дугаар сарын 31-ний өдөр хүртэлх хугацаанд зарцуулах эрхтэй.~~

[/Энэ хэсгийг 2013 оны 11 дүгээр сарын 07-ны өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон/](#)

43.5.Төсвийн захирагч нь энэ хуулийн 43.1.3, 43.1.5-д зааснаас бусад төсвийг хоёр төсвийн жил дамжуулан зарцуулахгүй.

43.6.Төсөв зарцуулах эрхийг дараагийн төсвийн жилд шилжүүлсэн нь батлагдсан төсвөөр хэрэгжүүлэх хөтөлбөр, арга хэмжээний тухайн жилд хүрэх үр дүнгийн зорилтот түвшинг бууруулах үндэслэл болохгүй.

44 дүгээр зүйл.Туслах үйл ажиллагаа

44.1.Төсвийн байгууллага дараах шаардлагыг хангасан тохиолдолд туслах үйл ажиллагаа явуулж, орлого олж болно:

44.1.1.төсвийн ерөнхийлөн захирагч урьдчилан бичгээр зөвшөөрсөн байх;

44.1.2.туслах үйл ажиллагаанаас алдагдал учирвал түүнийг нөхөх төсвийн бус эх үүсвэрийг төлөвлөсөн байх;

44.1.3.санхүүгийн тайлан болон үр дүнгийн гэрээнд уг үйл ажиллагааны талаар зохих ёсоор тусгасан байх;

44.1.4.байгууллагын хөрөнгийг зориулалт бусаар ашиглаагүй, ажилтныг үүрэгт ажлаас нь хөндийрүүлээгүй байх;

44.1.5.туслах үйл ажиллагаа эрхлэх нь тухайн төсвийн байгууллагын чиг үүрэг, үндсэн үйл ажиллагаанд харшлахгүй байх.

44.2.Туслах үйл ажиллагааны зардалд тухайн үйл ажиллагааг эрхлэхтэй холбогдсон шууд болон шууд бус бүх төрлийн зардал, өглөг, санхүүгийн үүргийг оруулж тооцно.

44.3.Үндсэн үйл ажиллагааны зардлаас туслах үйл ажиллагаанд зориулж шууд болон шууд бусаар хөрөнгө зарцуулахыг хориглоно.

44.4.Туслах үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг төсвийн жилийн дундуур авсан бол түүний төсвийг нэмэлт төсөв хэлбэрээр, бусад тохиолдолд тухайн жилийн төсөвт тусган хэрэгжүүлнэ.

44.5.Туслах үйл ажиллагааны үр дүнд бий болох ашгийг дараах зүйлд зарцуулна:

44.5.1.тухайн байгууллагын үндсэн үйл ажиллагааны төсвийн санхүүжилтийг бууруулах;

44.5.2.тухайн салбар болон байгууллагын үйл ажиллагааг дэмжих зориулалт бүхий хөрөнгө оруулалт хийх;

44.5.3.тухайн салбар болон байгууллагын ажиллагчдын нийгмийн асуудлыг шийдвэрлэх.

44.6.Үлдэгдэл ашгийг төсвийн жилийн эцэст тухайн шатны төсвийн ерөнхий дансанд татан төвлөрүүлнэ.

[/Энэ хэсгийг 2016 оны 11 дүгээр сарын 10-ны өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон/](#)

44.7.Туслах үйл ажиллагааны үр дүнд бий болсон ашгийг энэ хуулийн 44.5.2, 44.5.3-т заасан зориулалтаар зарцуулахтай холбогдсон харилцааг энэ хуулийн 46 дугаар зүйлд заасны дагуу зохицуулна.

45 дугаар зүйл. Төсвийн зарлагын хэмнэлт

45.1. Төсвийн захирагчийн төсвийн дараах зарцуулагдаагүй үлдэгдлийг төсвийн зарлагын хэмнэлтэд тооцно:

45.1.1. урсгал төсвөөр хэрэгжүүлэх бараа, ажил, үйлчилгээ худалдан авах үйл ажиллагааны үед нэгжид ногдох өртөг, үнэ нь буурсны улмаас бий болсон үлдэгдлийг;

45.1.2. төсвийн байгууллагын үйл ажиллагааны зардлын үр ашгийг нэмэгдүүлж, чанарыг бууруулахгүйгээр нэгжид ногдох өртөг, зардлыг бууруулснаас бий болох үлдэгдлийг;

45.1.3. нэгжид ногдох норм, нормативаар тооцон төсвийг нь баталсан төсөл, арга хэмжээ, үйл ажиллагааны чанарыг бууруулахгүйгээр нэгжийн өртөг, зардлыг бууруулснаас бий болох үлдэгдлийг.

45.1.4. техник, технологийн өөрчлөлт хийх зэргээр барилга байгууламж, тоног төхөөрөмжийн ашиглалтын зардлыг бууруулснаас бий болсон үлдэгдэл;

[/Энэ заалтыг 2016 оны 11 дүгээр сарын 10-ны өдрийн хуулиар нэмсэн/](#)

45.1.5. энэ хуулийн 14.2.12, 16.5.9-т заасны дагуу зохион байгуулалтын бүтцийг шинэчлэн тогтоосны улмаас орон тоо буурсан бол түүнд ногдох цалин хөлс, бусад урсгал зардлын үлдэгдэл;

[/Энэ заалтыг 2016 оны 11 дүгээр сарын 10-ны өдрийн хуулиар нэмсэн/](#)

45.1.6. төлөвлөсөн хөтөлбөр, арга хэмжээг хүрэх үр дүн чанарыг нь бууруулахгүйгээр илүү үр ашигтай, оновчтой хувилбараар зохион байгуулснаар бий болсон үлдэгдэл.

[/Энэ заалтыг 2016 оны 11 дүгээр сарын 10-ны өдрийн хуулиар нэмсэн/](#)

45.2. Төсвийн захирагчийн төсвийн дараах зарцуулагдаагүй үлдэгдлийг төсвийн хэмнэлтэд тооцохгүй бөгөөд тухайн үлдэгдлийг тухайн шатны төсвийн ерөнхий дансанд төвлөрүүлнэ:

45.2.1. нэгжид ногдох норм, нормативаар тооцон төсвийг нь баталсан ба гүйцэтгэл нь анх тооцсон нэгжийн тоо хэмжээнээс бага бол;

45.2.2. төлөвлөсөн төсөл, арга хэмжээ хэрэгжээгүйн улмаас, эсхүл тоо хэмжээ нь буурснаас бий болсон үлдэгдэл;

45.2.3. хөрөнгө оруулалтын худалдан авах үйл ажиллагааны үед нэгжид ногдох өртөг, үнэ, тоо хэмжээ нь буурснаас бий болсон үлдэгдэл;

45.2.4. төсвийн байгууллага нь батлагдсан тооноос дутуу орон тоогоор ажилласнаас бий болсон төсвийн үлдэгдэл.

46 дугаар зүйл. Төсвийн зарлагын хэмнэлт, үндсэн үйл ажиллагааны

нэмэлт орлогыг зарцуулах журам

46.1.Төсвийн захирагч төсвийн зарлагын хэмнэлт, үндсэн үйл ажиллагааны нэмэлт орлогыг төсвийн үр ашгийг сайжруулах зорилгоор тухайн төсвийн жилд захиран зарцуулж болно.

46.2.Энэ хуулийн 46.1-д заасан төсвийг зарцуулах, тайлагнах, нягтлан бодох бүртгэлд тусгах, хяналт тавих журмыг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

46.3.Төсвийн зарлагын хэмнэлт, үндсэн үйл ажиллагааны нэмэлт орлогыг төсвийн хүлээгдэж байгаа гүйцэтгэлд үндэслэн дараахь арга хэмжээнд зарцуулж болно:

46.3.1.эх үүсвэр дутагдаж байгаа, эсхүл өр төлбөр үүссэн үндсэн үйл ажиллагааны урсгал зардлыг санхүүжүүлэх;

46.3.2.байгууллагын хамт олон, ажилтныг ажлын үр дүнг нь харгалзан урамшуулах;

46.3.3.нийт ажилтны нийгмийн асуудлыг шийдвэрлэх;

46.3.4.тухайн салбар болон байгууллагын үйл ажиллагааг дэмжих зориулалт бүхий хөрөнгө оруулалт хийх.

46.4.Энэ хуулийн 46.3.2, 46.3.3-т заасан урамшууллыг хуваарилах асуудлыг байгууллагын нийт ажилтныг оролцуулсан хамт олны хурлаар хэлэлцэн, шийдвэрлэх бөгөөд хамт олны хурлын тэмдэглэл болон шийдвэрийг үндэслэн тухайн шатны төрийн сан зарцуулах эрх олгоно.

46.5.Төсвийн зарлагын хэмнэлт, үндсэн үйл ажиллагааны нэмэлт орлогыг дараахь арга хэмжээнд зарцуулахыг хориглоно:

46.5.1.байгууллагын хэвийн үйл ажиллагааг алдагдуулах дараахь тохиолдолд:

46.5.1.а.ажилтны цалин хөлсийг хуульд заасан хугацаанд олгох боломжгүй байдалд хүрсэн;

46.5.1.б.төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг бууруулсан.

46.5.2.төсвийн жилд, эсхүл дараалсан хоёр улирлын төсвийн гүйцэтгэлийн тайлангаар өр төлбөр үүсгэх;

46.5.3.зочин төлөөлөгч хүлээн авах, гадаад томилолтын зардлыг санхүүжүүлэх;

46.5.4.байнгын орон тоо, шинэ бүтэц бий болгох замаар урсгал зардал нэмэгдүүлэх.

/Энэ зүйлийг 2016 оны 11 дүгээр сарын 10-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан/

47 дугаар зүйл.Нэмэлт төсөв

47.1.Төсвийн захирагч нь дараах нэмэлт төсвийг холбогдох төсөл, арга хэмжээнд зарцуулж болно:

47.1.1.төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж;

47.1.2.төсвийн жилийн явцад Улсын Их Хурлаас соёрхон баталсан, Засгийн газар хоорондын гэрээ болон олон улсын байгууллагаас авах хөнгөлөлттэй зээл;

47.1.3.Засгийн газрын нөөц сан, Засаг даргын нөөц хөрөнгө, түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс зохих байгууллагын шийдвэрийн дагуу тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө;

47.1.4.дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө;

47.1.5.төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого;

~~47.1.6.төсвийн урамшуулал.~~

/Энэ заалтыг 2016 оны 11 дүгээр сарын 10-ны өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон/

47.2.Нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна.

47.3.Энэ хуулийн 47.1.2, 47.1.6-д заасан орлогыг зөвхөн батлагдсан төсвийн хүрээнд зарцуулна.

/Энэ хэсэгт 2016 оны 11 дүгээр сарын 10-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/

ДОЛДУГААР БҮЛЭГ ӨМЧ ХӨРӨНГӨ, БОЛЗОШГҮЙ ӨР ТӨЛБӨР

/Энэ бүлгийн гарчигт 2015 оны 02 дугаар сарын 18-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/

48 дугаар зүйл.Өмч хөрөнгө

48.1.Төрийн болон орон нутгийн өмч, хөрөнгийн удирдлага, зохицуулалт, зарцуулалт, бүртгэл, тайлагналттай холбоотой харилцааг тусгай хуулиар зохицуулна.

49 дүгээр зүйл.Засгийн газар ор үүсгэж

49.1.Засгийн газар дараах зорилгоор ор үүсгэж болно:

49.1.1.Засгийн газрын төсөл, хотөлбөрийг санхүүжүүлэх;

49.1.2.улеын төлбөрийн тэнцлийг дэмжих зорилгоор Монголбанкны гадаад цэвэр албан нооцийг нэмэгдүүлэх;

49.1.3.төсвийн алдагдлыг санхүүжүүлэх;

49.1.4.хүүгийн хэмжээ болон зардлыг бууруулах зорилгоор орийг дахин санхүүжүүлэх;

49.1.5.улеын төсвийн улирлын чанартай орлогын дутагдлыг санхүүжүүлэх.

49.2.Энэ хуулийн 49.1.4 т заасны дагуу орийг дахин санхүүжүүлэхдээ түүний хугацааг сунгахыг хориглоно.

49.3.Ор үүсгэж бүрдүүлсэн эх үүсвэрийг зөвхон төсөвт тусган, баталсан хотөлбөр, төсөл, арга хэмжээг санхүүжүүлэхэд зарцуулна.

/Энэ зүйлийг 2015 оны 02 дугаар сарын 18-ны өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон/

50 дугаар зүйл.Засгийн газар зээл өлгөж

50.1.Тухайн жилийн төсвийн хуулиар эх үүсвэр нь батлагдсан тохиолдолд улеын төсөөе дараах зорилгоор зээл өлгөж болно:

50.1.1.аймаг, нийслэлийн төсвийн улирлын чанартай орлогын дутагдлыг санхүүжүүлэх;

50.1.2.Засгийн газрын тусгай сангаас хуульд заасан зориулалтаар;

50.1.3.гадаад уле, олон улеын байгууллагаас авсан зээлийг зориулалтын дагуу дамжуулан зээлдүүлэх.

50.2.Ор үүсгэж бүрдүүлсэн эх үүсвэрийг зөвхон төсөвт тусган, баталсан хотөлбөр, төсөл, арга хэмжээг санхүүжүүлэхэд зарцуулна.

/Энэ зүйлийг 2015 оны 02 дугаар сарын 18-ны өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон/

51 дүгээр зүйл.Засгийн газрын баталгаа

51.1.Засгийн газар хуульд заасан үндэслэлээр орийн баталгаа гаргаж болно.

~~51.2.Эх үүсвэр нь тухайн жилийн төсвийн хуулиар батлагдсан тохиолдолд энэ хуулийн 51.1-д заасан баталгааг олгоно.~~

~~51.3.Засгийн газрын баталгаа нь төсвийн бүрэлдэхүүн хэсэг байна.~~

~~51.4.Тухайн жилийн төсөвт тусган, баталсан хүүрэнд Засгийн газраас гаргах өрийн баталгааг Засгийн газрын өргөн мэдүүлэнээр Улсын Их Хурал хэлэлцэн батална.~~

[/Энэ зүйлийг 2015 оны 02 дугаар сарын 18-ны өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон/](#)

52 дугаар зүйл.Болзошгүй өр төлбөр

52.1.Засгийн газрын болзошгүй өр төлбөрийн талаарх мэдээллийг Улсын Их Хурал болон нийтэд мэдээлнэ.

52.2.Засгийн газрын болзошгүй өр төлбөрийн талаарх мэдээллийг жилийн болон тодотгосон төсвийн төсөл, төсвийн хагас болон бүтэн жилийн гүйцэтгэлийн тайланд бүрэн тусгана.

52.3.Болзошгүй өр төлбөр, өрийн баталгаа, тэдгээртэй холбогдсон мэдээлэлд төрийн аудитын төв байгууллага хяналт тавьж, дүгнэлт гаргана.

52.4.Болзошгүй өр төлбөр, зээлийн баталгаа, эдгээрээс учирч болзошгүй эрсдэл, төлбөрийн хэмжээг тооцон мэдээлснийг тэдгээрийг хүлээн зөвшөөрч, өглөг үүсгэсэнд тооцохгүй.

52.5.Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь болзошгүй өр төлбөрийн бүртгэл, хяналт, зохицуулалт, судалгаа болон магадлал, төсвөөс гарч болох зардлын хэмжээг тооцон бүртгэж, дүгнэлт гаргах, мэдээлэх чиг үүргийг гүйцэтгэнэ.

[/Энэ хэсгийг 2015 оны 02 дугаар сарын 18-ны өдрийн хуулиар нэмсэн/](#)

52.6.Болзошгүй өр төлбөрийн талаар дараах мэдээллийг холбогдох этгээд санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад нэн даруй ирүүлэх үүрэгтэй:

52.6.1.Засгийн газрын тусгай сангийн үүсгэсэн өр;

52.6.2.төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмч давамгайлсан хуулийн этгээдийн өр;

52.6.3.Концессын тухай хуульд заасны дагуу гаргасан баталгаа;

52.6.4.Засгийн газрын өрийн баталгаа гаргасан зээллэгийн хөрөнгөөр хэрэгжүүлж байгаа төсөл, арга хэмжээ;

52.6.5.болзошгүй өр төлбөрт хамаарах болон санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас шаардсан холбогдох бусад мэдээлэл.

[/Энэ хэсгийг 2015 оны 02 дугаар сарын 18-ны өдрийн хуулиар нэмсэн/](#)

52.7.Болзошгүй өр төлбөрийн хүрээнд улсын төсвөөс тухайн төлбөрийг гүйцэтгэх эрсдэл үүссэн бол тухайн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнтэй зөвшилцсөний үндсэн дээр Засгийн газар, Улсын Их Хуралд танилцуулж, шийдвэрлүүлнэ.

/Энэ хэсгийг 2015 оны 02 дугаар сарын 18-ны өдрийн хуулиар нэмсэн/

53 дугаар зүйл.Засгийн газрын өрийн удирдлага

~~53.1.Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага Засгийн газрын өрийн удирдлагыг дараах байдлаар хэрэгжүүлнэ:–~~

~~53.1.1.Засгийн газрын санхүүгийн хэрэгцээ, эрдэлийн үнэлгээг үндэслэн өрийн удирдлагын стратеги боловсруулж, хэрэгжүүлэх;~~

~~53.1.2.Засгийн газрын өрийн удирдлагын зорилт, өрийн хэмжээ, бүтэц, эрдэлийг богино, дунд хугацаагаар тодорхойлж, удирдан зохицуулах;~~

~~53.1.3.тухайн жилийн төсвийн хуулиар Засгийн газрын шинээр үүсгэх өр, баталгааны дээд хязгаарыг батлуулж мөрдөх;~~

~~53.1.4.төрийн өмчит болон төрийн өмчийн 51, түүнээс дээш хувийн оролцоотой хуулийн этгээдийн авах зээлийн хэмжээний дээд хязгаарыг тогтоох;~~

~~53.1.5.аймаг, нийслэлийн Засаг даргын улсын төсвөөс авах өрийн хэмжээний дээд хязгаарыг тогтоох;~~

~~53.1.6.Засгийн газрын өр болон өрийн баталгааны мэдээллийн санг бүрдүүлэх;~~

~~53.1.7.Засгийн газрын өрийн мэдээллийн ил тод байдлыг хангах;~~

~~53.1.8.зээлдүүлэгчийн эрх тэгш байдлыг хангах.~~

/Энэ хэсгийг 2015 оны 02 дугаар сарын 18-ны өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон/

53.2.Хөрөнгө, өр төлбөрийн удирдлага, Засгийн газрын зээл авах, зээл олгох, дамжуулан зээлдүүлэх, өрийн баталгаа гаргах, тэдгээрт тавигдах шаардлага, нөхцөл, хязгаарлалт, болзошгүй өр төлбөрийн удирдлагыг хэрэгжүүлэхтэй холбогдсон харилцааг хуулиар зохицуулна.

НАЙМДУГААР БҮЛЭГ ТӨСВИЙН ТАЙЛАГНАЛТ

54 дүгээр зүйл.Санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлан

54.1.Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайланд улс, орон нутгийн төсвийн санхүүгийн тайлан, төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төрийн болон орон

нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн санхүүгийн тайлан хамаарна.

54.2.Төсвийн ерөнхийлөн захирагч өөрийн эрхлэх асуудлын хүрээний төсвийн байгууллагын санхүүгийн тайлан, Засгийн газрын шугамаар авч, ашиглаж байгаа хөнгөлөлттэй зээл болон буцалтгүй тусламжийн хөрөнгөөр хэрэгжиж байгаа төсөл, хөтөлбөрийн санхүүгийн тайлан, төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн санхүүгийн тайланг санхүүгийн нэгтгэсэн тайланд хамааруулна.

54.3.Төсвийн ерөнхийлөн захирагч нь төсвийн гүйцэтгэл болон жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайланг нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу гаргана.

54.4.Санхүүгийн нэгтгэсэн тайлан нь дараах бүрэлдэхүүнтэй байна:

54.4.1.үйл ажиллагааны үр дүнгийн тайлан;

54.4.2.санхүүгийн байдлын тайлан;

54.4.3.мөнгөн гүйлгээний тайлан;

54.4.4.өмчийн өөрчлөлтийн тайлан;

54.4.5.санхүүгийн тайлангийн тодруулга.

54.5.Төсвийн гүйцэтгэлийн тайлан нь дараах бүрэлдэхүүн хэсэгтэй байна:

54.5.1.тухайн жилийн төсвийн орлого, зарлагын гүйцэтгэл /нийт дүнгээр, хөтөлбөрөөр, төсвийн захирагчаар, хөрөнгө оруулалтын арга хэмжээ бүрээр/;

54.5.2.татварын зарлагыг хуулийн этгээд, салбар бүрээр, холбогдох эрх зүйн үндэслэлийн хамт;

54.5.3.тухайн жил худалдан авсан бараа, ажил, үйлчилгээний гүйцэтгэл;

54.5.4.хөтөлбөр, арга хэмжээнд зарцуулсан төсөв, хүрсэн үр дүн, түүний танилцуулга /хөтөлбөрийн гүйцэтгэлийн биелэлт, бодлогын зорилтын хэрэгжилт, түүний үр нөлөөнд хийсэн дүгнэлт, хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлсэн хөрөнгө оруулалтын арга хэмжээний биелэлт, тасарсан бол шалтгаан/;

54.5.5.нэмэлт төсвийн гүйцэтгэл, түүний танилцуулга.

54.5.6.Засгийн газрын өр болон Засгийн газрын өрийн баталгааны мэдээлэл.

[/Энэ заалтыг 2015 оны 02 дугаар сарын 18-ны өдрийн хуулиар нэмсэн/](#)

54.6.Энэ хуулийн 42 дугаар зүйлд заасны дагуу төсөвт зохицуулалт хийсэн тохиолдолд хөтөлбөрийн гүйцэтгэлийг анх төлөвлөсөн хүрэх үр дүнгийн зорилттой нь харьцуулсан байдлаар тайлагнана.

55 дугаар зүйл. Сонгуулийн өмнөх эдийн засаг, санхүү,

төсвийн төлөв байдлын тайлан

55.1. Монгол Улсын Ерөнхийлөгчийн болон Улсын Их Хурлын сонгуулийг зарлахаас нэг сараас доошгүй хугацааны өмнө Монгол Улсын эдийн засаг, санхүү, төсвийн төлөв байдлын талаарх мэдээллийг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага Улсын Их Хуралд ирүүлнэ.

55.2. Энэ хуулийн 55.1-д заасан мэдээллийг Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн танилцуулна.

55.3. Улсын Их Хурал энэ хуулийн 55.1-д заасан мэдээлэлтэй танилцсаны дараа санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага сонгуулийн өмнөх макро эдийн засаг, санхүү, төсвийн төлөв байдлын тайланг бэлтгэж, нийтэд мэдээлнэ.

55.4. Сонгуулийн өмнөх макро эдийн засаг, санхүү, төсвийн төлөв байдлын тайланд дараах мэдээллийг тусгасан байна:

55.4.1. Монгол Улсын Ерөнхийлөгчийн болон Улсын Их Хурлын сонгуулийн бүрэн эрхийн хугацаанд Засгийн газраас хэрэгжүүлсэн эдийн засаг, санхүү, төсвийн бодлого, үр дүн нь Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан төсвийн тусгай шаардлагыг хангасан байдал;

55.4.2. ирэх дөрвөн жилийн макро эдийн засаг, төсвийн төлөв байдлын төсөөлөл;

55.4.3. Засгийн газрын өр, болзошгүй өр төлбөрийн дүн, түүний зориулалт, нөхцөл, хугацаандаа төлөгдөөгүй зээлийн үндсэн өр ба хүүгийн төлбөрийн дүн;

55.4.4. Монгол Улсын төсвийн тогтворжуулалтын сангийн үлдэгдлийн нийт дүн, энэ нь төсвийн тогтвортой байдлыг хангаж байгаа эсэх болон дараагийн хоёр жилийн хугацаан дахь тухайн сангийн эх үүсвэрийн өөрчлөлтийн тухай үнэлгээ;

55.4.5. болзошгүй өр төлбөр;

55.4.6. Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан, хүлээгдэж байгаа арга хэмжээ, түүнд төсвөөс гаргах зардлын хэмжээ, эх үүсвэр;

55.4.7. Засгийн газрын гэрээ, хэлэлцээрт тусгагдсан, хүлээгдэж байгаа Засгийн газрын өр төлбөр, баталгааны дүн;

55.4.8. сонгуулийн жилд Засгийн газраас гаргасан шийдвэр нь дараагийн жилүүдийн санхүү, төсвийн төлөв байдалд нөлөөлөх үзүүлэлт;

55.4.9. эдийн засаг, санхүү, төсвийн дунд хугацааны төсөөлөл нь Улсын Их Хурлаар батлагдсан дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэл, эсхүл тухайн жилийн төсөв, Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан төсвийн тусгай шаардлагад нийцэж байгаа талаарх тайлбар.

55.5.Энэ хуулийн 55.4.5-55.4.8-д заасан мэдээлэл, түүний төсөвт үзүүлэх нөлөөллийг тоон илэрхийллээр харуулна.

ЕСДҮГЭЭР БҮЛЭГ ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ХАРИЛЦАА

56 дугаар зүйл.Төсвийн шатлал хоорондын харилцаа

56.1.Дээд шатны төсвөөс доод шатны төсөвт дараах хэлбэрээр шилжүүлэг олгоно:

56.1.1.доод шатны төсвийн үндсэн тэнцлийн алдагдлыг санхүүжүүлэхэд зориулан дээд шатны төсвөөс олгох санхүүгийн дэмжлэг;

56.1.2.доод шатны төсвийн хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхэд нь зориулж дээд шатны төсвөөс олгох орлогын шилжүүлэг;

56.1.3.Засгийн газрын хэрэгжүүлэх зарим чиг үүргийг орон нутаг төлөөлөн хэрэгжүүлэхэд зориулж улсын төсвөөс олгох тусгай зориулалтын шилжүүлэг.

56.2.Доод шатны төсвийн үндсэн тэнцлийн ашгаас дээд шатны төсөвт дараахь байдлаар төвлөрүүлнэ:

56.2.1.доод шатны төсвийн үндсэн тэнцлийн ашиг нь суурь зарлагаас бага болон тэнцүү тохиолдолд үндсэн тэнцлийн ашгийн 70 хувийг тухайн шатны төсөвт үлдээж, үлдэх хэсгийг дээд шатны төсөвт төвлөрүүлнэ.

56.2.2.доод шатны төсвийн үндсэн тэнцлийн ашиг нь суурь зарлагаас их тохиолдолд суурь зарлагатай тэнцэх хэсгийн 70 хувийг тухайн шатны төсөвт үлдээж, үлдэх хэсгийг дээд шатны төсөвт төвлөрүүлнэ.

[/Энэ хэсгийг 2015 оны 11 дүгээр сарын 10-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан/](#)

[/Энэ хэсгийг 2016 оны 09 дүгээр сарын 09-ний өдрийн хуулиар өөрчлөн найруулсан/](#)

56.3.Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь аймаг, нийслэлийн төсөвт, аймаг, нийслэлийн Засаг дарга нь сум дүүргийн төсөвт олгох санхүүгийн дэмжлэг, орлогын шилжүүлэг, тусгай зориулалтын шилжүүлгийг дараах зөрчил илэрсэн тохиолдолд түүнийг арилгах хүртэлх хугацаанд түр зогсоох эрхтэй:

56.3.1.төсвийн тухай хууль тогтоомж зөрчсөн;

56.3.2.иргэдийн Төлөөлөгчдийн Хурал тухайн жилийн төсвөө үндэслэлгүйгээр нэмэгдүүлж баталсан;

56.3.3.тусгай зориулалтын шилжүүлгийн зориулалт, зарцуулалтын нөхцөл, шаардлагыг зөрчсөн;

56.3.4.орон нутгийн төсвөөс санхүүжүүлэх үйлчилгээний стандартыг мөрдөөгүйгээс нийт төсөв нь алдагдалтай гарсан;

56.3.5.орон нутгийн төсвийн тогтвортой байдал алдагдсан;

56.3.6.орон нутгийн төсвийг энэ хуулиар тогтоосон хугацаанд батлаагүй.

56.4.Орон нутгийн төсвийн суурь зарлагыг тооцох аргачлал, орон нутгийн төсвөөс санхүүжүүлэх үйлчилгээний стандарт, тэдгээрийн орцын болон төсвийн нормативыг Засгийн газар тогтооно.

56.5.Энэ хуулийн 56.1.3-т заасан тусгай зориулалтын шилжүүлгийн зориулалт, зарцуулалтад тавигдах нөхцөл, шаардлагыг энэ хуулийн 39.1, 39.2-т заасан гэрээгээр тусгайлан тогтоож, Засгийн газар хяналт тавина.

56.6.Энэ хуулийн 56.3-т заасан зөрчлийг арилгах, хууль тогтоомжийн хэрэгжилт болон орон нутгийн төсвийн тогтвортой байдлыг хангах, төсвийн харилцаанд оролцогчдын чадавхийг дээшлүүлэх зорилгоор Засгийн газар болон аймаг, нийслэлийн Засаг дарга тухайн орон нутагт тогтворжуулалтын хөтөлбөр хэрэгжүүлнэ.

57 дугаар зүйл.Орон нутгийн төсөв

57.1.Орон нутгийн төсвөөр хэрэгжүүлэх чиг үүрэг, орон нутгийн төсөвт хуваарилах орлогын нэр төрлийг энэ хуулиар тогтооно.

57.2.Орон нутгийн төсвийг алдагдалгүй төлөвлөн баталж, хэрэгжүүлнэ.

57.3.Орон нутгийн төсвийн урьд оны үлдэгдлээс санхүүжүүлэх зарлагыг төсөвт тусган баталж хэрэгжүүлэх ба зарлага нь санхүүжүүлэх эх үүсвэрээсээ хэтрэхгүй байна.

57.4.Сум, дүүргийн төсвийн орлогын улирлын чанартай дутагдлыг санхүүжүүлэх зорилгоор аймаг, нийслэлийн төсвөөс богино хугацаатай зээл олгож болно.

57.5.Орон нутгийн төсөвт Өрийн удирдлагын тухай хууль болон энэ хуулийн 41.5, 57.4, 62.2-т зааснаас бусад тохиолдолд өр үүсгэх, баталгаа гаргахыг хориглоно.

[/Энэ хэсэгт 2015 оны 02 дугаар сарын 18-ны өдрийн хуулиар нэмэлт, өөрчлөлт оруулсан/](#)

58 дугаар зүйл.Орон нутгийн төсвөөр хэрэгжүүлэх чиг үүрэг

58.1.Нийслэл өөрийн төсвөөр дараах чиг үүргийг бие даан хэрэгжүүлнэ:

58.1.1.нийслэлийн удирдлагыг хэрэгжүүлэх;

58.1.2.хот төлөвлөлт, барилгажуулалт, шинээр дэд бүтэц бий болгох;

58.1.3.нийслэлийн өмчийн барилга байгууламжийн их засвар, шинээр өмч бий болгох, хөрөнгө оруулалт хийх;

58.1.4.нийгмийн асрамж, халамжийн үйлчилгээ үзүүлэх, зохион байгуулах;

58.1.5.хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ядуурлыг бууруулах хөтөлбөр, арга хэмжээг хэрэгжүүлэх;

58.1.6.жижиг, дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх;

58.1.7.бэлчээрийн менежмент хийх;

58.1.8.усан хангамж, бохир ус цэвэрлэх байгууламж бий болгох, усны аж ахуйн хөнгөлөлт, үйлчилгээ үзүүлэх;

[/Энэ заалтыг 2016 оны 09 дүгээр сарын 09-ний өдрийн хуулиар өөрчлөн найруулсан/](#)

58.1.9.орон сууц, нийтийн аж ахуйн үйлчилгээ үзүүлэх;

58.1.10.үерийн хамгаалалтыг зохион байгуулах;

58.1.11.нийтийн тээврийн үйлчилгээ үзүүлэх;

58.1.12.мал амьтны халдварт өвчинтэй тэмцэх, хортон шавжийн устгал, хяналтыг хэрэгжүүлэх, мал эмнэлгийн үйлчилгээ үзүүлэх;

[/Энэ заалтыг 2016 оны 09 дүгээр сарын 09-ний өдрийн хуулиар өөрчлөн найруулсан/](#)

58.1.13.гамшгаас урьдчилан сэргийлэх;

58.1.14.байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх;

58.1.15.нийслэлийн доторх томоохон авто зам, гүүр, тэдгээрийн гэрэлтүүлэг, гэрлэн дохио болон бусад холбогдох байгууламжийг бий болгох;

58.1.16.нийслэлийн нутаг дэвсгэрийн хэмжээнд хийгдэх том хэмжээний тохижилт, нийтийн эзэмшлийн аж ахуйн үйлчилгээ, нийтийн ариун цэвэр, гудамж талбайн гэрэлтүүлэг, цэвэрлэгээ, хог зайлуулалтыг зохион байгуулах;

58.1.17.нийслэлийн доторх өндөр хүчдэлийн болон цахилгааны шугам, дэд өртөөний ашиглалт, засвар үйлчилгээ, хэвийн үйл ажиллагааг хангахтай холбогдсон бусад үйл ажиллагааг эрхлэх;

58.1.18.хуульд заасан бусад чиг үүргийг хэрэгжүүлэх.

58.2.Аймаг өөрийн төсвөөр тухайн шатанд хамаарах дараах чиг үүргийг бие даан хэрэгжүүлнэ:

58.2.1.аймгийн удирдлагыг хэрэгжүүлэх;

58.2.2.хот төлөвлөлт, барилгажуулалт, шинээр дэд бүтэц бий болгох;

58.2.3.орон нутгийн өмчийн барилга байгууламжийн их засвар, шинээр өмч бий болгох, хөрөнгө оруулалт хийх;

58.2.4.нийгмийн асрамж, халамжийн үйлчилгээг үзүүлэх, зохион байгуулах;

58.2.5.хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ядуурлыг бууруулах хөтөлбөр, арга хэмжээг хэрэгжүүлэх;

58.2.6.жижиг, дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх;

~~58.2.7.~~

/Энэ заалтыг 2016 оны 09 дүгээр сарын 09-ний өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон/

58.2.8.аймгийн нутаг дэвсгэрийн хэмжээнд бэлчээрийн менежмент хийх;

58.2.9.малын гэжээлийн нөөц бүрдүүлэх;

58.2.10.усан хангамж, бохир ус цэвэрлэх байгууламж, орон сууц, нийтийн аж ахуй, үерийн хамгаалалтыг зохион байгуулах;

58.2.11.нийтийн тээврийн үйлчилгээ үзүүлэх;

58.2.12.мал, амьтны халдварт өвчинтэй тэмцэх, хортон шавжийн устгал, хяналт, гамшгаас урьдчилан сэргийлэх, гамшгийн хор хохирлыг арилгах, мал эмнэлгийн үйлчилгээ үзүүлэх;

/Энэ заалтыг 2016 оны 09 дүгээр сарын 09-ний өдрийн хуулиар өөрчлөн найруулсан

58.2.13.байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх;

58.2.14.аймгийн доторх болон сум хоорондын авто зам, гүүр, тэдгээрийн гэрэлтүүлэг, гэрлэн дохио болон бусад холбогдох байгууламжийг бий болгох;

58.2.15.аймгийн нутаг дэвсгэрийн хэмжээнд хийгдэх том хэмжээний тохижилт, нийтийн эзэмшлийн аж ахуйн үйлчилгээ, нийтийн ариун цэвэр, гудамж талбайн гэрэлтүүлэг, цэвэрлэгээ, хог зайлуулалтыг зохион байгуулах;

58.2.16.аймгийн доторх өндөр хүчдэлийн болон цахилгааны шугам, дэд өртөөний ашиглалт, засвар үйлчилгээ, хэвийн үйл ажиллагааг хангах бусад үйл ажиллагааг хэрэгжүүлэх;

58.2.17.хуульд заасан бусад чиг үүргийг хэрэгжүүлэх.

58.3.Дүүрэг өөрийн төсвөөр дараах чиг үүргийг бие даан хэрэгжүүлнэ:

58.3.1.дүүргийн удирдлагыг хэрэгжүүлэх;

58.3.2.дүүргийн Засаг даргын шийдвэрээр олгодог нийгмийн халамж, асрамжийн үйлчилгээг үзүүлэх, зохион байгуулах;

58.3.3.дүүргийн нутаг дэвсгэр дэх нийтийн эзэмшлийн аж ахуйн үйлчилгээ, нийтийн ариун цэвэр, гудамж талбайн гэрэлтүүлэг, цэвэрлэгээ, хог зайлуулалтыг хийх;

58.3.4.эрчимжсэн мал аж ахуйг хөгжүүлэх, мал, амьтны халдварт өвчинтэй тэмцэх, хортон шавжийн устгал, хяналт, гамшгаас урьдчилан сэргийлэх, гамшгийн хор хохирлыг арилгах, мал эмнэлгийн үйлчилгээ үзүүлэх;

/Энэ заалтыг 2016 оны 09 дүгээр сарын 09-ний өдрийн хуулиар өөрчлөн найруулсан

58.3.5.дүүргийн нутаг дэвсгэрийн байгаль орчныг хамгаалах;

58.3.6.дүүргийн доторх нийтийн эзэмшлийн гэрэлтүүлгийн урсгал засвар, арчилгааг хийх, зохион байгуулах;

58.3.7.дүүргийн тохижилт, мод, ургамал цэцэрлэгжүүлэлт, явган зам, амралт болон хүүхдийн тоглоомын талбайг тохижуулах, арчлах;

58.3.8.хуульд заасан бусад чиг үүргийг хэрэгжүүлэх.

58.4.Сум өөрийн төсвөөр дараах чиг үүргийг бие даан хэрэгжүүлнэ:

58.4.1.сумын удирдлагыг хэрэгжүүлэх;

58.4.2.сумын Засаг даргын шийдвэрээр олгодог нийгмийн халамж, асрамжийн үйлчилгээг үзүүлэх, зохион байгуулах;

58.4.3.сумын нутаг дэвсгэр дэх нийтийн эзэмшлийн аж ахуйн үйлчилгээ, нийтийн ариун цэвэр, гудамж талбайн гэрэлтүүлэг, цэвэрлэгээ, хог зайлуулалтыг хийх;

58.4.4.мал, амьтны халдварт өвчинтэй тэмцэх, хортон шавжийн устгал, хяналт, гамшгаас урьдчилан сэргийлэх, гамшгийн хор хохирлыг арилгах, мал эмнэлгийн үйлчилгээ үзүүлэх;

/Энэ заалтыг 2016 оны 09 дүгээр сарын 09-ний өдрийн хуулиар өөрчлөн найруулсан/

58.4.5.сумын нутаг дэвсгэрийн хэмжээнд бэлчээрийн менежмент хийх;

58.4.6.сумын нутаг дэвсгэрийн байгаль орчныг хамгаалах;

58.4.7.сумын доторх нийтийн эзэмшлийн гэрэлтүүлгийн урсгал засвар, арчилгааг хийх, зохион байгуулах;

58.4.8.сумын тохижилт, мод, ургамал цэцэрлэгжүүлэлт, явган зам, амралт болон хүүхдийн тоглоомын талбайг тохижуулах арчлах;

58.4.9.усан хангамж, бохир ус, цэвэрлэх байгууламж бий болгох, усны аж ахуйн хөнгөлөлт, үйлчилгээ үзүүлэх;

/Энэ заалтыг 2016 оны 09 дүгээр сарын 09-ний өдрийн хуулиар нэмсэн/

58.4.10.орон нутгийн өмчийн барилга байгууламжийн их засвар, шинээр өмч бий болгох, хөрөнгө оруулалт хийх;

/Энэ заалтыг 2016 оны 09 дүгээр сарын 09-ний өдрийн хуулиар нэмсэн/

58.4.11.хуульд заасан бусад чиг үүргийг хэрэгжүүлэх.

/Энэ заалтын дугаарт 2016 оны 09 дүгээр сарын 09-ний өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/

58.5.Энэ хуулийн 58.1-58.4-т заасан чиг үүргийг дараах эх үүсвэрээс санхүүжүүлнэ:

58.5.1.аймаг, нийслэл, сум, дүүргийн татварын болон татварын бус орлого;

58.5.2.улсын төсвөөс олгох орлогын шилжүүлэг;

58.5.3.улсын төсвөөс олгох санхүүгийн дэмжлэг.

59 дүгээр зүйл.Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан

59.1.Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан нь дараах эх үүсвэрээс бүрдэнэ:

59.1.1.импортоос бусад бараа, ажил, үйлчилгээний нэмэгдсэн өртгийн албан татварын орлогын 5 хувь;

/Энэ заалтыг 2015 оны 11 дүгээр сарын 10-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан/

/Энэ заалтад 2016 оны 09 дүгээр сарын 09-ний өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/

59.1.2.Ашигт малтмалын тухай хуулийн 47³ дугаар зүйлд зааснаас бусад ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн орлогын 5 хувь;

/Энэ заалтад 2016 оны 11 дүгээр сарын 10-ны өдрийн хуулиар нэмэлт оруулсан/

59.1.3.орон нутгийн хөгжлийг дэмжих зорилгоор олгосон дотоодын төрийн бус байгууллагын болон гадаадын албан ёсны тусламж, хандив;

59.1.4.

/Энэ заалтыг 2016 оны 09 дүгээр сарын 09-ний өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон/

59.1.5 газрын тосны нөөц ашигласны төлбөрийн орлогын 30 хувь.

/Энэ заалтыг 2014 оны 07 дугаар сарын 01-ний өдрийн хуулиар нэмсэн/

59.2.Аймаг, нийслэл нь Орон нутгийн хөгжлийн сангаас болон улсын төсвөөс олгосон шилжүүлгийг доор дурдсанаар сум дүүргийн Орон нутгийн хөгжлийн санд хуваарилна:

59.2.1.энэ хуулийн 60.11-д заасан үйлчилгээний зардалд ногдох хэсгийг сум дүүргийн Орон нутгийн хөгжлийн санд шилжүүлэх;

59.2.2.энэ зүйлийн 59.2.1-д зааснаас бусад хэсгийн 30-аас доошгүй хувийг хүн амын тоо, алслалт, нутаг дэвсгэрийн хэмжээг харгалзан хуваарилах;

59.2.3.улсын төсвөөс аймаг, нийслэлийн Орон нутгийн хөгжлийн санд энэ хуулийн 60.2.6, 60.2.7-д заасан орлогын шилжүүлгийг 60 дугаар зүйлийн 60.6, 60.7-д заасан хувь хэмжээгээр хуваарилах.

/Энэ хэсгийг 2015 оны 05 дугаар сарын 21-ний өдрийн хуулиар өөрчлөн найруулсан/

/Энэ хэсгийг 2016 оны 09 дүгээр сарын 09-ний өдрийн хуулиар өөрчлөн найруулсан/

59.3.Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас тухайн жил орон нутгийн төсөвт олгох шилжүүлгийг тодорхойлохдоо дараах итгэлцүүрийг үндэслэн тогтооно:

59.3.1.орон нутгийн хөгжлийн индекс;

59.3.2.хүн амын тоо;

59.3.3.хүн амын нягтрал, алслалт, нутаг дэвсгэрийн хэмжээ;

59.3.4.орон нутгийн татварын идэвх санаачилга.

59.4.Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийг орон нутагт хуваарилахдаа ашигт малтмалын олборлолт хийгдсэн тухайн орон нутгийн нэг хүнд ногдох хэмжээг бусад орон нутгийн нэг хүнд ногдох хэмжээнээс 10 хүртэл хувиар нэмэгдүүлэн тогтооно.

59.5.Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан болон Орон нутгийн хөгжлийн сангаас олгох шилжүүлгийг тооцох аргачлалыг Засгийн газар батална.

60 дугаар зүйл.Орон нутгийн хөгжлийн сан

60.1.Тухайн шатны төсвийн ерөнхийлөн захирагч нь орон нутгийн хөгжлийг дэмжих зорилго бүхий Орон нутгийн хөгжлийн сантай байна.

60.2.Орон нутгийн хөгжлийн сан нь дараах эх үүсвэрээс бүрдэнэ:

60.2.1.Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас олгох шилжүүлэг;

60.2.2.энэ хуулийн 59.2-т заасан хөрөнгө;

~~60.2.3.~~

/Энэ заалтыг 2015 оны 11 дүгээр сарын 10-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан/

/Энэ заалтыг 2016 оны 09 дүгээр сарын 09-ний өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон/

60.2.4. татварын хувь хэмжээг нэмэгдүүлэх болон зарлагыг хэмнэх замаар бий болгосон нэмэгдэл эх үүсвэр;

60.2.5. тухайн орон нутгийн хөгжлийг дэмжих зорилгоор олгосон дотоод, гадаадын хандив, тусламж.

60.2.6. Ашигт малтмалын тухай хуулийн 47³ дугаар зүйлд зааснаас бусад ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн орлогоос улсын чанартай томоохон төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэгч хуулийн этгээдийн төлсөн ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн орлогыг хассан зөрүүний 10 хувь;

/Энэ заалтыг 2015 оны 05 дугаар сарын 21-ний өдрийн хуулиар нэмсэн/

/Энэ заалтад 2016 оны 09 дүгээр сарын 09-ний өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/

/Энэ заалтад 2016 оны 11 дүгээр сарын 10-ны өдрийн хуулиар нэмэлт оруулсан/

60.2.7. ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрлийн төлбөрийн орлогын 50 хувь.

/Энэ заалтыг 2015 оны 05 дугаар сарын 21-ний өдрийн хуулиар нэмсэн/

60.3. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийг дараах зүйлд зарцуулахыг хориглоно:

60.3.1. орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр хуулиар тогтоосон чиг үүргээс бусад хөтөлбөр, арга хэмжээ.

60.3.2. улс төрийн нам, төрийн бус байгууллагын зарлага;

60.3.3. үндэсний их баяр наадмаас бусад баяр, наадам, ойн арга хэмжээ, шашны зан үйлийн болон ёслолын зардал;

60.3.4. нийтийн эрх ашигт нийцээгүй үйл ажиллагаа;

60.3.5. зээл олгох, санхүүгийн үр дагавар бүхий баталгаа гаргах, хохирлыг нөхөн төлөх үүрэг авах;

60.3.6. орон нутгийн иргэдийн саналыг аваагүй, орон нутгийн төсвийн төлөвлөгөөнд тусгаж батлаагүй зардал, арга хэмжээ.

60.4. Энэ хуулийн 60.3.1-д заасан хуулиар тогтоосон чиг үүрэгт аймаг, нийслэл, сум, дүүргийн удирдлагыг хэрэгжүүлэх чиг үүрэг хамаарахгүй.

60.5.Аймаг, нийслэлийн орон нутгийн хөгжлийн сан нь энэ хуулийн 60.2.6-д заасан орлогын 33-аас доошгүй хувийг ашигт малтмалын олборлолт хийсэн сум, дүүргийн орон нутгийн хөгжлийн санд олгоно.

[/Энэ хэсгийг 2015 оны 05 дугаар сарын 21-ний өдрийн хуулиар нэмсэн/](#)

60.6.Аймаг, нийслэлийн орон нутгийн хөгжлийн сан нь энэ хуулийн 60.2.7-д заасан орлогын 50-аас доошгүй хувийг ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрлөөр олгогдсон талбай байрших сум, дүүргийн орон нутгийн хөгжлийн санд олгоно.

[/Энэ хэсгийг 2015 оны 05 дугаар сарын 21-ний өдрийн хуулиар нэмсэн/](#)

60.7.Энэ хуулийн 60.2.6-д заасан эх үүсвэрийг ашигт малтмал ашигласан аймаг, нийслэлийн орон нутгийн хөгжлийн санд, энэ хуулийн 60.2.7-д заасан эх үүсвэрийг ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрлөөр олгогдсон талбай байрших аймаг, нийслэлийн орон нутгийн хөгжлийн санд улсын төсвөөс шилжүүлнэ.

[/Энэ хэсгийг 2015 оны 05 дугаар сарын 21-ний өдрийн хуулиар нэмсэн/](#)

60.8.Энэ хуулийн 60.2.6-д заасан улсын чанартай томоохон төсөл, арга хэмжээ хэрэгжүүлэгч хуулийн этгээдийн жагсаалтыг Засгийн газар батална.

[/Энэ хэсгийг 2015 оны 05 дугаар сарын 21-ний өдрийн хуулиар нэмсэн/](#)

60.9.Энэ хуулийн 60.6, 60.7-д заасан нутаг дэвсгэр нь хоёр болон түүнээс дээш тооны засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийг хамрах бол хувь тэнцүүлэх замаар орон нутгийн хөгжлийн сангийн шилжүүлгийг хийнэ.

[/Энэ хэсгийг 2015 оны 05 дугаар сарын 21-ний өдрийн хуулиар нэмсэн/](#)

60.10.Энэ хуулийн 60.5-60.9-д заасан орлогын шилжүүлэг хийх нарийвчилсан аргачлалыг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

[/Энэ хэсгийг 2015 оны 05 дугаар сарын 21-ний өдрийн хуулиар нэмсэн/](#)

60.11.Энэ хуулийн 60.3.6 дахь заалтад 58.1.8, 58.1.12, 58.2.11, 58.2.12, 58.2.15, 58.3.4, 58.4.3, 58.4.4, 58.4.9, 58.4.10-т заасныг хэрэгжүүлэхтэй холбогдсон үйлчилгээний зардал хамаарахгүй.

[/Энэ хэсгийг 2016 оны 09 дүгээр сарын 09-ний өдрийн хуулиар нэмсэн/](#)

61 дүгээр зүйл.Засгийн газрын зарим чиг үүргийг орон нутагт

төлөөлөн хэрэгжүүлэх

61.1.Аймаг, нийслэлийн Засаг дарга Засгийн газрын дараах чиг үүргийг орон нутагт төлөөлөн хэрэгжүүлнэ:

61.1.1.сургуулийн өмнөх боловсрол;

61.1.2.ерөнхий боловсрол;

61.1.3.соёлын үйлчилгээ;

61.1.4.эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээ;

61.1.5.газрын харилцаа, кадастр;

61.1.6.хүүхдийн хөгжил, хамгааллын үйлчилгээ;

61.1.7.нийтийн биеийн тамир.

61.2.Энэ хуулийн 61.1-д заасан төлөөлөн хэрэгжүүлэх чиг үүргийг энэ хуулийн 39 дүгээр зүйлд заасан гэрээний үндсэн дээр улсын төсвөөс олгох тусгай зориулалтын шилжүүлгээр санхүүжүүлнэ.

61.3.Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга энэ хуулийн 61.1-д заасан төлөөлөн хэрэгжүүлэх чиг үүрэг бүрээр санхүүжилтийн хуваарилалт хийх саналаа орон нутгийн төсвийн төслийн хамт бэлтгэж, хуульд заасан хугацааны дотор зохих шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд өргөн мэдүүлнэ.

61.4.Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал энэ хуулийн 39 дүгээр зүйлд заасан гэрээ, Засаг даргын өргөн мэдүүлсэн саналд үндэслэн төлөөлөн хэрэгжүүлэх чиг үүрэг бүрээр хуваарилсан санхүүжилтийг энэ хуулийн 39 дүгээр зүйлд заасан гэрээгээр шилжүүлсэн нийт хэмжээнээс бууруулахгүйгээр орон нутгийн төсвийн нэг хэсэг болгож батална.

61.5.Тусгай зориулалтын шилжүүлгийг энэ хуульд заасан сар, улирлын хуваарийн дагуу аймаг, нийслэлийн төрийн санд шилжүүлнэ.

62 дугаар зүйл.Орон нутгийн хэрэгцээнд зориулж өр үүсгэх

62.1.Аймаг, нийслэлийн Засаг дарга энэ хуулийн 41.5,-д заасан зориулалтаар улсын төсвөөс тухайн төсвийн жилийн дотор эргэн төлөгдөх нөхцөлтэй өр үүсгэж болно.

[/Энэ хэсэгт 2015 оны 02 дугаар сарын 18-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/](#)

~~62.2.Нийслэлийн Засаг дарга энэ хуулийн 58.1-д заасан чиг үүргийг хэрэгжүүлэхэд шаардагдах хоронго оруулалтын төслийг дорov хүртэлх жилийн хугацаатайгаар өр үүсгэн санхүүжүүлж болно.~~

[/Энэ хэсгийг 2015 оны 02 дугаар сарын 18-ны өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон/](#)

~~62.3.Энэ хуулийн 62.2-т заасан өрийн хэмжээ нь өмнөх жилийн төсвийн суурь орлогын дүнгээс, төлөх өрийн үйлчилгээний нийт хэмжээ нь өмнөх жилийн төсвийн суурь орлогын 15 хувиас тус тус хэтрэхгүй.~~

[/Энэ хэсгийг 2015 оны 02 дугаар сарын 18-ны өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон/](#)

~~62.4.Нийслэлийн төсөвт энэ хуулийн 62.2-т заасан зориулалтаар ор үүсгэхдээ дараах хөрөнгө, өрлогыг өрийн барьцаа болгохыг хориглоно:~~

~~—62.4.1.энэ хуулийн 61.1-д заасан чиг үүргийг хэрэгжүүлэхэд хамаарах нийслэлийн өмчийн эд хөрөнгө;~~

~~—62.4.2.нийслэлийн төсвийн бүх өрлөг.~~

/Энэ хэсгийг 2015 оны 02 дугаар сарын 18-ны өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон/

62.5.Тусгай зориулалтын шилжүүлгийг өрийн барьцаа болгохыг хориглоно.

/Энэ хэсгийг 2015 оны 02 дугаар сарын 18-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан/

~~62.6.Энэ хуулийн 62.2-т заасан зориулалтаар ор үүсгэхдээ нийслэлийн Засаг дарга дараах зүйлийг баримтална:~~

~~62.6.1.өрийн зориулалтыг нийтэд мэдээлэх, шаардлагатай бол олон нийтийг оролцуулан нээлттэй хэлэлцүүлэг зохион байгуулж хэлэлцүүлэх;~~

~~62.6.2.ор үүсгэхдээ санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас зөвшөөрөл авах;~~

~~62.6.3.ор үүсгэн санхүүжүүлэх хөрөнгө оруулалтын төслийг нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар хэлэлцүүлж зөвшөөрөл авах.~~

/Энэ хэсгийг 2015 оны 02 дугаар сарын 18-ны өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон/

~~—62.7.Нийслэлийн Засаг дарга эзэлийн гэрээнд болон ор үүсгэх бусад аливаа гэрээнд гарын үсэг зурнаас хойш ажлын 10-өдрийн дотор гэрээний хуулбарыг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ.~~

/Энэ хэсгийг 2015 оны 02 дугаар сарын 18-ны өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон/

63 дугаар зүйл.Орон нутгийн төсөвт иргэд, олон нийтийн

оролцоог хангах

63.1.Баг, хорооны Засаг дарга Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээ, тэдгээрийг хэрэгжүүлэх дараалал, арга замын талаар баг, хороодод олон нийтийн нээлттэй санал асуулга явуулна.

63.2.Энэ хуулийн 63.1-д заасан санал болон баг, хорооны иргэдийн Нийтийн Хурал дээр гарсан саналыг иргэдийн Нийтийн Хурал хэлэлцэн, тэргүүлэх ач холбогдол бүхий төсөл, арга хэмжээг эрэмбэлэн сонгоно.

63.3.Энэ хуулийн 63.2-т заасны дагуу баг, хорооны иргэдийн Нийтийн Хурлаас ирүүлсэн саналыг сум, дүүргийн Засаг даргын Тамгын газар ач холбогдол, тухайн орон нутгийн хөгжлийн

бодлоготой уялдуулан эрэмбэлж, төсвийн төсөлд тусган сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд өргөн мэдүүлнэ.

63.4.Сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал нь энэ хуулийн 63.3-т заасан саналыг хэлэлцэж, төсвийн төсөлд тусган, батална.

64 дүгээр зүйл.Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын бүрэн эрх

64.1.Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал орон нутгийн төсвийн удирдлага, санхүүжилтийн талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

64.1.1.Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэлэлцэн батлах, хэрэгжилтэд хяналт тавих;

64.1.2.тухайн жилийн төсөв, түүний тодотголын төслийг хэлэлцэн батлах, хэрэгжилтэд хяналт тавих, нийтэд мэдээлэх;

64.1.3.төсвийн гүйцэтгэлийг хэлэлцэн батлах;

64.1.4.төсвийн гүйцэтгэлийн болон санхүүгийн тайлангийн талаарх Засаг даргын мэдээллийг сонсох.

65 дугаар зүйл.Аймаг, нийслэлийн Засаг даргын бүрэн эрх

65.1.Аймаг, нийслэлийн Засаг дарга орон нутгийн төсвийн удирдлага, санхүүжилтийн талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

65.1.1.тухайн шатны төсвийн төсөл, тодотголын төслийг боловсруулах, хэлэлцүүлэх, батлуулах, төсвийн гүйцэтгэлийг зохион байгуулж, тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд тайлагнах;

65.1.2.орон нутаг дахь төсвийн байгууллага, тусгай зориулалтын шилжүүлгээр санхүүжүүлэх хөтөлбөр, арга хэмжээний төсвийн төсөл, гүйцэтгэл, сар, улирлын мэдээ, санхүүгийн тайланг нэгтгэн боловсруулж, холбогдох төсвийн ерөнхийлөн захирагчид хүргүүлэх;

65.1.3.холбогдох төсвийн ерөнхийлөн захирагчтай Засгийн газрын зарим чиг үүргийг орон нутагт төлөөлөн хэрэгжүүлэх гэрээг байгуулж ажиллах;

65.1.4.орон нутгийн төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлэх бараа, ажил, үйлчилгээг худалдан авах гэрээг холбогдох хуульд нийцүүлэн байгуулах;

65.1.5.иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар баталсан орон нутгийн төсвийг энэ хуулийн 8.5.5-д заасан хугацаанд санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлэх;

65.1.6.энэ хуулийн 39.1-д заасан гэрээний дагуу улсын төсвийн байгууллагын төлөвлөсөн зардлыг зориулалтаар нь цаг хугацаанд нь, тасралтгүй бүрэн санхүүжүүлэх;

65.1.7.аймаг, нийслэлийн жилийн төсвийн сар, улирлын хуваарийг баталж, мөрдүүлэх;

65.1.8.тухайн шатны төсвийн байгууллагын орон тоог төсвийн захирагч бүрээр батлах.

66 дугаар зүйл.Сум, дүүргийн Засаг даргын бүрэн эрх

66.1.Сум, дүүргийн Засаг дарга орон нутгийн төсвийн удирдлага, санхүүжилтийн талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

66.1.1.тухайн шатны төсвийн төсөл, түүний тодотголын төслийг боловсруулах, хэлэлцүүлэх, батлуулах, төсвийн гүйцэтгэлийг зохион байгуулж, тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд тайлагнах;

66.1.2.орон нутаг дахь төсвийн байгууллага, тусгай зориулалтын шилжүүлгээр санхүүжүүлэх хөтөлбөр, арга хэмжээний төсвийн төсөл, гүйцэтгэл, сар, улирлын мэдээ, санхүүгийн тайланг нэгтгэн боловсруулж аймаг, нийслэлийн Засаг даргад хүргүүлэх;

66.1.3.аймаг, нийслэлийн Засаг даргатай Засгийн газрын зарим чиг үүргийг орон нутагт төлөөлөн хэрэгжүүлэх гэрээг байгуулж ажиллах;

66.1.4.иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар баталсан орон нутгийн төсвийг түүнийг баталснаас хойш ажлын долоон өдрийн дотор аймаг, нийслэлийн Засаг даргад хүргүүлэх;

66.1.5.энэ хуулийн 39.2-т заасан гэрээний дагуу улсын төсвийн байгууллагын төлөвлөсөн зардлыг зориулалтаар нь цаг хугацаанд нь тасралтгүй бүрэн санхүүжүүлэх;

66.1.6.сум, дүүргийн жилийн төсвийн сар, улирлын хуваарийг баталж мөрдүүлэх;

66.1.7.тухайн шатны төсвийн байгууллагын орон тоог төсвийн захирагч бүрээр батлах.

67 дугаар зүйл.Орон нутгийн төсөв боловсруулах, өргөн мэдүүлэх

67.1.Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга орон нутгийн төсвийн төслийг боловсруулж, энэ хуулийн 67.2-т заасан танилцуулгын хамт тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд өргөн мэдүүлнэ.

67.2.Орон нутгийн төсвийн төслийн танилцуулгад энэ хуулийн 32.2.1-32.2.12, 32.2.19, 32.2.20-д зааснаас гадна дараах зүйлийг тусгана:

67.2.1.орон нутгийн төсвийн бодлогын зорилтыг тусгасан дунд хугацааны төлөвлөгөө;

67.2.2.энэ хуулийн 22 дугаар зүйлд заасан төсвийн ангиллын дагуу боловсруулсан төсвийн төслийн тооцоо, танилцуулга;

67.2.3.аймаг, нийслэлийн төсвөөс сум, дүүргийн төсөвт олгохоор төлөвлөсөн санхүүгийн дэмжлэг, орлогын шилжүүлгийн санал;

67.2.4.дээд шатны төсөвт тусган баталсан дээд шатны төсөвт төвлөрүүлэх хөрөнгийн хэмжээ.

67.3.Аймаг, нийслэл, сум, дүүргийн төсвийн төслийг боловсруулах явцдаа төслийг тухайн шатны Засаг дарга олон нийтэд танилцуулж, тухайн аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн санал, хүсэлтийг иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд танилцуулна.

68 дугаар зүйл.Орон нутгийн төсөв батлах

68.1.Орон нутгийн төсөвт энэ хуулийн 33.2.1-33.2.7-д заасныг тусгаж, батална.

68.2.Төсвийн төслийг иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар хэлэлцэх явцад нэмж тусгах хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг тухайн шатны төсвийг өргөн мэдүүлсэн этгээдээс энэ хуулийн 29 дүгээр зүйлд заасан шаардлагыг хангаж байгаа эсэх талаар санал, дүгнэлтийг авсны үндсэн дээр тусгана.

68.3.Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас баталсан тухайн жилийн төсвийг ил тод, олон нийтэд хүртээмжтэй байдлаар мэдээлнэ.

АРАВДУГААР БҮЛЭГ ХЯНАЛТ, ШАЛГАЛТ

69 дүгээр зүйл.Дотоод аудит

69.1.Төсвийн ерөнхийлөн захирагч бүр хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих, төсвийн хөрөнгө, өр, төлбөр, орлого, зарлага, хөтөлбөр, арга хэмжээ, хөрөнгө оруулалтад санхүүгийн хяналт, шалгалт хийх, үнэлэлт, дүгнэлт, зөвлөмж гаргах, эрсдэлийн удирдлагаар хангахад чиглэсэн дотоод аудитын албыг байгуулж, дотоод аудитор ажиллуулна.

69.2.Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага төсвийн ерөнхийлөн захирагчийн дотоод аудитын албыг үйл ажиллагааны стандарт, арга зүйн удирдлагаар хангана.

69.3.Дотоод аудитад төсвийн ерөнхийлөн захирагчийн эрхлэх асуудлын хүрээний төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмч давамгайлсан хуулийн этгээдийн санхүүгийн үйл ажиллагааг хамаарна.

69.4.Дотоод аудитор нь санхүүгийн хяналт шалгалтын улсын байцаагчийн эрхтэй байна.

69.5.Дотоод аудитын албаны дүрмийг Засгийн газар батална.

АРВАННЭГДҮГЭЭР БҮЛЭГ ХАРИУЦЛАГА ХҮЛЭЭЛГЭХ

70 дугаар зүйл.Хууль тогтоомж зөрчигчид хүлээлгэх хариуцлага

70.1.Энэ хуулийн 6.2-6.4, 6.6, 25.10, 42.7, 57.5, 60.3,-т заасныг тус тус зөрчсөн нь тухайн шатны Засаг даргыг Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн[10] 32 дугаар зүйлд заасны дагуу огцруулах үндэслэл болно.

[/Энэ хэсэгт 2015 оны 02 дугаар сарын 18-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/](#)

70.2.Хуульд өөрөөр заагаагүй бол энэ хуулийн 14.1.1, 14.1.3-14.1.8, 14.1.14-т заасан төсвийн ерөнхийлөн захирагч нь энэ хуулийн 6.2-6.4, 6.6, 25.10, 42.1, 42.7, 46.5-д заасныг тус тус зөрчсөн нь томилсон эрх бүхий этгээд тухайн албан тушаалтныг албан тушаалаас нь огцруулах үндэслэл болно.

[/Энэ хэсэгт 2016 оны 11 дүгээр сарын 10-ны өдрийн хуулиар нэмэлт оруулсан/](#)

70.3.Энэ хуулийн 6 дугаар зүйл, 24.4-т заасныг зөрчсөн тохиолдолд эрх бүхий этгээд буруутай албан тушаалтанд төрийн албанд 10 жилийн хугацаанд эргэж орох эрхгүйгээр халах сахилгын шийтгэл ногдуулна.

70.4.Төсвийн тухай хууль тогтоомж зөрчсөн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол шүүгч, эсхүл санхүүгийн хяналт шалгалтын улсын байцаагч дараах шийтгэл ногдуулна:

70.4.1.энэ хуулийн 8.3-8.10-т заасан тооцоо, санал, төсвийн төсөл, мэдээ, тайланг тогтоосон хугацаанд нь хүргүүлээгүй бол нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг таваас арав дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох;

70.4.2.энэ хуулийн 14.2.7, 14.2.8, 16.5.7-д заасан бүрэн эрхээ зохих ёсоор хэрэгжүүлээгүй буруутай албан тушаалтныг нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг таваас арав дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох;

70.4.3.энэ хуулийн 20.3-т заасныг зөрчсөн буруутай албан тушаалтныг нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг хоёроос гурав дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох;

70.4.4.энэ хуулийн 22.5-д заасныг зөрчсөн буруутай албан тушаалтныг нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг таваас арав дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох;

70.4.5.энэ хуулийн 25.2-25.8, 25.12, 28.6, 29.6-д заасныг зөрчсөн бол буруутай албан тушаалтныг нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг таваас арав дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох;

70.4.6.энэ хуулийн 30.3, 39.4, 41.2, 42.2, 43 дугаар зүйл, 50.1, 50.2, 51.2, 65.1.6, 66.1.5-д заасныг зөрчсөн албан тушаалтныг нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг арваас арван тав дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох;

/Энэ заалтад 2015 оны 02 дугаар сарын 18-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/

70.4.7.энэ хуулийн 35.3-т заасан журмыг зөрчин, зөвшөөрөлгүйгээр банкинд данс нээлгэсэн төсвийн байгууллагын эрх бүхий албан тушаалтан, энэ хуулийн 35.4-т заасныг зөрчиж төсвийн байгууллагад данс нээсэн буруутай этгээдийг нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг таваас найм дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр тус тус торгох;

70.4.8.энэ хуулийн 36.5-д заасан журмыг зөрчин, төсвийн байгууллагад уг албатай давхардсан чиг үүрэг хэрэгжүүлэх орон тоо бий болгосон бол буруутай албан тушаалтныг нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг хоёроос гурав дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох;

70.4.9.төсвийн байгууллагын урамшууллыг захиран зарцуулах талаар энэ хуулийн 46.3, 46.4-т заасныг зөрчсөн албан тушаалтныг нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг гурваас тав дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох;

70.4.10.энэ хуулийн 55 дугаар зүйлд заасан сонгуулийн өмнөх макро эдийн засаг, санхүү, төсвийн төлөв байдлын тайланг хугацаанд нь гаргаж, мэдээлээгүй бол буруутай албан тушаалтныг нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг гурваас тав дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох;

70.4.11.энэ хуульд заасан нийтэд мэдээлэх үүргээ биелүүлээгүй албан тушаалтныг нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг дөрвөөс зургаа дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох.

70.5.Зөрчлийн хэлбэр, хүлээлгэх хариуцлагаас үл хамааран энэ хуулийг зөрчсөний улмаас төрд хохирол учруулсан буруутай этгээд уг хохирлыг төлж барагдуулна.

70.6.Энэ хуулийн 70.4.2, 70.4.4, 70.4.10-д заасан шийтгэлийг шүүгч, 70.4.1, 70.4.3, 70.4.5-70.4.9, 70.4.11-д заасан шийтгэлийг санхүүгийн хяналт, шалгалтын улсын байцаагч тус тус ногдуулна.

70 дугаар зүйл.Хууль зөрчигчид хүлээлгэх хариуцлага

70.1.Энэ хуулийг зөрчсөн албан тушаалтны үйлдэл нь гэмт хэргийн шинжгүй бол Төрийн албаны тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

/Энэ зүйлийг 2015 оны 12 дугаар сарын 04-ний өдрийн хуулиар өөрчлөн найруулахаар заасан бөгөөд үүнийг 2017 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө/

71 дүгээр зүйл.Хууль хүчин төгөлдөр болох

71.1.Энэ хуулийн 71.2, 71.3-т зааснаас бусад заалтыг 2013 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

71.2.Төсөв, улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл, дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлийн төслийг боловсруулах, өргөн мэдүүлэх, батлах, нийтэд мэдээлэх, төсвийн цаглабрыг мөрдүүлэх, сонгуулийн өмнөх эдийн засаг, санхүү, төсвийн төлөв байдлын тайланг бэлтгэх, Улсын Их Хуралд танилцуулах, нийтэд мэдээлэхтэй холбогдсон энэ хуулийн зүйл, заалтыг 2012 оны 02 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

71.3.2012 оны төсвийн тодотголын төсөл боловсруулах, өргөн мэдүүлэх, батлахтай холбогдсон харилцаанд энэ хуулийн 71.2 дахь хэсэг хамаарахгүй.

~~71.4.Энэ хуулийн 43.1.2 дахь заалт, 43.4 дэх хэсгийг 2011 оны 12 дугаар сарын 30 ны өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.~~

[/Энэ хэсгийг 2013 оны 11 дүгээр сарын 07-ны өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон/](#)

71.5.Энэ хуулийн 8 дугаар зүйлийн 8.4, 8.6 дахь хэсэг, мөн зүйлийн 8.6.3 дахь заалт, 12 дугаар зүйлийн 12.1.2 дахь заалт, 19 дүгээр зүйлийн 19.6.1 дэх заалт, 21 дүгээр зүйлийн 21.1 дэх хэсэг, 32 дугаар зүйлийн 32.1 дэх хэсэг, 42 дугаар зүйлийн 42.3.3 дахь заалтын "төсөв, Эрүүл мэндийн даатгалын сангийн төсөв, Ирээдүйн тэтгэврийн нөөц сангийн" гэснийг, 8 дугаар зүйлийн 8.8, 8.9 дэх хэсэг, 9 дүгээр зүйлийн 9.1.2 дахь заалтын “Эрүүл мэндийн даатгалын сангийн төсөв, Ирээдүйн тэтгэврийн нөөц сангийн төсөв,” гэснийг, 33 дугаар зүйлийн 33.1 дэх хэсгийн "төсөв, Эрүүл мэндийн даатгалын сангийн төсөв болон Ирээдүйн тэтгэврийн нөөц сангийн" гэснийг 2018 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн тус тус дагаж мөрдөнө.

[/Энэ хэсгийг 2016 оны 11 дүгээр сарын 10-ны өдрийн хуулиар нэмсэн/](#)

МОНГОЛ УЛСЫН

ИХ ХУРЛЫН ДАРГА

Д.ДЭМБЭРЭЛ

[1] Монгол Улсын Үндсэн хууль -“Төрийн мэдээлэл” эмхтгэлийн 1992 оны 1 дугаарт нийтлэгдсэн.

[2] Төсвийн тогтвортой байдлын тухай хууль - “Төрийн мэдээлэл” эмхтгэлийн 2010 оны 30 дугаарт нийтлэгдсэн.

[3] Нийгмийн даатгалын тухай хууль -“Төрийн мэдээлэл” эмхтгэлийн 1994 оны 8 дугаарт нийтлэгдсэн.

[4] Хүний хөгжил сангийн тухай хууль-“Төрийн мэдээлэл” эмхтгэлийн 2009 оны 45 дугаарт нийтлэгдсэн.

[5] Татварын ерөнхий хууль “Төрийн мэдээлэл” эмхтгэлийн 2008 оны 22 дугаарт нийтлэгдсэн.

[6] Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хууль-“Төрийн мэдээлэл” эмхтгэлийн 2010 оны 1 дугаарт нийтлэгдсэн.

[7] Хувь хүний орлогын албан татварын тухай хууль- “Төрийн мэдээлэл” эмхтгэлийн 2006 оны 38 дугаарт нийтлэгдсэн.

[8] Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль- “Төрийн мэдээлэл” эмхтгэлийн 2002 оны 4 дугаарт нийтлэгдсэн.

[9] Засгийн газрын тусгай сангийн тухай хууль- “Төрийн мэдээлэл” эмхтгэлийн 2006 оны 7 дугаарт нийтлэгдсэн.

[10] Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль- “Төрийн мэдээлэл” эмхтгэлийн 2007 оны 2 дугаарт нийтлэгдсэн.

ТЭРГҮҮН ЭЭЛЖИНД БОЛОВСРУУЛЖ, БАТЛУУЛАХ ШААРДЛАГАТАЙ ХУУЛЬ, УЛСЫН ИХ ХУРЛЫН БУСАД ШИЙДВЭРИЙН ТӨСЛИЙН ЖАГСААЛТ

Д/д	Хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төслийн нэр	Хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төслийн үзэл баримтлал	Хариуцах байгууллага	Хугацаа
1	Монгол Улсын 2017 оны төсвийн тухай хуулийн төсөл	Монгол Улсын 2017 оны төсвийн алдагдлыг өмнөх оныхоос бууруулж дунд хугацаанд төсвийн үндсэн тэнцлийг эерэг түвшинд хүргэх	Засгийн газар	Улсын Их Хурлын 2016 оны намрын чуулган
2	Монгол Улсын нэгдсэн төсвийн 2017 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2018-2019 оны төсвийн төсөөллийн тухай хуулийн төсөл	Төсвийн сахилга батыг сайжруулах, бизнесийн үйл ажиллагааг идэвхжүүлж, төсвийн орлогын бааз суурийг өргөжүүлэх, төсвийн алдагдлыг үе шаттайгаар бууруулж, дунд хугацаанд төсвийн үндсэн тэнцлийг эерэг болгох замаар өрийн дарамтыг бууруулах	Засгийн газар	Улсын Их Хурлын 2016 оны намрын чуулган
3	Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл	Жилийн 1.5 тэрбум төгрөгөөс бага орлоготой газар тариалан, мал аж ахуйн үйлдвэрлэл болон түүнд холбогдох туслах үйл ажиллагаа, хүнсний бүтээгдэхүүний үйлдвэрлэл, нэхмэлийн болон хувцас үйлдвэрлэл, барилгын материалын үйлдвэрлэл эрхэлж байгаа аж ахуйн нэгжийн орлогын албан татварыг 1 хувь болгон бууруулж, жижиг, дунд бизнесийн үйл ажиллагааг дэмжиж, төсвийн орлогын бааз суурийг өргөжүүлэх	Засгийн газар	Улсын Их Хурлын 2016 оны намрын чуулган
4	Активын удирдлагын институцийн тухай хуулийн төсөл	Арилжааны банкуудын оролцоотойгоор активын удирдлагын институц байгуулж, банкны системийн чанаргүй зээлийн хэмжээг бууруулах замаар санхүүгийн тогтвортой байдлыг хангах	Монголбанк Засгийн газар	Улсын Их Хурлын 2017 оны хаврын чуулган
5	Хөрөнгө оруулалтын тухай хууль болон холбогдох хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл	Гадаадын хөрөнгө оруулагч нарын эрхийг хамгаалах зөвлөлийн эрх зүйн үндсийг тодорхойлж, гадаадын хөрөнгө оруулагчтай холбоотой хэргүүдийг шийдвэрлэх, цаашид хөрөнгө оруулагчдын тогтвортой ажиллах нөхцөлийг бүрдүүлэх	Засгийн газар	Улсын Их Хурлын 2017 оны хаврын чуулган
6	Казиногийн тухай хуулийн төсөл	Казиногийн үйл ажиллагаа явуулах эрх зүйн орчин, дүрэм, журмыг бий болгож, хөрөнгө оруулагчтай хэлэлцээр хийх	Засгийн газар	Улсын Их Хурлын 2017 оны хаврын чуулган
7	Хурдан морины бооцоот уралдааны тухай хуулийн төсөл	Хурдан морины бооцоот уралдаан зохион байгуулах, үйл ажиллагаа явуулах эрх зүйн орчин, дүрэм, журмыг бий болгож, хөрөнгө оруулагчтай хэлэлцээр хийж, үйл ажиллагааг эхлүүлэх	Засгийн газар	Улсын Их Хурлын 2017 оны хаврын чуулган
8	Засгийн газрын өргөн мэдүүлсэн Улсын төсвийн төсөл дэх үндсэн хязгааруудыг УИХ-ын чуулганы хуралдааны хэлэлцүүлгийн явцад өөрчлөхгүй	Улсын төсвийн төсөл дэх үндсэн хязгаарууд болох төсвийн алдагдал, орлого, зарлага болон өрийн дээд хэмжээ зэрэг үзүүлэлтийг УИХ-ын чуулганы хуралдааны хэлэлцүүлгийн явцад дордуулахгүй байх, төсвийн боловсруулах, батлах үйл ажиллагааны сахилга бат, хариуцлагыг	Засгийн газар	Улсын Их Хурлын 2017 оны намрын чуулган

	байхаар холбогдох хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл	дээшлүүлэх		
9	Төв банкны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл	Төв банкны засаглалын бүтцийг олон улсын жишигт нийцүүлэх, Монголбанкны удирдлагын хараат бус байдлыг бэхжүүлэх, мөнгөний бодлогын хэрэгжилтийг сайжруулах, Монголбанкны үйл ажиллагааг илүү тодорхой болгох	Монголбанк, Засгийн газар	Улсын Их Хурлын 2017 оны хаврын чуулган
10	Үндэсний төлбөр тооцооны системийн тухай хуулийн төсөл	Төлбөр тооцооны дэд бүтцийг сайжруулах, төлбөрийн системийн үр ашигтай, найдвартай, тасралтгүй ажиллагааг хангах	Монголбанк Засгийн газар	Улсын Их Хурлын 2017 оны хаврын чуулган
11	Валютын зохицуулалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл	Валютын урсгалыг зохицуулах харилцааг сайжруулах, валютын зохиомол эрэлтийг бууруулах	Монголбанк Засгийн газар	Улсын Их Хурлын 2017 оны хаврын чуулган
12	Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл	Санхүүгийн зах зээлийн бүтцийг олон тулгуурт болгох, болзошгүй эрсдэлийг үнэлэх, хамгаалах, бодлогын уялдааг хангах институт болгох	Санхүүгийн зохицуулах хороо, Засгийн газар	Улсын Их Хурлын 2017 оны хаврын чуулган
13	Монгол Улсын Хөгжлийн банкны тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл	Төсвөөс эргэн төлөх нөхцөлтэй актив хөрөнгийн зарим хэсгийг Засгийн газарт шилжүүлэх Хөгжлийн банкны улсын төсөвтэй харилцах харилцааг боловсронгуй болгох, болзошгүй эрсдэлийг бууруулж, засаглал, ил тод байдал, тайлагналыг сайжруулж, үйл ажиллагааны цар хүрээг өргөжүүлэх, бие даасан байдлыг нэмэгдүүлэх	Засгийн газар	Улсын Их Хурлын 2017 оны хаврын чуулган

ЭДИЙН ЗАСГИЙГ СЭРГЭЭХ ХӨТӨЛБӨР

Зорилт, арга хэмжээ	Хэрэгжүүлэх арга зам	Хүрэх үр дүн	Хугацаа	Хариуцах этгээд
СТРАТЕГИ 1. МАКРО ЭДИЙН ЗАСГИЙГ ТОГТВОРЖУУЛАХ БОДЛОГО ХЭРЭГЖҮҮЛЭХ				
<p>1.1. Улсын төсвийн алдагдлыг бууруулж, санхүүжилтийн тогтвортой байдлыг хангахад чиглэсэн төсвийн бодлого хэрэгжүүлэх:</p> <p>1.1.1. Төсвийн сахилга батыг сайжруулах, төсвийн орлогын бааз суурийг өргөжүүлэх, үр дүнгээр санхүүжүүлэх, төсвийн норм, нормативыг баримтлан хэмнэлтийн горимд шилжих;</p> <p>1.1.2. “Үндэсний хэмнэлт”-ийн хөтөлбөр боловсруулж, хэрэгжүүлэх;</p> <p>1.1.3. Орон нутгийн хөгжлийн сангийн зарцуулалтад үр ашгийн шинжилгээ хийж, сангийн зарцуулалтыг ард иргэдэд нээлттэй, ил тод болгох;</p> <p>1.1.4. Төрөөс захиалгаар гүйцэтгэсэн бараа, ажил үйлчилгээний төлбөрөө авч чадахгүй байгаа иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын</p>	<p>Монгол Улсын 2017 оны төсвийн тухай хууль, Монгол Улсын нэгдсэн төсвийн 2017 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2018-2019 оны төсвийн төсөөллийн тухай хууль, Засгийн газрын тогтоол, Сангийн сайдын тушаал</p>	<p>Нэгдсэн төсвийн алдагдлын ДНБ-д эзлэх хувийг бууруулж 2017 онд 9.9 хувиас хэтрүүлэхгүй байх</p>	<p>2017-2018 оны эхний хагас жилд</p>	<p>Засгийн газар, Санхүүгийн зохицуулах хороо</p>

<p>төлбөрийг барагдуулах;</p> <p>1.1.5.Засгийн газрын үнэт цаасны арилжааг тогтмолжуулах, Хөрөнгийн биржээр дамжуулан борлуулах, үнэт цаасны зуучлагч компаниудын оролцоог нэмэгдүүлэх;</p> <p>1.1.6.Дотоодын зах зээлийг тарифын болон тарифын бус аргаар хамгаалах, дотоодын худалдан авалтыг бодлогоор дэмжиж, хууль эрх зүйн орчныг бий болгох;</p> <p>1.1.7.Хөрөнгийн зах зээлийн хүртээмжийг нэмэгдүүлж, олон нийтийн оролцоог хангах эрх зүйн орчныг сайжруулах;</p> <p>1.1.8.Байнгын болон түр ажлын байрыг тогтвортой хадгалж байгаа аж ахуйн нэгжийг татвар, зээлийн бодлогоор дэмжих;</p> <p>1.1.9.Концессоор хэрэгжсэн, одоо хэрэгжиж байгаа төсөл, хөтөлбөрүүдэд шалгалт хийж, цаашид хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний жагсаалтыг баталж, хэрэгжүүлэх механизмыг хөрөнгө оруулагч нарт тодорхой болгох.</p>				
<p>1.2.Төлбөрийн тэнцлийн дарамтыг бууруулж, инфляцийн тогтвортой байдлыг хангахад чиглэсэн мөнгөний бодлого хэрэгжүүлэх:</p> <p>1.2.1.Активын удирдлагын мэргэшсэн</p>	<p>Засгийн газрын тогтоол, Сангийн сайдын тушаал, Монголбанкны Ерөнхийлөгчийн тушаал</p>	<p>Гадаад валютын улсын нөөцийг нэмэгдүүлсэн байх</p>	<p>2017 онд</p>	<p>Засгийн газар, Монголбанк, Санхүүгийн зохицуулах хороо</p>

<p>институцийн эрх зүйн орчныг бүрдүүлэх;</p> <p>1.2.2.Эдийн засгийн бодит өсөлт, макро эдийн засгийн тогтвортой байдлыг дэмжих хүүгийн уян хатан бодлого хэрэгжүүлэх, банкны системийн шалгуур үзүүлэлтүүдийг зохистой түвшинд байлгах;</p> <p>1.2.3.Валютын урсгал түр зуур нэмэгдэх үед төгрөгийн нийлүүлэлтийг огцом нэмэгдүүлэхгүй байх, дунд, урт хугацаанд валютын нөөцийг тогтвортой байлгах, хамгаалах зарчим баримтлах;</p> <p>1.2.4.Хөгжлийн банк, Жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих сан, “Үнэ тогтворжуулах” хөтөлбөрийн хүрээнд олгосон зээлийн ашиглалтад шалгалт хийж, дүгнэлт өгөх;</p> <p>1.2.5.Орон сууцны 8.0 хувийн хүүтэй зээлийн хөтөлбөрийг үргэлжлүүлж, ипотекийн зээлийн даатгалыг урт хугацаат даатгалын бүтээгдэхүүний хэлбэрт шилжүүлэх;</p> <p>1.2.6.Эдийн засгийн өсөлтийг дэмжсэн томоохон төслүүдийг урт хугацааны санхүүжилтээр хангах зорилгоор Хөрөнгө оруулалтын сан байгуулах;</p> <p>1.2.7.Экспортыг дэмжих үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх, экспортын</p>			
--	--	--	--

<p>даатгалын бүтээгдэхүүн бий болгох замаар экспортлогч үндэсний үйлдвэрлэгчдийг дэмжих.</p>				
<p>1.3.Гадаад валютын орох урсгалыг нэмэгдүүлж, ойрын хугацаанд төлөх гадаад өр төлбөрийг санхүүжүүлэх эх үүсвэрийг шийдвэрлэх:</p> <p>1.3.1.Алт хөтөлбөрийг шинэчлэн үргэлжлүүлэх;</p> <p>1.3.2.Засгийн газар, Хөгжлийн банкны гадаад бондыг эргүүлэн төлөх, дахин санхүүжүүлэх төлөвлөгөө боловсруулж, хэрэгжүүлэх;</p> <p>1.3.3.Засгийн газар, Монголбанк, Хөгжлийн банкны болзошгүй өр төлбөрийг судалж, эрсдэлээс сэргийлэх арга хэмжээ авах;</p> <p>1.3.4.Түншлэгч улс орон, олон улсын банк, санхүүгийн байгууллагуудтай зөвшилцөх уулзалтуудыг зохион байгуулж, урт хугацаатай, бага хүүтэй санхүүгийн эх үүсвэр татах;</p> <p>1.3.5.Гадаадын шууд хөрөнгө оруулалтыг татах хууль, эрх зүйн орчныг сайжруулж, урт хугацаанд тогтвортой ажиллах нөхцөлийг бүрдүүлэх;</p> <p>1.3.6.Хөрөнгө оруулагчдын эрх ашгийг хамгаалах зөвлөл байгуулж ажиллах;</p>	<p>Засгийн газрын тогтоол, Сангийн сайдын тушаал, Монголбанкны Ерөнхийлөгчийн тушаал</p>	<p>Гадаадын шууд хөрөнгө оруулалт нэмэгдэх, хөрөнгө оруулагчид урт хугацаанд тогтвортой ажиллах нөхцөлийг бүрдүүлэх</p>	<p>2017-2018 оны эхний хагас жилд</p>	<p>Засгийн газар, Монголбанк</p>

<p>1.3.7.Банк, санхүүгийн системийн ил тод, нээлттэй байдлыг хангаж, гадаадын банкны салбар нэгж нээн ажиллуулах эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох;</p> <p>1.3.8.Техник, эдийн засгийн үндэслэл нь хийгдсэн, хөрөнгө оруулагч нь тодорхой болсон бэлэн төслүүдийг бүх талаар дэмжиж, хэрэгжилтийг эрчимжүүлэх;</p> <p>1.3.9.Хөрөнгө оруулагчдын хууль ёсны эрх ашгийг хамгаалах талаар эрх зүйн орчныг боловсронгуй болгох;</p>				
<p>СТРАТЕГИ 2. ДУНД ХУГАЦААНД ЭДИЙН ЗАСАГТ БҮТЦИЙН ӨӨРЧЛӨЛТ ХИЙЖ, ТОГТВОРТОЙ ӨСӨЛТИЙГ ХАНГАХ,</p> <p>ӨРИЙН ДАРАМТЫГ БАГАСГАХ</p>				
<p>2.1.Уул уурхайн бус салбарын экспортын орлогыг нэмэгдүүлж, эдийн засгийг төрөлжүүлэх үндэс суурийг тавих:</p> <p>2.1.1.Иргэний нисэхийн үйлчилгээнд дэвшилтэт техник, технологийг нэвтрүүлж, дамжин өнгөрөх нислэгийн тоог нэмэгдүүлж, навигацийн орлогыг өсгөх;</p> <p>2.1.2.Хөрш орнуудтай хийх худалдааг өргөжүүлэх, хил орчмын төрийн байгууллага хоорондын уялдааг хангаж, хилийн боомтын нэвтрүүлэх хүчин чадлыг нэмэгдүүлж, үйлчилгээг сайжруулах;</p> <p>2.1.3.Аялал жуулчлалын гол маршрутын</p>	<p>Засгийн газрын тогтоол</p>	<p>Уул уурхайн бус салбарын үйлдвэрлэл, экспорт нэмэгдсэн байх</p>	<p>2017-2018 оны эхний хагас жилд</p>	<p>Засгийн газар</p>

<p>зам дагуу түр буудаллах цэг, үйлчилгээний цогцолбор байгуулах;</p> <p>2.1.4.Казиногийн үйл ажиллагаа эрхлэх эрх зүйн орчныг бүрдүүлэх;</p> <p>2.1.5.Хурдан морины бооцоот уралдаан зохион байгуулах эрх зүйн орчныг бүрдүүлэх;</p> <p>2.1.6.Импортыг орлох барилгын материалын дотоодын үйлдвэрлэлийг бодлогоор дэмжих;</p> <p>2.1.7.Хүнс, хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг эрчимжүүлж, импортыг орлох бүтээгдэхүүний хэрэглээг нэмэгдүүлэх;</p> <p>2.1.8.“Атрын III аян”-ыг үргэлжлүүлж, үр тариа, төмс, гол нэрийн хүнсний ногооны хэрэгцээг дотоодын үйлдвэрлэлээр хангах;</p> <p>2.1.9.“Малыг эрүүлжүүлэх” хөтөлбөрийг шинэчлэн эрх зүйн орчныг бий болгох;</p> <p>2.1.10.“Ноолуур” хөтөлбөрийг шинэчлэн боловсруулж, хэрэгжүүлэх;</p> <p>2.1.11.Гадаадын зах зээлд экспортлох боломжтой программ хангамж, техник хангамжийн үйлдвэрлэлийг хөгжүүлэх;</p>				
---	--	--	--	--

<p>2.1.12.Иргэдийг гадаад улсад тодорхой хугацаагаар ажиллуулах арга хэмжээг төрөөс авч хэрэгжүүлэх;</p> <p>2.1.13.Иргэдийг шинэ ургацын хүнсний ногоогоор хангах зорилгоор дотоодын үйлдвэрлэлийг дэмжих, хүлэмжийн цогцолбор аж ахуй байгуулах;</p> <p>2.1.14.Олон улсын байгууллагаас гаргадаг зээлжих зэрэглэл, бизнес эрхлэлт, өрсөлдөх чадвар, хөрөнгө оруулалтыг татах чадвар зэрэг индексүүдийг сайжруулах;</p>				
<p>2.2.Бодит салбарын өсөлтийг дэмжих томоохон төслүүдийг эхлүүлж, дэд бүтцийн бүтээн байгуулалтын ажлыг эрчимжүүлэх:</p> <p>2.2.1.Таван толгойн бүлэг ордыг ашиглах, Таван толгойн 450 МВТ-ын цахилгаан станц, Гацууртын алтны орд, Дулааны III цахилгаан станцын 250 МВТ-ын өргөтгөл, Чойбалсангийн ДЦС-ын 50 МВТ-ын өргөтгөл зэрэг төслүүдийг хэрэгжүүлэх;</p> <p>2.2.2.Таван толгой-Гашуун сухайт, Нарийн сухайт-Шивээхүрэн, Зүүнбаян-Ханги, Эрдэнэт-Овоот, Хөөт-Бичигт чиглэлийн төмөр замын бүтээн байгуулалтын ажлыг дэмжиж, Богд хан төмөр замын барилгын ажлыг эхлүүлэх;</p> <p>2.2.3.Эрчим хүчний салбарын тасралтгүй, найдвартай ажиллагааг хангах хүрээнд</p>	<p>Улсын Их Хурлын тогтоол, Засгийн газрын тогтоол</p>	<p>Дэд бүтэц, бүтээн байгуулалтын томоохон төслийг эрчимжүүлж, эдийн засгийн бодит өсөлтийг 2018 онд 5.1 хувь, 2019 онд 7.1 хувьд хүргэх, шинэ ажлын байр олноор бий болгох замаар ажилгүйдлийг бууруулах</p>	<p>2017-2018 оны эхний хагас жилд</p>	<p>Засгийн газар</p>

<p>цахилгаан станц, цахилгаан дамжуулах агаарын шугам, дэд станцуудыг шинээр барих, өргөтгөх ажлыг хэрэгжүүлэх;</p> <p>2.2.4.Томоохон үйлдвэрлэл дагасан жижиг, дунд үйлдвэрлэлийн хөгжлийг дэмжиж, төрөлжсөн кластерыг бий болгох замаар өрхийн амьжиргааг дээшлүүлэхэд дэмжлэг үзүүлэх;</p> <p>2.2.5.Хөшигийн хөндийд баригдаж байгаа Олон Улсын нисэх онгоцны шинэ буудлыг даган бий болох хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөнд тодотгол хийж, хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө боловсруулж, шинэ хотын бүтээн байгуулалтыг эхлүүлэх.</p>				
<p>2.3.Эдийн засгийн өсөлтийг дэмжих хариуцлагатай засаглалыг бэхжүүлж, хууль эрх зүйн тогтвортой орчныг бүрдүүлэх:</p> <p>2.3.1.Засгийн газрын өргөн мэдүүлсэн Улсын төсвийн төсөл дэх үндсэн хязгааруудыг /төсвийн алдагдал, орлого, зарлага болон өрийн дээд хэмжээ г.м/ Улсын Их Хурлын чуулганы хуралдааны хэлэлцүүлгийн явцад нэмэгдүүлэхгүй байхаар хууль, эрх зүйн орчныг бүрдүүлэх;</p> <p>2.3.2.Төв банкны засаглалын бүтцийг олон улсын жишигт нийцүүлэх, Монголбанкны удирдлагын хараат бус байдлыг бэхжүүлэх, мөнгөний бодлогын хэрэгжилтийг сайжруулах, Монголбанкны үйл ажиллагааг</p>	<p>Монгол Улсын хууль, Улсын Их Хурлын тогтоол, Засгийн газрын тогтоол, Сангийн сайдын тушаал, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын тушаал</p>	<p>“Дэлхийн засаглалын үзүүлэлт”-ээр Монгол Улсын эзлэх байрыг ахиулах</p>	<p>2017-2018 оны эхний хагас жилд</p>	<p>Засгийн газар, Монголбанк, Санхүүгийн зохицуулах хороо</p>

<p>тодорхой болгох чиглэлээр Төв банкны тухай хуульд өөрчлөлт оруулах;</p> <p>2.3.3.Валютын урсгалыг зохицуулах харилцааг сайжруулах зорилгоор Валютын зохицуулалтын тухай хуулийг шинэчлэн боловсруулж, батлуулах;</p> <p>2.3.4.Санхүүгийн зах зээлийн бүтцийг олон тулгуурт болгох, болзошгүй эрсдэлийг үнэлэх, хамгаалах, бодлогын уялдааг хангах институт болгох зорилгоор Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах;</p> <p>2.3.5.Хөгжлийн банкны улсын төсөвтэй харилцах харилцааг боловсронгуй болгох, болзошгүй эрсдэлийг бууруулах, засаглал, ил тод байдал, тайлагналыг сайжруулах, үйл ажиллагааны цар хүрээг өргөжүүлэх, бие даасан байдлыг нэмэгдүүлэх чиглэлээр Монгол Улсын Хөгжлийн банкны тухай хуулийг шинэчлэн батлуулж, бүтцийн өөрчлөлт хийх;</p> <p>2.3.6.Монгол Улсын Санхүүгийн зах зээлийг 2025 он хүртэл хөгжүүлэх үндэсний хөтөлбөр боловсруулж, батлуулах;</p> <p>2.3.7.Төрөөс бизнес эрхлэгчдэд олгож байгаа тусгай зөвшөөрлийн тоог гурав дахин цөөрүүлж, мэргэжлийн хяналт, татвар, нийгмийн даатгал, хууль хяналтын</p>				
--	--	--	--	--

<p>байгууллагын давхардсан хяналт шалгалт, хүнд суртлыг арилгах;</p> <p>2.3.8.Төрийн албаны шинэтгэлийн хүрээнд төрийн байгууллагын бүтэц, бүрэлдэхүүнийг мэргэшсэн, хариуцлагатай, цомхон, тогтвортой байх эрх зүйн орчныг бүрдүүлэх;</p> <p>2.3.9.Годорхой эрхэлсэн ажилгүй иргэдийг богино хугацааны цагийн ажилд зуучлах, цалин хөлсийг тухай бүр олгох боломжийг бүрдүүлэх;</p> <p>2.3.10.Ажлын байрны эрэлт, хэрэгцээнд үндэслэж богино хугацаанд мэргэжил олгох сургалтыг зохион байгуулж, ажиллах хүчийг бэлтгэх.</p>				
---	--	--	--	--



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2016 оны 11 дүгээр сарын 24-
ний өдөр

Улаанбаатар хот

Дугаар 71 “ЭДИЙН ЗАСГИЙГ СЭРГЭЭХ ХӨТӨЛБӨР” БАТЛАХ ТУХАЙ

Эдийн засгийг сэргээх зорилгоор Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.1 дэх хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.“Эдийн засгийг сэргээх хөтөлбөр”-ийг 1 дүгээр хавсралтаар, “Тэргүүн ээлжинд боловсруулж, батлуулах шаардлагатай хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төслийн жагсаалт”-ыг 2 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

2.Эдийн засгийг сэргээх чиглэлээр дараахь арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Засгийн газар /Ж.Эрдэнэбат/, Монголбанк /Н.Баяртсайхан/, Санхүүгийн зохицуулах хороо /С.Даваасүрэн/-нд тус тус үүрэг болгосугай:

1/“Эдийн засгийг сэргээх хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх нарийвчилсан төлөвлөгөө баталж, хэрэгжүүлэх;

2/энэ тогтоолын хавсралтад заасан банк, санхүү, төсөв, бодит салбарын үйл ажиллагааг дэмжих, тогтворжуулахад шаардагдах хөрөнгийг гадаад, дотоод эх үүсвэрээс нэн даруй босгох арга хэмжээг авч хэрэгжүүлэх;

3/эдийн засгийг сэргээхтэй холбоотой тэргүүн ээлжинд боловсруулж батлуулах хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төслүүдийг Улсын Их Хуралд яаралтай өргөн мэдүүлэх.

3.Хөтөлбөрийн хэрэгжилтийн явц, үр дүнг тооцож, хугацаандаа хэрэгжээгүй заалт бүрийг хариуцах албан тушаалтанд зохих хариуцлага хүлээлгэж, хөтөлбөрийн явцыг хагас жил тутам Улсын Их Хуралд танилцуулж байхыг Монгол Улсын Засгийн газар /Ж.Эрдэнэбат/, Монголбанк /Н.Баяртсайхан/, Санхүүгийн зохицуулах хороо /С.Даваасүрэн/-нд тус тус үүрэг болгосугай.

4.Энэ тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Улсын Их Хурлын холбогдох байнгын хороодод даалгасугай.

5.Энэ тогтоолыг баталсантай холбогдуулан Улсын Их Хурлын 2014 оны “Эдийн засгийн идэвхижлийг нэмэгдүүлэх зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын 34

дүгээр тогтоол, 2015 оны “Эдийн засгийн хүндрэлээс гарах арга хэмжээний хөтөлбөр батлах тухай” Улсын Их Хурлын 41 дүгээр тогтоолыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

6.Энэ тогтоолыг 2016 оны 11 дүгээр сарын 24-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА

М.ЭНХБОЛД

3章添付資料

List of project in related area by international donors

Donor Name	GIZ
Project Name	Integrated Mineral Resource Initiative II
Type	
C/P	Ministry of Industry, NDA
Total Cost	€ 5150,000.00
Duration	2014 - 2020
Implementing Org.	
In-charge person	Dr.Dr.h.c. Stefan Hanselmann (Program Director)
Project Goal	The ability of national and local partner institutions to promote inclusive and sustainable growth based on mineral resource wealth is improved.
Project activity	<p>The initiative comprises three fields of activity:</p> <ol style="list-style-type: none"> 1.Sustainable location development in mining regions 2.Macroeconomic management of a resource-based market economy 3.Supporting the agreement between Germany and Mongolia on cooperation in the field of mineral resources <p>The project pursues a multi-stakeholder and multi-level approach. It strengthens the partner ministries' capacity for macroeconomic management of a resource-based economy. Assistance is provided to media representatives, universities, and the private sector to enable them to promote the economic discourse. The project adopts an integrated approach to location development in the region: dialogue platforms and capacity development measures are implemented and the stakeholders are enabled to improve their participation in economic, social, and political discourse and development.</p>
Source	https://www.giz.de/projektdaten/projects.action?request_locale=en_EN&n=201421304

3章添付資料

List of project in related area by international donors

Donor Name	Europe Aid
Project Name	Economic Governance for Equitable Growth (EG4EG)
Type	Services
C/P	MOF, MoPDSP
Total Cost	€ 3394,000.00
Duration	Feb 15-Feb 18
Implementing Org.	GIZ
In-charge person	Mr.Peter Potier
Project Goal	<p>The overall objective of the project is to strengthen the economic governance of revenues from Mongolia's mineral wealth towards sustainable development.</p> <p>The specific objective of the project is to strengthen institutional capacities of selected key Ministries within the Mongolian administration to enhance revenue generation and public service delivery, emphasising the efficient and effective management and utilization of revenues from the mining sector for equitable growth.</p>
Project activity	<p>The main expected results of the current project are:</p> <p>Component 1 – Technical Assistance (TA) to the MoED Result 1: Institutional strategic planning and coordination capacity of the MoED towards an efficient and effective management and utilisation of revenues from the mining sector for equitable growth, strengthened.</p> <p>Component 2 – Technical Assistance (TA) to the MoF Result 2: Institutional capacity of the MoF in terms of strategic planning, revenue forecasting, improved taxation and financial models, aiming at the extractive industries, strengthened.</p> <p>Component 3 - Technical Assistance (TA) to the MOPDSP Result 3: Institutional capacities of the MoPDSP to enhance service delivery, emphasising on the development and implementation of a sustainable, balanced, efficient and effective social protection framework, utilising revenues from the mining sector, strengthened.</p>
Source	http://ec.europa.eu/europeaid/projects/economic-governance-equitable-growth-eg4eg_en

3章添付資料

List of project in related area by international donors

Donor Name	World Bank
Project Name	Third Sustainable Livelihoods Project
Type	
C/P	MOF
Total Cost	\$36200,000.00
Duration	2014-2018
Implementing Org.	
In-charge person	Helene Monika Carlsson Rex
Project Goal	The objectives of the Third Sustainable Livelihoods Project for Mongolia are to improve governance and community participation for the planning and delivery of priority investments in rural areas of Mongolia.
Project activity	<p>The project comprises 3 components.</p> <p>Component 1: Capacity building for local governance and livelihoods Aims to build the capacity at local and national levels for the implementation and further development of the Government's program and mechanisms for support rural development. At the local level, provide training and technical assistance in the areas of medium-term planning, community participation, budget preparation, procurement, supervision, reporting and monitoring and evaluation. At the national level, provide technical support to central public administrative organizations.</p> <p>Component 2: Good governance performance-based support program, includes budget preparation and adoption, budget execution, accounting, reporting, internal and external control and public scrutiny. Particular importance will be given to citizen participation. This will also carry out annual performance assessments.</p> <p>Component 3: Project management and monitoring and evaluation Supports the implementation structure, financing of staff costs, related expenditures, monitoring and evaluation, procurement, and financial management.</p>
Source	http://projects.worldbank.org/P125232/third-sustainable-livelihoods-project?lang=en&tab=overview

3章添付資料

List of project in related area by international donors

Donor Name	World Bank
Project Name	Multi-Sectoral Technical Assistance Project
Type	TA
C/P	MOF
Total Cost	\$12000,000.00
Duration	2010-2017
Implementing Org.	
In-charge person	Taehyun Lee
Project Goal	The objectives of this TA loan are to: (i) improve budget preparation, public investment planning, and public financial management; (ii) strengthen social policy planning and implementation for the poor and vulnerable; and (iii) stabilize the financial sector.
Project activity	The Project comprises three major components in line with the focus of the government's development objectives as well as with DPC1 and DPC2. These include: (i) strengthening budget preparation, public investment planning, and public financial management; (ii) social protection reform; and (iii) stabilizing the financial sector. The Project will also include a project management component to effectively carry out the implementation and daily project administrative work.
Source	http://projects.worldbank.org/P119825/mongolia-multi-sectoral-technical-assistance-project?lang=en

3章添付資料

List of project in related area by international donors

Donor Name	KOICA
Project Name	The Project for the Medium Term Fiscal Planning Capacity Building and Improvement of Fiscal Management E-system in Mongolia
Type	
C/P	MOF (Department of Budget Investment & Fiscal Planning)
Total Cost	
Duration	Dec 2015 - Jul 2018
Implementing Org.	
In-charge person	
Project Goal	
Project activity	<p>Topic 1: Legal and Institutional Frameworks of MTEF</p> <p>Topic 2: Procedural Reform of MTEF for Better Fiscal Coordination</p> <p>Topic 3: Capacity Building for Macro-Economic Forecasting and Aggregate Fiscal Management</p> <p>Topic 4: Prioritization of Public Investments and Management of Fiscal Projects</p> <p>Topic 5: Rearrangement of the Organizational Structure for Better Fiscal Management</p> <p>Topic 6: Building Information Systems for Improving MTEF's Credibility</p>
Source	n.a.

3章添付資料

List of project in related area by international donors

Donor Name	ADB
Project Name	Transparency and Efficiency in Public Financial Management
Type	TA
C/P	MOF (Budget Investment)
Total Cost	\$1100,000.00
Duration	Nov 2014-Nov 2016
Implementing Org.	ADB
In-charge person	Ms.Uchimura, ADB
Project Goal	Completed preparation for (i) a public investment information management and monitoring platform including PMPPI and PIMIS, and (ii) an e-taxation system
Project activity	<p>Component 1: Improve Transparency and Efficiency in Public Investment</p> <ol style="list-style-type: none"> 1. Analysis of integrated system management for the functional and secured platform with policy recommendations and a system management manual 2. Capacity development for relevant officials and ICT personnel; and enhancement of public awareness and understanding of the PMPPI with development of a general users guideline 3. Pilot testing support with an assessment and an action plan for full implementation <p>Component 2: Electronic Taxation System</p> <ol style="list-style-type: none"> 1. Diagnostic assessment of the current ICT system for electronic tax administration with development of an investment and action plan for full implementation of an e-taxation system 2. Analysis of workflow management to control an entire e-taxation system, and manage data and information risks 3. Capacity building for relevant officials and ICT personnel with development training materials
Source	https://www.adb.org/projects/47200-001/main#project-overview

RESOLUTION OF THE GOVERNMENT OF MONGOLIA

2017 January 04

No. 5

Ulaanbaatar

Re: Formulating General Plan for
Mongolia's Population Settlement

In order to ensure the implementation of the Sustainable development concept of Mongolia – 2030, Green development policy, and the Action plan of the Government of Mongolia 2016-2020, the followings are RESOLVED by the Government of Mongolia on the basis of the Provision 1 of Article 30 of Law on Government and the 6.1.3 and 15.1.1 of Urban Development Law:

1. To approve the members of the National committee which is responsible for organizing formulation and approval of the General Plan for Mongolia's Population Settlement by the Appendix;
2. To oblige G.Munkhbayar, Minister of construction and urban development, to organize the works to prepare the draft of the General Plan for Mongolia's Population Settlement and to submit to the National committee for discussion;
3. To oblige B.Choijilsuren, Minister of finance, and G.Munkhbayar, Minister of construction and urban development, to appropriate funds to formulate the plan specified in the 1 of this resolution in the state budget of 2018 and 2019, include in the projects and programs to be implemented by foreign and international organizations, and to fund the formulation of the plan by other resources;
4. With the approval of this resolution, the resolution "Formulating General Plan for Mongolia's Population Settlement" of the Government of Mongolia numbered 141 dated 2014 May 03 shall be invalid.

Prime Minister of Mongolia

J.ERDENEBAT

Minister of Construction and Urban Development

G.MUNKHBAYAR

MEMBERS OF THE NATIONAL COMMITTEE WHICH IS RESPONSIBLE FOR
ORGANIZING FORMULATION AND APPROVAL OF THE GENERAL PLAN FOR
MONGOLIA'S POPULATION SETTLEMENT

- | | |
|-----------------|---|
| Director | - Prime Minister of Mongolia |
| Deputy director | - Minister of Construction and Urban Development |
| | - Governor of the Capital city and Mayor of Ulaanbaatar city |
| Members: | - Deputy director in charge of local affairs of the Cabinet Secretariat of the Government of Mongolia |
| | - State secretary of the Ministry of Environment and Tourism |
| | - State secretary of the Ministry of Foreign Affairs |
| | - State secretary of the Ministry of Finance |
| | - State secretary of the Ministry of Justice and Internal Affairs |
| | - State secretary of the Ministry of Defense |
| | - State secretary of the Ministry of Education, Culture, Science and Sport |
| | - State secretary of the Ministry of Road and Transportation |
| | - State secretary of the Ministry of Mining and Heavy Industry |
| | - State secretary of the Ministry of Labor and Social Protection |
| | - State secretary of the Ministry of Food, Agriculture and Light Industry |
| | - State secretary of the Ministry of Energy |
| | - State secretary of the Ministry of Health |
| | - Head of National Development Agency |
| | - President of the Academy of Science |
| | - Head of the Communications, Information and Technology Agency |
| | - Head of the General Agency of State Registration and Intellectual Property |
| | - Head of the National Agency for Meteorology and Environment Monitoring |
| | - Head of the General Agency for Border Protection |
| | - Head of the Civil Aviation Authority |
| | - Head of the Immigration Agency |
| | - Head of the General Archival Agency |
| | - Head of the Mineral Resources and Petroleum Authority |
| | - Head of Agency of Land Management, Geodesy and Cartography |
| | - Head of National Emergency Management Agency |
| | - Director of Geo Ecological Society |
| Secretary | - State secretary of the Ministry of Construction and Urban Development |



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2017 оны 1 дүгээр
сарын 4-ний өдөр

Дугаар 5

Улаанбаатар
хот

“Монгол Улсын хүн амын нутагшилт,
суурьшлын хөгжлийн ерөнхий
төсөл” боловсруулах тухай

Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030, Ногоон хөгжлийн бодлого, Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн зорилтыг хэрэгжүүлэх зорилгоор Засгийн газрын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Хот байгуулалтын тухай хуулийн 6.1.3, 15.1.1-д заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. “Монгол Улсын хүн амын нутагшилт, суурьшлын хөгжлийн ерөнхий төсөл”-ийг боловсруулан батлуулах ажлыг удирдан зохион байгуулах үүрэг бүхий Үндэсний хорооны бүрэлдэхүүнийг хавсралт ёсоор баталсугай.
2. Монгол Улсын хүн амын нутагшилт, суурьшлын хөгжлийн ерөнхий төслийг боловсруулах ажлыг шуурхай зохион байгуулж, Үндэсний хороогоор хэлэлцүүлэхийг Барилга, хот байгуулалтын сайд Г.Мөнхбаярт даалгасугай.
3. Энэ тогтоолын 1 дүгээр зүйлд заасан төслийг боловсруулахад шаардагдах хөрөнгийг 2018, 2019 оны улсын төсөвт тусган гадаад орон, олон улсын байгууллагаас хэрэгжүүлэх төсөл, хөтөлбөрт хамруулж, холбогдох бусад эх үүсвэрээс санхүүжүүлэх арга хэмжээ авахыг Сангийн сайд Б.Чойжилсүрэн, Барилга, хот байгуулалтын сайд Г.Мөнхбаяр нарт даалгасугай.
4. Энэ тогтоол гарсантай холбогдуулан “Монгол Улсын хүн амын нутагшилт, суурьшлын хөгжлийн ерөнхий төсөл боловсруулах тухай” Засгийн газрын 2014 оны 5 дугаар сарын 3-ны өдрийн 141 дүгээр тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.



Монгол Улсын Ерөнхий сайд

Ж.ЭРДЭНЭБАТ

Барилга, хот байгуулалтын сайд

Г.МӨНХБАЯР

"МОНГОЛ УЛСЫН ХҮН АМЫН НУТАГШИЛТ, СУУРЫШЛЫН ХӨГЖЛИЙН
ЕРӨНХИЙ ТӨСӨЛ"-ИЙГ БОЛОВСРУУЛАН БАТЛУУЛАХ АЖЛЫГ
УДИРДАН ЗОХИОН БАЙГУУЛАХ ҮҮРЭГ БҮХИЙ
ҮНДЭСНИЙ ХОРООНЫ БҮРЭЛДЭХҮҮН

Дарга	-Монгол Улсын Ерөнхий сайд
Дэд дарга	-Барилга, хот байгуулалтын сайд; -Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч.
Гишүүд:	-Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын орон нутгийн асуудал хариуцсан дэд дарга; -Байгаль орчин, аялал жуулчлалын яамны Төрийн нарийн бичгийн дарга; -Гадаад харилцааны яамны Төрийн нарийн бичгийн дарга; -Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга; -Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга; -Батлан хамгаалах яамны Төрийн нарийн бичгийн дарга; -Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яамны Төрийн нарийн бичгийн дарга; -Зам, тээврийн хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга; -Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны Төрийн нарийн бичгийн дарга; -Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Төрийн нарийн бичгийн дарга; -Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Төрийн нарийн бичгийн дарга; -Эрчим хүчний яамны Төрийн нарийн бичгийн дарга;

- Эрүүл мэндийн яамны Төрийн нарийн бичгийн дарга;
- Үндэсний хөгжлийн газрын дарга;
- Шинжлэх ухааны академийн ерөнхийлөгч;
- Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газрын дарга;
- Улсын бүртгэл, оюуны өмчийн ерөнхий газрын дарга;
- Цаг уур, орчны шинжилгээний газрын дарга;
- Хил хамгаалах ерөнхий газрын дарга;
- Иргэний нисэхийн ерөнхий газрын дарга;
- Иргэний харьяалал, шилжилт хөдөлгөөний ерөнхий газрын дарга;
- Архивын ерөнхий газрын дарга;
- Ашигт малтмал, газрын тосны газрын дарга;
- Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газрын дарга;
- Онцгой байдлын ерөнхий газрын дарга;
- Геоэкологийн хүрээлэнгийн захирал.
- Барилга, хот байгуулалтын яамны Төрийн нарийн бичгийн дарга.

Нарийн бичгийн
дарга